



Нэгдсэн Үндэстний Байгууллагын  
Боловсрол, Шинжлэх Ухаан,  
Соёлын Байгууллага



Японы  
Итгэлийн Сан



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



# ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БАГШИЙН БОЛОВСРОЛ

## ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР ХОТ  
2015 ОН



“Тэгш хамруулан сургах багшийн боловсрол” зөвлөмж  
Англи нэр: Promoting Inclusive Teacher Education: Advocacy Guides

Энэхүү зөвлөмжийг ЮНЕСКО–гийн Бангкок дахь салбараас анх хэвлэн гаргасан.  
Ази, Номхон далайн бүс нутгийн Боловсролын Товчоо  
Мом Луанг Пин Малакул зууны барилга  
920 Сухумвит гудамж, Праканонг, Клонгтой  
Бангкок 10110, Тайланд

©ЮНЕСКО 2013

©ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс 2015 (Монгол хэлнээ орчуулсан  
хувилбар)  
Бүх эрхийг хадгалсан болно

Энэхүү номыг ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар болон ЮНЕСКО-гийн Бангкок дахь салбарын тусламжтайгаар Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам (БСШУЯ), Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ), Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС), ЮНЕСКО-гийн МҮК хамтран Монгол хэлнээ нутагшуулан хэвлүүлсэн болно.

ISBN 978-92-9223-493-5 (Хэвлэмэл)

ISBN 978-92-9223-494-2 (Цахим)

Энэхүү товхимол хэвлэгдсэн аливаа дүрс тэмдэгтүүд болон агуулга нь ЮНЕСКО-гийн зүгээс аливаа улс орон, газар нутаг, хот болон хотын захиргаа, хил хязгаарын талаарх хууль, эрх зүйн халдашгүй байдлыг хөндөөгүй болно.

Үүнд орсон тоо баримт, илэрхийлсэн үзэл бодлын талаар зохиогчид өөрсдөө хариуцлага хүлээх бөгөөд ЮНЕСКО болон бусад байгууллагад хамаарахгүй болно. ЮНЕСКО-гийн Бангкок дахь салбар нь тус номын болон бусад хэвлэлүүдийн агуулгыг түгээн дэлгэрүүлэхийг эрмэлзэж байгаа бөгөөд аливаа материалыг хэвлэх, өөрчлөх, дахин хэвлэх, орчуулах зэргээр санал зөвлөгөөг хүлээн авахад бэлэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [ikm.bgk@unesco.org](mailto:ikm.bgk@unesco.org) авна уу.

Хянан тохиолдуулсан: Б.Насанбаяр, Р.Туяа, доктор (Ph.D), П.Мөнхзул

Хэвлэлийн эхийн Монгол хувилбарыг бэлтгэсэн:

Д.Одгэрэл доктор (Ph.D), Г.Батцэнгэл доктор (Ph.D), Р.Туяа, доктор (Ph.D),

Ч.Жаргал

Англи хэлнээс хөрвүүлсэн: Д.Цэдэвсүрэн, доктор (Ph.D) / МУБИС-н багш нарын баг /

“Адмон Принт” ХХК-д хэвлэв.

Улаанбаатар хот, 2015 он

## Өмнөх үг

Тэгш хамруулан сургах боловсрол нь бүх нийтийн боловсрол эзэмших цар хүрээг нэмэгдүүлэх, хүн бүрт мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж олгох ба боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм.

Тэгш хамруулан сургах боловсролын үзэл санааг хэрэгжүүлэхэд сургалтын агуулга, хандлага, үйл явц, бүтэц, зохион байгуулалт зэрэг нь бүх нийтийн боловсролд нийцсэн байхаар өөрчлөлт, шинэчлэлийг хийх шаардлага тулгарч байна. Үүний биелэлтэд багш бүрийн үүрэг, оролцоо зайлшгүй чухал билээ.

Багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд тэгш хамруулах сургалтын орчинг бүрдүүлж, түүнийг хэрэгжүүлэх, сайжруулах чадвар бүхий боловсон хүчин бэлтгэн гаргах үүрэгтэй байдаг. ЮНЕСКО-гийн Бангкок дахь Ази, Номхон далайн бүс нутгийн Боловсролын Товчооноос тус бүс нутгийн орнуудын багш бэлтгэх боловсролын чиг хандлагыг нягтлахад тухайн бүс нутгийн нэлээд орны багш бэлтгэдэг их дээд сургуулиуд нь суралцагч бүрийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан сургалтыг зохион байгуулах мэдлэг, чадвар бүхий боловсон хүчин бэлтгэхийг зорилгоо болгон ирсэн нь харагдаж байна.

Дээрх туршлагад үндэслэн ЮНЕСКО-гоос энэхүү **“Тэгш хамруулан сургах багшийн боловсрол”** хэмээх цуврал товхимолыг боловсруулсан ба үүнд “Удирдамж”, “Бодлого”, “Хөтөлбөр”, “Хэрэглэгдэхүүн”, “Арга зүй” гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Уг товхимолд тэгш хамруулан сургах боловсролын үзэл санаанд нийцсэн багш боловсролын шинэчлэл, хөгжил дэвшлийг бий болгох хүсэл эрмэлзэлтэй хэн бүхэнд дэмжлэг болохуйц зөвлөмжүүдийг багтаасан болно. Эдгээр товхимол нь ягштал даган мөрдөх ёстой гарын авлага бус, харин зөвлөхүүд өөр өөрсдийн орчин нөхцөлийн онцлог болон хэрэгцээг тооцон бодож үзэх, хэрэгжүүлэх боломжтой санаануудыг танилцуулсан болно.

Энэхүү цуврал товхимол нь Ази, Номхон далайн орнуудын багш боловсролд тэгш хамруулах боловсролын үзэл санааг тусган, чанартай боловсрол олгох тогтолцоог бий болгоход хувь нэмэр оруулна хэмээн гүнээ найдаж байна.



Гван-Жо Ким

Захирал

ЮНЕСКО, Бангкок

## Талархал

Тэгш хамруулан сургах багшийн боловсрол хэмээх энэхүү зөвлөмжийг манай орны боловсролын үйл ажиллагаанд дэмжлэг болгон ЮНЕСКО-гийн Бангкок дах салбар болон Бээжин дэх төлөөлөгчийн газар, Японы Боловсрол соёл спорт шинжлэх ухаан, технологийн яамнаас санхүүжүүлж орчуулан хэрэгжүүлж байгаад баяртай байна.

Түүнчлэн 2012 оны 7-р сард Тайландын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын “Чанартай Багш Боловсролоор Тэгш Хамруулан Сургах Боловсрол олгох нь” ЮНЕСКО-гийн бүс нутгийн мэргэжилтнүүдийн уулзалтаас гарсан энэхүү үйл ажиллагааг эхлүүлсэн Иан Каплан, Ингрид Льюис нарт талархаж илэрхийлье.

Гарын авлагын монгол хувилбарыг бүтээхэд Монголын Боловсрол Соёл Шинжлэх ухааны яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Насанбаяр, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын мэргэжилтэн П.Мөнхзул, Багшийн Мэргэжил дээшлүүлэх институтийн Захиалгат сургалтын албаны дарга Р.Туяа, арга зүйч Ч.Жаргал, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Д.Одгэрэл, Г.Батцэнгэл нар хамтран ажиллалаа.

Тус зөвлөмжийг бэлтгэх хэлэлцүүлэгт оролцсон Боловсролын хүрээлэн, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Монголын дүлий иргэдийн үндэсний хороо, “Өгөөмөр сэтгэл” ТББ, Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль, 34, 116, 87 дугаар сургууль, 186,199 дүгээр цэцэрлэгийн багш нар өөрсдийн байгууллагын хүрээнд болон хүрээнээс гадуур тэгш хамруулан сургах боловсролын талаарх өөрсдийн мэдлэг, туршлагаа илэн далангүй хуваалцсанд талархаж байна.

Тэгш хамруулан сургах багшийн боловсрол нь бодлого боловсруулагчид төдийгүй, багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш, оюутан, багшаар ажиллаж байгаа нийт боловсролын салбарын багш удирдах ажилтан нарт зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна. Энэ нь зөвхөн хөгжлийн бэрхшээлээс гадна, хэл яриа, соёл, зэрэг хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан сургалтын үйл ажиллагааг явуулах нь манай улсын боловсролын яамнаас дэвшүүлж байгаа хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилготой бүрэн нийцсэн цаг үеэ олсон чухал асуудал юм.

Эцэст нь хэлэхэд Бүх Нийтийн Боловсролыг Чанартай Багш Боловсролд чиглүүлэхэд Ази-Номхон далайн орнуудад тэгш хамруулан сургах боловсролыг ирээдүйн багшийн чухал үзүүлэлт болгон хэрэгжүүлж түүнээс урган гарч буй үр ашигт чин сэтгэлээсээ баяртай байна.

БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

## АГУУЛГА

<b>Зөвлөмж - 1 УДИРДАМЖ</b> .....	<b>1</b>
Удиртгал .....	2
Зөвлөмж .....	9
Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ? .....	19
<b>Зөвлөмж - 2 БОДЛОГО</b> .....	<b>21</b>
Удиртгал .....	22
Бэрхшээл.....	27
• Тэгш хамруулан сургах боловсролын ойлголт, үзэл бодол	
• Хамтын ажиллагаа	
• Бодлого хэрэгжилт	
• Нийгэм-эдийн засгийн бодлого	
Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ? .....	43
<b>Зөвлөмж - 3 ХӨТӨЛБӨР</b> .....	<b>49</b>
Удиртгал .....	50
Бэрхшээл .....	52
• Тэгш хамруулан сургах асуудал нь багш бэлтгэх хөтөлбөрийн нэгэн хэсэг болох нь	
• Тусгай хэрэгцээт боловсролоос тэгш хамруулан сургах сургалт руу шилжих нь	
• Онол практикийн зохистой харьцааг хангах нь	
• Хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх асуудал	
• Тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах явдал, тогтсон ташаа ойлголт, сэтгэлгээний буруу хэвшил	
Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?.....	69

<b>Зөвлөмж - 4 ХЭРЭГЛЭГДЭХҮҮН .....</b>	<b>75</b>
Удиртгал.....	76
Бэрхшээл.....	77
<ul style="list-style-type: none"> <li>• Тохиромжтой хэрэглэгдэхүүн</li> <li>• Практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах уян хатан бодлого</li> <li>• Явцуу хүрээг хамарсан хэрэглэгдэхүүнээс зайлсхийх</li> </ul>	
Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?.....	99
<b>Зөвлөмж - 5 АРГА ЗҮЙ .....</b>	<b>105</b>
Удиртгал .....	106
Бэрхшээл .....	109
<ul style="list-style-type: none"> <li>• Харилцан адилгүй суралцагчидтай ажиллах нь</li> <li>• Заах арга ба ур чадвар</li> <li>• Багшлах дадлага, эргэцүүлэл ба дэмжлэг</li> </ul>	
Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ? .....	135
<b>Хавсралт .....</b>	<b>139</b>

# Зөвлөмж 1-Удирдамж

1

УДИРДАМЖ

## Удиртгал

“Тэгш хамруулан сургах багшийн боловсрол” товхимол нь таван цуврал зөвлөмжөөс бүрдэнэ. Эдгээр зөвлөмжид багш бэлтгэх хөтөлбөрийн тэгш хамруулах сургалтад тулгарч буй бэрхшээл, саадуудыг хөндөх төдийгүй тэгш хамруулах боловсролын үзэл санаа, зарчмуудыг хэрэгжүүлэх үр дүнтэй стратеги, шийдлүүдийг зөвлөмжлөн санал болголоо.

Энэхүү цуврал нь танилцуулга буюу удирдамжаар эхэлж байна. Энэ хэсэгт тэгш хамруулах багш боловсролын ерөнхий тойм болон тус ойлголтын хүрээнд зөвлөмж гэж юу болох талаар тайлбарлана. Мөн бусад дөрвөн зөвлөмж болох “Бодлого”, “Хөтөлбөр”, “Хэрэглэгдэхүүн,” “Арга зүй”-д тусгасан сэдвүүдийг танилцуулна.

## Удирдамж хэнд зориулагдсан бэ?

Боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг илүүтэй тусгах тал дээр ажиллах багш, хүсэлтэй хүн бүхэнд зориулагдав.

Тус асуудлыг шийдвэрлэхэд оролцогчид нь:

- Бодлого боловсруулагчид – засгийн газрын түвшинд багш боловсролын шинэчлэлийн асуудалд дэмжлэг, зөвлөмж өгдөг багш боловсролын сургууль, мэргэжлийн байгууллагуудад шинэ санаа хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа шинэчлэл хийх, шинэ бодлого хэрэгжүүлэх зэрэгт зөвлөмж өгдөг
- Багш бэлтгэдэг сургуулийн удирдлага – засгийн газрын багш боловсролын бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэхийг дэмждэг, багш бэлтгэдэг сургуулийн багш нарыг уриалах ‘дотоод зөвлөмж’ өгөх хүсэлтэй хүмүүс,
- Багш бэлтгэдэг сургуулийн багш - өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагатай байгааг өөрийн сургуулийн удирдлагад санал оруулах, засгийн газрын бодлогын түвшинд өөрчлөлт хийх хүсэлтэй багш нар,
- Олон улсын ТББ, агентлагийн ажилтан – багш боловсролын шинэчлэлийн төлөө засгийн газарт санал оруулах, оролцогч талуудыг тус өөрчлөлтөд уриалах, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжих хүсэлтэй хүмүүс,
- Багш болон оюутан-багш нар – харилцан адилгүй анги бүлгийн орчинд ажиллах үүднээс өөрсдөө болон ирээдүйд багш болохоор суралцах багш нарыг бэлтгэх боловсролыг сайжруулахыг дэмжих хүсэлтэй хүмүүс,
- Суралцагчид болон тэдний хамт олон – сайн боловсрол эзэмших хэрэгцээнийхээ улмаас багш боловсролд анхаарлаа хандуулж хүсэлтэй хүмүүс.



## Удирдамжийг хэрхэн ашиглах вэ?

Энэхүү цуврал нь шинэ санал, санаануудыг товч танилцуулах зорилготой, ба харин зааварчилгаа биш юм. Асуудалд хамааралтай хэн бүхэн өөр өөрсдийн ялгаатай нөхцөл байдал, хэрэгцээнд үнэлгээ хийсний үндсэн дээр аливаа мэдээ, мэдээлэл, зорилт, арга хэрэгслийг тохируулан авч үзэх шаардлагатай.

Удирдамж тус бүрт өөрийн нөхцөл байдлыг эргэцүүлэн дүгнэх, чухал шийдвэр гаргахдаа сонирхлын бүлгүүдийг хэрхэн оролцуулах зэрэг асуудлыг тусгасан болно.

## Удирдамжид ямар асуудлыг хөндөх вэ?

Таван зөвлөмж нь дараах сэдвүүдийг хөндөнө:

**Зөвлөмж 1: Удирдамж** – Энэ хэсэг нь тэгш хамруулан сургах боловсролын талаар товч танилцуулгийн тухай

Тус удирдамжийг тэгш хамруулан сургах боловсролын талаар ойлголт авч болох цор ганц гарын авлага болгон ашиглах нь учир дутагдалтай. Тэгш хамруулан сургах боловсролын талаар ойлголт, мэдлэгтэй эсвэл ойлголттой болохын тулд бусад нэмэлт мэдээлэл, бусад эх сурвалжийг ашиглана хэмээн тооцож байна. Цаашилбал багш бэлтгэх сургалтын явцад тэгш хамруулан сургах боловсролын талаар мэдлэг, ойлголттой байхын ач холбогдлыг тайлбарлана. Бусад дөрвөн зөвлөмжид багш бэлтгэх сургалтын дөрвөн чухал талбарт өөрчлөлт хийхийг уриалсан зөвлөмжийг тусгасан.

**Зөвлөмж 2: Бодлого** – Тэгш хамруулан сургах боловсролын бодлогод анхаарал хандуулан, боловсролын тогтолцооны янз бүрийн түвшин дэх бодлогыг хэрхэн нийцүүлэх, өөрчлөн сайжруулах тухай (яам, багш бэлтгэх сургууль, дунд сургуулийн түвшинд).

**Бодлого** гэж ихэнхдээ үндэсний хэмжээний болон багш бэлтгэдэг сургуулийн хүрээнд баримтлах боловсролын талаарх дүрэм журам, хууль, тогтоомжийг хэлнэ. Тэгш хамруулан сургах боловсролын бодлого нь хувь хүн, хамтлаг/хамт олон, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ.

**Зөвлөмж 3: Хөтөлбөр** – Багш боловсролын бүтэц, дарааллыг бүхэлд нь хэрхэн өөрчлөх тухай.

**Сургалтын хөтөлбөр** гэдэг нь багш бэлтгэх боловсролын байгууллагад судлах бүх хичээлийг хамруулан ойлгоно. Сургалтын хөтөлбөр нь суралцахуйн тодорхой үр дүнд хүрэх зорилгоор сурах үйл явцыг дараалалтайгаар зохион байгуулах арга зам юм. Сургалтын хөтөлбөр нь юуг, яагаад, хэрхэн сургахад чиглүүлдэг. Сургалтын хөтөлбөр нь нийгэм<sup>1</sup>, улс төр, сургууль/багш нарын харилцан

<sup>1</sup> Braslavsky, C. 1999. “Боловсролын ОУ-н 48-р Конференц, тэгш хамруулах сургалтын хөтөлбөрийн эргэн тойрон дахь бүс нутаг хоорондын хэлэлцүүлэг”. 2008. Женев хот, ЮНЕСКО-Олон улсын боловсролын товчоо.

холбоог тусгадаг тул тэгш хамруулах сургалтын хөтөлбөр боловсруулах нь багш боловсролын сургах, сурах бүтцийг бүхэлд нь анхаарсан тэнцүү, үл ялгаварлах нийгмийг бий болгох хүсэл сонирхлыг илэрхийлэх юм.

**Зөвлөмж 4: Хэрэглэгдэхүүн** – Багш бэлтгэх боловсролд сургах, сурах үйл явцыг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, өөрчлөх тухай

*Сургалтын хэрэглэгдэхүүн* гэдэг нь багш бэлтгэдэг боловсролын байгууллагад ашиглагддаг нөөц (сурах бичиг)-ийг хэлнэ. Үүнд багш бэлтгэх боловсролд багш нарын сургалтдаа хэрэглэдэг сургалтын хэрэглэгдэхүүнээс гадна оюутан багш нарын суралцахдаа хэрэглэдэг бусад хэрэглэгдэхүүнийг хамруулан авч үзнэ.

**Зөвлөмж 5: Арга зүй** – Багш бэлтгэдэг боловсролын байгууллагын заах арга зүйг сайжруулах, өөрчлөх тухай.

*Арга зүй* гэдэг нь сургах, сурах үйл ажиллагааны онол, практикийг хэлнэ. Өөрөөр хэлбэл сургах, сурах үйлийг ойлгох, зохион байгуулах, хөтлөн чиглүүлэх явдал юм. Иймээс арга зүй нь сургахуйн арга, техникийг агуулсан сургалтын бүтэцчилсэн хүрээ буюу боловсролын хандлагын илэрхийлэл юм. Тухайлбал, тэгш хамруулах сургалтын арга зүйд хүн тус бүрийн онцлогийг харгалзсан, суралцагч төвтэй арга зүй багтана.

Эдгээр дөрвөн зөвлөмжийн агуулгын бүтэц нь:

- Хөндөж буй чиглэл тус бүрийг тулгамдаж буй асуудлаар нь бүлэглэн авч үзсэн
- Тухайн бүс нутгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх хүмүүст өөрсдийн нөхцөл байдлыг тодорхойлоход тус болох асуултуудыг зөвлөмжлөн оруулсан
- Тэгш хамруулах боловсролыг хариуцагч хэн бүхэнд зорилго, зорилтууд, чиг хандлагаа оновчтой тодорхойлоход шаардагдах мэдээ мэдээлэл өгөх, мөн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь хэр үр дүнтэй байсныг илрүүлэх үзүүлэлтүүд зэргийг зөвлөмжилсэн болно

Зөвлөмж бүрийн ард хүснэгтэд боломжит албан тушаалтанг нэгтгэн оруулсан бөгөөд тус бүрт нь хариуцах эздийг нь тодорхойлж , мөн эдгээр зөвлөмжийг өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн хэрхэн ашиглаж болох талаар тэмдэглэл хөтлөх зай гаргасан. Тодорхой асуудлаар хийгдсэн тохиолдлын судалгааг боломжтой хэсэг бүрт оруулсан болно.

## **Тэгш хамруулан сургах боловсрол гэж юу вэ?**

“Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралтгүй үйл явц юм.”

Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь суралцагчдын нийгэм, эдийн засаг, соёл, хэл, бие махбод болон бусад зүйлсийг үл харгалзан бүх суралцагчдын харилцан адилгүй хэрэгцээнд анхаарлаа хандуулсаар, боловсролын тогтолцоонд хийгдэх өөрчлөлтийн цогц үйл явц юм.

*Тэгш хамруулан сургах боловсрол нь үйл явц мөн.*

Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь боловсролын тогтолцоо, сургууль, сургуулийн удирдлага, багш нар бүх хүүхдийг ялгаварлахгүйгээр сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн идэвхтэй үйл явц юм. Энэ бол урьдаас төлөвлөсөн цаг хугацаанд тодорхой заавруудыг мөрдсөнөөр хүрч болдог тогтонги загвар, зорилго биш, харин тасралтгүй үйл явц аж.

*Тэгш хамруулан сургах боловсролын тухай ойлголт нь боловсролын бүхий л талбарыг хамардаг*

Тэгш хамруулан сургах боловсрол нь бүх нийтийн боловсролд тулгамдаж буй бэрхшээлүүдийг шийдвэрлэх, бүх суралцагчдын харилцан адилгүй байдлыг хүлээн зөвшөөрүүлэхэд боловсролын бодлого, үйл ажиллагаа, практикийг чиглүүлдэг. Түүнчлэн хүүхэд, залуус, насанд хүрэгч хэн бүхний сурч боловсрох эрхийг дэмжихийг зорьдог. Тэгш хамруулан сургах боловсрол нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн дээд боловсрол, цаашилбал насан туршийн, насанд хүрэгчдийн боловсрол, академик болон мэргэжлийн сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа гээд албан, албан бус боловсролын бүхий л үйл ажиллагаа, түвшин, салбарт хамаатай.

*Тэгш хамруулан сургах боловсрол нь тулгарч буй аливаа бэрхшээлийг шийдвэрлэн, сайн туршлагад тулгуурлана.*

Суралцагчдад боловсрол эзэмших, сурах үйл явцад идэвхтэй оролцох, чадавхиа (боловсролын болон нийгмийн) нэмэгдүүлэхэд нь тулгарч болзошгүй бэрхшээлийг олж тогтоон, тэдгээрийг шийдвэрлэх нь тэгш хамруулан сургах боловсролын гол үйл ажиллагаа юм. Бэрхшээл нь ихэвчлэн хандлага, үйл ажиллагаа, нөөц боломж, бодлого, байгууллагын бүтэц, удирдах үйл явц, дэд бүтэц, хүрээлэн буй орчин зэрэгтэй холбоотой үүсэж болно. Сургалтын байгууллага, сургууль бүр, тэгш хамруулах сургалтыг үр өгөөжтэй хэрэгжүүлэх, суралцагчдын хэрэгцээг харгалзан тэгш хамруулах сургалтын зохистой орчинг буй болгоход зөвхөн асуудал шийдвэрлээд зогсохгүй, мөн үр дүнтэй хэрэгжиж буй үйл ажиллагааг онцлон, түүн дээр суурилан цааш хөгжихийн тулд туршилт, эргэцүүлэл хийдэг байх шаардлагатай.

*Тэгш хамруулан сургах боловсрол нь олон улсын дэмжлэг авдаг*

Тэгш хамруулан сургах боловсрол нь үл ялгаварлал болон тэгш боломж гэсэн үндсэн зарчмуудаар баталгааждаг. Эдгээр үндсэн зарчмуудыг хангах, тэгш

хамруулан сургах боловсролын зөвлөмж хэрэгжүүлэхэд ашиглаж болох Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ), Бүх нийтийн боловсрол (БНБ) зэрэг олон тооны олон улсын баримт бичгүүд байдаг. Эдгээрийг тэгш хамруулан сургах боловсролоос ангид, ялгаатай хэмээн авч үзэж үл болно. Аливаа боловсролын тогтолцоо нь суралцагч нэг бүрийг тэгш хамруулахад хичээл зүтгэл, чармайлт гаргахгүй бол эдгээр санаачлагууд нь хэрэгжих боломжгүй юм.

*Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлалд боловсролын хүртээмж, чанар, гүйцэтгэл, үр дүнг хамааруулах нь*

Хүүхдийг сургуульд хамруулах, боловсролын хүртээмжийг дээшлүүлэх дангаараа хангалтгүй, харин бид суралцагчдад чанартай бага боловсролыг эзэмшүүлээд, дунд (дээд) түвшин рүү дэвшихэд нь анхаарах нь зүйтэй. Иймд эхлээд бид яагаад хүүхдүүд сургуулиа дүүргэж чаддаггүй шалтгаануудыг тодруулах хэрэгтэй. Тэдгээр нь ихэнхдээ санхүүгийн эсвэл нийгмийн шинжтэй шалтгаанууд байдаг. Тухайлбал, сургуулийн зардал хэт өндөр, хүүхдээрээ гэрийн ажилд туслуулах, гэрээ тэжээлгэхийн тулд хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл хүүхдүүд нь гэрлэх нь илүү ашигтай гэсэн бодлоос үүдэн хүүхдээ сургуулиас завсардуулдаг.

Мөн боловсролын тогтолцоонд буй дараах хүчин зүйлийн улмаас хүүхдүүдийг сургууль завсардалт руу “гүлхэж” байна. Үүнд:

Суралцагч төвтэй заах арга дутагдалтай чанаргүй сургалт, уялдаа муутай, ойлгомжгүй эсвэл хүртээмжгүй сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, хөгжлийн бэрхшээл, хүйс, гарал угсаа, хэл зэргээр ялгаварлан, гадуурхаж, сургуулиас хасах, таагүй, тухгүй сургуулийн орчин, үнэлгээний явцуу, ялгавартай хэлбэр, гэр сургууль хооронд, сургуулийн шат хоорондын (тухайлбал, боловсролын өмнөх – бага боловсрол хоорондын, бага – дунд боловсрол, дунд – дараагийн/дээд боловсрол), хөтөлбөр хоорондын (албан – албан бус боловсрол, техникийн – мэргэжлийн сургалтын сургууль - их дээд сургууль хоорондын) шилжилтийн үр өгөөжгүй арга, хэлбэрүүд (стратегийн) байна.

*Тэгш хамруулан сургах боловсрол нь багш боловсролыг эргэн нягтлахад хүргэнэ.*

Багш нар суралцагчдад хандах арга барил, ашигладаг сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүй, суралцагчдын харилцан адилгүй байдлыг хүлээн авч, үүнийг давуу тал хэмээн харах чадвар, тулгамдсан сорилт бэрхшээл, харилцан адилгүй сурах хэрэгцээнд дасан зохицон, эерэг хандах чадавхи зэргээрээ тэгш хамруулан сургах боловсролын үйл хэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Өнөөгийн багш бэлтгэх боловсрол нь багшлах ур чадварыг л анхааран үзэж байна. Тиймээс багш боловсролоор тэгш хамруулан сургах чадвартай багш нарыг бэлтгэх нь нэн чухал ч энэ нь зөвхөн тэгш хамруулан сургах боловсролын онолыг заагаад зогсохгүй боловсролын хүртээмж, оролцоо, сурахуйд тулгарч буй саадыг олж

тогтоох, эргэцүүлэх чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, асуудал шийдвэрлэх чадвартай, суралцагчдад эрх тэгш хандах зэрэг практик чадварыг эзэмшүүлэх нь чухал байна. Тэгш хамруулан сургах боловсрол эзэмшүүлэх нь оюутан-багш нарын заах арга зүйг сайжруулах, тэдний үүргийг илүү нарийвчлан, багш нарыг сургалтын хөтөлбөр боловсруулах чадвартай болгох асуудал тул оюутан-багшийн үүрэг, хандлага, чадамжийг дахин нарийвчлан авч үзэх шаардлагатай.

*Тэгш хамруулан сургах боловсрол нь сонирхлын бүлгүүдийн идэвхтэй оролцоог шаарддаг.*

Тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэхэд хүүхэд, эцэг эх, гэр бүл, асран халамжлагч, багш, иргэд, иргэний нийгмийн болон цөөнхийн бүлгийн төлөөлөл, засгийн газар, хувийн хэвшлийнхэн гээд бүгд чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэдний дуу хоолой нь багш нарыг тэгш хамруулан сургах чиглэлээр сайтар бэлтгэхэд онцгой үүрэгтэй. Түүнчлэн сонирхлын бүлгүүдэд багш боловсролын шинэ чиг хандлагын талаар танилцуулах, багш боловсролыг шинэчлэх үйл ажиллагааг манлайлах боломж олгох, практикт суурилсан багш боловсролын үйл ажиллагаанд оролцуулах хэрэгтэй байна. Эдгээрийг идэвхтэй оролцоог хангахын тулд бодлогоор дэмжих шаардлагатай.

## **Тэгш хамруулан сургах боловсролыг багш бэлтгэх боловсролд тусгахын ач холбогдол**

Тэгш хамруулан сургах боловсрол нь нийгэм, улс төр, эдийн засгийн олон талын үр ашигтайг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг. Эдгээр нь харилцан уялдаа бүхий эрх тэгш, тогтвортой нийгмийг бий болгодог. Ийм нийгмийг бий болгох ялангуяа нийгмийн тогтвортой хөгжлийн үр өгөөжийг бүх хүүхэд, залуус, насанд хүрэгчдэд хүртээмжтэй болгохын тулд тэгш хамруулсан, суралцагч төвтэй боловсрол зайлшгүй шаардлагатай юм.

Тэгш хамруулан сургах боловсрол нь бүх нийтийн чанартай боловсролын гол шалгуур болох: ирц, оролцоо, амжилт – д тулгуурладаг тул багш нар болон сонирхлын бүлгүүдэд онц хэрэгцээтэй. Иймээс тэгш хамруулан сургах боловсролыг ойлгох, түүнд нухацтай хандах, багш бэлтгэх боловсролын бүхий л үйл ажиллагаанд оруулах нь зүйтэй. Багш бэлтгэх боловсролоор харилцан адилгүй байдлыг хүлээн зөвшөөрдөг, сургалтаа чанартай зохион байгуулдаг, анги танхим, сургууль, нийгэмд оршин буй нийгэм, боловсролын олон асуудалтай нүүр тулж ажиллах чадвартай багш нарыг бэлтгэх нь нэн чухал байна.

Тэгш хамруулан сургах боловсрол нь бүх нийтэд зориулсан бодит чадвар эзэмшүүлэх сурах, сургах үйлийг дэмжиж, соёлын янз бүрийн нөхцөлд буй суралцагчдын харилцан адилгүй хэрэгцээг харгалзах мэдлэг, чадвартай багшийг бэлтгэхэд чиглэгдэнэ. Мөн суралцагчдын ялгавартай байдлыг дутагдал, бэрхшээл хэмээн үзэх бус, харин ч давуу тал хэмээн ойлгохыг багш

нарт уриалдаг. Түүнчлэн суралцагчийн онцлог, хэрэгцээнд нь тохирох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн заах аргуудыг хэрэглэх боломж олгодог. Цаашилбал тэгш хамруулан сургах боловсрол нь багшийг ажилдаа дуртай байж, үйлчилгээ үзүүлж буй нийгэмдээ үнэлэгдэх багш мэргэжлийн сэтгэл ханамж, ур чадварын соёлыг бий болгох хөшүүрэг болдог. Тэгэхээр тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь насан туршийн суралцахуй, хөгжлийн үйл явцын нэгээхэн хэсэг юм.

Сургалтын хэрэглэгдэхүүний судалгааны үр дүнгээс үзэхэд тэгш хамруулан сургах боловсролыг багш бэлтгэх боловсролын түвшнээс илүүтэй багш мэргэжил дээшлүүлэх түвшинд анхааран үздэг байна:

“Тэгш хамруулан сургах боловсролын талаарх хамгийн өргөн хүрээнд хэрэглэгдсэн сургалтын хэрэглэгдэхүүн нь багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад зориулагдсан байдаг... багш бэлтгэх боловсролд ашиглагдах сургалтын хэрэглэгдэхүүн ач холбогдолтой боловч хангалттай гэж үзэхэд дутагдалтай байна.”<sup>2</sup>

Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо нь өнөөгийн байдлаар тэгш хамруулах сургалт, дадлагыг хөгжүүлэхэд илүү боломжтой байна. Үнэн хэрэгтээ тэгш хамруулан сургах боловсрол нь багш нар яг одоо ажлын талбар дээрээ сургалт явуулж байгаа учраас хэрэгтэй гэдэг утгаар бус харин эдүгээ багшилж буй олон багш тэгш хамруулан сургах боловсролын талаар маш бага эсвэл огт туршлагагүй байдаг тул багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй.

Нөгөөтэйгүүр багш бэлтгэх боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг илүү цогцоор нь хэрэгжүүлэх нь олон чухал үр ашгийг авчирна. Тухайлбал:

- Тэгш хамруулан сургах боловсролыг багш бэлтгэх болон багш мэргэжил дээшлүүлэх боловсрол хоорондын харилцан бие биеэ нөхсөн одоогийн байгаа харилцааг илүү тэгшитгэх, цаашид батжуулах үндэс болгон ашиглах боломжтой.
- Багш нарыг ажлын гараагаа эхлүүлэхээс өмнө нь тэгш хамруулан сургах боловсролын талаар сургах нь тэднийг хожим нь сургаж, нэгэнт тогтсон хандлага/үйл ажиллагааг нь өөрчлөхөөр хүчин чармайлт гаргах хөрөнгө оруулалт хийснээс илүү зардал бага, үр ашиг өндөр байна.
- Багш бэлтгэх боловсролд тэгш хамруулан сургах боловсролыг нэвтрүүлснээр олон багш нар бэлтгэгдэж олон сургуульд тэгш хамруулах сургалтыг хүртэнэ (багш бэлтгэх боловсрол нь багшийн мэргэжил дээшлүүлэх боловсролтой харьцуулахад илүү олон тооны оюутан-багш нарт хүрнэ).
- Хэрэв багш нар тэгш хамруулан сургах боловсролыг өөрсдөө багш боловсролоор суралцах эхний өдрөөсөө сурч эхэлбэл, тэд үүнийг нэмэлт

<sup>2</sup> Booth, T болон Dyssegard, B. 2008. *Ганц Чанар Хангалттай Бус – БНБ-ын хөгжилд тэгш хамруулан сургах боловсролын үнэт зүйлсийн оруулах хувь нэмэр*. Копенгаген, Данийн Гадаад Хэргийн Яам, ДАНИДА 9 х

ачаа дарамт гэж бус, харин сайн багшид байх учиртай үндсэн үүрэг нь хэмээн ойлгоно.

- Ирээдүйн сургуулийн удирдагчдад тэгш хамруулан сургах боловсрол олгосноор урт хугацаанд үр ашиг авчрах бөгөөд тэгш хамруулан сургах боловсролыг сургууль, нийгмээрээ өндрөөр үнэлэн, хэрэгжүүлж, боловсронгуй болгох үндэс тавигдана.

## Зөвлөмж гэж юу вэ?

“Зөвлөмж нь өөр өөр газраас, ялгаатай үзэл бодол, сонирхол бүхий хүмүүс нэгдэн дэлхий нийтэд буй хуваагдал, тэгш бус байдлыг ил гарган тавьдаг.”<sup>3</sup>

**Зөвлөмж** нь “Хүүхдүүдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрахын тулд засгийн газар, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөхөөр загварчлагдсан зохион байгуулалт бүхий цогц үйл ажиллагаа юм”.<sup>4</sup>

### Зөвлөмжийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

- Шийдвэр гаргагчдад нөлөөлөх зорилго бүхий үйл явц
- Бодит байдлын учир шалтгааныг илрүүлэх, шийдвэрлэх
- Тухайн асуудалд шийдвэр гаргагчдын анхаарлыг татахын сацуу олон нийтийн анхаарлыг мөн хандуулах, ингэснээр бодлого, хандлагын өөрчлөлт харилцан бие биеэ бататгана.
- Хөгжил, шинэчлэл, бодлогын өөрчлөлт, түүнийг хэрэгжүүлэх үйл явцыг дэмжих стратегийн арга хэрэгсэл болно.
- Асуудал шийдвэрлэх, өөрчлөлт хийх хөтөлбөрийн бодлогыг дэмжин сайжруулах арга зам болно.<sup>5</sup>

## Зөвлөмжийн гол зарчмууд

### Зөвлөмж нь өөрчлөлт рүү чиглэдэг:

Зөвлөмж нь тодорхой нөхцөлд эсвэл оролцогч талуудад бодит өөрчлөлт авчрахыг зорьдог. Ер нь аливаа бэрхшээлийн талаар гомдоллож суухын оронд тухайн нөхцөл байдал хэрхэн, яагаад шударга бус, хүртээмжгүй байгаад анхаарал хандуулан, түүнийг өөрчлөхөд түлхэц өгөхийг хэлж байгаа юм.

### Зөвлөмж нь өөрчлөлт хийхийг хүсэж буй хүмүүс хоорондоо түүнийг

<sup>3</sup> Fortun, K. 2001. *Бопалын Зөвлөмж: Байгаль орчин хамгаалал, Гамшиг, Дэлхийн хэмжээний асуудал*. Чикаго, Чикагогийн Их Сургуулийн хэвлэл. 16 х

<sup>4</sup> Хүүхдийг Ивээх сангийн тодорхойлолт. [www.savechildren.net/advocacy](http://www.savechildren.net/advocacy). (2013.03.10)

<sup>5</sup> ТЭЭОУХ. 2007. Хүүхдийн гэрлэлтийг зогсоох арга хэмжээ: Хөтөлбөр боловсруулагч, Идэвхтэн нарын Гарын Авлага. Лондон, Төлөвлөгөөтэй Эцэг Эх Олон Улсын Холбоо, 19 х

### **хэлэлцэх асуудал:**

Зөвлөмж нь зөвхөн санаа зовнилоо илэрхийлэх дуу хоолой бус, харин өөрчлөлтийг эрэлхийлэхэд чиглэгдэж байгаа тул бидний хүсэж буй өөрчлөлтийг авчрах нөлөө бүхий хүмүүстэй үр ашигтай харилцаатай байхыг шаардана. Иймд зөвлөмж нь ажил хэрэгч харилцаа, хэлэлцээрийн үндсэнд бий болдог ба зөвхөн шаардлага тавих бус харилцан ярилцах нь чухал юм. Үр дүнтэй зөвлөмж нь асуудлыг хэлэлцэхдээ эерэг харилцааг чухалчилдаг. Оролцогч талууд ирээдүйд үр өгөөжтэй байх үйл ажиллагааг онцолж, боломжтой урагшлах арга замыг төлөвлөн “зураглах” хэрэгтэй.

### **Зөвлөмж нь нотолгоон дээр суурилдаг:**

Бид аливаа нөхцөл байдлыг тодорхой дүрсэлж чадах баримт нотолгоогүйгээр, мөн тухайн нөхцөл байдал хэрхэн, яагаад тэвчишгүй байгаад дүн шинжилгээ хийн бататгаагүй байж аливаа асуудлыг онцолж, өөрчлөлт хийхэд уриалах боломжгүй юм. Тухайлбал, хэрэв багш нар суралцагчдын харилцан адилгүй хэрэгцээг харгалзаж чадахуйц мэдлэг, чадвар эзэмшиж чадахгүй байна гэдгийг онцлохыг хүсвэл тэдэнд тэгш хамруулан сургах боловсролыг олгох илүү сайн хөтөлбөр, сургалт санал болгохын тулд бид одоогийн сургалт ямар байдалтай байгааг харуулах нотолгоо, мөн тус сургалт нь яагаад багш нарт шаардлагатай мэдлэг, чадвар олгож чадахгүй байгааг задлан шинжлэх хэрэгтэй болно. Түүнчлэн бид өөрсдийн санал болгож буй хувилбар, шийдлийнхээ үндэслэл, давуу талыг харуулах нотолгоотой байх шаардлагатай. Тухайлбал, тухайн зөвлөмжид нийцсэн амжилттай хэрэгжүүлж болох үйл ажиллагааны жишээг цуглуулах гэх мэт.

### **Зөвлөмж нь түншлэл дээр тулгуурладаг**

Ихэнх тохиолдолд ганцаараа бие даан ярьж буй хүн томоохон өөрчлөлтөд хүрэхэд хүчин мөхөсддөг. Тийм ч учраас зөвлөмж гэдэг түншлэгчдийг дайчлан оролцуулах хамтын үйл явц юм. Тухайлбал, хувь хүмүүс бүлэг болон нэгдэж өөрчлөлтийг уриалах, эсвэл байгууллагууд холбоо, сүлжээ болон нэгдэж баримт, нотолгоогоо хамтад нь нийлүүлж, шийдвэр гаргагчдад хүргэх дуу хоолойгоо илүү хүчтэй болгож болно. Түүнчлэн хамтын ажиллагаа нь зөвлөхүүдийн (хамтын) дуу хоолойг тусгахын зэрэгцээ уялдаа холбоо бүхий бодит зөвлөмжийг хүргэдэг ач холбогдолтой. Зөвлөмж дээр түншлэх нь шийдвэр гаргагчдыг будлиулах олон/эргэлзээтэй зөвлөмж бүхий тааруухан уриалга хүргэх, зөвлөхүүдэд үл итгэх шалтаг өгөхөөс сэргийлдэг. Хамтын ажиллагаа нь зөвлөмжийн зорилт, үйл ажиллагаа, уриалгыг боловсруулахад янз бүрийн оролцогч талуудын үзэл бодлыг тусгах боломжоор хангадаг.



## Үр өгөөжтэй зөвлөмжийн шинж чанар

Зөвлөмж нь дараах шаардлагуудад нийцвэл амжилттай болсонд тооцогдоно:

- Өөр хаа нэгтэйгээс “импортлосон” загвар хэрэглэхээс илүүтэйгээр өөрийн нөхцөл байдал (тэгш хамруулах сургалтыг дэмжихүйц ойлголт, хэрэгжиж буй үйл ажиллагаа хамаарна)-д бодитоор оршиж байгаа санаа, үйл ажиллагааг сайтар ойлгосон туршлага дээр тулгуурлана.
- Тухайн нөхцөлд тулгамдаж байгаа саад бэрхшээлийг сайтар ойлгосон ойлголт дээр тулгуурлана.
- Тулгарч болох эсэргүүцэл, ийм эсэргүүцэл хаанаас ирж болох талаар сайн ойлголттой байх.
- Сайтар бодож, төлөвлөсөн урт болон богино хугацааны зорилго, төлөвлөгөө боловсруулах.
- Ерөнхий ойлголт, таамаглал дээр бус баримт, нотолгоон дээр суурилсан байх.
- Асуудлыг дүрслэн тайлбарлах, эсвэл хүсэн хүлээж буй өөрчлөлтийг харуулсан тохиолдлын судалгааг ашиглах
- Онолын маргааны үед санал бодлоо хамгаалах практик туршлагын жишээтэй байх, мөн оролцогч талуудад зориулсан практик хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах
- Зөрчилдөх бус эерэг, мэдрэмжтэй, ажил хэрэгч харилцан ярианд төвлөрөх
- Зөвлөмж гаргаж буй бүлэг, эсвэл байгууллага нь найдвартай мэдээлэл дамжуулах, чанартай хөтөлбөр хэрэгжүүлэх нэр хүндтэй байх.<sup>6</sup>

## Шууд, дам, чадавхижуулах зөвлөмж

Зөвлөмж нь өөр өөр хэлбэртэй байж болно. Тухайлбал:

- Шууд зөвлөмж: Тэгш хамруулан сургах боловсролд багш нарыг сургах зөвлөмж гаргах тохиолдолд зөвлөхүүд багш нарыг хариуцсан боловсролын сайд, дарга нар, эсвэл багш бэлтгэх сургуулийн захирал, сургалтын хөтөлбөр боловсруулагчидтай шууд ярилцахыг хэлнэ.
- Дам зөвлөмж: Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан шийдвэр гаргагчдад нөлөөлөх үйл ажиллагаа хамаарна. Тухайлбал багш нарыг тэгш хамруулан сургах боловсрол олгох зөвлөмж гаргах тохиолдолд багш бэлтгэдэг бүх их дээд сургуульд мэдээллийн ухуулга явуулах, сонин хэвлэлд өнөөгийн багш боловсролын бодит байдал, хэрхэн/яагаад шинэчлэл хийх шаардлагатай талаар хэвлэн нийтэлж болох юм.
- Чадавхижуулах зөвлөмж: Иргэний нийгмийг дэмжих зорилготой бөгөөд

<sup>6</sup> ТЭЭОУХ. 2007. Хүүхдийн гэрлэлтийг зогсоох арга хэмжээ: Хөтөлбөр боловсруулагч, Дэмжигчдийн Гарын Авлага. Лондон, Төлөвлөгөөтэй Эцэг Эх Олон Улсын Холбоо, 20 х

гадны хүмүүст найдахаас илүүтэй хүмүүс өөрсдөө өөрчлөлтийг хийхийг мэдэх, уриалах чадвартай гэсэн итгэлийг бий болгодог. Багш нарт тэгш хамруулан сургах боловсрол олгох зөвлөмж өгөх тохиолдолд багш, оюутан, нийгэмлэг, орон нутгийн байгууллага, эмэгтэйчүүдийн байгууллага, эцэг эхийн зөвлөл, сургуулийн удирдах хороо, ТББ-уудын багш бэлтгэх боловсрол (их дээд сургуулиар дамжуулан багш бэлтгэх шатанд, орон нутгийн сургуулиар дамжуулан багшийн мэргэжил дээшлүүлэх шатанд)-д оролцох чадавхийг бий болгох. Энэ төрлийн оролцоо нь боловсролын мэргэжилтнүүдийг сургалтын үйл явцад өөрчлөлт хийх хэрэгцээ байгааг онцгойлон анхаарахыг уриалахаас эхлэн, сургалтуудад идэвхтэй оролцох, оюутан багш нарт санал болгож буй онол хэрхэн бодит байдал дээр хэрэгжих талаар тохиолдлын судалгаа хийх, практик зөвлөгөө өгөх, тайлбарлах явдал юм.

Тодорхой тооны, мөн төлөөлөлтэй хүмүүсийг тэнцвэртэй оролцуулснаар сайтар боловсруулсан зөвлөмж гарна:

- Өөрчлөлт хийх шаардлагатай асуудлуудтай нэн тэргүүнд тулж буй хүмүүс (чанаргүй, ялгавартай боловсрол хүртэж буй суралцагчид, орон нутгийн сургуулийн сургалтад сэтгэл дундуур байгаа эцэг эх, сургуулийн орчинд харилцан адилгүй сурах хэрэгцээ бүхий суралцагчидтай ажиллах үед гарч болох бэрхшээлтэй нүүр тулахад хангалттай бэлтгэгдээгүй гэж өөрийгөө үзэж байгаа багш).
- Тулгамдаж буй бэрхшээлийг даван туулах туршлага хуримтлуулсан, мэргэжлийн хүмүүс (багш нарт чиглэгдсэн тэгш хамруулан сургах боловсролыг дэмждэг багш бэлтгэх сургуулийн багш, боловсролын мэргэжилтнүүд, тэгш хамруулах сургалтыг хэдийнээ хэрэгжүүлээд эхэлсэн багш гм.)
- Зөвлөгөө өгөх, олон нийттэй харилцах тал дээр туршлагатай хүмүүс (улс/орон нутгийн хэмжээнд боловсрол, эрх тэгш байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ).

## Ямар нөхцөлд хэн зөвлөгөө өгөх вэ?

Зөвлөмжийн талаар ярихдаа эхлээд уншигч танаас эхэлье. Зөвлөмжид та ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ? Та үүнийг өөрийнхөө төлөө болон, өөрийн ажил үйл ажиллагааны төлөө эргэцүүлэн үзэхэд илүүдэхгүй. Ийнхүү эргэцүүлэхэд тань дөхөм болгох үүднээс дараах асуултыг толилуулж байна. Үүнд:

- Тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэхэд та хэрхэн оролцох вэ? Та хаана, хэрхэн, хэнтэй ярилцаж ямар санал, зөвлөгөө өгч болох вэ?
- Таны хувьд, тэгш хамруулан сургах боловсролын ямар асуудал хамгийн чухал вэ? Яагаад энэ таны хувьд чухал гэж? Яагаад зөвлөмж гаргах

шаардлагатай асуудал вэ?

- Та хэнээс тусламж, дэмжлэг авах боломжтой вэ, өөрөөр хэлбэл та тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхэд ямар хувь хүн, бүлэг, сүлжээг ашиглаж болох вэ?
- Та өөрийн зөвлөмжийн зорилтуудаа дэмжихэд ямар хэрэгсэл, нөөц, боломж ашиглах боломжтой байна вэ?
- Бид өмнө нь зөвлөмж нь тодорхой асуудал дээр мэдээлэл, хөтөлбөрийн оролцоотой байж чадах хүчирхэг, нэр хүндтэй бүлэг, байгууллага хийвэл илүү амжилттай болохыг дурдсан. Гэхдээ энэ нь зөвлөмжийг зөвхөн тухайн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд л өгдөг гэж ойлгох нь ташаа юм. Багш боловсролын талаарх зөвлөмжийг сургуулийн сурагчдаас авахуулаад багш, эцэг эх, ТББ, орон нутгийн бүлэг, олон улсын компани бүлэг, донор (багш боловсролын салбар нь гаднаас санхүүжилт авдаг улс орнуудад) хүртэл түүнчлэн боловсролын ахмад ажилтан гээд олны оролцоотой хийж болно.

Тодорхой тооны, мөн төлөөлөлтэй хүмүүсийг тэнцвэртэй оролцуулснаар сайтар боловсруулсан зөвлөмж гарна:

- Өөрчлөлт хийх шаардлагатай асуудлуудтай нэн тэргүүнд тулж буй хүмүүс (чанаргүй, ялгавартай боловсрол хүртэж буй суралцагчид, орон нутгийн сургуулийн сургалтад сэтгэл дундуур байгаа эцэг эх, сургуулийн орчинд харилцан адилгүй сурах хэрэгцээ бүхий суралцагчидтай ажиллах үед гарч болох бэрхшээлтэй нүүр тулахад хангалттай бэлтгэгдээгүй гэж өөрийгөө үзэж байгаа багш).
- Тулгамдаж буй бэрхшээлийг даван туулах туршлага хуримтлуулсан, мэргэжлийн хүмүүс (багш нарт чиглэгдсэн тэгш хамруулан сургах боловсролыг дэмждэг багш бэлтгэх сургуулийн багш, боловсролын мэргэжилтнүүд, тэгш хамруулах сургалтыг хэдийнээ хэрэгжүүлээд эхэлсэн багш г.м.)

Зөвлөгөө өгөх, олон нийттэй харилцах тал дээр туршлагатай хүмүүс (улс/орон нутгийн хэмжээнд боловсрол, эрх тэгш байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ).


## Зөвлөмж хэнд зориулагдах вэ?

Өөрчлөх оролдлого хийж буй асуудлын цар хүрээ, тавьсан зорилт, нийгэм улс төрийн нөхцөл байдал зэргээс хамааран зөвлөмж олон янзын хүнд чиглэгдэж болно. Энэ асуудалд бодитоор хандах нь чухал, өөрөөр хэлбэл, та хэнд нөлөө үзүүлэх талаараа бодоод зогсохгүй, өөрийн одоогийн албан тушаал, чадавхи, чадвар, туршлага, нотолгооны үндэслэл зэргээ тооцон үзэж хэнд нөлөөлөх бололцоотой гэдгээ нухацтай бодож үзэх нь зүйтэй.

Ерөнхийдөө багш нарыг тэгш хамруулан сургах боловсролоор бэлтгэх үүднээс багш бэлтгэх боловсролд өөрчлөлт хийх утгаараа дараах хүмүүст зориулагдана.

Үүнд:

- Багш боловсрол, түүний сургалтын хөтөлбөртэй холбоотой үндэсний хэмжээний бодлого болон санхүүгийн шийдвэр гаргадаг боловсролын яамны албан тушаалтнууд, удирдлага,
- Орон нутгийн хэмжээнд багш боловсролтой холбоотой шийдвэр гаргагч бүс/дүүрэг/орон нутгийн түвшний боловсролын мэргэжилтэн,
- Багш боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулдаг их сургуулийн багш, ажилтан, захирал, эрхлэгч, сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүд,
- Багш бэлтгэх их дээд сургуулийн удирдлага,
- Багш бэлтгэх их дээд сургуулийн багш нар,
- Багш боловсрол олгодог эсвэл санхүү, сургалтын хэрэглэгдэхүүн, техникийн зөвлөгөөгөөр хангадаг төрийн, төрийн бус байгууллага,
- Багш бэлтгэх боловсрол (мөн мэргэжил дээшлүүлэх тасралтгүй сургалт)-ын нэг хэсэг болгон практик, сургуульд суурилсан сургалтыг хөгжүүлэхэд түлхэц үзүүлэх (а) чухал үүрэг гүйцэтгэх боломжтой, (б) сургуульдаа ажиллахаар ирэхдээ илүү сайн бэлтгэгдсэн шинэ багш нарыг бэлтгэх үүднээс багш боловсролыг сайжруулах шаардлага тавьж чадах багш, ахлах багш нар,
- (а) Багш бэлтгэх боловсролын үйл ажиллагаанд түлхэц үзүүлж чадах, (б) шинэ багш нар сургуульд ажиллахаар ирэхдээ илүү сайн бэлтгэгдсэн байх үүднээс багш бэлтгэх боловсролыг сайжруулах шаардлага тавьж чадах сургуулийн удирдах хороо, зөвлөлийн гишүүд,
- Ирээдүйн ажилд нь сайтар бэлтгэж чадах боловсролын чанар, хэлбэрийн талаар илүү ихийг мэдэх хүсэлтэй (ингэснээр тэд багш боловсролын шинэчлэл хийх уриалгыг дэмжих юм) мөн өөр хэлбэрээр боловсрол эзэмшсэн 'эхний давалгаа' байхаас үл айх оюутан-багш.



Зөвлөмжлөх үе шатууд<sup>7</sup>

## Бид зөвлөмжид хэрхэн хандах вэ?

Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бусад төсөл/хөтөлбөрийн нэгэн адил төлөвлөж, бэлтгэл хангах шаардлагатай. Учир нь та эхний оролдлогоор зөвлөмжийн бүх зорилтдоо хүрэх боломжгүй тул зөвлөмжөө эргэх холбоо бүхий үе шатуудаар<sup>7</sup> авч үзэх хэрэгтэй. Нөхцөл байдалд үнэлгээ өгч, асуудлыг ойлгож, баримт нотолгоо цуглуулж, оролцогч талуудтай зөвлөлдөхөөс эхэлнэ. Дараа нь зөвлөмжийн зорилт, зорилтот бүлэг, хүргэх мэдээ, арга хэрэгсэл, цаг хугацаагаа тодорхойлох гэх мэт дүн шинжилгээ хийх үе явагдана. Дараа нь зөвлөмж өгөх үйл ажиллагаа хийгдэнэ. Үүний дараа юу болсон талаар эргэцүүлэл хийж, дараа дараачийн зөвлөмжөө төлөвлөх, хэрэгжүүлэхийн өмнө тус нөхцөл байдалд гарсан аливаа өөрчлөлтөд үнэлгээ хийх нь чухал юм.

## Нөхцөл байдлын шинжилгээ

Энэхүү удирдамж нь нөхцөл байдлын дүн шинжилгээний талаар дэлгэрэнгүй тайлбарлахгүй ч багш боловсролын өнөөгийн байдлыг үнэлэх, тэгш хамруулан сургах боловсролд багш нарыг бэлтгэхэд чухал ач холбогдолтой ямар мэдээ, нотолгоо байж болох талаар санал болгож байна. Үүнд:

- Чанарын ба тоон мэдээ (ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, жүжигчилсэн тоглолт, урлаг, гэрэл зураг, зураглал гэх мэтийг ашигладаг оролцогчдын судалгааны зэмсэг ашиглах, оролцогч талуудаас асуулга авах, байгууллагын судалгаа хийх зэрэг тоон арга зэмсэг ашиглах)
- Бэрхшээлтэй тулгарч буй хүмүүсийн болон сонирхлын бүлгүүдийн санал, үзэл бодол
- Тохиолдлын судалгаа (тулгамдаж буй асуудал, авсан арга хэмжээний жишээ, хүлээж буй үр дүн)
- Холбогдох бодлого, тогтоомж, журам
- Адил төстэй асуудлаар өмнө нь, эсвэл одоогоор хийгдэж буй үйл ажиллагаа

Зөвлөмжөө бэлтгэх үедээ асууж болох асуултууд нь тухайн нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байх ч, ерөнхийдөө дараах байдлаар томъёологдож болно:

- Тэгш хамруулан сургах боловсролын чадавхийг багш мэргэжлийн үндэсний стандартын нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрсөн эсэх? Багшийг тэгш хамруулан сургах чадавхиа хөгжүүлэхийг бодлогоор шаарддаг эсэх?
- Одоогоор хэдэн оюутан-багш багш бэлтгэх боловсролоор тэгш хамруулан сургах боловсролын онол, практикийг эзэмшиж байгаа вэ? Хэдэн багш мэргэжил дээшлүүлэх сургалтаар тэгш хамруулан сургах боловсролын талаарх сургалтыг хүртэж байгаа вэ?
- Багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш нар, оюутан-багш нарын харилцан

<sup>7</sup> Зөвлөмжийн тойрог нь үйлийн судалгааны тойрог болон бусад эргэх тойрогтой төстэй – зөвлөмжийг тасралтгүй үргэлжилсэн, эргэх үйл явц хэмээн онцолж байгаа юм.

адилгүй байдал хэр хэмжээнд байгаа вэ (хүйс, үндэс язгуур, хөгжлийн бэрхшээл зэргийг тооцоход)?

- Багш боловсролд тэгш хамруулах боловсрол хэр тусгалаа олсон байна вэ? Богино хугацааны сургалт уу, их сургуулийн цогц модуль уу? Заавал судлах уу, сонгон судлах уу?
- Багш боловсрол өөрөө тэгш хамруулан сургах боловсрол мөн үү? Оюутан-багш, болон багш нар ялгавартай байдалд анхаарал хандуулдаг уу?
- Сургалтын хэдэн хувь нь лекцийн танхимд, хэдэн хувь нь сургууль/танхимд дадлагад суурилан явагддаг вэ?
- Багш нар нь тэгш хамруулан сургах боловсролыг юу гэж үздэг вэ? Тэд өөрсдийн чадварт сэтгэл хангалуун байдаг уу, сэтгэл зовнидог уу, эргэлздэг үү, илт эсэргүүцэн дургүйцдэг үү?
- Тэгш хамруулан сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлж буй үлгэр жишээ авч болохуйц багш боловсролын сургалтын жишээ бий юу?
- Багш нарт зориулсан тэгш хамруулан сургах боловсролын талаарх сургалтыг зөвлөмж болгохыг дэмжих, цаашилбал зөвлөмж хэрэгжүүлэх ажилд үлгэр жишээ болох багш, сургууль, байгууллага байна уу?
- Суралцагчид болон эцэг эх багш, сургалтын талаар ямар бодолтой байдаг вэ? Харилцан адилгүй суралцагчидтай харилцахад багш нарыг бэлтгэхийн тулд ямар өөрчлөлт хийх хэрэгтэй хэмээн тэд үзэж байгаа вэ?
- Багш бэлтгэх их дээд сургуулийн багш нар оюутнуудтайгаа тэгш хамруулан ажиллахад хэрхэн бэлтгэгдэж, дэмжлэг авч байгаа вэ?

## Дүн шинжилгээ

Энэ үе шатанд зөвлөмжийн зорилтуудыг тодорхойлдог. Тэдгээр нь богино болон урт хугацааны зорилтууд, эсвэл том зорилтдоо хүрэхэд тань тус болох богино хугацааны цуврал зорилтууд байж болно. Зорилтоо ач холбогдлоор нь жагсаахдаа бусад оролцогч талууд хүрэхийг хүсэж буй өөрчлөлтийн аль нь нэн яаралтай, чухал болох талаар харилцан адилгүй үзэл бодолтой байж болох тул бодолцох нь зүйтэй. Энэ хэсэгт та мөн зөвлөмжийн үйл ажиллагаагаа төлөвлөнө - мөн л бусдын оролцоотой үйл явц юм. Зөвлөмжийн төлөвлөлтөд олон янзын хүмүүсийг оролцуулснаар та үйл явцыг илүү хариуцах эзэнтэй болгож, зөвлөмж гаргах үйл ажиллагаандаа илүү олон хүний чадвар, туршлага, цаг хугацааг ашиглах боломжтой болно.

### Үйл ажиллагаа

Зөвлөх үйл ажиллагаа нь тухайн нөхцөл байдал, зорилго, зөвлөхүүдийн урчадвар/туршлага зэргээс хамаардаг тул бид багш боловсрол болон тэгш хамруулан сургах боловсролтой холбоотойгоор яг ямар зөвлөх үйл ажиллагаа явуулах талаар тодорхой тайлбарлах боломжгүй юм. Гэвч дараагийн дөрвөн цуврал удирдамжид бид багш боловсролын зарим асуудлуудтай холбоотой боломжтой гэж үзсэн зөвлөмжүүдийг оруулсан. Түүнчлэн амжилттай хэрэгжүүлсэн үйл

ажиллагааны үр дүнд гарах өөрчлөлт ямар байх талаар санаагаа тусгасан билээ.

## Зөвлөмжийг бид хэрхэн хүргэх вэ?

Зөвлөмжөө хүргэх арга хэлбэрт хязгаар байхгүй! Хэдий тийм ч, таны сонгон ашиглах арга хэрэгсэл зөвлөмж болон зорилтот бүлэгт тохирохуйц байх ёстойг анхаарагч хэрэгтэй. Тухайлбал:

- Хүмүүсийн хоорондын харилцаа : хурал, семинар, бага хурал, утасны яриа, дугуй ширээний ярилцлага, тохиромжтой олон нийтийн ажил (захидал бичих, явган аялал, жагсах) гм.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл: сонин, радио, зурагт, орон нутгийн чанартай үзүүлбэр, тараах материал, зурагт хуудас, сонин, сэтгүүлийн нийтлэл, ном, номын бүлэг, цахим хуудас, олон нийтийн сүлжээ гм.

Та мөн зөвлөмжөө хэрхэн “эхлүүлэх” буюу танилцуулах талаар бодох нь зүйтэй. Хэрэв таны бүхий л хүчин чармайлт зөвхөн зөвлөмж болон материалаа загварчлах дээр төвлөрч, зорилтот бүлэгтээ зөвлөмжөө хэрхэн хүргэх тал дээр хангалттай анхаараагүй нөхцөлд зөвлөмж үр дүнгээ өгөхгүй, бүтэлгүйтэх тохиолдол гарна. Асуудалд олон хүний дэмжлэгийг авахын тулд зөвлөмжөө хүргэх анхаарал татахуйц арга хэмжээ зохион байгуулах эсвэл олны анхаарлыг хандуулах их хэмжээний материал тараах нь зөв санаа байж болно. Эсвэл илүү болгоомжтой арга замыг сонгон, хүрэхийг хүсэж буй зорилтот бүлгээ олны анхаарлын төвд оруулалгүй, чимээгүй боловч шийдэмгий байдлаар шууд холбоо тогтоох арга ч тохиромжтой байж болно.

Зөвлөмжөө хүргэхдээ та тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой олон улсаар хуульчлагдсан баримт бичгийг ашиглаж болно. Олон улсад хуульчлагдсан баримт бичгийн жагсаалтыг дор үзүүлэв.

Нэр	Тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой гол онцлог
Боловсрол дах ялгаварлан гадуурхлын эсрэг конвенци (1960) <a href="http://portal.unesco.org/en/ev.php-URL_ID=12949&amp;URL_DO=DO_TOPIC&amp;URL_SECTION=201.html">http://portal.unesco.org/en/ev.php-URL_ID=12949&amp;URL_DO=DO_TOPIC&amp;URL_SECTION=201.html</a>	Конвенци нь боловсрол эзэмших боломжийг эрх тэгш олгох суурь зарчмыг дүрэмчилсэн. Конвенциор боловсрол дахь бүх талын ялгаварлалыг хориглож, бүх нийтэд хүртээмжтэй чанартай боловсрол олгох болзол тавьдаг.
Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Олон Улсын Гэрээ (1966) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CESCR.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CESCR.aspx</a>	Гэрээний 13-р Зүйлд хүн бүрийг сурч, боловсрох эрхтэйг зааж, боловсрол нь “бүх хүнийг чөлөөт нийгэмд үр ашигтай оролцох оролцоог хангах”-ыг заасан.

<p>Иргэний болон Улс төрийн Эрхийн Олон Улсын Гэрээ (1966) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx</a></p>	<p>Тус Гэрээний 18-р Зүйлд “өөрсдийн итгэл үнэмшлийн дагуу” хүүхдүүддээ “шашны болон ёс суртахууны боловсрол олгох” “эцэг эхийн эрх чөлөө”-г хүндэтгэн үзэх тухай заасан.</p>
<p>Арьс Өнгөөр Ялгаварлах Бүх хэлбэрийг халах олон улсын конвенци (1965) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CERD.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CERD.aspx</a></p>	<p>Конвенцийн 7-р зүйлд “сургалт, боловсрол, соёл, мэдээллийн талбарт” “арьс өнгөөр ялгаварлахад хүргэх үзэл”-тэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар заасан.</p>
<p>Эмэгтэйчүүдийг Ялгаварлах Бүх Хэлбэрийг Халах тухай Конвенци (1979) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CEDAW.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CEDAW.aspx</a></p>	<p>10-р зүйлд эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй бөгөөд боловсрол эзэмшихэд ялгаварлах байдлыг халах арга хэмжээ авахыг тусгасан.</p>
<p>Тусгаар Улсуудын Уугуул болон Овгийн Хүмүүстэй холбоотой Конвенци (1989) <a href="http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:12100:0::NO::P12100_ILO_CODE:C169">http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:12100:0::NO::P12100_ILO_CODE:C169</a></p>	<p>27-р зүйлд уугуул иргэдийг боловсролын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад оролцуулах талаар, 28-р зүйлд тэдгээрийн хүүхдүүдийг “өөрсдийн уугуул хэл дээр уншиж, бичиж сургах” талаар тус тус заасан.</p>
<p>Хүүхдийн Эрхийн Конвенци (1989) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CRC.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CRC.aspx</a></p>	<p>28-р зүйлд хүүхэд бүр сурч боловсрох эрхтэй бөгөөд бүх үйл ажиллагаанд “хүүхдийн ашиг сонирхол хамгийн чухлаар тавигдана” хэмээн заасан.</p>
<p>Бүх Цагаач Ажилчид болон Гэр бүлийн гишүүдийн Эрхийг хамгаалах Олон Улсын Конвенци (1990) <a href="http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CMW.aspx">http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CMW.aspx</a></p>	<p>30-р зүйлд цагаач ажилчны хүүхэд бүр “тухайн улсын иргэдтэй тэгш байдлаар” сурч боловсрох эрхтэй, 45-р зүйлд тухайн хүүхдэд “эх хэл” дээр нь боловсрол олгохыг уриалсан.</p>
<p>Хүүхдийн Тэвчишгүй Хөдөлмөрийг Халах Яаралтай Арга Хэмжээ авах, Хориглох Конвенци (1999) <a href="http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO:12100:P12100_ILO_CODE:C182">http://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO:12100:P12100_ILO_CODE:C182</a></p>	<p>7-р зүйлд хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг халж, үнэ төлбөргүй суурь боловсрол, мэргэжлийн сургалтад хамруулахыг уриалсан.</p>
<p>Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Эрхийн Конвенци (2006) <a href="http://www.ohchr.org/EN/HRBodies/CRPD/Pages/ConventionRightsPersonsWithDisabilities.aspx">http://www.ohchr.org/EN/HRBodies/CRPD/Pages/ConventionRightsPersonsWithDisabilities.aspx</a></p>	<p>24-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүн сурч, боловсрох эрхтэйг бататган, тэгш хамруулан сургах боловсрол хүртээхийг уриалсан.</p>



## Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?

Бусад төсөл, хөтөлбөрт ажлын нэгэн адил таны зөвлөмж хүргэх ажил үр дүнд хүрч байгаа эсэхийг мэдэх нь зүйтэй. Зөвлөмжөө төлөвлөж, зорилтуудаа тодорхойлохдоо зөвлөх үйл явц, үр дүнг хэмжих үзүүлэлт (индикатор) гаргаж, хэрхэн хэмжихээ мөн тодорхойлох хэрэгтэй. Үзүүлэлт боловсруулах, үнэлэх үйл явцыг оролцогч талуудын оролцоотой хийх нь чухал.

Зөвлөмжийн үйл явцын эдгээр үзүүлэлт нь жишээлбэл хэдэн ухуулах сурталчилгааны материал түгээсэн, радиогийн хэлэлцүүлэг нэвтрүүлгийг хэдэн хүн сонссон, төлөвлөсөн уулзалт, хэлэлцүүлэг болсон эсэх, хэн хэн ирсэн/ оролцсон гэх зэргийн мэдээлэл цуглуулахад чиглэгдэх ёстой.

Үйл ажиллагааны үр нөлөөг тогтоох үзүүлэлтүүдээр зорилтот бүлгийн хандлага, үйл ажиллагааны өөрчлөлтийг хэмжих оролдлого хийж болох юм (асуулгаар тоон үзүүлэлт гаргах, эсвэл фокус бүлгийн ярилцлагаар чанарын үзүүлэлт гаргах). Түүнчлэн гарч буй үр нөлөөг одоо буй механизмаар дамжуулан зорилтот бүлгийн зан байдлыг хянах замаар хэмжих боломжтой (жишээлбэл, засгийн газрын түвшний хэлэлцүүлгийн үеэр яамны боловсон хүчин тэгш хамруулан сургах боловсролын асуудлыг хөндөн ярьсан эсэх, хэдий хугацаанд, юу ярьсан талаарх протоколтой танилцах гм).

Гэвч ганцхан зөвлөмжийг онцлон өөрчлөлт гарах үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлоход хүндрэлтэйг санах нь чухал. Аливаа өөрчлөлт нь нэг удаагийн зөвлөмж санаачилснаар болдоггүй, харин урт хугацаанд олон зөвлөхүүд олон удаагийн зөвлөмж хүргэж байж болдог үйл явц. Иймээс таны гаргасан хичээл зүтгэлийн үр дүнг тодорхой харуулах үзүүлэлт гаргах нь өөрөө их төвөгтэй ажил юм.



## **Зөвлөмж 2-Бодлого**

2

Бодлого

## Удиртгал

‘Бодлого’ нэртэй энэхүү зөвлөмж нь ‘Тэгш хамруулан сургах багшийн боловсрол’-д зориулан гаргасан цуврал таван зөвлөмжийн хоёр дахь нь юм. Энэхүү зөвлөмжийг дангаар нь хэрэглэж болох бөгөөд мөн бусад дөрвөн цуврал болох ‘Удирдамж’, ‘Хөтөлбөр’, ‘Хэрэглэгдэхүүн’, ‘Арга зүй’ гэсэн зөвлөмжтэй хамтаар хэрэглэж болно.

Энэхүү зөвлөмжийг багш боловсролын бодлогын хүрээний үзэл бодол, ойлголтод тулгуурлан гаргасан. Багш боловсролын байгууллага, боловсролын яам, бусад боловсролын асуудал хариуцсан үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, тэгш хамруулан сургах бодлогын хэрэгжилтэд шийдэл, гарц, стратегийг тодорхойлоход энэхүү зөвлөмж санал болгож байна.

### Бодлого гэдэг нь ямар утгатай вэ?

‘Бодлого’ гэдэг үг нь өргөн утгаараа хувь хүн, бүлэг, байгууллагын үйл ажиллагааг, (тухайлбал, тэгш хамруулах сургалт гэх мэт) зохион байгуулах, зохицуулах дүрэм, журам, хууль, зарчмууд юм. Ихэнх тохиолдолд олон улсын болон үндэсний бодлого нь тухайн дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд удирдамж болохуйц зарчмуудыг тодорхойлсон байдаг. Бодлогыг амьдралд нэвтрүүлэхийг (өөрөөр хэлбэл бодлогын үр нөлөөллийн бодит амьдралд авчрах үйл явц) энэхүү зөвлөмжид ‘бодлогын хэрэгжилт’ хэмээн нэрлэсэн.

Бодлогыг боловсруулах тухай бодно гэдэг нь ердөө л цаасан дээр хэвлэгдсэн дүрэм журам, хууль, зарчмын тухай бодох биш, харин хүмүүсийн хоорондын харилцаа, хэлэлцүүлэг, маргаан, мэтгэлцээний тухай эдгээр ойлголт, үзэл бодлын утга санаа нь хэрхэн тухайн бодлогыг бий болгодгийг эргэцүүлэхийг хэлнэ. Бодлого нь хөдөлгөөнгүй, хатуу чанга, нэг мөр тогтсон зүйл биш, харин идэвхтэй үйл ажиллагаа гэж ойлгох нь зүйтэй.

Түүнчлэн энэхүү зөвлөмж нь тэгш хамруулах боловсролын асуудлыг онцгойлон авч үзсэн бөгөөд тэгш хамруулах боловсрол нь салангид байдаг зүйл биш, харин эдийн засаг, нийгмийн бодлогын салшгүй нэгэн хэсэг гэдэг өргөн утгаар нь авч үзэх ёстой.<sup>1</sup> Тэгш хамруулах сургалтын хөгжил нь тэгш хамруулах нийгэм, эдийн засгийн хөгжилтэй салшгүй холбоотой. Эдгээр нь хамтдаа байснаар тэгш хамруулах нийгмийн үндэс суурийг бүрдүүлэх юм.

### Бодлого яагаад чухал вэ?

Бодлогыг хэрэгжүүлэх нь дан ганц засгийн газар, яамны хийдэг ажил биш юм. Тэгш хамруулан сургах боловсролд нөлөө үзүүлэхүйц бодлого нь бүсийн,

<sup>1</sup> Лалл, М. 2007. Хөгжиж буй орнуудын бүх нийтийн боловсролд дүн шинжилгээ хийхэд зориулсан бодлогын судалгааны үзэл баримтлалын тойм. Хүрэх замыг бүтээх – Нэг сэдэвт судалгааны зохиол Дугаар.11. Лондон, Боловсролын хүрээлэн.

үндэсний, дүүргийн, засаг захиргааны, орон нутгийн түвшинд мөн сургууль, байгууллага, багш боловсролын түвшинд боловсруулагдана.

Боловсролын болон нийгэм, эдийн засгийн бодлого нь сонирхлын бүлэг, оролцогч талуудын үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлэх учраас тэгш хамруулах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхэд мөн адил маш тодорхой дэмжлэг, зааварчилгаа бүхий бодлого чухал байна.

Энд хэлэлцэгдэх асуудалд үүрэг хариуцлага нь чухлаар тавигдах тэгш хамруулах боловсролыг бүхий л түвшинд хэрэгжүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулж буй мэргэжилтэн, багш нар ухамсарлан ойлгох ёстой. Иймээс бодлого нь дээрх үүрэг, хариуцлагыг ухамсарлан ойлгож, хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэхүйцээр боловсруулагдсан байна.

## Бодлого боловсруулахад бодлого яагаад чухал вэ?

Онолын хувьд тэгш хамруулах сургалтыг хэрэгжүүлэх нь хялбар санагдаж болох ч бодит амьдралд багш боловсролын байгууллага, сургуулиуд тэгш хамруулах сургалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарсаар байна. Энэ нь тухайн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааны чанар, ихээхэн шалтгаалдагтай холбоотой. Тэгш хамруулах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, багш бэлтгэх сургуулийн багш, оюутан-багш, багш сурган хүмүүжүүлэгч, сурагч, эцэг эх/гэр бүл, мэргэжил дээшлүүлэх олон нийтийн байгууллага зэрэг оролцогч бүхий л талын тогтвортой, нарийн нягт хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй.<sup>2</sup> Иймээс тэгш хамруулах боловсролын бодлогыг амьдралд илүү үр дүнтэй хэрэгжүүлэн, суралцагч болон суралцахууд эерэг нөлөөлөл авчрахын тулд бодлого нь тодорхой, ойлгомжтой, бодит амьдралтай холбоотой, мөн оролцогч талуудад нөлөөлөхүйц байх ёстой. Тэгш хамруулан сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлж дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд бүх бодлого боловсруулагчдад боловсролын бодлогоо боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зааварчилгаа, удирдамж хэрэгтэй байдаг. Эдгээр зааварчилгаа, дэмжлэгийг тодорхойлох гол хэрэгсэл нь удирдамж юм. Түүнчлэн энэ нь бүх оролцогчдод дуу хоолойгоо нэгтгэн бодлогод нөлөөлөх боломжийг олгодог бөгөөд ингэснээр бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

## Бодлогод хэрхэн дүн шинжилгээ хийж болох вэ?

Бодлогод дүн шинжилгээ хийнэ гэдэг нь зөвхөн бодлого боловсруулагч, судлаачдын ажил биш, харин бодлогод оролцогч талуудын оролцвол зохих үйл ажиллагаа юм.

<sup>2</sup> ЮНЕСКО. 2009. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын зөвлөмж. Парис, ЮНЕСКО, 14 х

Засгийн газар, яамдын бие бүрэлдэхүүн, багш бэлтгэх боловсон хүчин, оюутан-багш, багш сурган хүмүүжүүлэгч, тэдний мэргэжил дээшлүүлэлтийг хариуцсан эрх бүхий байгууллага болон сургуулийн бусад гишүүд удирдамжийг бусдад мэдээлэхийн тулд хэрэгжиж буй бодлогыг сайтар ойлгох ёстой. Бодлогод дүн шинжилгээ хийх анхны алхам бол өөрийн онцлог нөхцөл байдалд ямар бодлого хэрэгжиж байгаад үнэлэлт өгөх явдал юм. Үүнийг асуулга, судалгаагаар болон бусад аргаар хийж болно.

### **Бодлогод дүн шинжилгээ хийх**

Тухайн байгууллагын янз бүрийн түвшин дэх бодлогыг шинжлэх судалгааны нэгэн хэрэгсэл бол асуулга юм. Түүнчлэн бодлого нь албан байгууллагын түвшинд, эсвэл нийт хүн амын хувьд хэрхэн хэрэгжиж, үргэлжлэх хугацаанд ямар өөрчлөлт авчирч байгааг илрүүлэхэд асуулгыг ашиглах нь үр дүнтэй байдаг. Судалгааны тойм дээр үндэслэн тодорхой асуудлын хүрээнд боловсруулсан бодлогыг жишээлэн авч үзүүлэлтүүд боловсруулан үнэлгээ хийж болно.

Асуулгад дараах зүйлийг тусгаж болно. Үүнд:

- 1.** Танай байгууллага тодорхой асуудлын хүрээнд боловсруулсан албан ёсны бодлого боловсруулсан эсэх
- 2.** Бодлогын бүрэлдэхүүн хэсгүүд
- 3.** Бодлогыг хэрхэн хэрэгжүүлж, сайжруулж буй байдал  
Бодлогын үр өгөөж
- 4.** Бодлогын сэтгэл ханамж <sup>3</sup>(Рейсман, 2007. х. 28)

Бодлогод дүн шинжилгээ хийх явцдаа түүнийг олон талаас нь задлан шинжлэх шаардлагатай. Хүснэгт 1-д санал асуулгын ерөнхий бүтэц<sup>4</sup>, мөн тэгш хамруулах сургалтын бодлогын дүн шинжилгээ хийх боломжтой асуултыг оруулав.

<sup>3</sup> Рейсман, Ж., Жинапп, А. Стачовиак С. 2007. *Мэдээлэл цуглуулах арга техникийн гарын авлага: Лавлах бичиг 'Зөвлөмж, бодлогыг мөрдөх зааварчилгаа.'* Байгууллагын судалгаа үйлчилгээ.

<sup>4</sup> Шинэчилсэн: EENET Сонин Дугаар. 12. 2008 оны 8-р сар. 'Үндэсний боловсролын бодлого, төлөвлөгөөг хэрхэн тэгш хамруулах вэ?' EENET.

<p><b>Тэгш хамруулан сургах боловсролын тодорхойлолт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тэгш хамруулах сургалтын талаар танай бодлогод тодорхой оруулсан байдаг уу?</li> <li>• Тусгай/тусгай хэрэгцээт боловсрол болон 'тэгш хамруулах сургалт'-ыг олгох боловсролын хооронд ялгаа байна уу?</li> </ul>
<p><b>А) Чанартай боловсрол</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлого бүх нийтийн боловсрол олгох, боловсролын чанарыг ахиулах үйл ажиллагаа хоёрын эргэх холбоонд суурилсан уу?</li> <li>• Сургууль завсардагчдын тоог бууруулах, шинээр элсэгчдийг тоог нэмэгдүүлэхийн тулд боловсролын чанар хамран сургалт хоёр нийцэж байх ёстой гэж ойлгодог уу?</li> <li>• Чанартай сургалт гэдэг нь зөвхөн ангид хичээллэх бус өргөн хүрээнд сурах тухай гэдгийг ойлгодог уу?</li> </ul>
<p><b>В) Холистик хандлага</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод тэгш хамруулах боловсролын үзлийг нэвтрүүлснээр суралцагч бүр илүү чанартай боловсрол олж авах нь боловсролын тогтолцоог өөрчлөх нэгэн арга хэлбэр гэж үздэг үү?</li> <li>• Танай бодлогод албан, албан бус боловсролыг хамтад нь эзэмшүүлэх асуудлыг авч үзсэн үү?</li> </ul>
<p><b>С) Нөөцийн хуваарилалт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод боловсролын санхүүжилтийг хийхдээ тэгш хамруулах боловсролыг оролцуулан хамтад нь төсөвлөдөг үү, эсвэл тусад нь төсөвлөдөг үү?</li> </ul>
<p><b>Д) Байгаа нөөц, хүчин чадал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод аль хэдийн бий болсон санаа, туршлагыг олж илрүүлэн цаашид хөгжүүлэхийг зорьдог уу? Эсвэл тэгш хамруулах сургалтыг цоо шинээр эхлүүлэх, эсвэл хаа нэгтэйгээс оруулж ирнэ гэж боддог уу?</li> <li>• Үндэсний, бүсийн, орон нутагт оршин буй нөөц баялгийг ашиглахыг дэмждэг үү?</li> </ul>
<p><b>Е) Хяналт, үнэлгээ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод хүүхэд, залуучуудын боловсролын ахиц, хөгжлийн дэлгэрэнгүй судалгаа хийхийг дэмждэг үү?</li> <li>• Боловсролын тогтолцоон дахь тэгш хамруулах сургалтыг хянах, шалгах бүтэцчилсэн хүрээ танай бодлогод байдаг уу?</li> </ul>

<p><b>Ф) Оролцооны судалгааны мэдээ, баримтыг цуглуулах</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлого хүүхэд, залуучуудын оролцооны боловсролын судалгаан дээр суурилсан уу?</li> </ul>
<p><b>Г) Багш боловсрол</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тэгш хамруулан сургах боловсролын онол, практикийг багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны бодит шинэчлэлтэй уялдуулсан уу?</li> <li>• Тэгш хамруулах сургалт нь багш нэг бүрийн хийх ёстой ажил, үүрэг гэж үздэг үү?</li> <li>• Багш боловсролын байгууллагууд заах аргын хуучинсаг хандлага болон тэгш хамруулах сургалтын талаарх багахан хэмжээний туршлагыг мэдэрч асуудлыг шийддэг үү?</li> </ul>
<p><b>Н) Уян хатан хөтөлбөр</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод сонирхлын бүлгүүдийн санал, зөвлөгөөг авч хөтөлбөрийн шинэчлэл хийхийг дэмждэг үү?</li> <li>• Хөтөлбөр боловсруулахад орон нутгийн оролцоог дэмждэг үү?</li> </ul>
<p><b>И) Тэгш хамруулах сургалт хүний эрхийн асуудал болох нь</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Танай бодлогод тэгш хамруулах бодлогоо хэрэгжүүлэхдээ хүний эрхийн асуудлыг тусгадаг уу? Энэ нь тэгш хамруулах бодлогын үндэс гэдгийг ойлгодог уу?</li> </ul>

Энэхүү зөвлөмжийн дараах хэсэгт тодорхой тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг багш бэлтгэх боловсролд хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг, мөн боломжит стратеги, шийдлийг оруулсан болно. Бодлогын стратеги гэж нэрлэж байгаагийн гол учир нь бодлого нь ерөнхий, харин түүнийг боловсруулсан хүмүүсийн нийгэм, соёл, улс төрийн чиг хандлагын илрэл болж байдаг оршиж байна. Түүнчлэн бодлогод дүн шинжилгээ хийх явцдаа ч бид нийгэм, соёлын болон улс төрийн үзэл бодлогоо тусгадаг. Иймээс бодлогод дүн шинжилгээ хийхдээ түүнд нөлөөлж буй олон хүчин зүйлийн дотор мөн өөрийн үзэл баримтлал, хандлага нөлөөлдгийг мэдэж байх зайлшгүй шаардлагатай.

.....

# Бэрхшээл 1

## Тэгш хамруулан сургах боловсролын ойлголт, үзэл бодол

### Нөхцөл байдлын шинжилгээ

*Боловсролд оролцогч талууд хэрэгжиж буй бодлогын талаар хангалтгүй мэдлэгтэй байдаг.*

Зарим улсын боловсролын тогтолцоо, багш боловсролын байгууллага, сургуульд тэгш хамруулах сургалтын бодлого байдаггүй. Гэсэн хэдий ч тэгш хамруулах сургалтын бодлого нь олон улсын, бүсийн, үндэсний, орон нутаг, засаг захиргааны гэх мэт олон түвшинд ямарваа нэгэн хэмжээгээр тусгалаа олсон байдаг тул бодлого байна уу, үгүй юу гэдэг асуудлыг бид энд авч үзэхгүй. Харин боловсролд оролцогч талууд хэрэгжиж буй бодлогын талаар хангалттай мэдээлэл, мэдлэгтэй байдаггүй тухай илүү авч үзэхийг зорьсон билээ.

*Тэгш хамруулах сургалтын боловсролыг дэмжих чиг хандлагын бүтэцчилсэн хүрээ дутагдалтай байдаг.*

Тэгш хамруулах сургалтын боловсролыг олон талаас нь хөндсөн олон бодлого байдаг хэдий ч эдгээр нь салангид, бие биетэйгээ уялдаа холбогдолгүй байдгаас чиг хандлагыг тодорхойлсон нэгэн хүрээ болдоггүй. Энэ нь бодлогын хэрэгжилтэд саад учруулах хүндрэл үүсгэдэг.

*Бодлогод нөлөөлөх хүмүүс түүнийг ойлгож, дэмжихгүйгээс болоод бэрхшээл тулгардаг.*

Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих бодлогыг заримдаа боловсролд оролцогч талууд болох багш бэлтгэх мэргэжилтэн, багш сурган хүмүүжүүлэгч болон эцэг эх/гэр бүл сайн ойлгож, дэмждэггүй. Оролцогч талуудын энэхүү дутмаг ойлголт, дэмжлэг нь түүнийг бодитой боловсруулах, дүгнэх, хөгжүүлэх үйл явцад оролцохгүй байх шалтгаан болж байна. Бодлого боловсруулах үйл явцад тэдний оролцоо байхгүй байснаас бодлогын талаар хангалтгүй ойлголттой байгаад зогсохгүй бодлого хэрэгжүүлэлтийн үйл явцад идэвхгүй оролцох нөхцлийг бүрдүүлдэг. Энэ мэт нөхцөл байдал нь бодлогыг үр дүнгүй, шаардлагын түвшинд хэрэгжүүлэхэд, саад болох эрсдлийг бий болгож байна.

*Олон улсын, үндэсний, орон нутгийн бодлогод тодорхойлсон тэгш хамруулан сургах боловсролын үзэл, ойлголтын ялгаатай байдал, хоорондын зөрчил*



Олон улс, бүс, үндэсний болон орон нутгийн ихэнх бодлогод тэгш хамруулан сургах боловсролын асуудлыг тусгасан байдаг ч эдгээр үзэл, бодол нь нэг нь нөгөөтэйгөө холбогдохгүй, тэр ч байтугай хоорондоо зөрчилдөх явдал гардаг. Цаашилбал, үндэсний, засаг захиргааны/дүүргийн, орон нутгийн түвшний бодлогод тэгш хамруулах сургалтын олон улсын стандартад нийцсэн нарийн тодорхойлолт нь тусгагдаагүй байдаг. Энэхүү нөхцөл байдал нь боловсролын тогтолцоог бүхэлд нь, ялангуяа багш боловсролын байгууллагууд тэгш хамруулан сургах боловсролыг тодорхой, бодитой стратегээр эзэмшүүлэхэд хүндрэл бэрхшээл учруулдаг.

*Үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, багш боловсролын бодлого, хэрэгжилт хоорондын зөрчил*

Багш боловсролын байгууллагуудын менежментийн хувьд ч, зохион байгуулж буй сургалтын хувьд ч тэдгээрийн бодлого, түүний хэрэгжилт үндэсний хэмжээний хууль, тогтоомжид тусгаагүй байдаг. Энэ нь багш боловсролын байгууллагын тэгш хамруулах сургалтын чанарт сөргөөр нөлөөлж багш нарт шаардлагын дагуу хичээлээ бэлтгэн заахад бэрхшээл учруулдаг.

**Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:**

- Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжиж буй өнөөгийн бодлогын (олон улсын, бүсийн, үндэсний, орон нутгийн) талаар та хэр мэдлэгтэй байгаа вэ? Эдгээрийг хаанаас яаж олж авч, тэдэнд дүн шинжилгээ хийх боломж байна вэ?
- Тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэхэд хэрэг болохуйц хууль, тогтоомжийн талаар мэдлэгтэй байна уу? Эдгээр хууль, тогтоомж нь байгаа юу? Хэрэв байхгүй бол хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж боловсруулахад танд оролцох боломж байна уу?
- Өөрийн хамтран ажилладаг байгууллага, сонирхлын бүлгүүдэд хэрэгжиж буй тэгш хамруулан сургах боловсролыг илүү сайн ойлгуулж, өөрийн нөхцөл байдалд тохирсон орон нутгийн бодлого боловсруулахад та хэрхэн оролцож болох вэ?
- Тэгш хамруулан сургах боловсролын олон улсын стандартыг өөрийн нөхцөл байдалд (жишээлбэл: боловсролын яам, эсвэл танай багш боловсролын байгууллага) хэрэгжиж буй бодлогод хэрхэн нэвтрүүлэх вэ? Энэ үйл явцад хэн оролцох хэрэгтэй вэ? Тэд хэрхэн үр өгөөжтэй оролцож чадах вэ?

## Зөвлөмжүүд

### Бодлогын зөвлөмж 1

*“Тэгш хамруулан сургах боловсролын талаар сайтар мэдлэгтэй байх, мөн олон улсын, үндэсний, орон нутгийн түвшний бодлого хоорондын уялдаа холбоо сайн байх шаардлагатай .”*

### Бодлогын зөвлөмж 2

*“Боловсролын яам болон багш боловсролын байгууллагууд нь бодлогоо нэгтгэж, дүгнэн харах, шаардлагатай үед шинээр боловсруулах, түүгээр дамжуулан боловсролын тогтолцоонд тэгш хамруулан сургах боловсролын арга хандлагыг нэвтрүүлэх, дэмжих хэрэгтэй.”*

Зөвлөмж 1, 2-ыг хамтад нь бүлэглэсний учир нь бодлогын талаар таниулах үйл явцыг бодлогын уялдаа холбоо, зохицуулалт, цаашдын хөгжлийг үнэлэх зэргийн уялдаа холбоог чухалчлахын үүднээс авч үзсэнд оршино. Бодлогын цоорхойг нөхөхийн тулд бодлогыг түвшин бүрт нь уялдаа холбоог сайжруулах, бодлогыг шинэчлэн боловсруулах, мөн оролцогч талуудын тэгш хамруулан сургах боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах нь чухал юм.

Бодлогыг таниулах, түүнийг боловсруулах, хэрэгжүүлэх нь хамтын үүрэг, хариуцлага юм. Иймээс боловсролын яам тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой үндэсний бодлогыг боловсруулах, зохицуулах, дүгнэх үүрэг хариуцлага хүлээж, сонирхлын бүлгийн идэвхтэй оролцоог хангах нь мөн чухал .

Улсын болон орон нутгийн боловсролын байгууллага, багш боловсролын байгууллага, сургуулийн төлөөллийн оролцоо нь энэхүү үйл явцад чухал. Багш боловсролын байгууллага болон боловсролын яамдын хамтын итгэлцэл дээр суурилсан нэгдмэл санаа бодол, харилцаа нь тэгш хамруулан сургах боловсролыг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд нэн чухал зүйл юм. Түүнчлэн багш боловсролын байгууллагууд тэгш хамруулан сургах боловсролд өөрсдийн хэрэгжүүлж буй бодлогыг эргэн харж, үнэлгээ, дүгнэлт хэрэгтэй. Энэхүү үйл явцад оюутан багш, багш бэлтгэх багш, удирдлагыг мөн идэвхтэйгээр оролцуулах нь зүйтэй. Багш боловсролын байгууллага, сургууль, нийгэмлэгийн тэгш хамруулан сургах боловсролын бодлогод хандаж буй хандлага, тэдний мэдлэг нь энэхүү бодлогыг тодорхой, ач холбогдолтой боловсруулах, хэрэгжүүлэх гол түлхүүр юм.

Бодлогын үнэлгээ, цаашдын хөгжилд цаг хугацаа, цар хүрээний хүчин зүйл нөлөөтэй. Эдгээрийг дараах байдлаар тооцож болно. Үүнд:

- Тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг хөгжүүлэх, үнэлэн дүгнэхэд олон хүнийг хамруулсан үндэсний болон орон нутгийн хэмжээнд сургалт, семинар, бага хурал, форумыг зохион байгуулах
- Багш боловсролын байгууллагад боловсролын бодлогыг заадаг бол оюутан-багш нар бодлоготой холбоотой баримт бичиг, бодлогод дүн шинжилгээ хийдэг, хэлэлцүүлэг өрнүүлдэг байх

Боловсролын яамд эсвэл багш боловсролын байгууллагын аль аль нь бодлогын шинжилгээ, цаашдын хөгжлийн асуудлыг ганц нэг удаа хийдэг зүйл хэмээн үзэлгүйгээр өөрчлөх, шинэчлэх үйл явц хэмээн ойлгох ёстой. Сайн бодлого нь түүнийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад тогтмол засан сайжруулахаас шалтгаалдаг бөгөөд энэ нь тухайн бодлогын цаашдын үр дүнд чухал байна.

Бодлогын баримт бичиг нь нээлттэй, олдоцтой байх нь энэ үйл явцын гол түлхүүр. Хэрэв бодлогын баримт бичиг нь бүх түвшинд олдоцтой, хүртээмжтэй байвал түүнийг засан сайжруулах, үнэлэх, шаардлагатай бол үндэсний болон олон улсын бодлогын стандартад нийцүүлэх боломж бий болно. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийн талаас түүнийг бодлогын бүхий л баримт бичгүүдэд ойлгомжтой тодорхойлох нь чухал үүрэгтэй. Хэрэглээний боломжийг нэмэгдүүлэхийн тулд бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болох, заавар, удирдамж, гарын авлагыг үндэсний болон орон нутгийн хэл, мөн бройлийн үсгээр хангалттай хэмжээнд хэвлэх, эдгээртэй оролцогч талууд танилцаж, ойлгож, дүн шинжилгээ хийдэг байх нь чухал.

Тэгш хамруулан сургах боловсролыг хөхүүлэн дэмжиж, түүний талаар гүн бат ойлголтын суурийг тавихад боловсролын судалгаа болон шалгалт үнэлгээний систем бүрэлдсэн байх шаардлагатай. Боловсролд оролцогч олон талуудын санал, чиг хандлагыг тоон болон чанарын арга хэмжээгээр авч бодлогодоо тусгах хэрэгтэй. Үүнд тулгамдаж буй асуудлуудаар судалгааны мэдээ баримт цуглуулах, тэдгээрийг задлан шинжлэх механизм бүрдүүлэх чухал үүрэгтэй. Судалгааг зөвхөн ор нэр төдий хийх бус үр өгөөжтэй өөрчлөлт хийхэд чиглэгдсэн байвал зохистой. Тэгш хамруулах сургалт боловсролын философийн цөм нь үйлийн судалгаа бөгөөд бодлого хэрэгжүүлж буй түвшин бүрт үнэлгээ, дүгнэлт өгөх гол арга зам билээ. Зөвлөмж 5-д (*Арга зүй*) үйлийн судалгааны талаар илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

Түүнчлэн судалгааг үйл ажиллагаанд гарсан нөлөөллийг илрүүлэх зэрэг боловсролын бусад асуудалд үнэлгээ хийхэд хэрэглэдэг. Жишээлбэл, үйл ажиллагааны үр өгөөжийг үнэлэхдээ тэгш хамруулан сургах боловсролын тал дээр үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагууд түүний үзэл баримтлал, арга, хандлагыг хэр адилхан хэмжээнд, эсвэл ялгаатай хэрэгжүүлж буйг илрүүлэх шалгуур ашиглаж болно. Багш боловсролын байгууллагын багш бэлтгэх боловсон хүчин болон оюутан багш нараас ярилцлага авах, судалгаа явуулах, ажиглалт хийх зэрэг аргаар харьцуулсан судалгаа явуулж дээрх мэдээллийн санг бүрдүүлж болно.

### **Бодлогын зөвлөмж 3**

*“Бодлогыг дүгнэх, нэгтгэх, хөгжүүлэх үйл явцад тэгш хамруулан сургах боловсролыг багш боловсролд хамааруулан тусгах хэрэгтэй.”*

Багш боловсрол дахь ойлгомжтой, тодорхой тэгш хамруулан сургах боловсролын бодлого нь тухайн боловсролын ерөнхий зорилго, зорилтуудад нийцсэн байхын

сацуу түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тусгай, онцгой асуудлыг ч тусгасан байх шаардлагатай. Тухайлбал,

- Оюутан-багшийн элсэлт, багш сурган хүмүүжүүлэгчдийг ажилд сонгон шалгаруулах тэгш бус байдал (эмэгтэйчүүд, үндэсний болон хэлний цөөнх, хөдөө орон нутгийн болон, алслагдсан газрын хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл гм)
- Тэгш хамруулах боловсролын сурах, сургах аргагүй, мөн явцын бодит үнэлгээг бий болгох, хөгжүүлэх
- Багш сурган хүмүүжүүлэгч, оюутан-багш хоорондын болон багш боловсролын байгууллага, сургууль/сургуулийн нийгэмлэгийн хамтын ажиллагаа, харилцааг бэхжүүлэх
- Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэх боломжийг ханган өөр өөр түвшний суралцагчид болон тэгш хамруулах сургалтыг дэмжих, багшийн өөртөө итгэлтэй байдлыг бий болгох

## Лаос улсын жишээ

*Үндэсний бодлогод дүн шинжилгээ хийх, шинэчлэх* <sup>5</sup>

2008 онд Женевт болсон ЮНЕСКО-гийн тэгш хамруулан сургах боловсролын бага хурлаас Лаос улсад хэрэгжүүлж буй боловсролын бодлогын үнэлгээг хийсэн. Ингэхдээ нарийн бодлого боловсруулахын сацуу түүнийг бодит хэрэгжилтийг дэмжихийн тулд тэгш хамруулан сургах боловсролын заалтуудыг боловсролын хуульд тусган оруулсан байна.

Лаос улс багш нарт шаардлагатай боловсрол, чадварыг эзэмшүүлснээр тэгш хамруулан сургах боловсрол, түүний чанар сайжирна гэдгийг чухалчлан үзэж бодлого боловсруулах, сайжруулах үйл явцыг үргэлжлүүлэн хийсээр байна. Багшийн боловсролд чанарын шинэчлэл хийхдээ багшийг сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулж төвлөрлийг сааруулснаар тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн багшлах боловсон ажиллуулах боломж бүрджээ. Энэ нь тухайн орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулсан байна.

<sup>5</sup> ЮНЕСКО. 2012. *Бус Нутгийн Шинжээчдийн Уулзалт Тайлан: Ази-Номхон далайн орнуудад чанартай багш боловсролыг тэгш хамруулан сургах боловсролоор түгээх нь*. Бангкок, ЮНЕСКО.

## Монгол улсын жишээ

Боловсролын тухай хуулийн 5. 1.4 –д “Иргэнийг сурч боловсроход үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж нөхцлөөр хангана.” гэж заасан байдаг. Өнөөгийн нөхцөлд тэгш хамруулан сургах гэсэн ойлголтыг бодлогын түвшинд боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш ажилтан зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдгээр ойлгож байгаа нь тухайн боловсролын талаархи ойлголтын зөрүүтэй байдал нь харагдаж байна. Мөн хүүхдийн ялгаатай байдалд анхаарал хандуулах багш цөөн байна. Энэ нь олон жил гадаад оронд сурч боловсорч байсан хүүхдэд хэл яриа, соёлын бэрхшээл, онцгой авьяас чадвартай хүүхдийг хэрхэн бусад сурагчидтай тэгш хамруулах сургах боломжоор хангах нь бэрхшээл хэвээр байна.

Иймээс өнөөгийн боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлого цаг үеэ олсон чухал асуудал юм. Энэ бодлогын хүрээнд тэгш хамруулан сургах ойлголтыг багш нарт жигд хүртээх боломж бүрдэж байна.

## Бэрхшээл 2

### Хамтын ажиллагаа

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Яамдуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны зохицуулалт хангалтгүй байна.*

Тэгш хамруулан сургах боловсрол нь боловсролын салбарын бүхий л байгууллагуудын хамтын ажиллагааг шаарддаг. Боловсролын яам тэгш хамруулан сургах боловсролын бодлого, түүний хамтын арга хандлагыг бусдад таниулан сурталчилдаггүй бол сургууль, нийгэмлэг дэх тэгш хамруулан сургах боловсролын үр дүн сайжрахгүй. Хамтын ажиллагааны хангалтгүй, сул дорой байдал нь бодлого, түүний хэрэгжилтэд зөрчил үүсгэж эмх замбараагүй байдалд хүргэдэг. Зарим орны боловсролын яамдын тодорхой нэг хэлтэс нь тэгш хамруулан сургах боловсролын асуудлыг хариуцан ажилладаг. Боловсролын яамны нэг хэлтэс нь тэгш хамруулан сургах боловсролд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай хэдий ч энэ тохиолдолд түүнийг боловсролоос тусдаа, салангид зүйл мэт болгон яамны тухайн хэлтэс нь цорын ганц үүрэг хариуцлага хүлээгч нэгэн болж хувирдаг. Энэ нөхцөл байдал нь хамтын ажиллагааг дэмжихэд сөрөг нөлөө үзүүлж нийт яамны хэмжээнд тэгш

хамруулан сургах боловсролын үйл ажиллагаанд саад болдог.

Нэмж хэлэхэд боловсролын яамны болон бусад яамдын (жишээлбэл эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өнчин хүүхдүүд, шилжиж ирсэн ажилчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд гэх мэт асуудал хариуцсан яамд) сул дорой хамтын ажиллагаа нь дан ганц боловсрол гэлтгүй ядуурал, хөдөлмөрийн чадваргүй болох, шилжин суурьшилт, эрүүл мэндийн тааруу байдал, үндэсний цөөнхийн асуудал гэх мэт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тэдний нэгдсэн арга хандлагын чадавхийг бууруулдаг.

*Төрийн болон төрийн бус байгууллагууд, засгийн газрын яамд, багш боловсролын байгууллага хоорондын хамтын ажиллагааны хангалтгүй, сул дорой байдал*

Энгийнээр бодоход бүх яам, багш боловсролын байгууллагууд нь боловсролын асуудалд хамтран оролцож тэгш хамруулан сургах боловсролын нэгдсэн нэг үзэл ойлголтыг төлөвшүүлэн хамтарч ажиллах боломжтой мэт байдаг. Гэтэл бодит амьдрал дээр ихэнх улс оронд боловсролын яамдын хэлтсүүд, төрийн болон бус байгууллагууд, багш боловсролын байгууллагууд нь боловсролын бодлогын мөн чанар, хэрэгжүүлэх арга, хэлбэрийн талаар өөр хоорондоо зөрчилтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү хамтын ажиллагааны хангалтгүй, сул дорой байдал нь тархай бутархай байдал бий болгох, нөөц бололцоо болон цаг хугацаа гарздах, ойлгомжгүй, заримдаа эсрэг тэсрэг мэдээллийг олон түмэнд хүргэж, шаардлагагүй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, өөр бусад үр ашиггүй үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх зэргээр багш боловсрол, сургуулийн тэгш хамруулан сургах боловсролд хүрч үйлчилж чаддаггүй байна.

Сонирхлын бүлгүүд боловсролын бодлогыг боловсруулахад оролцоогүйгээс, тэдний зөвлөгөө, санал дутмаг, хангалтгүй байснаас энэхүү хамтын ажиллагааны сул дорой байдал үүсдэг. Үүнийг *‘Бэрхшээл 3 – Бодлогын хэрэгжүүлэлт’*-д илүү дэлгэрэнгүй тайлбарласан байгаа.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:**

- Тэгш хамруулан сургах боловсролын бодлого болон түүний хэрэгжилтийг дэмжихийн тулд яамд хамтран ажиллах арга хандлагыг (яамд хоорондоо хамтарсан болон дотооддоо) хэрхэн хөгжүүлэх вэ?
- Өөрийн ажиллаж буй байгууллага болон боловсролын бусад байгууллага хооронд тэгш хамруулан сургах боловсролын бодлого, түүний хэрэгжилтэд зориулсан хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх вэ?

## Зөвлөмжүүд

### Бодлогын зөвлөмж 4

*“Боловсролын яамнаас тэгш хамруулан сургах боловсролын тодорхой стратегиуд боловсруулж үүрэг, хариуцлагыг жигд хуваарилах, мөн эдгээрийг бусад яамдад түгээн дэлгэрүүлж тэдний оролцоог хангах нь зүйтэй.”*

Боловсролд тэгш хамруулах үзэл баримтлал, бодлогыг үр дүнтэй болгохын тулд яамны бусад бүх хэлтэс үүнийг ойлгон дэмжих хэрэгтэй. Яамдын хэлтсүүд нь (жишээлбэл, багш бэлтгэх боловсрол, бага, дунд, их, дээд сургуулийн боловсрол, хөтөлбөрийн хөгжил, боловсролын судалгаа гэх мэт асуудлыг хариуцсан) идэвхтэй хамтран ажиллаж тэгш хамруулан сургах боловсролын зорилгыг тодорхойлон гаргаж чадвал бүхий үйл явцад бодит хөрөнгө оруулалт болох юм. Бэрхшээл 1-д өгүүлсэн бодлогод дүн шинжилгээ хийх, хөгжүүлэх үйл явц нь олон яам, хэлтсийг боловсролын үйл ажиллагаанд татан оролцуулж ойр дотно хамтын ажиллагааг бий болговол ихээхэн үр дүнтэй болж чадна.

Холбогдох яамдын хэлтсүүд хамтарч тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нь гол зорилго хэдий ч хэлтэс тус бүрийн үйл ажиллагааг дүгнэх, шинжлэх нарийн, тодорхой, найдвартай үнэлгээний систем мөн чухал шаардлагатай.

Боловсролын яамд нь тэгш хамруулан сургах боловсрол үзэл баримтлалыг бусад яамдад түгээн дэлгэрүүлэх хэдий ч үүнийг дагнан хариуцсан тодорхой нэгэн хэлтэс зайлшгүй байх шаардлагатай. Боловсролд тэгш хамруулах бодлогыг ач холбогдолтой, үр дүнтэй, хамтын ажиллагаа болгохын тулд хариуцлагын нарийн тогтолцоо, тодорхой зорилгод чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурласан яамд хоорондын үйл ажиллагааг хөгжүүлэх ёстой.

### Бодлогын зөвлөмж 5

*“Боловсролын яам, багш боловсролын байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын тогтвортой, гүн бат харилцаа нь тэгш хамруулан сургах боловсролын үр дүнтэй хандлагыг бий болгодог.”*

Яамд, багш боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудад тэгш хамруулан сургах боловсролыг эзэмшүүлэхийн тулд хамтын ажиллагааны үр дүнтэй алхмуудыг хийх нь зүйтэй. Хамтран ажиллаж үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хяналт, шалгалт, үнэлгээний системийг боловсруулах, нэгдмэл ойлголт, хандлагыг бий болгох, багш боловсролын байгууллагуудад тэгш хамруулан сургах боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх зэргээр дээрх алхмуудыг хэрэгжүүлж болно.

Энэхүү хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд боловсролын яамны бодлого боловсруулагчид багш боловсролын байгууллагуудад менежер, багш сурган хүмүүжүүлэгчидтэй биечлэн уулзаж ажил хэргийн гүн бат харилцаа холбоо тогтоож, багш боловсролын хэрэгцээ, шаардлагыг нарийн сайн ойлгож ажилласнаар ач холбогдолтой, үр дүнтэй бодлого боловсруулж, амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой юм. Нөгөө талаас багш боловсролын байгууллагын мэргэжилтэн болон оюутнууд нь тэдэнд тулгарч буй асуудлыг ойлгон (жишээлбэл, бодлогын форум, сургалт семинар, бага хурлаар дамжуулан) боловсролын яамны үйл ажиллагааг дэмжин ажиллах нь зүйтэй.

Боловсролд тэгш хамруулах тогтолцоог бий болгоход дан ганц яам, багш боловсролын байгууллагын хамтын ажиллагаа төдийлөн эерэг нөлөө авчрахгүй.

Албан бус боловсролын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг төрийн бус байгууллагууд нь тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэх, зохион байгуулах арвин баялаг туршлагатай байдаг учраас энэхүү бодлогыг хөгжүүлэх, дэмжихээр үйл ажиллагаа явуулж буй боловсролын яамд болон багш боловсролын байгууллагуудад үр дүнтэй удирдамж өгч чадна.

Тэгш хамруулан сургах боловсролыг эрхлэн явуулдаг дадлага туршлагатай засгийн газрын бус эдгээр байгууллагуудтай нэгдэн ажиллаж үндэсний болон орон нутгийн бодлогоо хөгжүүлж чадвал багш боловсролын байгууллагууд нь тэгш хамруулан сургах боловсролыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд энэ чиглэлийн чадавхийг бий болгоход чухал үүрэгтэй.



## Бангладеш улсын жишээ

*Албан бус боловсролоос суралцахуй<sup>6</sup>*

Бангладешт хэрэгжүүлж буй албан бус боловсролын зарим хөтөлбөрүүд нь албан боловсрол эзэмших боломжгүй хүүхдүүдийг тэгш хамруулах албан бус боловсролд хамруулж чадсан. Жишээлбэл: Дака Ахсаниагийн хэрэгжүүлсэн хэлний мэдлэгийн түвшингээрээ харилцан адилгүй хүүхдүүдэд хичээл заах ЦОР ГАНЦ төсөл нь албан бус боловсролыг хөгжүүлсэн сайн жишээ болж чадсан гэж саяхны судалгаанд гарчээ.<sup>7</sup>

## Монгол улсын жишээ

Монгол Улсын боловсролын их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хамтран тэгш хамруулах сургах багшийн сургалтад тулгарч буй бэрхшээл үзэл санаа зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгоор хоёр өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Боловсролын хүрээлэн, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Монголын дүлий иргэдийн үндэсний хороо, “Өгөөмөр сэтгэл” ТББ, Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль, 34, 116, 87 дугаар сургууль, 186,199 дүгээр цэцэрлэгийн багш нар өөрсдийн байгууллагын хүрээнд болон хүрээнээс гадуур тэгш хамруулан сургах боловсролын талаарх мэдлэг, туршлагаа илэн далангүй хуваалцав. Хэлэлцүүлгээс тэгш хамруулан сургах багшийн боловсрол нь багш мэргэжлийн агуулгад зайлшгүй байх хэрэгцээ шаардлагатай бөгөөд үүнийг багш мэргэжил олгодог төрийн болон төрийн бус бүх сургуулийн агуулгад оруулах хэрэгтэй гэсэн санал гарлаа. Мөн одоо багшаар ажиллаж байгаа нийт боловсролын байгууллагын багш нарт мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгаар зайлшгүй эзэмшүүлэх ажлыг багшийн мэргэжил дээшлүүлэх бүх байгууллагад мэдэгдэж хамтран ажиллах шаардлагатай гэж үзлээ. Иймд багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч нарыг сургагч багшаар бэлтгэх ажил эхлүүлээ.



<sup>6</sup> ЮНЕСКО. 2012. *Бүс Нутгийн Шинжээчдийн Уулзалт Тайлан: Ази-Номхон далайн орнуудад чанартай багш боловсролыг тэгш хамруулан сургах боловсролоор түгээх нь*. Бангкок, ЮНЕСКО.

<sup>7</sup> ЮНЕСКО. 2011. *Бангладеш улс дахь Анхан шатны багш нарын шүүмж, дүгнэлт*. Сургалтын хөтөлбөр – Эцсийн тайлан. Бангкок, ЮНЕСКО.

# Бэрхшээл 3

## Бодлогын хэрэгжилт

### Нөхцөл байдлын шинжилгээ

*Бодлого боловсруулагчид болон бодлого хэрэгжүүлэгчдийн уялдаа холбоогүй үйл ажиллагаа*

Бодлого боловсруулагчид болон бодлого хэрэгжүүлэгчдийн уялдаа холбоогүй үйл ажиллагаа нь багш боловсролын байгууллага, сургууль, нийгмийн хөгжилд нөлөөлдөг. Мөн энэхүү нөхцөл байдал бодлогыг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг биелүүлэхгүй үл тоомсорлох, бодлогыг тодорхой бус ойлгомжгүй болгож багш боловсролын байгууллага, сургууль, нийгэмд эерэг өөрчлөлт авчирдаггүй. Бодит амьдралд нийцэхгүй, салангид бодлого боловсруулсан үед энэхүү холбоогүй байдал бий болдог.

*Орон нутгийн боловсролын байгууллага, сургуулийн оролцоог дэмжин, тэдний санал бодлыг хүлээж авах нь бодлогын шаардлага юм.*

Бодлогодоо багш боловсролын байгууллага, сургуулийн идэвхтэй оролцоог дэмжихгүй бол тэдний боловсролд авчрах баялаг дадлага, туршлага, ур чадвар, мэдлэгээс авч чадахгүйд хүргэх эрсдлийг бий болгодог. Цаашлаад олон нийтийн төлөөлөл болох эцэг эх, гэр бүл, шашны бүлгүүд тэгш хамруулан сургах боловсролыг ойлгож дэмжихгүй бол бүх суралцагчдын боловсролыг дэмжих хандлага хангалтгүй болно.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:**

- Боловсролд тэгш хамруулах боловсролыг хөгжүүлэхийн тулд танай боловсролын байгууллага бодлого боловсруулагчдыг хэрхэн дэмжиж ажиллах вэ?
- Тэгш хамруулан сургах боловсролыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэн, хөгжүүлэх үйл явцад орон нутгийн иргэдийн төлөөллийг (жишээлбэл, эцэг эх, гэр бүл, шашны болон бусад олон нийтийн төлөөлөл) хэрхэн оролцуулах вэ?
- Багш боловсролын байгууллагууд тэгш хамруулах сургалтыг зохион байгуулахдаа тухайн орон нутгийн олон нийтийн төлөөллийн эрдэм мэдлэг, чадвар, дадлага, туршлагыг хэрхэн тусган ажиллаж чадах вэ?

## Зөвлөмжүүд

### Бодлогын зөвлөмж 6

*“Бодлого боловсруулагч болон бодлого хэрэгжүүлэгчид хамтран ажиллаж, нэгдмэл ойлголттойгоор боловсролд тэгш хамруулах бодлогын хэрэгжүүлэх тодорхой стратеги боловсруулах хэрэгтэй.”*

Багш боловсролд хамааралтай бодлогыг хэрэгжүүлэхэд зөвхөн багш боловсролын байгууллага төдийгүй багш нарыг сонгон шалгаруулах, багш бэлтгэх ажлыг хариуцаж буй улсын, орон нутгийн, дүүргийн боловсролын байгууллага зэрэг боловсролын системийн бүхий л түвшинд хэрэгжинэ. Бодлого боловсруулагч болон бодлого хэрэгжүүлэгчид бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах хэрэгтэй бөгөөд боловсролд тэгш хамруулах бодлого, түүнийг хэрэгжүүлэх стратегийг боловсруулахдаа бүх түвшний төлөөллийг оролцуулах чухал шаардлагатай байна. Тухайлбал, үндэсний бодлогыг хөгжүүлэхэд багш боловсролын байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй оюутны төлөөллийг оролцуулах эсвэл тодорхой нэгэн дүүрэгт дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд тохирсон нэмэлт стратегийг боловсруулахад дүүргийн боловсролын мэргэжилтнүүдийг татан оролцуулах хэрэгтэй.

### Бодлогын зөвлөмж 7

*“Боловсролын бодлого нь орон нутгийн сонирхлын бүлгүүдийн идэвхтэй оролцоог дэмжих хэрэгтэй.”*

Өмнө нь дурдаж байсанчлан, боловсролд тэгш хамруулах бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд орон нутгийн боловсролын төлөөллийн оролцоо зайлшгүй чухал шаардлагатай. Тэдний оролцоо нь тухайн орон нутгийн олон нийтийн боловсролын хэрэгцээ, шаардлагыг тусгаж өгдөг. Орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагын хуримтлуулсан эрдэм мэдлэг, чадвар, дадлага, туршлага нь арвин их нөөц, баялаг байдаг учраас эдгээрийг бодлогодоо тусгаж, тэднийг үйл ажиллагаандаа оролцуулж байх хэрэгтэй.

Багш, сургуулийн удирдлага нь эцэг эх, гэр бүл зэргээр дамжуулан олон нийтийн оролцоог сургуулийн менежмент, арга зүй, сургалтын үйл явцад оролцуулах хэрэгтэй. Энэ талаар Арга зүйн удирдамж 5-д дэлгэрэнгүй тайлбарласан. Ийм үйл ажиллагаа нь бодлогыг албан ёсны болгоход их нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, сургуулиуд бодлогоороо зохицуулан тэдэнд бодлогыг таниулах, сургалт зохион байгуулах зэргээр үйл ажиллагаандаа хамруулах хэрэгтэй.

Олон нийт болон багш боловсролын байгууллага хоорондын үр дүнтэй харилцан ажиллагаанд бодлого нь мөн чухал нөлөө үзүүлнэ. Жишээлбэл, багш боловсролын байгууллага, сургуулиуд эдгээр байгууллагатай харилцан хоёр талын холбоо тогтоож илүү идэвхтэй үр дүнтэй ажиллах боломжтой.

Үүнийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

- Тухайн орон нутагт оюутан-багш нар дадлага хийх боломжийг бодлогоор дэмжих
- Оюутан багш ба багш бэлтгэх боловсон хүчин орон нутгийн сургуулиудад сайн дураар ажиллах боломжийг бодлогоор зохицуулах
- Багш боловсролын байгууллага нь орон нутгийн багш нарт нэмэлт мэргэшүүлэх сургалт зохион байгуулах боломжийг бодлогоор зохицуулах
- Багш боловсролын байгууллага өөрсдийн багш бэлтгэх дадлага туршлага, ур чадвараа орон нутгийн сургуулийн удирдлага, багш нартай хуваалцан лекц, семинар зохион байгуулах боломжийг бодлогоор зохицуулах

Түүнчлэн багш боловсролын байгууллагын үйл ажиллагаанд оюутны төлөөллийг олон чиглэлээр илүүтэй оролцуулах ажлыг хийх шаардлагатай байна.

## Энэтхэг улсын жишээ

*Боловсрол дахь олон нийтийн оролцоо*<sup>8</sup>

Нийгмийн идэвхтэй харилцааг тэгш хамруулан сургах боловсролд илүү түлхүү оролцуулах зорилгоор Баруун хойд Энэтхэгийн Ражастанд нэгэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд удалгүй тэгш хамруулан сургах боловсролд нийгмийг хамруулаад зогсохгүй түүнчлэн 'багшлах боловсон хүчин'-г сургах шаардлагатай гэж үзсэн. Багшийг хүндэтгэн сэдэл тэмүүлэл төрүүлэн, урам зориг өгч, дэмжин ажиллах нь энэхүү асуудлыг шийдвэрлэх гол асуудал байсан. Хийх явцдаа суралцах, аажмаар тасралтгүй суралцъя гэсэн уриаг төслөөс гаргасан.

<sup>8</sup> Шинэчилсэн: Рамачандран, V. 2001. 'Анхан шатны боловсролд нийгэмлэгийн оролцоо.' Ражастаны санаачлагаас. *Эдийн засаг, улс төрийн долоо хоногийн тойм*. Vol – XXXVI, No. 25, 2001 оны 6-р сар

## Монгол улсын жишээ

### *Бодлогын хэрэгжилт*

Өнөөгийн нөхцөлд багш өөрийн даасан анги буюу хичээл зааж байгаа ангийн сурагчдыг боловсролд тэгш хамруулж чадахгүй байна. Энэ нь хууль эрх зүйн бодлого ерөнхий, хоорондын уялдаа холбоо бага байдагтай холбоотой.

Жишээлбэл: Боловсролын тухай хуулийн 43.1.8-д ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдэл сар бүр олгох

Нийгмийн хамгааллын тухай хуулийн 7.8-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын байгууллагын холбогдох албан тушаалтан,энэ хуулийн 10.1-д заасан нийгмийн хамгаалал эрүүл мэнд боловсролын комиссын гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалинг олгоно.

10.1- заалт иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг дараах байдлаар тодорхойлно. /10.1.1-16 хүртлэх нас, 10.1.2-16 –аас дээш нас,магадлан итгэмжлэх комисс шийдвэрлэнэ. /

Дээрхи эрх зүйн баримт бичигт тусгасан нэмэгдэл нь тодорхой бус ерөнхий тусгагдсанаас багш нар тодорхой нэмэгдэл авч чаддаггүй.

Иймээс багш нар өөрийн ангидаа байгаа сурагчдад тэгш хандаж боловсрол олгох, хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан үзэж чадахгүй байна.

Харин сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9 дэх заалтад “хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхэдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно.” гэж заасан.

Эрх зүйн баримт бичигт ихэвчлэн тэгш хамруулах сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй гэсэн ойлголтоор тусгасан байна.

### **Бодлогын зөвлөмж 8**

*“Орон нутгийн сонирхлын бүлгүүд боловсролын бодлогыг ойлгох, шинэчлэх, хөгжүүлэх үйл явцад оролцох шаардлагатай.”*

Хэрэгжиж буй бодлогод орон нутгийн сонирхлын бүлгүүдийн бодлогыг шинэчлэх, шинэ бодлогыг хэрэгжүүлэхэд шууд оролцоо зайлшгүй хэрэгтэй байна. Багш бэлтгэх боловсон хүчин, оюутан багш, дүүргийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдлага, тэргүүлэх багш, багш нар, эцэг эх, гэр бүл, хүүхдүүд зэрэг сонирхлын бүлгүүд нь боловсролд тэдний дуу хоолой байх ёстой гэдгийг ойлгон, ухаарч өөрсдийн амьдралд нөлөөлөхүйцээр бодлогыг хэрэгжүүлж, дэмжиж, үнэ цэнэтэй байлгах ёстой. Цаашилбал, орон нутгийн түвшинд тэдний оролцоо үр өгөөжтэй бодлого боловсруулах хамгийн сайн стратеги болж чадах юм.

# Бэрхшээл 4

## Нийгэм эдийн засгийн бодлого

### Нөхцөл байдлын шинжилгээ

*Боловсролын бодлогын 'зах зээлд чиглэсэн' хандлага болон тэгш хамруулан сургах боловсрол хоорондын нийцгүй байдал*

Боловсролын 'зах зээлд чиглэсэн' хандлага нь боловсролыг зах зээлийн талбар мэт болгож түүнд уралдаж тэмцэж, өрсөлдөж хүрнэ гэсэн зарчмаар ажилладаг.<sup>9</sup>

Цаашлаад 'зах зээлд чиглэсэн' хандлага нь боловсролын үнэлэмжийг ердөө л эдийн засгийн үр ашгаар<sup>10</sup> нь дүгнэхээс бус нийгмийн үр ашгийг нь огтхон ч тооцдоггүй. Боловсролын 'зах зээлд чиглэсэн' хандлага нь ихэвчлэн боловсрол дахь эрх тэгш байдалд урьдчилан таамаглаагүй үр дагавар авчирдаг төдийгүй боловсролын нийгмийн бүтцэд<sup>11</sup> маш их хохирол учруулдаг. Боловсрол эзэмших нь хүний үндсэн эрх бөгөөд нийтийн сайн сайхны төлөө үйлчилдэг бол 'зах зээлд чиглэсэн' хандлага нь тэгш хамруулан сургах боловсролын эсрэг ажилладаг.

Боловсролын 'зах зээлд чиглэсэн' хандлага нь тэгш хамруулан сургах боловсролд ямар байдлаар эсрэг байдгаас дурдвал:

- Багш боловсролын байгууллага, сургууль, багш нарын хоорондын хамтын ажиллагааг 'чөлөөт зах зээл' уралдааны талбар болгодог. (жишээлбэл, багш нарын ажлын үр дүнг эцсийн үнэлгээний шалгуураар үнэлж цалинжуулснаар тэгш хамруулах сургалтыг үнэгүйдүүлэх, шаардлагагүй, зохимжгүй өрсөлдөөнийг бий болгох, багш нарын хүсэл, эрмэлзлэлийг мохоох, сурах, сургах үйл явцыг техникийн чанартай үнэлгээний арга хэрэгслээр үнэлэх гм)-
- Суралцах үйлийг хэт явцуу шалгуураар хэмжээсжүүлэн *Арга зүйн зөвлөмж 5-д* дэлгэрэнгүй өгүүлсэн стандартчилагдсан тестэд хэт найддаг.
- Боловсролын нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөө, үр ашгийг үнэлэлгүйгээр боловсролыг ердөө л эдийн засгийг хөгжүүлэх гарц гэж үздэг.
- Нийгэмд эдийн засгийн үр ашиг авчрахгүй суралцагчдыг сургаж буй (жишээлбэл, тэд нар өндөр ур чадвар эзэмшээгүй, өндөр цалин хөлс

<sup>9</sup> Колкло, К. 1993. Хэн төлбөртэй сурах вэ? Боловсролын бодлогыг шинэ-либерал хандлагаар үнэлэх нь, Колкло, К. Манор, Ж. (хамт). *Улс уу, Зах зээл үү?: Шинэ-либерализм болон бодлоо хөгжүүлэх хэлэлцүүлэг*. Оксфорд, Оксфорд Их Сургуулийн Хэвлэл.

<sup>10</sup> Пивзи, Ф. Лингард, Б. 2006. ЭЗХАБ-ын боловсролын асуудлын өөрчлөлт ба даяарчлал. Лаудер, Х., Браун, П., Дилабо, Ж., Халсэй, А.Х. (хамт). *Боловсрол, Даяарчлал, Нийгмийн өөрчлөлт*. Оксфорд, Оксфорд Их Сургуулийн Хэвлэл. Робертсон, С.Л. 2005. Боловсролын ирээдүйг дахин төсөөлөн шинэчлэхүй: дэлхий дахины эдийн засгийн мэдлэгийн дискурс ба боловсролын системийн шаардлага. *Харьцуулсан Боловсрол*, 41:2, хх.151-70.

<sup>11</sup> Боловсролын бодлогын 'зах зээлд чиглүүлсэн' хандлага нь багш нарт хэрхэн сөргөөр нөлөөлж буйд дүн шинжилгээ хийхүй, харна уу, жишээлбэл: Вонгалис, А. 2004. Дэлхий дахины боловсролын бодлогын чиглэл: Хойд болон Өмнийн багш нарт тусаж буй нөлөөлөл. *Олон Улсын Боловсролын Сэтгүүл*.5(4), хх. 488-501

авдаггүй, эсвэл үндэсний эдийн засагт ашиг авчрахгүй нь тодорхой гэж үзэн) боловсролын үнэ цэнийг хүлээн зөвшөөрдөггүй, ойлгодоггүй

Түүнчлэн боловсролын бодлогыг эдийн засгийн бодлого гэх мэт бусад бодлогоос салангид тусад нь авч үзэж болохгүй юм.

Боловсрол, эрүүл мэндийн салбараа хангалттай санхүүжүүлж чаддаггүй эдийн засгийн бодлого нь тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.

Тэгш хамруулан сургах боловсрол нь дан ганц материаллаг байдал, санхүүгийн нөөц бололцоон дээр тулгуурладаггүй (хөрөнгө, мөнгөний хангамж тааруу сургууль, олон нийтийн байгууллагад ч тэгш хамруулах сургалт сайн хөгжсөн байх нь бий) хэдий ч боловсролдоо хангалттай санхүүжилт хийдэггүй зарим орны засгийн газар ихэвчлэн багш боловсролыг чанаржуулах, боловсролын салбарын бүх түвшний суралцагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж чаддаггүй.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:**

- Нийгэм-эдийн засгийн бодлогын боловсролд үзүүлж буй нөлөө нь юу вэ? Хамтын ажиллагаа, нэгдэл нягтрал, тэгш хамруулан сургах боловсролыг дэмжихээс илүүтэй хариуцлага тооцсон, өрсөлдөөн бүхий зөвхөн хувь хүнд чиглэсэн бодлого байна уу?
- Тэгш хамруулан сургах боловсрол, ялангуяа багш боловсролд хөрөнгө оруулалтыг хийхэд яг одоо танай улсын барьж буй чиг бодлого юу вэ? Одоогийн хийж буй боловсролын санхүүжилтэд нийгмийн болоод боловсролын хамран сургалтад сөргөөр нөлөөлөх улс төрийн хүчин зүйл байна уу?
- Танай байгууллагад гадны болон өөрсдийн дотоодын бодлого боловсруулагчдад цэвэр боловсролын 'зах зээлд чиглэсэн' хандлагаас илүүтэйгээр холистик байдлаар тэгш хамруулан сургах боловсролыг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэхэд хэрхэн дэмжин тусладаг вэ?
- Шударга бус, тэгш хамруулан сургах боловсролын бус (үүнтэй холбоотой эдийн засгийн) бодлогод та хэрхэн хандаж асуудлыг шийдвэрлэхэд юу хийж чадах вэ? Энэхүү үйл явцад оролцохдоо өөрийгөө дэмжих байгууллага, хүмүүсийг хэрхэн олж чадах вэ?

## Зөвлөмжүүд

### Бодлогын зөвлөмж 9

*“Үндэсний боловсролын бодлого нь шууд ‘зах зээлд чиглэсэн’ хандлагад баригдалгүй боловсрол бол олон нийтийн сайн сайхны төлөө гэдэг үзэл баримтлалд суурилах нь зүйтэй. Иймд орон нутгийн санхүүжилтэд үүнийг тусгах хэрэгтэй.”*

Боловсрол эзэмших нь хүний үндсэн эрх бөгөөд олон нийтийн сайн сайхны төлөө үйлчилдэг гэсэн үзэл баримтлалаас тэгш хамруулан сургах боловсролын үзэл санаа бий болсон.

Үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчид, багш бэлтгэх сургуулиуд, багш нар, сургууль энэхүү санааг хамтран ажиллаж нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, түүнчлэн хамтын ажиллагааг бодлогын бүх түвшинд дэмжин ажиллах хэрэгтэй. Энд дурдаж буй хамтын ажиллагаанд багш боловсролын байгууллагууд, багш нарын холбоо, НҮБ-ын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Байгууллага, Хүүхдийн Сан, Дэлхийн Банк зэрэг засгийн газар хоорондын байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай хамтран тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх асуудлыг оруулна.

Боловсролын хангалттай санхүүжилт чухал бөгөөд үүний тодорхой хэсгийг тэгш хамруулан сургах боловсролын багшийг бэлтгэхэд санхүүжилтийн төсөвлөх хэрэгтэй. Тухайлбал,

- Багш боловсролын байгууллагууд алслагдмал орон нутгийн, үндэсний болон хэлний цөөнхийн, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг элсүүлэх, илүүтэй дэмжих, нийгмийн тодорхой бүлгийн хүмүүс (жишээ нь: хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэд, ядуус, үндэсний цөөнх, алслагдмал газар амьдардаг хүмүүс гэх мэт)-ийн нийгэмд болон боловсролд тэгш хамруулах санхүүжилтийн механизм бүрдүүлэх .
- Албан болон албан бус багш боловсролын байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих
- Багш мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, үүнд багшийн тасралтгүй хөгжих боломжийг дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх

## Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?

Удирдамж 1-д дурдсанчлан зөвлөмжийг төлөвлөхдөө тодорхой шалгуурууд боловсруулснаар өөрийн ажлын үр дүн, үйл явцыг шалгаж дүгнэхэд тань хэрэг болно. Боловсруулах зөвлөмжийн зорилгоос хамааран шалгуураа боловсруулах шаардлагатай. Шалгуурууд нь төлөвлөгөөтэй төстэй бөгөөд үүнийг сайжруулахад боловсролд оролцогч талуудыг татан оролцуулах хэрэгтэй.



Доорх жагсаалтад нэлээд үр дүнтэй шалгууруудаас санал болгон оруулав. Аливаа зөвлөмж гэдэг нь бодлогыг боловсронгуй болгоход чиглэгддэг тул үүнийг түүнд сайтар бэлтгэхийн тулд засгийн газрын яамд, орон нутаг, дүүргийн боловсрол хариуцсан удирдлага, багш бэлтгэдэг сургуулиуд тэгш хамруулан сургах боловсролын бодлогод доорх санааг тусгавал зохистой. Үүнд:

- Олон улсын, үндэсний, орон нутгийн түвшинд тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг нэгтгэж, засгийн газрын яамд, орон нутаг, дүүргийн боловсролын алба, багш бэлтгэдэг сургуулиуд, ерөнхий боловсролын сургуулиуд эдгээр бодлогын талаар мэдлэгтэй байж үүнийг амьдралд хэрэгжүүлэхэд хамтран оролцох
- Багш боловсрол нь тэгш хамруулан сургах боловсрол хэмээн үзэж тус сургалтын бодлого дээр боловсролын яам, багш бэлтгэдэг сургуулиуд хамтран ажиллах
- Тэгш хамруулан сургах боловсролын хэрэгжилтээр багш боловсролын үйл ажиллагааны өсөлт хөгжилт, боловсролын бодлогод дүн шинжилгээ хийх
- Боловсролын яам болон засгийн газрын бусад яамд (жишээ нь: эрүүл мэндийн яам, нийгмийн хамгааллын яам гэх мэт) нь тэгш хамруулан сургах боловсролын үзэл санаа, ойлголтын талаар нэгдсэн нэг санаа бодолтой байх нэгдсэн чиг хандлагыг боловсролын бодлогын баримт бичигт тусгаж бодит амьдралд хэрэгжүүлэх
- Тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, үнэлэх үйл явцад засгийн газрын яамд, багш бэлтгэдэг сургуулиуд, орон нутаг, дүүргийн боловсролын алба, төрийн болон төрийн бус байгууллагуудыг жигд татан оролцуулах
- Бодлого боловсруулагчид болон бодлого хэрэгжүүлэгчид нь бодлого хэрэгжүүлэх тал дээр нэгдсэн нэг санаа бодолтой байж зөв стратеги боловсруулах
- Тэгш хамруулан сургах боловсролын талаар багш бэлтгэдэг сургуулиуд ижил байр суурь баримталж багшлахуйн арга хандлага, дадлыг хэрэгжүүлэх. Багш бэлтгэх боловсон хүчин, оюутан-багшийн дунд ажиглалт, судалгаа, асуулга явуулах, багш бэлтгэдэг сургуулиуд энэ чиглэлээр харьцуулсан судалгаа хийж мэдээллийг цуглуулах.
- Багш боловсрол мөн боловсролын салбарт оролцогч орон нутгийн төлөөллийн идэвхтэй оролцоог бодлогоор дэмжих
- Боловсролын бодлогыг ойлгох, шинэчлэх, боловсронгуй болгоход орон нутгийн боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
- Боловсролыг зөвхөн эдийн засгийн тулгуур гэж үздэг боловсролын 'зах зээлд чиглэсэн' хандлага нь тэгш хамруулан сургах боловсрол, нийгмийн эсрэг үйлчилдгийг санаж байх
- Боловсролын системийн бүхий л түвшинд боловсрол нь нөөц эх үүсвэртэй, санхүүжилттэй байх

# Хавсралт


Бид дээр дурдсан туршилтын зөвлөмж бүрт тохирсон боломжит хувилбарыг та бүхэнд санал болгон доорх хүснэгтэнд оруулав. Түүнчлэн өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн эдгээр зөвлөмжөөс алийг нь хэрэглэж болох, санаа бодлоо бичихэд тань зориулан зай үлдээв. Боловсролд оролцогч талууд болон хамт олонтойгоо хэлэлцүүлэг хийх явцдаа өөрийн санаа бодлоо баяжуулж байх хэрэгтэй. Зөвлөмжийн талаарх зөвлөгөө, арга барилын талаар Удирдамж-1-ээс дэлгэрүүлэн уншина уу.

Зөвлөмж гэж юу вэ?	Зөвлөмж хэнд зориулагдсан бэ?	Энэхүү зөвлөмжийг өөрийн нөхцөл байдалд хэрхэн нийцүүлж ашиглах вэ?
<p><i>Тэгш хамруулах сургалтад учирч буй бэрхшээлүүдийг ойлгох, тус сургалтыг хэрэгжүүлэх бодлогын стратегийг тодорхойлоход бодлого боловсруулагчид, бодлого хэрэгжүүлэгчид хамтран ажиллах шаардлагатай.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллага</li> <li>• Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд</li> </ul>	
<p><i>Боловсролын бодлого боловсруулахад багш бэлтгэдэг сургуулиуд, орон нутгийн боловсролын байгууллагын идэвхтэй оролцоог дэмжих шаардлагатай.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулийн ажилтнууд</li> <li>• Орон нутгийн боловсролын газар сургууль хамт олон, хөрөнгө оруулагчид</li> </ul>	
<p><i>“Боловсролын бодлогыг ойлгох, өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх процесст орон нутгийн боловсролын байгууллагуудыг татан оролцуулах хэрэгтэй.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн</li> <li>• Сургуулиудын удирдлага</li> <li>• Багш сурган хүмүүжүүлэгчид</li> </ul>	

<p><i>Олон нийтэд олгох боловсрол нь чанартай сайн байх,</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн</li> <li>• Сургуулийн удирдлага</li> <li>• Багш сурган хүмүүжүүлэгч</li> </ul>	
<p><i>“Боловсролд тэгш хамруулах сургалтын талаар баримталж буй одоогийн бодлогыг олон улсын, үндэсний болон орон нутгийн бодлоготой уялдаа холбоог нь сайжруулах шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллага</li> </ul>	
<p><i>““Боловсролын яам, багш бэлтгэдэг сургуулиуд сургалт явуулж буй арга хандлагаа эргэн харж , багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийг тэгш хамруулах сургалтын бодлоготой уялдуулах шаардлагатай.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтэн</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Багш сурган хүмүүжүүлэгчид</li> <li>• Багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллага</li> </ul>	
<p><i>“Боловсролын бодлогыг эргэн харах, боловсронгуй болгох, тэгш хамруулах сургалтыг хэрэгжүүлэх асуудалд нэн ялангуяа багш бэлтгэдэг сургуулиудыг татан оролцуулах нь чухал.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох яамдын мэргэжилтнүүд (эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, сангийн яам, Хөдөлмөрийн яам г.м)</li> </ul>	
<p><i>Боловсролын яам нь, тэгш хамруулах сургалтыг хариуцахын зэрэгцээ тус сургалтын талаарх үзэл санааг бусад яамдын дунд түгээн дэлгэрүүлэх стратегийг хэрэгжүүлвэл зохино.” .”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Холбогдох яамны мэргэжилтэн</li> <li>• Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд,</li> </ul>	

<p><i>“Тэгш хамруулах сургалтын үр дүн нь Боловсролын яам болон багш бэлтгэдэг сургуулиуд, төрийн болон төрийн бус байгууллага хоорондын тогтвортой хамтын ажиллагаанаас хамаарна. .”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Нийслэл орон нутгийн түвшний боловсролын байгууллагын удирдлага</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Төрийн бус байгууллага</li> </ul>	
---	---	--

\* Зөвлөмж 1-д өгүүлсэн зөвлөгөөнд үндэслэн өөрийн санаа бодлоо бичнэ үү.



## Зөвлөмж 3-Хөтөлбөр

3

Хөтөлбөр

## Удиртгал

Хөтөлбөр хэмээх энэхүү зөвлөмж нь тэгш хамруулан сургах боловсролын багшийг бэлтгэхэд чиглэсэн 5 удирдамжийн гутгаар нь юм. Үүнийг “Удирдамж”, “Бодлого”, “Хэрэглэгдэхүүн”, “Арга зүй” зэрэг бусад 4 удирдамжтай хамт буюу дангаар нь ч ашиглах боломжтой.

Энэхүү зөвлөмжид багш бэлтгэх хөтөлбөрт тулгамдаж буй асуудал, бэрхшээлд гол анхаарлыг хандуулахыг зорьсон. Иймээс боловсролын яам, багш бэлтгэдэг сургуулиуд, мөн бусад сонирхлын гол бүлгүүдэд тэгш хамруулан сургах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд шаардлагатай стратегийн шийдэл, шийдвэрлэх арга замыг санал болгож байгаагаараа онцлог юм.

### Хөтөлбөрийг бид хэрхэн ойлгох вэ?

Энэхүү зөвлөмжид бид “Хөтөлбөр” гэдэг нэрийн дор дунд сургуулийн суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөр бус, харин багш бэлтгэх хөтөлбөрийг авч үзэж байгааг дурдах нь зүйтэй.

Хөтөлбөр гэдэг аливаа зүйлийг хийж сурахын тулд тавьсан зорилгодоо хүрэхийн тулд сурах үйлийг бүтэцчилэн зохион байгуулах нэгэн төрлийн арга юм. Үүнд юуг сурах, яагаад сурах, мөн энэхүү сурах үйлийг хэрхэн дэмжих, хэрэгжүүлэх зэрэг асуудал багтана. Цаашилбал хөтөлбөр нь өргөн утгаараа нийгэм, улс төр, сургууль, багш нарын харилцаа, хамтын ажиллагааны тусгал болдог гэдэг утгаараа аливаа ялгаварлан гадуурхал үгүй, эрх тэгш нийгэм бүтээн цогцлоох тухайн улс орны хүсэл эрмэлзлэлийг илтгэдэг.<sup>1</sup>

Энэхүү удирдамж нь тэгш хамруулан сургах асуудлыг дараах байдлаар хөтөлбөртэй хамааруулан авч үзнэ. Үүнд:

- Тэгш хамруулан сургах сургалтын хөтөлбөр: багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулан сургах асуудал, мөн суралцагч-төвтэй хамруулан сургах сургалтын хандлага, арга зүй зэрэг нь тусгалаа олсон, суралцагчдын ялгавартай хэрэгцээ, шаардлагад нийцсэн, уян хатан байна
- Хөтөлбөр боловсруулахад ашиглах тэгш хамруулан сургах хандлагууд: тэгш хамран сургах боловсролын багшийг бэлтгэх хөтөлбөрийг боловсруулахад эцэг эх, багш, суралцагчид, асран халамжлагчид, багш бэлтгэдэг сургуулийн багш нар зэрэг сонирхлын бүх бүлгийн төлөөллийг тэдний нас, хүйс, орон нутгийн байршил зэргийг харгалзан тэгш зарчимд тулгуурлан идэвхтэй оролцуулна.

<sup>1</sup> Браславский.С.1999. “Тэгш хамран сургах хөтөлбөр болон багшийн бэлтгэлийн бүс нутгийн хэлэлцүүлэг”, Боловсролын олон улсын 48-р бага хурлын илтгэл, Женев, 2008

## Багш бэлтгэх хөтөлбөр яагаад чухалаар

### тавигдаж байна вэ?

Багш боловсрол, ялангуяа багш бэлтгэх хөтөлбөр нь ирээдүйн багшийн мэдлэг, цогц чадамж, хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс тэгш хамруулан сургах боловсролыг дэмжие гэвэл оюутан-багш нарт мэргэжлийн боловсролын анхны өдрөөс сургалтыг дуустал хамруулах сургалтын арга зүй, зарчмуудад тулгуурлан сурах, сургах үйлийг зохион байгуулах мэдлэг, чадвар, туршлага хуримтлуулах боломж олгох нь маш чухал байна.

Ихэнх улс оронд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр багш нарын мэдлэг, чадварыг мэргэжил дээшлүүлэх тогтолцоогоор ихэнхдээ хийж байна. Мэдээж энэ нь тухайн чиглэлийн мэдлэг, чадвар олж авах боломжгүй байсан багш нарыг сургах, мөн энэхүү чиглэлээр багш нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх зорилгын үүднээс ач холбогдолтой байна. Гэсэн хэдий ч багш бэлтгэх хөтөлбөр, багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа хоёрт хоёуланд нь тухайн асуудал тодорхой байр суурийг эзэлж байж үр дүн гарна. Үнэн хэрэгтээ багш бэлтгэх үндсэн хөтөлбөрөөр ирээдүйн багш нарт суурь мэдлэг, чадвар эзэмших, туршлага хуримтлуулах боломж олгох, цаашид энэ чиглэлээр олж авсан мэдлэг, чадварыг мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаагаар гүнзгийрүүлэх нь илүү үр дүнтэй байна.

Хэдийгээр тэгш хамруулан сургах асуудлыг багш бэлтгэх хөтөлбөрт оруулах нь зарчмын том өөрчлөлт боловч үүгээр бүх асуудал шийдэгдэнэ гэж үзвэл бас хангалтгүй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад олон асуудал тулгарна. Удирдамжийн энэхүү хэсэгт бид сүүлийн үеийн судалгаагаар олж тогтоосон зарим бэрхшээлийг танилцуулж байна<sup>2</sup>. Эдгээр нь:

- Тэгш хамруулан сургах асуудлыг багш бэлтгэх хөтөлбөрийн нэгэн бүрэлдэхүүн гэж үзэлгүй салангид асуудал болгон авч үзэх
- Тэгш хамруулан сургах асуудлыг өргөн утгаар нь бус, зөвхөн хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээгээр хязгаарлаж ойлгох
- Тэгш хамруулан сургах сургалтыг үр өгөөжтэй, практик дадал, чадварт суурилсан хөтөлбөрөөр бус, харин онол давамгайлсан хөтөлбөрөөр зохион байгуулах
- Багш бэлтгэх сургуулийн багш нар болон хөтөлбөр боловсруулагчид энэ талаарх хангалтгүй мэдлэг, чадвартай байгаа нь тэгш хамруулах сургах асуудлыг багш бэлтгэх хөтөлбөрт сайтар интеграцчилан оруулахад саад учруулах
- Багш бэлтгэх хөтөлбөрт буй тэгш бус, ялгаварлан гадуурхах байдал, түгээмэл тааралдах ташаа ойлголт, буруу хэвшил

<sup>2</sup> Тухайлбал, (i) Форкагс, Р. 2012 “2015 он хүртэлх Багш боловсролын хөгжил”, Бангкок, ЮНЕСКО; (ii) “Чадваржуулах боловсролын сүлжээ (EENET)”, ЮНИСЕФ

Та бүхэн өөрийн орны онцлог нөхцөлд тэгш хамруулан сургах боловсролын ямар асуудлууд тулгарч буйг олж тогтоон шийдвэрлэх арга замыг хайх нь зүйтэй. Энд танилцуулж буй зүйл бол багш бэлтгэх хөтөлбөрт тухайн асуудлыг хэрхэн тусгах тухай бөгөөд энэ нь шууд дагаж мөрдөх жор биш юм.

## Бэрхшээл 1

### Тэгш хамруулан сургах асуудал нь багш бэлтгэх хөтөлбөрийн нэгэн хэсэг болох нь:

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Тэгш хамруулах сургалтыг тусгайлан зохион байгуулах ёстой хэмээн үздэг явдал элбэг тохиолддог.*

Ихэнх тохиолдолд тэгш хамруулан сургах асуудлыг багш мэргэжлийн үндсэн хөтөлбөрт интеграцчилан оруулаагүй учраас окутан-багш нар мэргэжлийн үндсэн сургалтынхаа явцад энэ талаар сурч мэдэх боломжгүй байдаг. Харин тухайн чиглэлийг хөтөлбөртөө оруулсан сургуулиудын хувьд энэ нь ихэнхдээ “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах”, “тусгай хэрэгцээт боловсрол” зэрэг нэртэй салангид, тусдаа курс хичээл эсвэл модуль байдаг. Зарим тохиолдолд эдгээр нь сонгох хичээлийн багцад байдаг учраас окутнуудын үндсэн дүнд бага нөлөөлдөг гэдэг утгаараа тэд тэр бүр сонгон судалдаггүй. Энэ байдал нь тэгш хамруулан сургах асуудлыг багш бүр сайтар мэддэг байх ёстой гэдэг утгаараа бус харин мэргэжлийн хүний ажиллагаа шаардсан, тусдаа асуудал хэмээн ойлгож ирснийг гэрчилж байна. Иймээс шинээр бэлтгэгдсэн багш нар тэгш хамруулан сургах асуудлыг сайтар мэддэггүй, суралцагчдынхаа ялгавартай, янз бүрийн хэрэгцээ бүхий орчин нөхцөлд ажиллах бэлтгэлгүй, зарим талаар хүсэлгүй байх тохиолдол бий. Суралцагчид нь нас, хүйс, яс үндэс, соёл, нийгмийн байдал, хэл зэрэг олон зүйлээр бие биеээсээ ялгаатайг багш нар сайтар ойлгох хэрэгтэй.

*Багш бэлтгэх хөтөлбөрийн сул тал нь тэгш хамруулан сургах асуудлыг багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо руу шилжүүлэхээс аргагүйд хүргэдэг.*

Багш бэлтгэх хөтөлбөрт тухайн асуудал ул суурьтай тусгалаа олоогүйгээс дээрх чиглэлээр багшийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаагаар нөхөн олгож байна. Иймэрхүү “гал унтраах” маягийн арга хэмжээ нь төдийлөн үр өгөөжтэй, ашигтай байж чадахгүй нь ойлгомжтой.



Энэ нь багш нарыг ажлаас нь хөндийрүүлэн тэднийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, мөн сургалтын зардал, багшийн хөлс гэх мэт зардал гардагтай холбоотой. Түүнчлэн зардалтай холбоотойгоор багш болгон тэр бүр хамрагдах боломжгүй байдаг. Бага зардлаар олон багшийн мэргэжлийг дээшлүүлэхэд каскад загвар<sup>3</sup> илүү үр дүнтэй хэмээн өргөн хэрэглэдэг. Гэвч сүүлийн үед хийгдэж буй үйл ажиллагааны үр дүн нь тэгш хамруулан сургах асуудлыг дан ганц мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд үүрүүлэх нь ач холбогдол багатайг нотолсоор байна.

Вьетнам улсын Боловсрол, сургалтын яам, Catholic Relief Services хамтран 1 долоо хоногийн хугацаатай багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. 2008 он гэхэд тус оронд багшилж буй нийт 944,000 багшийн 2.8% -ийг сургасан байна<sup>4</sup>. Энэ нь 26,000 багш болж байгаа бөгөөд харьцангуй олон багшийг богино хугацаанд сургасан амжилт боловч ерөнхий цар хүрээ, хүртээмжээр нь авч үзвэл дан ганц мэргэжил дээшлүүлэх тогтолцоогоор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүйг харуулж байна. Мөн тухайн чиглэлийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг багш бүр тэр бүр уриалгахан хүлээж авахгүй тохиолдол ч гарна. Олон жилийн туршлагатай багш нарт ийм зүйлийг мэдэхгүй байна, чадвар дутаж байна, мэргэжлээ дээшлүүлэх шаардлагатай гэхэд төдийлөн дуртай хүлээж авахгүй байх, түүнчлэн тэгш хамруулан сургах асуудлыг өөрсдийн ажил үүргээс гадуур, нэмэлт ачаа мэт хүлээж авах хандлага ажиглагддаг.

### Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:

- Багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулах сургалтыг тусдаа курс хичээл, модулиар зохион байгуулдаг уу? Эдгээр хичээлийн агуулга нь ямар байдаг вэ? Хамруулан сургах арга зүй, хандлага нь тухайн хичээлд интеграцчилан орсон байдаг уу?
- Оюутан-багш нар тэгш хамруулан сургах хичээлийг заавал сонгох ёстой юу?
- Оюутан-багшийн нийт үнэлгээнд тухайн хичээлийн үнэлгээ нь бусад хичээлтэй адил жинтэй тооцогддог уу?
- Улсын хэмжээнд тэгш хамруулан сургах асуудал багш бэлтгэх, мөн багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хэр зэрэг тусгалаа олсон байдаг вэ? Эдгээр хөтөлбөр нь хичнээн багш, оюутан-багшид хүрсэн бол?
- Хамруулан сургах чиглэлээр зохион байгуулж буй мэргэжил дээшлүүлэх сургалтуудад үнэлгээ хийдэг үү? Тухайлбал, багш нар хэр нааштай хүлээж авсан, үр дүнд нь сургалтад ямар өөрчлөлт гарсан, хэр хэмжээнд сайжирсан гэх мэт. Багш бэлтгэх хөтөлбөрт энэ нь ямар байна вэ?

<sup>3</sup> Үүнийг янз бүрийн хэлбэрээр зохион байгуулж болно. Сургагч багш нарыг дунд түвшний сургалтад хамруулж, эхлэн суралцагчдад заалгаж болно. Зарим тохиолдолд цөөн тооны сургагч-багшийг бэлтгээд бусад нь заалгаж болно.

<sup>4</sup> Форлин, С. Нгуйет, ДТ. 2010. "Оюутан-багш нарыг тэгш хамруулах боловсролын чиглэлээр бэлтгэхэд багш нарт үзүүлэх үндэсний стратеги"

## Зөвлөмжүүд

### Хөтөлбөрийн зөвлөмж 1.

*“Багш бэлтгэгдээ боловсролын бүх байгууллага, үүн дотроо коллеж, их дээд сургуулиуд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр бүх багшийг сургах шаардлагатай”.*

Тэгш хамруулан сургах асуудлыг хөгжлийн бэрхшээл, ялгавартай сургалт, тусгай хэрэгцээг сонирхож буй цөөн тооны оюутанд сонголтоор ордог зүйл огт биш юм. Харин ямар ч сургуульд, боловсролын ямар ч түвшинд, ямар ч хичээлийг заадаг бай багш бүр энэ чиглэлээр бэлтгэгдсэн байх ёстой. Иймээс багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж буй оюутан-багш бүрийг тэгш хамруулах сургалтын агуулга, арга зүйг судлах боломж олгох нь чухал байна.

Зарим оюутны хувьд хүүхдийг тэгш хамруулан боловсрол эзэмшүүлэх, нийгмийн эрх тэгш ёс, шударга ёс үйлчлэх ёстойг ойлгож ухамсарладаг ч тэдэнд үүнийг бодит амьдрал дээр ажил хэрэг болгоход туслалцаа хэрэгтэй. Харин зарим оюутны хувьд энэ нь өмнө нь бодож байгаагүй цоо шинэ зүйл, зарим талаар айхгүй ч аягүй зүйл байж болох талтай. Ийнхүү оюутан-багш бүр өөр өөрийн ойлголттой байгааг харгалзан багш бэлтгэх хөтөлбөрийг зохион байгуулах, үүнд шаардлагатай бол эргэцүүлэл, үнэлгээ зэргээр хандлагаа өөрчлөхөд нь туслах, цаашилбал практик мэдлэг, чадвар олж авахад чиглүүлэх нь маш чухал ач холбогдолтой байна.

### Хөтөлбөрийн зөвлөмж 2

*Багш боловсролын хөтөлбөрт буй бүх хичээл, модульд тэгш хамруулан сургах, эрх тэгш байдал, хүний эрхийн асуудлыг тусгаасан байна.*

Ирээдүйн багш нарт тэгш хамруулах боловсрол эзэмшүүлэхэд одоогийн зааж буй салангид хичээл, модулийн агуулгыг өргөтгөн гүнзгийрүүлэх нь хангалтгүй. Тэр байтугай тухайн хичээлийг заавал судлах хичээл болгоод ч хангалтгүй. Тэгш хамруулан сургах асуудал нь гагцхүү боловсролын салшгүй нэгэн хэсэг болох, ялангуяа багш бэлтгэх хөтөлбөрийн бүрэлдэхүүн, нэгж бүрт шингэж орж байж байдал өөрчлөгдөнө.

Хичээлийн хөтөлбөр, модуль бүр эрх тэгш байдал, мөн бүх хүүхдийг хамруулан сургах асуудлыг тусгаад зогсохгүй бодит практикт үүнийг сурах, сургах үйлээр хэрхэн хэрэгжүүлэхийг жишээлэн үзүүлэх шаардлагатай. Түүнчлэн хичээл бүрээр оюутан-багшид суралцагч бүрийг хэрхэн сургах, сургалтыг хэрхэн тэгш хамруулах арга зүйд тулгуурлан зохион байгуулах бодит мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэх ёстой. Хэрэв энэхүү асуудал нь багш бэлтгэх хөтөлбөрийн өдөр тутмын практикт биеллээ олж, тодруулбал багш бүр өдөр тутмын сургалтдаа үүнийг

ярьж, хэрэгжүүлж байх юм бол дээрх асуудал нь тусгай, онцгой гэхээсээ илүүтэй боловсролд зайлшгүй байх ёстой энгийн асуудал болон хувирч эсэргүүцэл, үйл ойлголцолтой тулгарах нь багасаж, харин ч асуудалд уян хатан ханддаг, бүтээлч багш нар шинээр бэлтгэгдэх асар том боломж бий болно.

Дээрх байдлаар тэгш хамруулан сургах асуудлыг боловсролын салбарт интеграцчилан өөрчлөхөд олон улс оронд маш том зарчмын өөрчлөлтийг багш бэлтгэх хөтөлбөртөө хийх шаардлагатай. Мэдээж үүнд хөтөлбөр боловсруулагчид болон хөтөлбөрийг гардан хэрэгжүүлэх багш нарын чадавхийг дээшлүүлэх асуудал чухал үүрэгтэй байна.

Багш бэлтгэх хөтөлбөрийг дээрх чиглэлээр өөрчлөхөд ганц нэг удаагийн арга хэмжээ хангалтгүй. Иймээс “Хөтөлбөрийн зөвлөмж 2”-рт заасан зүйлийг хэрэгжүүлэх боломжтой, бодитой, ойрын зорилт байдлаар жижиглэн томъёолох нь ач тустай байна. Түүнчлэн зөвлөмжүүд нь салангид бие даасан зорилтууд биш юм. Тодруулбал, хоёрдугаар зөвлөмж нь бэрхшээл 4-тэй нарийн холбоотой. Иймээс багш бэлтгэх хөтөлбөрт өөрчлөлт хийхийн тулд маш нарийн боловсруулсан, стратегийн төлөвлөгөө чухал байна.

## Бэрхшээл 2

**Тусгай хэрэгцээт боловсролоос тэгш хамруулан сургах сургалт руу шилжих нь**

**Нөхцөл байдлын шинжилгээ**

*Өнгөцхөн өөрчлөлт*

Улс орнуудын боловсролын яам, багш бэлтгэх сургуулиудаас тэгш хамруулах боловсролыг түлхүү оруулах арга хэмжээ авахдаа эргээд л “тусгай хэрэгцээт боловсрол”, “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсрол” зэрэг нэртэй хичээлүүдийг оруулдаг. Хичээлийн нэрийг өөрчилж болно. Гэхдээ эцсийн зорилго нь зөвлөмж 1-т тодорхойлсны дагуу тухайн асуудалд, суралцагчдад холистик үзлээр хандаж байж өөрчлөлт хийж чадна. ЮНЕСКО (Бангкок)-оос багш бэлтгэх хөтөлбөрт хийсэн судалгаагаар “багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулан сургах асуудал тулгуур концепцийн хувьд байхгүй байна”<sup>5</sup> хэмээн ерөнхийд нь дүгнэжээ. Зарим улс оронд тэгш хамруулах сургалтад зөвхөн “тусгай хэрэгцээтэй” болон “хөгжлийн бэрхшээлтэй” хүүхдэд хамааралтай сэдвүүдийг оруулж байгаа нь хангалтгүй<sup>6</sup>.

<sup>5</sup> Форгакс, 2012, 29 х

<sup>6</sup> Форгакс, 2012, 30 х

Ялангуяа тэгш хамруулан сургах хөтөлбөрт хүйсийн тэнцвэртэй байдал, олон хэлний боловсролын асуудал дийлэнх орны хөтөлбөрт тусгалаа олоогүй байна<sup>7</sup>. Тухайлбал зарим оронд багш бэлтгэх сургуулиудын хөтөлбөрт хүйсийн асуудлыг эсвэл огт оруулалгүй, эсвэл бүхий л хөтөлбөртөө тусгаагүй, салангид хичээлээр тусгайлан оруулж байна.<sup>8</sup>

Зарим тохиолдолд хичээлийн нэр, агуулгыг өөрчлөөгүй, тухайлбал оюутан-багшид “тусгай боловсрол” нэртэй хичээл орсоор байгаа бөгөөд үүнд тэгш хамруулах боловсрол огт дурдагдахгүй байна.<sup>9</sup>

Цаашилбал зөвхөн багш бэлтгэх сургуулиуд дээрх бэрхшээлтэй тулгарч байна гэвэл үгүй юм. Тэгш хамруулан сургах асуудлыг зөвхөн “тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээл” зэргээр төлөөлүүлэн ойлгож байгаа нь засгийн газар, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын хандлага, мөн тэдгээрийн боловсруулсан бодлого, удирдамж, зөвлөмжид ч илэрхий байсаар байна. Тэгш хамруулах сургалтын асуудал анхнаасаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, суралцагчдын сурах эрхийг хангах, хамгаалах хөдөлгөөнөөс үүсэлтэй тул мэдээж хөгжлийн бэрхшээлийн асуудлыг авч үзэх нь ойлгомжтой. Гэхдээ бодлого боловсруулагчид, практик үйл ажиллагааг гардан зохион байгуулж буй багш нарын хэн хэн нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах асуудал бус, харин бүх суралцагчдад дэмжлэг үзүүлэх асуудал тул хөтөлбөрт ийм байдлаар тусгахын ач холбогдлыг ойлгох нь чухал байна.

Ази, Африкийн 4 орны засгийн газрын бодлого, стратегийн төлөвлөгөөний үнэлгээний тайланд *“бодлогын баримт бичгүүдэд тусгай боловсрол, интеграцчилсан боловсрол, тэгш хамруулах боловсрол зэргийг хольж хутгасан, түүнчлэн сүүлийн асуудлыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамааруулан ойлгодог дутагдал байна”* хэмээн дүгнэжээ<sup>10</sup>.

### **Хөтөлбөрөө шинэчлэлд хандах**

Багш бэлтгэх хөтөлбөрт буй тусгай хэрэгцээт боловсролын асуудлыг зохион байгуулж буй арга, хэлбэр нь үүнийг тусдаа байх ёстой, мэргэшсэн багш заах хичээл гэдэг санааг улам бататгаж байна. “Багш бэлтгэх хөтөлбөрт зааж буй тусгай хэрэгцээт боловсролын хичээл нь тусдаа, бие даасан хичээл байх ёстой бөгөөд зөвхөн энэ чиглэлээр мэргэшсэн багш тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах ёстой гэсэн санааг улам дэмжиж байна”.<sup>11</sup> Энэхүү байдалд эрх мэдэл чухал үүрэг гүйцэтгэж байгааг хэлэх нь зүйтэй. Зарим багш бэлтгэдэг сургууль тусгай сургуульд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш бэлтгэж, үүгээрээ дагнан мэргэшсэн байдаг. Ийм тохиолдолд хүүхдийг тэгш

<sup>7</sup> ЮНЕСКО, 2012. “Ази, Номхон далайн орнууд: чанартай багш боловсролоор тэгш хамруулах боловсролд хүрэх”, ЮНЕСКО-ийн бүсийн зөвлөхүүдийн уулзалтын тайлан, Бангкок, 23 х

<sup>8</sup> Форкакс, 2012, 32 х

<sup>9</sup> Форкакс, 2012, 30 х

<sup>10</sup> Льюис, 2007. “Непал, Танзани, Вьетнам, Замби зэрэг орнуудын тэгш хамруулах боловсролын бодлого, төлөвлөгөөнд хийсэн судалгаа”, [http://www.eenet.org.uk/resources/docs/Policy\\_review\\_for\\_NORAD.pdf](http://www.eenet.org.uk/resources/docs/Policy_review_for_NORAD.pdf)

<sup>11</sup> “Тэгш хамруулах сургалтын багш боловсрол: олон улсын судалгааны тойм”, Тусгай хэрэгцээт боловсролын Европын хөгжлийн агентлаг, 2009, 596 х

хамруулан сургах асуудлыг бүх багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөрт оруулж багш бүр заах чадвартай байна гэхээр дээрх сургуульд зааж буй хөтөлбөр, бэлтгэсэн багш нарын эрх мэдэл халдаж буй мэт таагүй хүлээж авах тохиолдол гарна.

Цаашилбал, эдгээр сургууль нь тухайн улс орны хэмжээнд нэр хүндтэй, шийдвэр гаргах эрх мэдэлтэй бол тэдгээрийн бодол хандлагыг өөрчлөх, хөтөлбөрөө шинэчлэх шаардлага тавихад бүр ч их бэрхшээлтэй байх нь ойлгомжтой. Түүнчлэн тэгш хамруулах сургалт зохион байгуулж буй сургуулийн багш нар ч гэсэн тухайн чиглэлийг өргөн утгаар нь буюу хүйсийн тэгш байдал, цөөнхийн хэлний бэрхшээл, хүний эрхийн асуудлыг хөтөлбөртөө оруулах шаардлага тавихад өөрсдийн тусгай курс хичээлтэй байхыг илүүд үзэх, дүргүйцэх магадлал байсаар байна.

### Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:

- “Тэгш хамруулах сургалт” нэртэй хөтөлбөрт тань бүх суралцагчдыг хамруулан боловсрол олгох асуудал өргөн утгаараа тусгалаа олсон уу? Эсвэл зөвхөн “тусгай хэрэгцээ”, “ хөгжлийн бэрхшээл”-д илүү анхаарч байна уу?
- Тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад заахаар мэргэшсэн багш нар, бусад багш нар хамтран ажилладаг уу? Эсвэл тэдний хооронд үйл ойлголцол, өрсөлдөөн байдаг уу?
- Багш бэлтгэх сургуулийн удирдлага, багш нар тэгш хамруулах боловсролын асуудлаар нэгдсэн ойлголт, эерэг хандлагатай байдаг уу? Эсвэл хөтөлбөрийг өөрчлөх, шинээр хичээл оруулах, байгаа хичээлийг өөр хичээлээр солих зэрэгт дургүйцдэг үү?

## Зөвлөмжүүд

### Хөтөлбөрийн зөвлөмж 3.

*Багш бэлтгэх сургуулийн багш нар, хөтөлбөр боловсруулагчид тусгай хэрэгцээ болон тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр мэдлэг, ойлголт тасралтгүй дээшлүүлж байх ёстой.*

Тэгш хамруулах сургалтын талаарх буруу ташаа, хязгаарлагдмал ойлголт амь бөхтэй байсаар байвал ирээдүйн багш нар буюу оюутан-багш нар түүнийг тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад заах асуудалтай хольжхутган, тодорхойгүй ойлголт авсаар байх болно. Иймээс хөтөлбөр боловсруулагчид, түүнийг хэрэгжүүлж буй багш бэлтгэх сургуулийн багш нар тухайн чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэх янз бүрийн ажиллагаанд тасралтгүй хамрагдаж байх нь чухал байна. Тухайлбал:

- Багш боловсролын судалгааны ажилд түлхүү оролцуулж багш бэлтгэх хөтөлбөрийг шинэ мэдээлэл, туршлагаар баяжуулж байх
- Багш нарын тэгш хамруулах сургалтыг илүү үр өгөөжтэй заах, хөтөлбөрөө боловсронгуй болгож байх боломж бүрдүүлэх үүднээс тэдний мэргэжлийн мэдлэг, чадварыг тогтмол дээшлүүлж байх

#### **Хөтөлбөрийн зөвлөмж 4.**

*Багш бэлтгэх сургуулиуд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр өөрчлөлт, шинэчлэлийг өөрсдөөсөө байгууллагаасаа эхэлж хөтөлбөртөө тусгасан байна.*

Ирээдүйн багш нарт шинэ мэдлэг, чадварыг эзэмшүүлэх гэдэг утгаараа багш боловсрол нь боловсролын салбарт хийгдэж буй шинэчлэлд голлох үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ шинэчлэлийг сургуулиуд өөрсдөөсөө эхлэх нь зүйтэй. Аливаа өөрчлөлт, шинэчлэлийг хийхэд өөрсдөө хүсэл эрмэлзэлтэй, нээлттэй байх нь чухал. Тухайлбал:

- Багш нарт сурах, мэргэжлээрээ хөгжих олон хувилбарт боломжуудыг олгож хөтөлбөрөө тасралтгүй шинэчлэн сайжруулдаг байх
- Багш нарт бусад орны, болон сургуулиудын туршлагаас суралцах, тэгш хамруулах сургалтын чиглэлээр олон улсын хэлэлцүүлэгт оролцох боломж олгох
- Багш бэлтгэх сургуулийн багш нарыг сургалтаа чанартай зохион байгуулах, оюутан-багш нарыг илүү үр өгөөжтэй сургахад тэднийг хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй хүмүүстэй ажиллаж туршлага хуримтлуулах боломжоор хангах
- Багш нарын хийсэн судалгаа, шинэлэг санаа, арга туршлагыг хүлээн зөвшөөрөх, бусадтай хуваалцах механизм бүрдүүлэх гэх мэт.

#### **Хөтөлбөрийн зөвлөмж 5.**

*Засгийн газраас багш бэлтгэх бүх сургуулийн хөтөлбөрт тэгш хамран сургах асуудлыг тусгах заалт бүхий багшийн стандарт боловсруулах, мөрдөх*

Засгийн газраас багш бэлтгэдэг бүх сургуулийн хөтөлбөрт тэгш хамруулан сургах асуудлыг оруулж, оюутан-багш нарын энэ чиглэлээр сайтар бэлтгэхэд хяналт тавих, анхаарах нь зүйтэй. Хэдийгээр багш бэлтгэх хөтөлбөрт хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээ, үндэстний цөөнхийн боловсрол зэргээр илүү нарийвчлан сургах хичээлүүд байж болох ч цаг үеийн гол шаардлага бол оюутан-багш бүрийг хамрах бүх үндсэн хөтөлбөрүүдэд дээрх асуудлыг оруулах явдал юм.

Үүнийг хэрэгжүүлэхэд засгийн газрын зүгээс тухайн чиглэлээр багш бэлтгэх сургууль болон багш нарын чадавхийг дээшлүүлэхэд нэлээд дэмжлэг хэрэгтэй. Том өөрчлөлтийг нэг дор хийх боломжгүй тул үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хийх нь илүү үр дүнтэй байна. Тухайлбал, эхлээд боловсролын яамны ажилтан, мэргэжилтнүүдэд тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулж тэднийг сургавал цаашид багш бэлтгэх сургуулиудын хөтөлбөрийн чанарт үнэлгээ өгөх, стандартын хэрэгжилтийг хянах, зөвлөгөө өгөхөд илүү үр өгөөжтэй байна.

## Бэрхшээл 3

### Онол практикийн зохистой харьцааг хангах нь

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Хичээлүүдэд онол давамгайлсан*

Багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулан сургах хичээлүүд нь хэт онолжсон буюу тэдгээрт онол давамгайлсан байх нь олонтаа. Мэдээж аливаа нэгэн ухагдахуун, үзэгдлийн ард онолын ямар үндэслэл байгааг бид зайлшгүй мэдэх ёстой. Гэхдээ тэгш хамруулан сургах асуудал нь энгийн концепци биш бөгөөд задлан шинжилгээ, эргэцүүлэл зэрэг ажиллагаа, цаг хугацаа шаардсан үйл ажиллагаагаар түүнийг тусгай хэрэгцээт боловсрол болон боловсролын бусад асуудлуудаас ямар ялгаатайг илрүүлэн, түүний мөн чанар, онцлогийг ойлгох боломжтой. Ерөнхийдөө тухайн асуудлыг бид бодит практикт ажиглаж, өөрсдөө хийж туршиж байж илүүтэй ойлгодог өөрийн онцлогтой. Харамсалтай нь дэлхийн ихэнх улс оронд зохион байгуулж буй багш боловсрол нь оюутан-багшид ажлын талбарт гарахаас нь өмнө боловсролд тэгш хамруулах чиглэлээр бодит туршлага хуримтлуулах боломж олгохгүй.

ЮНЕСКО-ийн багш боловсролд хийсэн үнэлгээний тайланд “Багш бэлтгэх хөтөлбөр нь багшийн чадамжийг хөгжүүлэхээс илүүтэй агуулгад суурилсан байна” хэмээн дүгнэжээ. Үүнийг Ази, Номхон далайн орнуудын “Багшийн чанартай боловсролоор тэгш хамруулах боловсрол руу” хэмээх ЮНЕСКО-ийн бүс нутгийн уулзалт (2012 оны 7-р сар)-аар дахин баталгаажуулсан байна. Тухайлбал, зарим орны хувьд “...багш бэлтгэх хөтөлбөрийн тэгш хамруулах сургалтад онол хэт давамгайлах хандлага байна. Үүнээс улбаалан шинээр төгссөн багш нарын танхимын сургалтаар олж авсан, сурсан зүйл, бодит амьдрал хоёрын хооронд том зөрөө гарч байна” хэмээн дүгнэсэн байна.

Ийнхүү дэлхий нийтийн хэмжээнд багш боловсрол болон бодит амьдралын хэрэгцээ, нөхцөл байдлын хооронд гарч буй энэхүү зөрөөтэй асуудал нь оюутан-багшид танхимын сургалтаар олж авсан онолын мэдлэгээ практик үйл ажиллагаагаар шалган баталгаажуулж, туршлага хуримтлуулах боломж бага

байгаагаас үүдэлтэй байна.

*Бодит амьдралд тулгардаг асуудлыг шийдвэрлэхэд оюутан-багш нарт дэмжлэг дутагдаж байна.*

Тэгш хамруулах боловсрол нь бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн, хялбар зүйл биш бөгөөд харин тасралтгүй өөрчлөн, сайжруулж байх үйл явц юм. Түүнчлэн хичээл зааж буй багш нар нь тухайн чиглэлээр мэргэшсэн эксперт байх албагүй бөгөөд тулгамдаж буй асуудлыг соргогоор олж харан тодорхойлох, үр өгөөжтэй байгаа туршлагыг хэрэгжүүлэн хөгжүүлэх чадвартай байх ёстой.

Асуудал шийдвэрлэх чадварыг зөвхөн лекцээр зааж, эсвэл номноос уншаад олоод авчихдаг зүйл биш юм. Үүнийг зөвхөн практикаар буюу туршин хийж үзэж байж багш өөртөө бий болгодог. Харамсалтай нь багш бэлтгэх хөтөлбөр, үүн дотроо тэгш хамруулах сургалт нь оюутан-багшид туршлагажих боломж, тодруулбал, ажиглалт, гар бие оролцож хийж үзэх боломж хангалттай өгч чадахгүй байна. Багш бэлтгэх боловсролд онолд суурилсан сургалт голлож харин практикт тулгуурласан сурах үйл нь орхигдож, дагалдах маягтай байна. Үүнд:

Оюутан-багшийн мэдлэг, чадварын үнэлгээнд тэгш хамруулах сургалтын агуулга, арга зүйн мэдлэг, чадварын эзлэх жин бага байгаатай холбоотой.

Түүнчлэн багш бэлтгэх хөтөлбөр нь оюутан-багш нарыг суралцагч бүрийн сурах хэрэгцээ, давуу болон сул талыг тодорхойлох удирдамж, заавраар хангаж өгч чадахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг оношлох, тэдэнд дэмжлэг үзүүлэх техникийн гэмээр тусгай курс, хичээл байдаг (эдгээр нь ихэвчлэн тусгай сургуульд ажиллах, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах сонирхолтой багш, оюутан-багшид зориулсан). Гэвч жирийн сургалттай сургуулийн суралцагчдын олон янзын хэрэгцээг хүүхэд бүрээр тодорхойлох мэдлэг, чадварыг бүх багшид эзэмшүүлэх сургалт үгүйлэгдсээр байна.

Суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд багш нарын ажиллаж, амьдарч буй сургалтын болон нийгмийн орчин нөхцөл, өөрсдийн үүрэг хариуцлага, практик үйл ажиллагааг шүүн тунгаах, эргэцүүлэх чадвараас ихээхэн шалтгаална.

*Сургалтын хөтөлбөр нь номлож буй зүйлээ практикт хэрэгжүүлэх талаас хангалтгүй байна.*

Боловсролд хүүхдийг хэрхэн тэгш хамруулан сургах асуудлыг багш хийж, туршиж үзэж байж илүү ойлгож авдаг. Харамсалтай нь өнөөгийн байдлаар оюутан-багшийг тэгш хамруулан сургах арга зүйгээр бус, харин багш төвтэй, лекцээр сургаж байна. Багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулан сургах асуудал орсон ч түүнийг зааж буй арга зүй (идэвхтэй оролцооны, суралцагч төвтэй) нь түүнд зохицохгүй бол үр дүнгээ өгөхгүй.



Тодруулбал, хөтөлбөрийн өөрийнх нь бүтэц, дизайн нь тэгш хамруулах сургалтын (сурах, сургах үйл) хандлага, арга зүйг хэрэглэх, мөн туршин үйлдэх практик боломж хомс байдлаар боловсруулагдсан бол хичээл зааж буй багшийн багшид мөн л тухайн хичээлийг үр бүтээлтэй заах мэдлэг, туршлага дутагдана. Үүнээс үүдэн сургалтын үр дүн, бодит амьдралын хэрэгцээ, шаардлагын хооронд зөрөө гарна гэсэн үг юм. Цаашилбал, ийм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үр дүн багатай нь аман шалгалт, бичгийн ажил гэх мэт түгээмэл хэрэглэгдэж буй үнэлгээний арга, хэлбэртэй ихээхэн холбоотой байна. *(Бид арга зүйн асуудлыг зөвлөмж 5-д илүү нарийвчлан тусгасан).*

### Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:

- Багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулах сургалтын лекц, хичээлийн ажиглалт, дунд сургуульд хийх практик зэрэг тус бүр хэдэн хувийг эзэлж байна вэ?
- Бодит сургалтын орчин буюу танхимд болон сургуульд хийх практик хичээл, дадлага зэрэг нь тухайн хөтөлбөрийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болж чадсан уу?
- Практикт-суурилсан сурах үйлээр олж авсан мэдлэг, чадварыг хэрхэн үнэлж байна вэ? Энэ нь нийт үнэлгээнд онолын хичээлүүдтэй адил жин, хувийг эзэлж байна уу?
- Хөтөлбөр нь уламжлалт сургалтын арга зүйтэй харьцуулахад асуудал шийдвэрлэх, бүтээлч эргэцүүлэл бүхий үйлд хэр анхаарч байна вэ?
- Багш-оюутны асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд хөтөлбөр нь хэр дэмжлэг үзүүлэхээр байна вэ?

## Зөвлөмжүүд

### Хөтөлбөрийн зөвлөмж 6.

*“Багш бэлтгэх хөтөлбөр нь практикт суурилсан үйл ажиллагаанд илүү анхаарах ёстой”.*

Тэгш хамруулах сургалтыг зөвхөн онолд тулгуурласан хандлагаар зохион байгуулбал үр өгөөж багатай байна.

Иймээс багш бэлтгэх хөтөлбөрийг оюутан-багшийг чадваржуулах талаас нь дараах байдлаар боловсруулсан байвал зохино. Үүнд:

- Туршлагатай багш нартай хамтран хичээлийн ажиглалт хийж хэлэлцэх, үр дүнд нь тулгуурлан тэгш хамруулах сургалтад тулгамдаж буй асуудлыг эргэцүүлэн дүгнэх. Энэхүү үйл ажиллагаанд тухайн чиглэлээр оюутан-

багштай хамтран ажиллах, өөрийн гэсэн баялаг туршлагатай, тэдэнтэй түүнээсээ хуваалцах, загварчлан үзүүлэх чадвартай багш нарыг олоход амаргүй байдаг тул анхаарах хэрэгтэй. Түүнчлэн оюутан-багштай ажиллах багш нарт ямар туршлагыг хуваалцах, ямар хандлага, арга зүйгээр зөвлөн туслах зэргээр өөрсдөд нь мөн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг чухал гэдгийг бодолцох нь зүйтэй.

- Янз бүрийн хэрэгцээтэй суралцагчидтай ажиллах, мөн асуудал шийдвэрлэх чадвараа хөгжүүлэх зэрэгт тусгайлан анхаарсан багшлах дадлага байх ёстой. Үүний тулд бодит байдлын симуляц хийх, видео бичлэг ашиглан хэлэлцэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилласан янз бүрийн төсөлт ажлуудыг өргөн ашиглах нь үр дүнтэй .
- Багшлах дадлагын үеэр оюутан-багш нар бие биенийхээ хичээлд сууж ажиглан суралцагчдыг илүү хамруулах, оролцуулах ямар боломж байгааг хамтран хэлэлцэх
- Хамруулах сургалт болон ялгавартай сургалтад тулгамдаж буй асуудлаар оюутан-багш нараар үйлийн судалгаа хийлгэх. Ингэснээр тэд төгсөөд ажлын талбартаа тулгарах аливаа асуудлыг шийдвэрлэх практик чадвар олж авахаас гадна их сургуулийн сургалтын зайлшгүй шаардлага болж буй тэдний судалгааны чадвар сайжрахад нөлөөлнө.

### **Хөтөлбөрийн зөвлөмж 7.**

*“Багш бэлтгэх хөтөлбөр нь оюутан-багшид тэгш хамруулан сургах онол, арга зүй болон сургалтын бодит байдлыг холбож ойлгоход дэмжлэг үзүүлэхүйцээр боловсруулагдсан байна.”*

Хөтөлбөрийн нэгэн зорилго нь оюутан-багш нарт судалсан онол, арга зүй нь сургалтын бодит байдалтай хэрхэн холбогдож буйг ойлгоход оршино. Тэгш хамруулах сургалтыг зөвхөн онолд суурилсан, эсвэл зөвхөн практик сургалтаар зохион байгуулах нь үр өгөөжгүй. Харин дээрх хоёр хэлбэр нь интеграцчилсан байдлаар хамтдаа зохион байгуулагдаж бие биенээ тэтгэж байх ёстой. Оюутан-багш нар өөрсдийн практик үйл ажиллагаагаа судалсан онолын үүднээс задлан шинжилж тэдгээрийн холбогдлыг сайтар ойлгох чадвартай болох нь чухал байна.

Эцэст нь, багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нар өөрсдөө тэгш хамруулах сургалтын болон суралцагч төвтэй арга зүйгээр сургалтаа зохион байгуулах нь чухал ач холбогдолтойг дурдах нь зүйтэй. (Энэ талаар зөвлөмж 5-д илүү дэлгэрэнгүй авч үзсэн).

# Бэрхшээл 4

## Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх асуудал

### Нөхцөл байдлын шинжилгээ

*Багш бэлтгэх хөтөлбөр боловсруулагчдын тэгш хамруулах сургалтын талаарх мэдлэг хангалтгүй байх.*

Хөтөлбөр боловсруулагчид тэгш хамруулах боловсролын талаар сайтар мэддэг, түүнийг бодит амьдралд хэрхэн хэрэгжүүлэх практик туршлагатай байж оюутан-багшийг сургах онол практикийн зохистой харьцаа бүхий чанартай хөтөлбөр боловсруулна. Харамсалтай нь ихэнх тохиолдолд засгийн газрын түвшинд байгуулсан хөтөлбөр боловсруулах нэгж болон багш бэлтгэх сургуулийн багш нар тухайн чиглэлээр онол, практикийн хангалттай мэдлэг, туршлага байдаггүй. Хэдийгээр тусгай хэрэгцээт боловсрол, эсвэл хөгжлийн бэрхшээл зэргээр мэргэшсэн багш нар байвч тэгш хамруулах боловсролын бүхий л асуудлыг багш бэлтгэх хөтөлбөрт зөвхөн оруулахад хангалтгүй юм.

*Хөтөлбөрийг идэвхтэй оролцооны болон тэгш хамруулах сургалтын зарчмуудаар боловсруулдаггүй.*

Ихэнх улс оронд үндэсний хэмжээнд ч, багш бэлтгэх сургуулийн түвшинд ч тэгш хамруулах боловсролын хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлэхдээ хүйсийн тэнцвэрт байдал, хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй, үндэстний цөөнх, хэл, шашин шүтлэг талаасаа бүрэн төлөөллийг бий болгож чадахгүй байна. Хөтөлбөр боловсруулах багийг ард иргэдийн бүхий л төлөөлтэй бүрдүүлж чадахгүй бол тэгш хамруулах боловсролын хөтөлбөрт үүнтэй холбоотой бүх асуудал тусгалаа олж чадахгүй гэсэн үг юм. Энэ нь оюутан-багш нарт мэдлэг, чадвар эзэмшүүлэх сурах үйл явцын чанарт муугаар нөлөөлж, тэр ч байтугай тэгш хамруулах сургалтын зарим асуудлууд мартагдах аюултай.

Хөтөлбөр боловсруулах багийн хангалтгүй мэдлэг, чадвараас гадна сонирхлын бүлгийн санал, зөвлөгөө тогтмол авдаггүй нь бас нэгэн бэрхшээл болно. Эдгээр санал нь хөтөлбөрийг бодит амьдралтай холбох, тулгамдаж буй асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй. Ялангуяа боловсролын төвлөрсөн системтэй улс оронд хөтөлбөр боловсруулах тусгай нэгж тухайн ажлыг гүйцэтгэж байгаа тохиолдолд энэ нь маш чухлаар тавигдана.

*Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш бэлтгэх сургуулийн багш нарын мэдлэг, чадвар хангалтгүй байх*

Үндэсний хэмжээнд боловсруулсан тэгш хамруулах боловсролын хөтөлбөр байхгүй байсан ч багш бэлтгэх сургуулийн багш нар хөтөлбөрөө шинэчлэх,

практик ажилдаа тэгш хамруулах сургалтын арга зүй, туршлагыг нэвтрүүлэх мэдлэг, чадвартай бол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарахгүй. Гэвч багш нарт практик туршлага дутагдах, боловсролын салбарт хийгдэж буй өөрчлөлт, хөгжлийн шинэ хандлага, шинэ санаа авах боломж хомс, иймээс өөрсдөө сурч байсан арга зүйгээр заах зэргээс үүдэн багш бүрт энэхүү чадавхи бий болоогүй байна.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:**

- Багш боловсролын хөтөлбөрүүдийг хэн боловсруулдаг вэ? Эдгээр хүмүүс нь тэгш хамруулах боловсролын талаар ямар практик туршлагатай вэ?
- Хөтөлбөр боловсруулах баг байгаа юу? Байгаа бол багийн гишүүд нь бүх ард түмний төлөөлөл болж байгаа юу?
- Багш бэлтгэх хөтөлбөрт сонирхлын бүлгийн саналыг тусгадаг уу? Хэрэв тийм бол тэд ямар бүлгийг төлөөлж байгаа вэ? Мөн тэд санал бодлоо тусгахын тулд хэрхэн оролцдог вэ?
- Багш бэлтгэх сургуулийн багш нарт хөтөлбөрөө суралцагчдынхаа ялгавартай сурах хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхийг зөвшөөрдөг үү? Үүнийг хийхэд тэдэнд шаардагдах мэдлэг, чадвар бий юу?
- Хөтөлбөр боловсруулах, шинэчлэхэд удирдамж болохуйц ямар материал, нөөц ашигладаг вэ?

## **Зөвлөмжүүд**

### **Хөтөлбөрийн зөвлөмж 8**

*Тэгш хамруулан сургах боловсролын талаар мэдлэг, чадвартай, туршлагатай хөтөлбөр боловсруулагчдыг сонгон ажиллуулах, мөн хөтөлбөр боловсруулах явцад сонирхлын бүлгийг оролцуулах, тэдний санал, зөвлөмжийг авах боломжоор хангана.*

Үндэсний хэмжээнд, эсвэл байгууллагын түвшинд багш бэлтгэх хөтөлбөр боловсруулах асуудал цаг үеэсээ түрүүлж явах ёстой. Өөрөөр хэлбэл хөтөлбөр боловсруулагчид нь тэгш хамруулах боловсролыг тогтолцооны өөрчлөлт хийх, мөн суралцагч бүрийг дэмжих талаас нь ирээдүйн хөгжил бүхий өргөн утгаар нь харах мэдлэг, чадвартай байна. Түүнчлэн багш боловсролын бүхий л хөтөлбөрт тэгш хамруулах, хүний сурч боловсрох эрх, тэгш байдал зэргийг хэрхэн интеграцчлан оруулах вэ гэдгийг сайтар мэдэхээс гадна хийсэн өөрчлөлт, тусгасан санаа нь шинэлэг байх ёстой.

Багш бэлтгэх сургуулийн багш нар багш боловсрол дахь шинэчлэлийн үйл явц, хөгжил дэвшлийг судалж шинэлэг санаа, тэргүүн туршлагыг хэрхэн хөтөлбөртөө шингээх талаар эргэцүүлэн хөтөлбөрөө сайжруулж байх нь цаг үеийн шаардлага

юм. Иймээс хүний нөөцийн талаар дараах асуудлууд чухал байна. Үүнд:

- Мэдлэг, чадвартай, бүтээлч, туршлагатай хүмүүсийг хөтөлбөр боловсруулах багт сонгон ажиллуулах
- Хөтөлбөр боловсруулах багт ард иргэдийн бүрэн төлөөлөл болох хүмүүсийг сонгох (жишээлбэл, эрэгтэй/эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй/бэрхшээлгүй, хэл болон нийгмийн янз бүрийн байдал, хот/хөдөө орон нутгийн г.м)
- Хөтөлбөр боловсруулах багийн бүрэлдэхүүнд байнгын хяналт тавьж, тодорхой чиглэлээр мэдлэг, чадвар дутагдвал тийм чадвар бүхий хүмүүсийг сонгон шалгаруулж хүч нэмэх, сэлбэх
- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр хөтөлбөр боловсруулагчдыг сургах (тэгш хамруулах боловсрол эзэмшүүлж буй газруудад айлчлах, тэгш хамруулах сургалтын арга зүй, идэвхтэй оролцооны арга зүйн сургалт сургалт г.м)

Үйл явц талаасаа дараах асуудлууд чухал ач холбогдолтой байна. Үүнд:

- Хөтөлбөр боловсруулах багийн гишүүдэд тухайн чиглэлээр сурах, сургах үйлийн талаар сонирхлын бүлгүүдийн санал зөвлөгөө тогтмол авч байхын ач холбогдлыг ойлгуулах, тэдэнтэй хийх уулзалтыг зохион байгуулах чадвартай болоход дэмжлэг үзүүлэх
- Сонирхлын бүлгүүдийн санал, зөвлөгөөг тогтмол авч байх зохион байгуулалтын механизмыг бий болгох (зөвлөх уулзалт, фокус бүлгийн ярилцлага г.м)
- Засгийн газар, боловсролын яамдаас хөтөлбөр боловсруулах баг нь сонирхлын бүлгүүдийн санал, зөвлөгөөг, хүлээн авах, хүндэтгэн сонсох, ажилдаа тусгаж байгаа эсэхэд байнгын хяналт тавих

## Хөтөлбөрийн зөвлөмж 9

*Багш бэлтгэх сургуульд багш сонгон шалгаруулахад тэгш хамруулан сургах онол, арга зүйн мэдлэг, чадвар, туршлагыг нэгэн шалгуур болгох; түүнчлэн ажиллаж буй болон шинээр ажилд орсон бүх багшийг дээрх чиглэлээр сургах, мэргэжлийг нь тасралтгүй дээшлүүлж байна.*

Багш бэлтгэх сургуулийн багш нар тэгш хамруулах сургалтын хөтөлбөрийг өөрсдөө сайтар ойлгож хэрэгжүүлэх, орчин, нөхцөлдөө тохируулан өөрчлөх чадвартай байна. Иймээс тэгш хамруулах боловсрол, тэгш байдал, суралцагчдын эрхийн үндсэн зарчмуудыг мэддэг, эсвэл дор хаяж эдгээрийн талаар сурч мэдэх хүсэл сонирхолтой, чин эрмэлзэлтэй багш нарыг сонгон шалгаруулж ажиллуулах шаардлагатай.

Түүнчлэн сонгон шалгаруулахдаа суралцагчдын сурах хэрэгцээ, онолын мэдлэгийг бодит практикийн шаардлагад тус тус нийцүүлэн сурах шинэ

туршлагыг бий болгоход чиглэсэн шинэчлэлийн санааг хүлээж авах, хэрэгжүүлэх чадвартай байх ёстой.

Хөтөлбөр боловсруулагчдынх нь хувьд багш нарыг тэгш хамруулах боловсролын концепцийг илүү ойлгох, практик үйлээр бодит туршлага хуримтлуулах, мөн тухайн чиглэлээр үндэсний болон олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлаар хэлэлцэх, мэтгэлцэх зэргээр мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамруулах шаардлагатай.

Дүгнэн хэлбэл, тэгш хамруулах боловсролын асуудлыг мэргэжлийн хөгжил, насан туршийн сурах үйлийн нэгэн салшгүй хэсэг болгон авч үзэх цаг үеийн шаардлага байна.

## Монгол улсын жишээ

*Багш бэлтгэх хөтөлбөрт тэгш хамруулан сургах практикийг нэвтрүүлэх бүтээлч үйл ажиллагаа.*

МУБИС-ийн Багшийн Сургуулийн оюутнууд Тусгай Хэрэгцээт Боловсрол, Сэтгэл хэл засал хичээлээр сурч мэдсэн тэгш хамруулан сургах онолын мэдлэгээ практик үйл ажиллагаатай холбохын тулд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо; Өгөөмөр сэтгэл ТББ; Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо; Монголын Даун синдромын холбоо ТББ; Аутизмын холбоо ТББ; УБ хотын тусгай 6 сургуулиудтай хамтран ажиллаж эдгээр төрийн болон төрийн бус байгууллагууд оюутнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх ойлголтыг бодит амьдрал дээр баталгаажуулах туршлага суралцахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн тус сургуульд хэрэгжиж буй Сурган Хүмүүжүүлэх Хичээлийн хөтөлбөрийн агуулга болон оюутны дадлагын удирдамжийг шинэчлэн боловсруулахдаа тэгш хамруулан сургах зарчмуудыг тусган бага насны хүүхдийн суралцахуйг дэмжих үйл ажиллагаандаа оюутан багш хэрхэн тусгаж байгааг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулан хэрэгжүүлж байна.

Тэгш хамруулан сургах зарчмууд, үзэл санаа, нийгмийн оролцоо хөгжлийн талаар Багшийн сургуулийн Тусгай Хэрэгцээт Боловсрол хичээлийн агуулгад тусгаснаар бага ангийн багш болох гэж байгаа оюутнуудын дунд хандлагын эерэг өөрчлөлтүүд гарч байна.

# Бэрхшээл 5

## Тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах явдал тогтсон ташаа ойлголт, сэтгэлгээний буруу хэвшил

### Нөхцөл байдлын шинжилгээ

Оюутан-багш нар тэгш хамруулан сургах чиглэлээр мэдлэг, чадварыг зөвхөн судалж буй хичээлээс гадна тухайн хичээлийг ямар хандлагаар зааж, ямар хэрэглэгдэхүүн ашиглаж байгаагаас олж авдаг өвөрмөц онцлогтой. Тэгэхээр тухайн хичээлд ямар нэгэн тогтсон буруу хэвшил (стереотип), ташаа ойлголт байгаа нь нөлөөлнө гэсэн үг юм.

Багш бэлтгэх хөтөлбөр нь бусад хөтөлбөрийн нэгэн адилаар зарим бэрхшээлтэй тулгардаг нь дээрх хандлагатай холбоотой байдаг. Жишээлбэл сургалтын явцад үншиж судлах материалд, ялангуяа тохиолдлын судалгаанд (кейсийн судалгаанд) жендерийн тэгш бус байдлаар жишээлсэн, эсвэл аливаа улс орны хувьд хүн амын дийлэнх болсон үндэстэн, ястны асуудалд тулгуурлан угаас ийм байдаг хэмээн буруу ташаа дүгнэлт хийсэн байх явдал тохиолддог (*Энэ талаар зөвлөмж 4-д илүү дэлгэрэнгүй авч үзсэн*).

Түүнчлэн хөтөлбөр нь агуулга, үндсэн үйл ажиллагаа, бүтэц зэргийн хувьд бүх оюутан-багшид бүгдэд нь ойлгомжтой байх ёстой. Гэтэл зарим тохиолдолд үндэсний цөөнхийн төлөөлөл бүхий оюутнуудад судалж буй материалыг ойлгоход хэлний талаас бэрхшээл тулгарах, хөгжлийн бэрхшээлтэй (сонсголын гм) оюутнуудад хамрагдах боломжгүй сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, эсвэл эрэгтэй багш эрэгтэй оюутнуудаа илүүд үзэх гэх мэт асуудлууд гардаг. Цаашилбал, сургалтын хэлбэр, хичээлийн хуваарь нь зарим оюутны хувьд бэрхшээл учруулдаг тохиолдол ч бий. Тухайлбал, амьдралын эрхээр ажил хийж амьдралаа залгуулдаг, эсвэл бага насны хүүхэдтэй эмэгтэй оюутнуудад өдрийн ангид элсэн суралцах, эсвэл санхүүгийн боломжоос хамааран удаан хугацаагаар суралцах боломжгүй, хурдан мэргэжлээрээ ажил хийх шаардлагатай хүмүүст бэрхшээл тулгардаг.

Ерөнхийдөө багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд (тэгш хамруулах асуудлыг интеграцлан оруулахад тулгардаг бэрхшээлээс гадна) тухайн нийгэмд байдаг ялгаварлан гадуурхах аливаа үзэгдэл нь мөн бэрхшээл болдог.

### Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно. Үүнд:

- Оюутан-багш, тэдгээрийн багш нар нь тухайн улсын болон орон нутгийн ард иргэдийн бүрэн төлөөлөл болж чаддаг уу?
- Ерөнхийд нь авч үзвэл, багш бэлтгэх хөтөлбөр нь хүйсийн тэнцвэртэй

байдал, хөгжлийн бэрхшээл, хэл, шашин шүтлэг, үндэстэн, ястны асуудал, ядуурал зэргийг тооцож чадсан байдаг уу?

- Багш бэлтгэх хөтөлбөрийг аливаа ялгаварлал, гадуурхлаас ангид эрх тэгш байдлыг хангах чиглэлээр мэргэшсэн хүмүүсээр хянуулж саналыг нь авсан байдаг уу?
- Хөтөлбөрт байдаг, мөн байж болзошгүй аливаа ялгаварлал, гадуурхлыг олж тогтоох, байгаа бол асуудлыг шийдвэрлэх чиглэлээр багшийн багшийг сургаж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг үү?
- Багшийн багшид өөрсдийн итгэл үнэмшил, үнэт зүйл, хандлагыг эргэцүүлэн дүгнэх боломж олгодог уу?

## Зөвлөмжүүд

### Хөтөлбөрийн зөвлөмж 10.

*“Ялгаварлан гадуурхах явдлаас сэргийлэх үүднээс багш бэлтгэх хөтөлбөрийг сонирхлын бүлгүүдийн саналыг тусган тасралтгүй засан сайжруулж, шаардлагатай бол шинэчилж байна”.*

Багш бэлтгэх бүх хөтөлбөрийг боловсруулах, эсвэл байгаа хөтөлбөрийг засан сайжруулахдаа тэдгээр нь бүхэлдээ эрх тэгш байдлыг хангасан, мөн тэдгээрт ялгаварлал, гадуурхлын шинжтэй аливаа зүйл, сэтгэлгээний буруу хэвшил, ойлголт байгаа эсэхийг сайтар нягтлах шаардлагатай. Үүний тулд хөтөлбөрийн агуулга, сургалтын хэрэглэгдэхүүн, кейсийн судалгаа, жишээ баримт, дүрс, зураг, сургалтын бүтэц, үндсэн үйл ажиллагаа, тэр байтугай хичээлийн хуваарь зэргийг ялгаварлан гадуурхлын аливаа зүйл байгаа эсэх талаас нь байнга хянаж шалгах, байгаа тохиолдолд засан сайжруулж байдаг уламжлал тогтох нь зүйтэй.

Багш бэлтгэх хөтөлбөр боловсруулахдаа тухайн бүс нутгийн ард иргэд, олон нийтийн төлөөлөл бүхий хүмүүсийг оролцуулах, цаашилбал хүйсийн тэнцвэртэй байдал, үндэсний цөөнхийн хэлний асуудал, үндэстэн ястны онцлог, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хамралт, эрх үүрэг зэргээр мэргэшсэн хүмүүсээр хөтөлбөрөө хянуулж тэдний санал, дүгнэлтийг тусгах зайлшгүй шаардлагатай. Иймээс хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтэд ялгаварлан гадуурхлын аливаа хэлбэр, сэтгэлгээний буруу ташаа хэвшил, ойлголт байгаа эсэх талаас нь байнгын хяналт тавьж тодорхой хугацаанд шинжилгээ, үнэлгээ хийдэг байх нь чухал ач холбогдолтой байна.

### Хөтөлбөрийн зөвлөмж 11.

*“Багш бүр өөрийн хөтөлбөртөө ялгаварлан гадуурхах аливаа зүйл байгааг олж хардаг, хэрэв байвал засан сайжруулах чадвартай байна”.*



Үнэн хэрэгтээ ямар ч засан сайжруулсан, эсвэл шинээр боловсруулсан хөтөлбөр төгс төгөлдөр болдоггүй, мөн хэрэглэгдэх бодит байдалд бүрэн нийцэхгүй тохиолдол гардаг. Иймээс тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нар хөтөлбөрөө задлан шинжилж, аливаа ялгаварлал, гадуурхлын шинжтэй мэдээлэл, үйл ажиллагаа байгааг олж хардаг, байгаа тохиолдолд тэдгээрийг өөрчлөх, засан сайжруулах чадвартай байх ёстой. Түүнчлэн тэд хөтөлбөр хэрэгжүүлэх явцад илэрсэн аливаа асуудлыг оюутан-багш нарт ойлгуулах, цаашид ийм зүйлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тэдэнд зааж сургах ёстой.

## Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?

Зөвлөмж 1-т бид үйл ажиллагаагаа төлөвлөхдөө хөтөлбөрийн үр өгөөжийг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулах шаардлагатайг дурдаж байсан билээ. Мэдээж эдгээрийг сонирхлын бүлгүүдийн төлөөлөл бүхий идэвхтэй оролцооны арга зүйгээр тавьсан зорилго, зорилтуудтайгаа уялдуулан нарийвчлан боловсруулдаг. Багш бэлтгэх хөтөлбөрийг өөрчлөх, багш нарыг тэгш хамруулан сургах чиглэлээр сайтар бэлтгэх үйл ажиллагаа нь хэр өгөөжтэй болсныг үнэлж тогтоох боломжтой хэмээн үзээд дараах шалгуур үзүүлэлтийг санал болгож байна.

Үүнд:

- Боловсролын яамны эрх бүхий ажилтнууд тэгш хамруулан сургах чиглэлээр багш нарыг сургах арга, хэлбэрийг сайжруулах асуудлаар хэлэлцэх
- Боловсролын яамнаас дараах асуудлуудыг шийдвэрлэсэн үндэсний хэмжээний стандарт, удирдамж боловсруулан хэрэгжүүлэх. Үүнд: а) тэгш хамруулан сургах асуудал нь багш боловсролын салшгүй нэгэн хэсэг болох, б) тухайн чиглэлээр бие даасан хичээл орохоор бол тухайн асуудлыг өргөн утгаар нь тайлбарлах, судлахыг зорих, в) тусгай хэрэгцээт боловсрол, эсвэл хөгжлийн бэрхшээл зэргээр тусгай хичээл нарийвчлан орох бол тэдгээрийг зөв оновчтой нэрлэх (тэгш хамруулан сургах хэмээн нэрлэхгүй байх)
- Боловсролын яам, багш бэлтгэх сургуулиуд багш болон хөтөлбөр боловсруулагчдыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт боловсруулан мөрдөх; сонгон шалгаруулсан багш нар нь янз бүрийн нийгмийн давхаргын төлөөлөл байхын хувьд хүний эрх, эрх тэгш байдал, тэгш хамруулан сургах боловсрол олгоход голлон чиглэсэн багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай байх
- Тэгш хамруулан сургах чиглэлээр багш бэлтгэх сургуулийн багш нар, хөтөлбөр боловсруулагчдыг сургах, практик мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, тасралтгүй хэрэгжүүлэх
- Багш бэлтгэх сургуулиуд а) тэгш хамруулах сургалтын хөтөлбөр нь

хөгжлийн бэрхшээл болон тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөрүүдтэй харьцуулбал боловсрол дах эрх тэгш байдал, хамруулах сургалт болон хүүхдийн эрхийг хэр тусгасан, б) багш бэлтгэх хөтөлбөр нь бүхлээрээ дээрх асуудлуудыг хэр тусгасан зэргийг тодруулан одоогийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүддээ үнэлгээ хийх

- Багш бэлтгэх сургуулиуд эрх тэгш байдал, хамруулах сургалт болон хүүхдийн эрх зэргийг хөтөлбөрүүддээ интеграцчлан оруулах
- Багш бэлтгэх сургуулийн удирдлагаас бүх багш, оюутан-багш нарт тухайн чиглэлийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх хариуцлага хүлээх
- Багш бэлтгэх сургуулиуд нь тэгш хамруулах чиглэлээр хийгдэж буй судалгааны цар хүрээ, чанарыг дээшлүүлэх, мөн багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах судалгаа, судлаачдыг дэмжих, хамтран ажиллах
- Оюутан-багш нараар тэгш хамруулах боловсролыг зөвхөн онолын, эсвэл тусдаа хичээлээр судлуулахгүй байх
- Оюутан-багш нар зөвхөн онол сонсоод зогсохгүй, ажиглалт хийж практик үйл ажиллагаанд хамрагдах боломжтой байх
- Оюутан-багш нар а) тэгш хамруулах сургалтын онол, арга зүйг бодит амьдралтай холбох, б) тэгш хамруулах сургалтыг өөрийн амьдрал, туршлагатай холбож бүтээлчээр эргэцүүлэн дүгнэх чадвартай байх
- Оюутан-багш нар нь мэргэжлийн сургалтын явц, мөн боловсролын бусад орчинд хүүхдийг ялгаварлан гадуурхах аливаа хэлбэртэй тэмцэх, тухайн асуудлыг шийдвэрлэх мэргэжлийн мэдлэг, чадвартай байх
- Бүх шатны сургуулийн багшийг бэлтгэх хөтөлбөрт хэл, хүйс, яс үндэс, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, нийгмийн гарал/байдал зэрэг асуудлыг тусгах, мөн нийгмийн бүх гишүүдийн эрх, эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн байх
- Багш бэлтгэх хөтөлбөр нь тэгш хамруулах сургалтыг бодит амьдралд хэрхэн хэрэгжүүлэхийг идэвхтэй оролцооны, суралцагч төвтэй арга, арга зүйгээр загварчлан болон жишээлэн харуулсан байх

# Хавсралт

Дараах хүснэгтэд тус зөвлөмжид дурдсан хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн давах зөвлөмжүүдийг санал болгон орууллаа. Түүнчлэн тус хүснэгтийн бөглөөгүй хэсэгт нь та бүхэн өөрсдийн нөхцөл байдалд тохирсон шийдэл, арга замын талаарх санаа оноогоо бичиж болно. Энэхүү зөвлөмжийг та бүхэн хамт олноороо хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах зорилт дэвшүүлээрэй. Тус удирдамжийг хэрхэн ашиглах талаар Удирдамж-1- ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Зөвлөмжүүд	Зөвлөмж хэнд зориулагдсан бэ?	Зөвлөмжийг өөрийн нөхцөлд хэрхэн ашиглах вэ?
<p><i>“Багш бэлтгэгдэг боловсролын бүх байгууллага, үүн дотроо коллеж, их дээд сургуулиуд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр бүх багшийг сургах шаардлагатай”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтан</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуулиудын багш, судалгааны хүрээлэнгүүдийн ажилтнууд, хөтөлбөр боловсруулагчид</li> <li>• Сургуулиа төгсөөд тэгш хамруулан сургах янз бүрийн орчинд ажиллах мэдлэг, чадвар бүхий чанартай мэргэжлийн боловсрол авах эрхтэй оюутан-багш</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын хөтөлбөрт буй бүх хичээл, модульд тэгш хамруулан сургах, эрх тэгш байдал, хүний эрхийн асуудлыг тусгасан байна”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуулиудын багш, судалгааны хүрээлэнгүүдийн ажилтнууд, хөтөлбөр боловсруулагчид</li> <li>• Оюутан-багшид хичээл зааж буй багш нар</li> <li>• Сургуулиа төгсөөд тэгш хамруулан сургах янз бүрийн орчинд ажиллах мэдлэг, чадвар бүхий чанартай мэргэжлийн боловсрол авах эрхтэй оюутан-багш</li> </ul>	

<p><i>“Багш бэлтгэх сургуулийн багш нар, хөтөлбөр боловсруулагчид тусгай хэрэгцээ болон тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр мэдлэг, ойлголтоо тасралтгүй дээшлүүлж байх ёстой”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт, мөн багш бэлтгэх хөтөлбөр боловсруулагчид, багш бэлтгэх сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, дэмжих үйл ажиллагааг хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтан</li> <li>• Багш бэлтгэх хөтөлбөр боловсруулагчид, багш бэлтгэх сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, дэмжих үйл ажиллагааг хариуцсан боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Оюутан-багшид хичээл зааж буй багш нар</li> <li>• Багш бэлтгэх сургуулиудын багш, ажилтнууд</li> <li>• Тэгш хамруулан сургах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг судлаачид</li> </ul>	
<p><i>“Багш бэлтгэх сургуулиуд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр өөрчлөлт, шинэчлэлийг өөрсдөөсөө эхэлж хөтөлбөртөө энэхүү шинэчлэлээ тусгасан байна”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөр болон сургалтад өөрчлөлт хийх эрх мэдэл бүхий багш бэлтгэх сургуулиудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулагчид, багш, ажилтнууд</li> </ul>	
<p><i>“Засгийн газраас багш бэлтгэх бүх сургуулийн хөтөлбөрт тэгш хамран сургах асуудлыг тусгах заалт бүхий багшийн стандарт боловсруулах, мөрдөх”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багшийн стандартын хэрэгжилтэд хяналт тавих орон нутгийн боловсролын газар болон төв захиргааны албан тушаалтан, мэргэжилтэн</li> <li>• Засгийн газрын чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж буй төрийн бус байгууллага, донорууд</li> </ul>	

<p><i>“Багш бэлтгэх хөтөлбөрт практик чадвар эзэмшүүлэх асуудлыг түлхүү оруулах”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан ажилтнууд</li> <li>• Оюутан-багшийн дадлагын сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Оюутан-багшийн дадлагыг санхүүжүүлэх, дэмжих төрийн бус байгууллагууд</li> <li>• Практик мэдлэг, чадвар олж авах хүсэл эрмэлзэлтэй оюутан-багш нар</li> </ul>	
<p><i>Багш бэлтгэх хөтөлбөр нь оюутан-багшид тэгш хамруулан сургах онол, арга зүй болон сургалтын бодит байдлыг холбож ойлгоход дэмжлэг үзүүлэхүйцээр боловсруулагдсан байна.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан ажилтнууд</li> <li>• Тэгш хамруулан сургах онол, арга зүйг бодит практиктай холбож ойлгоход мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг судлаачид</li> </ul>	
<p><i>Тэгш хамруулан сургах боловсролын талаар мэдлэг, чадвартай, туршлагатай хөтөлбөр боловсруулагчдыг сонгон ажиллуулах, мөн хөтөлбөр боловсруулах явцад сонирхлын бүлгийг оролцуулах, тэдний санал, зөвлөмжийг авах боломжоор хангана.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Хөтөлбөр боловсруулагчдыг сонгон ажиллуулах үндэсний, орон нутгийн болон бүс нутгийн эрх бүхий ажилтнууд</li> <li>• Багш бэлтгэх хөтөлбөр боловсруулах явцад идэвхтэй оролцох, санал бодлоо тусгах сонирхолтой багш болон сонирхлын бүлгүүд</li> </ul>	

<p><i>“Багш бэлтгэх сургуульд багш сонгон шалгаруулахад тэгш хамруулан сургах онол, арга зүйн мэдлэг, чадвар, туршлагыг нэгэн шалгуур болгох; түүнчлэн ажиллаж буй болон шинээр ажилд орсон бүх багшийг дээрх чиглэлээр сургах, мэргэжлийг нь тасралтгүй дээшлүүлж байна”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэх сургуульд багш сонгон шалгаруулж авах үндэсний, орон нутгийн болон бүс нутгийн эрх бүхий албан тушаалтнууд, ажилтнууд</li> <li>• Тэгш хамруулан сургах чиглэлээр мэргэшсэн, бусадтай мэдлэг, чадвараасаа хуваалцах туршлагатай багш нар; тухайн чиглэлээр мэдлэг, туршлагатай багатай, сургалтад хамрагдах сонирхолтой багш нар</li> </ul>	
<p><i>“Ялгаварлан гадуурхах явдлаас сэргийлэх үүднээс багш бэлтгэх хөтөлбөрийг сонирхлын бүлгүүдийн саналыг тусган тасралтгүй сайжруулж, шаардлагатай бол шинэчилж байна”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> <li>• Хөтөлбөрийн зөв зохистой хэрэгжилтийг хангах, хянах иргэний нийгмийн төлөөлөл</li> </ul>	
<p><i>“Багш бүр өөрийн хөтөлбөртөө ялгаварлан гадуурхах аливаа зүйл байгааг олж хардаг, хэрэв байвал засан сайжруулах чадвартай байна”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, санхүүжилт хариуцсан боловсролын яамны холбогдох ажилтан, албан тушаалтнууд</li> <li>• Багш бэлтгэх сургуулийн удирдлага</li> <li>• Багш бэлтгэх боловсролын байгууллагуудын удирдлага</li> </ul>	



## Зөвлөмж 4-Хэрэглэгдэхүүн

4

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

## Удиртгал

“Хэрэглэгдэхүүн” хэмээх энэхүү зөвлөмж нь “Тэгш хамруулан сургах багшийн боловсрол”-оор бэлтгэсэн 5 цуврал удирдамжийн 4 дэх нь юм. Энэхүү зөвлөмжийг дангаар нь бие даасан товхимол болгож эсвэл “Удирдамж,” “Бодлого,” “Хөтөлбөр,” “Арга зүй” гэсэн бусад дөрвөн зөвлөмжийн хамт хослуулан хэрэглэж болно.

Энэ товхимолд багш бэлтгэх боловсролын салбарт ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүний талаар гарч буй тулгамдсан асуудлуудыг тусгахыг зорилоо. Дэд сэдвүүдэд эхлээд Ази–Номхон далай орнуудын судалгааны тайланд дурдагдсан нөхцөл байдал, бэрхшээл түүнийг даван гарах зөвлөмжийг дараа нь манай монгол орны нөхцөл дэх бодит байдлыг хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг тоймлон бичлээ.

## Багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн гэж юуг хэлэх вэ?

Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүнд багшийн хичээлдээ хэрэглэж байгаа болон оюутан багшийн сурах үйл явцдаа хэрэглэж байгаа хэрэглэгдэхүүний аль алийг нь оруулдаг. Энэхүү удирдамжид ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хэрэглэж байгаа багш, суралцагчдын хэрэглэгдэхүүн гэхээс илүү багш бэлтгэх сургалтад хэрэглэж буй хэрэглэгдэхүүнийг илүү онцлон авч үзэж байна.

Багш боловсролын хэрэглэгдэхүүнд дараах зүйлийг багтаана:

- Сурах бичиг
- Дасгалын ном, тараах материал, г.м.
- Лавлах ном
- Зурагт хуудас болон бусад төрлийн үзүүлэх материал
- Загварчлан үзүүлэх болон бусад үзүүлэн таниулах материал
- Дүрс бичлэг болон сонсох материал
- Компьютерын программ хангамж

Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь хичээлийн хөтөлбөртэй нягт холбоотой бөгөөд багш сурган хүмүүжүүлэгч нарт түүнийг хэрэгжүүлэхэд нь тус дэм болох ёстой. Хөтөлбөр гэдэг нь тодорхой үр дүнд хүрэх зорилгоор сурах үйл явцыг зохион байгуулах, уялдуулах нэгэн арга хэлбэр юм.

Энэ нь юуг, яагаад сурах вэ, мэдлэгийг хэрхэн бий болгохыг хөтлөн удирддаг. Харин хэрэглэгдэхүүн нь энэ үйл явцыг хэрэгжүүлэхэд тус дэм болдог. Энэ үйл явцыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэхүүн тус дэм болдог.



## **Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь удирдамжийн нэг чухал хэсэг болох нь**

Аливаа сурах, сургах үйлд хичээлийн хэрэглэгдэхүүн чухал байдаг. Оюутан-багшийн хувьд хичээлийн хэрэглэгдэхүүн нь онолын чухал ухагдахуунуудыг ойлгоход тус дэм болохоос гадна амьдралын бодит жишээн дээр тулгуурласан практик ач холбогдолтой байж онол, практик хоёрыг уялдуулахад чиглэгдсэн байвал зохино.

Оюутан-багш уншиж танилцсан материалынхаа талаар шүүмжлэлтэй хандаж болох боловч багш боловсролын хэрэглэгдэхүүн нь оюутнуудад хэрэглэхэд хялбар, сайн чанарын, сэдэв агуулгын хувьд тохиромжтой бөгөөд хүртээмжтэй байх шаардлагатай.

Дээрх бүгдээс үзэхэд тэгш хамруулан сургах боловсролын багш бэлтгэхэд тохирсон хөтөлбөрийг шинэчлэхээс гадна багш боловсролын хөтөлбөрүүдэд ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг бас дахин хянаж үзэх шаардлагатай байна.

## **Бэрхшээл 1**

### **Тохиромжтой хэрэглэгдэхүүн**

#### **Улс орнуудын хувьд -Нөхцөл байдлын шинжилгээ**

*Тэгш хамруулан сургах боловсролд ашиглах хэрэглэгдэхүүн дутмаг байна.*

Өнөөгийн дунд сургууль болон багш бэлтгэх сургуулиудад сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа хичээл маш олон байдаг. Иймээс тэгш хамруулан сургах боловсролын талаар сургалтын хэрэглэгдэхүүн багш боловсролын байгууллагуудад тэр болгон байхгүй байгаа нь гайхах зүйл биш юм. Бид хөтөлбөрийн талаарх 3-р зөвлөмжид хамгийн зөв хандлага нь бол тэгш хамруулан сургах боловсролын талаар заавал бие даасан хичээлийн төрлүүд (мөн хичээлийн хэрэглэгдэхүүн) байх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүрч байсан. Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь сургалтын бүх сурах бичиг болон багш боловсролын хэрэглэгдэхүүнд тусгагдсан байх ёстой тэдгээрийн салшгүй нэгэн хэсэг юм.

ЮНЕСКО-ийн саяхан нийтэлсэн багш боловсролын талаарх тайланд энэхүү үзэл баримтлал нь бүрэн гүйцэд тусгагдаагүй байна гэж заажээ. Тухайлбал зарим улс оронд багш боловсролын сурах бичиг болон холбогдох хэрэглэгдэхүүнд дүн шинжилгээ хийхэд тэгш хамруулан сургах боловсрол болон түүний үзэл

баримтлалын талаар дурдаагүй байна.<sup>1</sup> Тэгш эрх болон тэгш хамруулан сургах боловсролын үзэл санааг багш боловсролын үндсэн хэрэглэгдэхүүнд тусгагаагүй байсан нь олонтаа тохиолдож байжээ.

*Сургалтын хэрэглэгдэхүүнүүд нь тэгш хамруулах сургалтын талаар шаардлагын түвшинд тусгахгүй байна*

Хэдийгээр тэгш хамруулан сургах боловсролын хэрэглэгдэхүүн нь тусдаа бие даасан ном, хэвлэл болон үндсэн хэрэглэгдэхүүнд дурдагдсан байсан ч гэсэн өргөн утгаараа тодорхой ялгарахгүй зөвхөн хөгжлийн бэрхшээл, эсвэл тусгай хэрэгцээ гэх мэт явцуу хүрээнд илэрч байна. Иймэрхүү байдал багш боловсролын олон хөтөлбөрүүдээс харагдаж байна. Тухайлбал, саяхан нэг улсад судалгаа хийхэд тараах материалыг голдуу сургалтын хэрэглэгдэхүүн болгон хэрэглэж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд энэ нь хүндрэлтэй байдаг бөгөөд тэгш хамруулан сургах боловсролын шаардлагыг хангахгүй байна гэж тэмдэглэжээ.<sup>2</sup>

Дээрх байдлыг багш боловсролын хэрэглэгдэхүүнийг тогтмол шинэчлэхэд зориулсан тусгай санхүүжилт гаргадаггүйгээс, аль эсвэл иймэрхүү төрлийн шинэчлэлт, боловсруулалтыг тухайн орнуудын яам болон багш бэлтгэх байгууллагуудад бодлого, төсөвт тусгайлан оруулдаггүй зэргээс болсон хэмээн тайлбарлаж болох юм. Бас нэг шалтгаан нь багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, төлөвлөдөг хүмүүсийн мэргэжлийн ур чадвар хангалтгүй, эсвэл аливаа өөрчлөлтийг хийх шаардлагатайг ухамсарлаагүй, мөн яаж хийхийг мэдэхгүй байгаа зэргээр тайлбарлаж болох юм.

*Сургалтын хэрэглэгдэхүүн нь орон нутгийн онцлогт таарч тохирохгүй байна*

Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг нь өөр улс оронд бэлтгэсэн байх нь олонтаа тохиолддог. Тухайлбал: Европ, АНУ, эсвэл Австралид хэвлэгдсэн номнуудыг Ази даяар хэрэглэх явдал байдаг. Хэдийгээр эдгээр нь тэгш хамруулан сургах талаар маш сайн мэдээллийг агуулсан байж болох ч оюутан-багш нар өөрийн орны нөхцөл байдалд, ялангуяа өвөрмөц соёл, ахуйн нөхцөл байдалд хэрхэн ашиглах талаасаа хүндрэлтэй байж болох юм. Үүнээс үүдэн тухайн оюутан-багш тэгш хамруулан сургах боловсролыг өөрийн улс оронд тохирохгүй, эсвэл өөрийн улсын онцлог нөхцөл байдалд их хэмжээний хичээл чармайлт гаргах нь ашиггүй хэмээн дүгнэлтэд хүрэхэд нөлөөлж болох юм.

Өөр улс оронд хэвлэгдсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнүүд нь өөр өөр үзэл баримтлалууд болон чиг хандлагуудын хооронд харьцуулалт хийхэд тохиромжтой байж болно. Гэвч багш, сурган хүмүүжүүлэгч болон оюутан-багш нарт өөр нөхцөл байдлын талаарх хэрэглэгдэхүүнийг өөрийн онцлог шинжтэй

<sup>1</sup> Р. Форгакс, 2012. 2015 онд БНБ хүрэхэд багш боловсролыг хөгжүүлэх нь. Оюутан багш нар хичээл зааж эхлэхээс өмнө тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал, арга барилтай хэр танилцсан бэ? Бангладеш, Камбож, БНХАУ, АБНЛАУ, Монгол, Балба, Тайланд, Вьетнамын багш боловсролын тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ (2008-2011). Бангког, ЮНЕСКО, 33 х

<sup>2</sup> Мөн хэвлэлийн 34 х

нөхцөл байдалд хэрхэн, яаж ашиглах тал дээр зөвлөгөө, тусламж хэрэгтэй болдог.

Цаашилбал, гадаад улс орноос оруулж ирсэн материал нь англи хэл дээр эсвэл тухайн улсын үндсэн хэл дээр орчуулагдсан байдаг бөгөөд цөөнхийн хэл дээр орчуулаагдаагүй байх нь олонтаа тааралддаг тул оюутан-багш нарт бүгдэд нь хүртээмжтэй байж чадахгүй юм. Өөрийн улс оронд хэвлэгдсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнүүд ч мөн адил агуулгаараа тохиромжгүй байж болох юм. Эдгээрийг багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж буй хүмүүс нь хөтөлбөр боловсруулагчдын адил өөрийн улс орныхоо хүйс, хөгжлийн бэрхшээл, угсаа, гарал үүсэл, хэл, хот хөдөөгийн ялгаа зэрэг хүн амын онцлогуудыг тэр болгон тусгаагүй байж болно. Түүнчлэн багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж байгаа хүмүүс нь санамсаргүйгээр тухайн нийгмийнхээ олонхийн үзэл бодол, баримтлалыг ном сурах бичигтээ тусгасан байж ч болно.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно**

- Багш боловсролын байгууллагууд болон оюутан-багш нар сургалтын хэрэглэгдэхүүнийг зохих хэмжээгээр нь хэрэглэж чаддаг уу? Байгууллагын номын санд хангалттай ном бий юу? Номын дэлгүүрээс худалдаж авах боломжтой юу?
- Багш боловсролын хэрэглэгдэхүүнд а) тэгш хамруулан сургах боловсролын талаар дагнан бичсэн хичнээн ном байна вэ? б) Өөр сэдвээр бичигдсэн боловч тэгш хамруулан сургах боловсролын талаар дурдсан ном бий юу?
- Сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн хоёрын хооронд уялдаа холбоо байна уу?
- Тэгш хамруулан сургах боловсролын талаарх багш боловсролын хэрэглэгдэхүүнүүд нь уг ухагдахууныг өргөн далайцтай авч үзэж байна уу эсвэл зөвхөн хөгжлийн бэрхшээлийн талаар онцолсон байна уу? Хэрэглэгдэхүүн нь бүх оюутан-багш нарыг хөгжлийн бэрхшээл, ялгаварлан гадуурхах болон бусад асуудлын талаар эргэцүүлэн бодохыг хөхүүлэн дэмжиж байна уу, эсвэл зөвхөн тусгай мэргэжлийн ангийн оюутнуудад зориулагдсан байна уу?
- (а) Насны ялгаатай анги бүлэг, (б) олон сурагчтай ангид бүх хүүхдийг хамруулах, (в) заах арга дах хүйсээр ялгаварлан гадуурхах үзлийг арилгах, (г) өөр өөр хэлээр ярьдаг хүүхдүүдэд заах гэх мэт асуудлуудаар тусгайлан авч үзсэн багш боловсролын хэрэглэгдэхүүн байгаа эсэх. Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь эдгээр асуудлаар практик ач холбогдолтой удирдамж өгсөн эсэх.
- Тэгш хамруулан сургах боловсролын талаар хэрэглэгдэхүүнүүдийн хэд нь тухайн орон нутаг, улс оронд хэвлэгдсэн, хэд нь тухайн бүс нутгаас гадна хэвлэгдсэн байна вэ?
- Гадаадын хэрэглэгдэхүүнүүд нь ямар улсад хэвлэгдсэн байна вэ?

Тэдгээрийг хэрхэн сонгож шалгаруулсан байна вэ?

- Гадаадын ном, сурах бичгээс багш боловсролын чиглэлээр заавал унших эсвэл уншвал зохих номын жагсаалтад оруулахдаа агуулгын ямар нэгэн дүн шинжилгээнд хамруулсан эсэх мөн эдгээр хэрэглэгдэхүүнийг орон нутгийнхаа нөхцөл байдалд хэрхэн тохируулан өөрчлөх талаар ямар нэгэн удирдамж өгсөн эсэх.
- Тэгш хамруулан сургах боловсролын талаарх хэрэглэгдэхүүнээс хэд нь тухайн улс орон, бүс нутгийн хэл дээр хийгдсэн байна вэ?
- Тэгш хамруулан сургах боловсролын талаарх багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулахад нийгмийн бусад ялгаатай бүлгийн хүмүүс (эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй, өөр хэлээр ярьдаг эсвэл угсаа гарал үүсэлтэй, хотын, хөдөөгийн гм) оролцсон эсэх.
- Тэдгээр нь хэрэглэгдэхүүний зохиогч нь байна уу, эсвэл зураач нь байна уу? Боловсруулах явцад зөвлөхийн хувиар оролцсон байна уу, эсвэл дээрх бүгдэд нь оролцсон байна уу?

### Зөвлөмжийн зорилт

Ямар ч тохиолдолд сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг болон бусад эх үүсвэрүүд аль болох олон байх нь чухал. Тэгш хамруулан сургах боловсролын багш бэлтгэх болон тэгш хамруулах сургалтын хувьд багш боловсролын хэрэглэгдэхүүний төрөл болон чанарын талаар ярих нь чухал юм. Энэ нь зөвхөн тоо, хэмжээний талаарх асуудал огт биш.

## Зөвлөмжүүд

### Хэрэглэгдэхүүний зөвлөмж 1

*“Тэгш хамруулан сургах боловсролыг зөвхөн багш боловсролын онцгой, тусгай хэрэглэгдэхүүнээр хангах ёстой бөгөөд багш боловсролын хэрэглэгдэхүүний агуулгыг бүхэлд нь хамарсан байх ёстой”.*

Багш, сурган хүмүүжүүлэгч болон оюутан-багш нар тэгш хамруулан сургах боловсролын талаар бүхий л хэрэгслийг хэрэглэх боломжтой байх ёстой. Эдгээрт зөвхөн дан ганц тэгш хамруулан сургах боловсролын талаар бичсэн ном, сурах бичгүүдээс гадна тусгай мэргэжлийн багш боловсролын хэрэглэгдэхүүнүүд ч байж болно (жишээ нь, тоо, шинжлэх ухаан, түүх, гэх мэт салбаруудаар дагнасан багш боловсролын хэрэглэгдэхүүнд тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх асуудлыг оруулсан байж болно).

Дээрх хэрэглэгдэхүүн нь тэгш хамруулан сургах боловсролын талаар гүн гүнзгий ойлголтыг бий болгохоос гадна оюутан-багш нарт тодорхой нэг хүний сурах онцлог, шаардлагад нийцсэн сургалт явуулах чадварыг олж авахад нь тус дэм

болох учиртай. Түүнчлэн багш боловсролын хэрэглэгдэхүүн нь тухайн оюутан багшид тэгш хамруулан сургах боловсролын талаар нийтэд нь, ерөнхий ойлголт өгч байна уу, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй сурагчид гэх мэт тодорхой нэг хэсэг бүлгийн талаар авч үзэж байна уу гэдгийг тодруулах шаардлагатай.

## **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 2**

*“Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг үндэсний, бүс нутгийн хэмжээнд боловсруулах шаардлагатай бөгөөд агуулга, сэдвийн хувьд тэгш хамруулан сургах боловсролын талаар сүүлийн үеийн мэдээлэл, жишээнүүдийг агуулсан байвал зохино. Гадаадад хэвлэгдсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнд илүү бүтээлчээр шүүмжлэлтэй хандаж хэрэглэх нь чухал”.*

Багш бэлтгэх сургуулийн багш болон оюутнууд агуулга, сэдвийн хувьд тухайн орон нутгийн онцлогт тохирсон тэгш хамруулан сургах боловсролын талаарх хэрэглэгдэхүүнийг ашиглах хэрэгтэй. Үүний тулд тухайн орон нутгийн багш бэлтгэх сургуулийн багш оюутнуудтай холбоотой жишээ баримт дээр тулгуурлан хэрэглэгдэхүүнийг боловсруулах шаардлагатай. Түүнчлэн нутгийн болон үндэсний хэл дээр бичигдсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнүүд илүү ихээр байх нь зүйтэй бөгөөд үүнд зөвхөн гадаад хэлнээс орчуулахаас гадна тухайн орон нутгийн хэлээр ашиглахад зориулагдсан хэрэглэгдэхүүнийг бий болгох нь чухал юм.

Гадаадаас оруулж ирсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгохдоо тэдгээрийн өгч болох нэмэлт мэдээлэл, нийтлэг чиг хандлага, харьцуулалт зэргийг харгалзан үзэхээс гадна оюутнуудад унших материалаар булаах гэх мэт дарамт учруулах ёсгүй юм. Үүнээс гадна багш бэлтгэх сургуулийн багш оюутнуудад гадаад эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг хэрхэн өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн ашиглах, тайлбарлах талаар тодорхой удирдамж өгсөн байх шаардлагатай. Ялангуяа багш бэлтгэх сургуулийн багш нар багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгох, ашиглах тал дээр бүтээлчээр, шүүмжлэлтэй хандах ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Тухайлбал, гадаад орнуудад хэвлэгдсэн номыг ашиглахдаа оюутнуудад хэзээ, хэрхэн өөрийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, мөн гадаадын жишээ баримтыг өөрийн орны жишээ баримтаар орлуулах арга барил, ур чадварыг эзэмшүүлсэн байвал зохино. Дээрх чиглэлээр багшлах боловсон хүчин тусгай ур чадвартай байх ёстой бөгөөд энэ нь дараагийн зөвлөмж руу биднийг хөтөлж байна.

## **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 3**

*“Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулж, боловсруулж байгаа багшлах боловсон хүчин нь мэргэжлийнхээ дагуу сүүлийн үеийн мэдээ баримт, дэвшилтэт аргуудыг эзэмшсэн байхаас гадна дотоод,*

*гадаадын дадлага, туршлагатай, танил байх шаардлагатай. Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж буй баг хамт олон нь улс орныхоо онцлог шинжүүдийг сайтар мэддэг байх ёстой.”*

Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулах ажлыг хариуцсан багш боловсролын байгууллага болон яамны мэргэжилтнүүд нь тэгш хамруулан сургах боловсролын талаар маш сайн мэдлэгтэй байх шаардлагатай. Энэ төрлийн ажилд шинээр ажилтан авахдаа тэгш хамруулан сургах боловсролын талаарх мэдлэг, дадлага, туршлага зэргийг харгалзан үзэж байвал зохино. Түүнчлэн багш боловсролын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж буй мэргэжлийн боловсон хүчнийг мэдлэг, боловсрол, ур чадварыг тогтмол дээшлүүлж байх шаардлагатай. Ингэснээрээ тэд тэгш хамруулан сургах боловсролын талаар сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлтэй байна. Үүнээс гадна багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж байгаа мэргэжилтнүүд нь тусгаарлагдмал бус харин бусад бүс нутаг, улс орны багш боловсролын хэрэглэгдэхүүн болон хөтөлбөр боловсруулагч нартай холбоотой ажиллаж, үзэл бодол, ажлынхаа дадлага туршлагыг солилцож байх нь чухал.

### **Монгол улс-Нөхцөл байдлын тодорхойлолт**

Багш сургалтандаа болон оюутан бие даан суралцах агуулгыг гүнзгийрүүлэн судлах, онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүн гэсэн санааг оролцогчид гаргаж байлаа. Манай улсын “Тэгш хамруулан сургах багш боловсрол”-ын хувьд онолын хэдэн ном байна. Тэдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаар бичсэн мэргэжлийн бүлэгт буюу энэ чиглэлээр суралцаж буй оюутанд зориулсан байна. Багшаар бэлтгэгдэж байгаа бүх оюутан багш нарт:

- Тооны хувьд хүртээмжтэй биш
- Мэргэжлийн нэршил ихтэй, уншиж судлахад энгийн биш онолын асуудал давамгайлсан
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан багш ашиглах хувилбаргүй. Өөрөөр хэлбэл брайлаар болон сонсох хэлбэрээр хэвлэгдээгүй байх,
- Зураг дүрсээр баяжуулаагүй ,схем диаграмм загварчлал бараг байхгүй,
- Тэгш хамруулан сургах асуудлаар ойлголт бага болон огт ойлголт авч байгаагүй оюутан багш нарт уншиж судлахад тохиромжтой бус гэсэн үнэлгээг хэлэлцүүлгээр гарган тавьж байлаа.

Санал зөвлөмжүүд: Багшаар бэлтгэгдэж байгаа бүх оюутан багш нарт хүртээмжтэй уншиж судлахад хялбар, ашиглаж хэрэглэхэд тохиромжтой байх талаар дараах зөвлөмжүүдийг санал болголоо.\

- Хэрэглэгдэхүүнд бодит жишээ кейс оруулах, зураг дүрсээр баяжуулах,
- Хэрэглэгдэхүүн боловсруулах үе шатанд дасгал даалгаврыг оюутан багш нараар гүйцэтгүүлж анализ хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх, тохиромжтой

хэрэглэгдэхүүн болох эсэхт явцын үнэлгээ хийж хариу мэдээлэл авч занших,

- Онол дадлагын харьцааг баримтлах, онолын асуудлын дараа заавал дадлага ажил гүйцэтгэх жишээ даалгавар, болон бие даан гүйцэтгэх дасгал даалгавар оруулах, мөн бүлэг бүрээр ном гарын авлагыг хэрхэн ашиглах, асуух зүйл байвал хэнд хандах, ямар шууудангийн хаягаар тодруулга хийх зэрэг нь тодорхой байх,
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан багш нарт зориулсан хэвлэлийн хувилбартай байхад анхаарах, хүртээмжийг нэмэгдүүлэх

## Бэрхшээл 2

### Практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Бодит амьдралд нийцсэн дадлага туршлагыг тэмдэглэж үлдээх, хуваалцах нь бэрхшээлтэй хэвээр байна.*

Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь багш боловсролын хөтөлбөрүүдийн адил онолын мэдээллийг их хэмжээгээр агуулсан байдаг нь олонтаа тааралддаг. Тэдгээр нь маш цөөн жишээ агуулсан байдаг бөгөөд оюутнуудад онолын мэдлэгээ амьдралд хэрхэн хэрэгжүүлэх тал дээр зөвлөгөө өгөх нь дутмаг байна.

Зарим талаараа энэ нь нэгэн том бэрхшээлийн хэсэг болж байна. Тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн зөв зүйтэй хөгжүүлэх талаар бичиж тэмдэглэсэн дорвитой жишээ баримт байдаггүй. Багш, сурагч, эцэг эх гэх мэт тэгш хамруулан сургах боловсролын талаар хамгийн сайн жишээ баримтыг буулгаж чадах хүмүүс нь өөрсдөө шаардлагатай дадлага, туршлага, цаг зав, боломж дэмжлэгээр хомс байдаг байна.<sup>3</sup> Ийм жишээ баримт болон тэдгээрийг баримтжуулах тогтсон арга барилгүйгээр багш, оюутнууд онолын мэдлэгээ “дүрслэн бодож”, шинэ санаа зохиож, бусадтайгаа түүнийгээ хуваалцахыг хичээдэг. Эцэст нь багш боловсролд шинэлэг мэдээлэл, баримт цөөхөн хэвээр үлддэг байна.

*Багш боловсролын хэрэглэгдэхүүн боловсруулагчдад бодит амьдрал дээр тулгуурласан дадлага, туршлага дутмаг байна.*

Багш боловсролын хэрэглэгдэхүүнд практик ач холбогдол дутмаг байгаа нь тэгш хамруулан сургах боловсролын хэрэглэгдэхүүн боловсруулагч нарт бодит амьдрал дээр тулгуурласан дадлага, туршлага байхгүйг харуулж байж

<sup>3</sup> Боловсролын Сүлжээг Дэмжих байгууллага (БСДБ) зэрэг байгууллагууд тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх үйл хэрэгт оролцож буй талуудад өөрсдийн бодит жишээ, туршлагаа тэмдэглэн үлдээж, бусадтай хуваалцахад нь тусалцаа өгч ажиллаж байна: [www.eenet.org.uk](http://www.eenet.org.uk)

болох юм. Тэдгээрийн тоонд сурах бичиг зохиогч нар, зураач, зурагчин, кино найруулагч нар ч орж болно. Хэдийгээр тэд тэгш хамруулан сургах боловсролын талаар онолын талын мэдлэгийг ойлгож харуулж чадах хэдий ч тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн явуулах тал дээр тайлбарлахдаа практик, дадлага, туршлагаар дутаж болох юм. Нөгөө талаас багш, хичээлийн эрхлэгч, эцэг эх, сурагч, цөөнхийн бүлгийн гишүүд зэрэг тэгш хамруулан сургах боловсролын талаар практик дадлага, туршлагатай хүмүүс нь өөрсдөө багш боловсролын хэрэглэгдэхүүний төлөвлөлт, биелэлт болон хяналтад ховор оролцдог байна.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно**

- Багш боловсролд ашиглаж байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг хэн төлөвлөж, бичиж, хянан тохиолдуулдаг вэ? Тэдгээр хүмүүсийг хэрхэн сонгон шалгаруулдаг вэ? Тэдгээр хүмүүс нь улс орныхоо хүн амын цөөнхийн бүлгүүдийг төлөөлж чадах уу?
- Багш боловсролын материалыг боловсруулж буй хүмүүс нь тэгш хамруулан сургах боловсролын салбарт ямар төрлийн дадлага туршлагыг ямар хэмжээнд эзэмшсэн бэ?
- Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж байгаа хүмүүст тэгш хамруулан сургах боловсролын талаар агуулга, сэдвийн хувьд тохиромжтой, дотоод гадаадын практик жишээг олж ашиглахад нь тус болох ямар тогтолцоо байдаг вэ?
- Гадаад орны хэрэглэгдэхүүнийг хэрхэн сонгож шалгаруулж, практик ач холбогдолтой эсэхийг тодорхойлдог вэ?
- Боловсролыг хөгжүүлэх явцад оролцож буй талууд тэгш хамруулан сургах боловсролын салбар дахь багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулахад үүрэг хариуцлага хүлээдэг үү? Хэрэв тийм бол төлөвлөлт, боловсруулалт, хяналтад хэрхэн хувь нэмэр оруулдаг вэ?

## **Зөвлөмжүүд**

### **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 4**

*“Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь тэгш хамруулсан сургалтын боловсролын талаар бодит амьдрал дээр тулгуурласан баримт, жишээнүүдийг боловсролын өөр өөр орчинд аль болох ихээр агуулсан байх шаардлагатай.”*

Хэрэв оюутнуудад тэгш хамруулан сургах боловсролын талаар бүрэн ойлголт өгч, бодит амьдрал дээр хэрэгжүүлж чадах дадал туршлагыг олгоё гэвэл тэдэнд хангалттай хэмжээний дадлага, туршлага олж авах боломжийг нь сургалтын хөтөлбөрт тусгасан байх хэрэгтэй гэдгийг зөвлөмж 3-аас бид олж мэдсэн. Багш



боловсролын энэхүү практик тал нь нэн ялангуяа өөр өөр насны суралцагчдад өөр өөр сургалтын арга барил хэрэглэдэг сургуульд ажиллахаар бэлтгэж буй оюутнуудад хэрэгтэй юм. Үүнээс үүдэн оюутан- багшийн бэлтгэлийг хангахад зориулагдсан хэрэглэгдэхүүн нь мөн адил практик ач холбогдолтой байх шаардлагатай.

Багш боловсролд хэрэглэж буй сургалтын хэрэглэгдэхүүн нь дараах хоёр шаардлагыг хангасан байна:

(а) Боловсролын янз бүрийн түвшний байгууллагад бусад хүмүүс амьдралын бодит жишээн дээр хэрхэн, яаж шийдвэрлэснийг хараад өөрийн нөхцөл байдалд тохируулж харьцуулан эргэцүүлэхэд нь тус дэм болохуйц төрөл бүрийн бодит амьдралын туршлага, жишээнүүдийг оюутнуудад өгсөн байх.

б) Оюутнуудыг төрөл бүрийн удирдамж, зөвлөмжүүдээр хангаснаар өөрсдийнх нь практик үйл ажиллагааг дэмжсэн байх.

Дээрх шаардлагуудыг биелүүлэхийн тулд тэгш хамруулан сургах боловсролын бодит амьдрал дээр гарсан жишээнүүдийг цуглуулснаар багш боловсролын хэрэглэгдэхүүн боловсруулагч нар болон сурган хүмүүжүүлэгчид сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад нь ашигтай юм. Энэ нь нөгөө талаас боловсролыг хөгжүүлэхэд оролцогч талуудад өөрсдийн амьдрал дээр тохиолдсон бодит жишээнүүдийг тэмдэглэж, бусадтай дадлага, туршлагаа солилцож байхыг шаардана. Тэгш хамруулан сургах боловсролын талаар амьдралын бодит жишээ, дадлага туршлагуудыг тэмдэглэсэн баримт олон байдаг ч тэдгээрийг бичиж тэмдэглээгүй тохиолдол бас цөөнгүй байна. Иймээс хамтарсан үйл ажиллагаа явуулж олон сургууль, боловсролын төслүүд өөрсдийн тэгш хамруулан сургах боловсролын талаарх бодит жишээ баримтуудаа тэмдэглэн үлдээх хэрэгтэй байна. Ингэснээр багш боловсролын үйл ажиллагаанд үзүүлж буй туслалцаа дэмжлэг нь шууд хүрч тогмолжино. Бичгээр тэмдэглэсэн жишээ, баримтуудаас гадна дуу бичлэг, гэрэл зураг, дүрс бичлэг зэрэг хэлбэрээр хадгалж үлдээх нь бусадтай хуваалцах, түгээх нэгэн үр өгөөжтэй хэлбэр болоод байна.

### **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 5**

*“Оролцогч талууд тэгш хамруулан сургах боловсролын талаарх сургалтын материалыг хянахад илүү их үүрэг хүлээх шаардлагатай”.*

Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулах үйл явцад сонирхлын бүлгүүд илүү их оролцоотой байх нь зохистой. (тэдгээрийг хөтөлбөр боловсруулахад оролцох ёстой гэдгийг зөвлөмж 3-т заасныг бид өмнө нь дурдсан билээ.) Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг төлөвлөж, бичиж боловсруулахад багш, эцэг эх, суралцагчид болон цөөнхийн бүлгийн гишүүд зэрэг бүгд зөвлөлдөн оролцох ёстой. Тухайн хичээлийг зааж байгаа багш нар нь хэрэглэгдэхүүний практик ач холбогдлын талаар өөрийн санал бодлоо илэрхийлж болохын

зэрэгцээ бусад оролцогч талууд багш нарын юуг мэдэх болон хийх ёстой гэдгийг тодорхой жишээ баримтуудаар эерэг ба сөрөг нөлөө бүхий тохиолдлуудаар харилцан ярилцах нь цаашид багш нарт юу хийх, юунаас зайлсхийх тал дээр удирдамж болж болох юм.

## Замби улсын жишээ

*Багш нарыг бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүнийг багш нар өөрсдөө боловсруулж байна.*

Энэхүү жишээ нь тэгш хамруулан сургах боловсролыг хөгжүүлэх явцад оролцогч талууд хэрхэн хамтран ажиллаж, практик амьдрал дээр тулгуурласан дадлага, туршлагаа хэвлүүлж байгааг харуулж байна. Замби улсын Мпика дүүргийн хэсэг сургуульд Боловсролын сүлжээг дэмжих байгууллагаас (EENET) санаачлан судалгааны төсөл хэрэгжүүлжээ. Тус төслийн зорилго нь багш нарыг өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийдэг, сайтар ойлгож тэмдэглэдэг болгоход оршиж байсан юм. Тус төсөлд оролцсон багш нар өөрийн сургууль дээр тэгш хамруулан сургах боловсролын үйл явцыг хэрэгжүүлэн заах арга, сурах үйл ажиллагааг улам чанаржуулахыг оролдлого хийж байсан боловч тэд үйл ажиллагаагаа тэмдэглэн баримтжуулж, илүү өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлээгүй тул бусад багш оюутнууд үр шимийг нь хүртэж чадаагүй юм.

Гадаад, дотоодын байгууллагуудын тусламжтайгаар хэд хэдэн цуврал сургалт семинар, ярилцлага гэх мэт туршилтын үйл ажиллагаа явуулсны эцэст багш нар өөрсдийн хийсэн судалгаа болон түүнд тохирсон арга хэмжээнийхээ талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хийж эхэлсэн байна. Үүний дараа тус судалгааг дэмжигч орон нутгийн байгууллага нь их хэмжээний судалгааны гар бичмэлийг хэвлүүлэхээр Боловсролын сүлжээг дэмжих байгууллага (EENET)-д илгээжээ. Хэдийгээр эхэндээ эдгээр судалгааны баримтуудыг хэвлэхэд тохиромжгүй байсан ч орон нутгийн дэмжигч байгууллагуудын тусламжтайгаар багш нартай хэд хэдэн удаа ярилцсаны эцэст зарим тодорхойгүй байсан зүйлийг нягталж дутуу байсан мэдээллийг нөхөж олсон байна.

Тус судалгааны мэдээ, тоо баримтуудыг “Дадлага, туршлагаа судлах нь”<sup>4</sup> гэсэн нэрээр ном болгон хэвлэсэн байна. Хожим нь энэ төсөлд оролцсон багш нар шинээр ирсэн багш нартаа тус номыг уншихыг зөвлөж, сургуулийнхаа хийж бүтээсэн ололт, амжилт, дадлага туршлагыг хуваалцахыг уриалах болжээ.

<sup>4</sup> БСДБ (EENET). 2003. Дадлага, туршлагаа судлах нь: Замбийн Мпика мужийн Читулика сургууль, Кабале бага сургууль, Мпика бага сургууль, Мусакания бага сургууль, Ниянжи дунд сургуулийн багш нарын бүтээлийн цомог. Манчестер. EENET. [http://www.eenet.org.uk/resources/docs/rsrching\\_experience.pdf](http://www.eenet.org.uk/resources/docs/rsrching_experience.pdf)

## Монгол улсад

Тэгш хамруулан сургах чиглэлийн хэрэглэгдэхүүн нь /гарын авлага, сурах бичиг/ ихэвчлэн хөгжлийн бэрхшээлийн талаарх онолын голдуу байгаа бөгөөд тэр бүр хүртээмжтэй биш байна. Аргазүйн болон практик ач холбогдолтой хэрэглэгдэхүүн дутагдалтай байгаа бөгөөд Замби улсын жишээгээр багш бүр тэгш хамруулан сургах асуудлаар жишээ кейсийг тэмдэглэн, арга туршлагаа хуваалцан өөрийн орны онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн бэлтгэн гаргах нь тулгамдсан асуудал болоод байна.

### Монгол улс-Нөхцөл байдлын тодорхойлолт, сайжруулах зөвлөмж

Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь онолын мэдээллийг их хэмжээгээр агуулсан байдаг нь олонтаа тааралддаг. Тэдгээр нь маш цөөн жишээ агуулсан байдаг бөгөөд оюутнуудад онолын мэдлэгээ амьдралд хэрхэн хэрэгжүүлэх тал дээр зөвлөгөө өгөх нь дутмаг байна Энэ асуудал манай улсын хувьд ч ижил байна. Жишээ баримтаар дэлгэрүүлсэн ном гарын авлага хэрэглэгдэхүүн байхгүй байна.

#### Санал зөвлөмжүүд:

- Дээр дурдагдсан онол дадлагын харьцааг баримтлах
- Тэгш хамруулан сургахад түгээмэл тохиолддог асуудлуудыг гарган түүнд хариулт, гаргалгаа, шийдвэрлэх арга замын хувилбаруудыг оновчтой тусгах,
- Жишээ баримт болон тэдгээрийг баримтжуулах тогтсон арга барилтай болж оюутнуудын багшлах дадлагын үеэр баримт жишээ цуглуулах, шинэлэг мэдээлэл эрэлхийлэхэд урам дэмжлэг өгөхөд анхаарах
- Сурах бичиг зохиогчид тэгш хамруулан сургах боловсролын талаар онолын мэдлэгийг ойлгож харуулж чадах хэдий ч тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн явуулах тал дээр тайлбарлахдаа практик, дадлага, туршлагаар дутагдалтай байдаг учраас зохиогчдын багийг сонгохдоо тэгш хамруулан сургалтыг гардан зохион байгуулж байгаа багш нарын төлөөллийг оролцуулах боломжийг хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй болон өвөрмөц ялгаатай хүүхэдтэй эцэг эх асран хамгаалагч нар болон багш нарын санаа бодлыг тусгах, хэлэлцүүлэгт урих, амьдрал дээр тэдэнтэй ажиллахад, сургаж хөгжүүлэхэд ямар асуудал бэрхшээл тулгардаг талаар жишээ баримтыг сурах бичиг гарын авлага боловсруулахаас өмнө цуглуулж эрэмбэлэх,
- Тулгардаг бэрхшээл асуудлыг даван туулахад зориулсан арга зам шийдлийг зохиогчид онолын болон практик ач холбогдлоор тайлбарлах
- Амьдрал дээр хэрэгжүүлсэн туршлага арга замыг хэрэглэгдэхүүнд тусгах,

- Багш, хичээлийн эрхлэгч, заах аргын нэгдлийн ахлагч, эцэг эх, сурагч, цөөнхийн бүлгийн гишүүд зэрэгтэгш хамруулан сургах боловсролын талаар практик дадлага, туршлагатай хүмүүс нь өөрсдөө багш боловсролын хэрэглэгдэхүүний төлөвлөлт, биелэлт болон хяналтад оролцох оролцоог нэмэгдүүлэх
- Сурах бичиг зохиогчдыг орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд судалгаа харьцуулалт хийх жишээ баримт цуглуулах, тэгш хамруулан сургах сургалтыг хэрэгжүүлж байгаа нөхцөл байдалтай биечлэн танилцах, багш, эцэг эх хөгжлийн болон нийгэм соёлын ялгаатай сурагчидтай ярилцах, ажиглах нөхцлийг бүрдүүлэх, цаг зав, боломж, цалин урамшууллаар дэмжих зэрэгт анхаарах хэрэгтэй байгааг хэлэлцүүлэгт оролцогчид хөндөн тавилаа.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутан багш нарт тулгардаг бэрхшээлийг багасгах, цаашилбал арилгахад тусалдаг хэрэгсэл бий болсоор байна. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан зарим хэрэгсэл түүнийг хэрхэн ашиглах талаар Дондовдоржийн Гэрэл /Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо/ -ийн танилцуулсан мэдээллийг энэхүү зөвлөмжид орууллаа.

Өнөөдөр харааны бэрхшээлийн улмаас учирч байгаа хүндрэл бэрхшээлүүдийг арилгах, багасгах, хөгжиж, боловсроход нь дэмжлэг үзүүлдэг туслах хэрэгслүүд шинээр зохион бүтээгдэж, өдөр тутмын хэрэглээнд нэвтэрсээр байгаа билээ. Үүнд тухайлбал

- Аливаа дүрс, тэмдэг тэмдэглэгээ болон текстийг брайль болон ердийн үсгээр хосолсон нарийвчлалтайгаар чанарын өндөр түвшинд хэвлэдэг BRAILE emboser
  - » **Perkins Бройли бичгийн машин:** /энэхүү машинд брайль үсгээр бичсэн текстэн мэдээлэл нь уг машины дэлгэц дээр ердийн үсгээр давхар гарч байдаг тул тухайн харааны бэрхшээлтэй оюутан залуучуудад үе тэнгийн найз нөхөд багш нар нь бичсэн зүйлийг харж хянах боломжтой болдог байна.
  - » **Ухаалаг самбар:** Энэ нь багшийн самбар дээр бичсэн хичээлийг wireless- интернэтийн тусламжтайгаар сул хараатай оюутан сурагчид нь өмнөө байгаа компьютерын дэлгэцэн дээр томруулсан үсгээр, хараагүй оюутан сурагчид нь брайль үсэгт хувирган хүлээн авах боломжтой байдаг.
  - » **Хэвлэмэл бүтээлийн бар код:** Хэвлэхэд ямар нэгэн нэмэлт зардал гардаггүй бөгөөд зөвхөн тухайн text-ийг хадгалахдаа бар кодтой хадгална гэсэн тохиргоог сонгож хадгалахад л болно. Орчин үеийн бүх ухаалаг гар утаснууд өөртөө байгаа “voice over” ( утасны дэлгэц дээрх text-ийг ярьж уншдаг application)-ын тусламжтайгаар бар кодтой хэвлэгдсэн бүх хэвлэмэл бүтээлүүдийг хараагүй хүнд уншиж өгөх боломжтой юм.

Өөрөөр хэлбэл бар кодтой хэвлэгдсэн ном хэвлэл сонин сэтгүүл гэх мэт бүхий л төрлийн хэвлэмэл бүтээлийг хараагүй хүн ухаалаг гар утасныхаа тусламжтайгаар унших боломжтой болдог байна.

## Бэрхшээл 3

### Сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулан ашиглах уян хатан чанар

#### Улс орны хувьд -Нөхцөл байдлын шинжилгээ

Дээрх бүлгүүдээс үзвэл оюутан-багш нарт зориулсан тэгш хамруулан сургах боловсролын талаарх сургалтын хэрэглэгдэхүүн нь тэр болгон шинэлэг, амьдралд ойр, жинхэнэ бодит үйл явдал, дадлага, туршлага дээр тулгуурласан байдаггүй нь илэрхий байна. Иймээс эдгээр хэрэглэгдэхүүнүүд нь оюутан-багш нарт харилцан адилгүй сурагчидтай нөхцөл байдалд орсон тохиолдолд өөрийн үүрэг зорилгоо ойлгож ухамсарлах, хэрэгжүүлэхэд тэр болгон тус болж чаддаггүй. Учир нь эдгээр сургалтын хэрэглэгдэхүүн нь өөр оронд ашиглахаар зориулан боловсруулагдсан байж болох юм.

Түүнчлэн боловсролын тогтолцооны бүх түвшин дэх сургалтын хэрэглэгдэхүүний талаарх байдлыг тусгаж болох бас нэг өөр бэрхшээл байж болно. Энэ нь багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн зарим тохиолдолд хэт явцуу бөгөөд хуучинсаг, нэг үзэл бодлыг тулгасан байдагт оршино. Багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдүүдийн хэрэглэдэг зарим сурах бичгийн адил хэт явцуу, тогтсон үйл ажиллагааг харуулсан байдаг учраас багш, сурган хүмүүжүүлэгч нарт тэдгээрийг өөрчлөхөд хүндрэлтэй, эсвэл зарим тохиолдолд бүр боломжгүй байдаг. Нэлээд хэдэн улс орны шалгалтын хатуу тогтсон тогтолцоо нь мөн л багш сурган хүмүүжүүлэгч нар хөтөлбөрт ороогүй хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Иймэрхүү уян хатан чанар байхгүй байгаа нь багш сурган хүмүүжүүлэгч нарт сургалтын хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр ашиглах, өөр бусад орны хэрэглэгдэхүүнийг өөрийн нөхцөл байдал болон оюутнуудын хэрэгцээ шаардлагад тохируулан өөрчлөн хэрэглэхэд бэрхшээлтэй болгодог ажээ. Үүнээс гадна хатуу тогтсон агуулга бүхий сургалтын хэрэглэгдэхүүн нь оюутан суралцагчдын идэвхтэй үйл ажиллагааг шаардсан, суралцагч төвтэй заах, сурах арга барилыг ашиглахад бэрх болгодог байна. Хэрэв тухайн багш, сурган хүмүүжүүлэгч нь уян хатан, чөлөөт аргаар заах арга барилыг эзэмшээгүй бол бүр боломжгүй болгодог байна.

Багш боловсролын олон тогтолцоонд үндсэн бэрхшээл, хүндрэл тулгарсан хэвээр байна. Оюутан багш нар тэгш хамруулан сургах боловсролын талаар мэдэх ёстой байтал тэдгээрийн хичээлдээ үзэж байгаа хэрэглэгдэхүүн нь энэ

асуудлыг хөндөө ч үгүй байдаг байна.

**Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжилхэд дараах асуултууд тус болно:**

- Тэгш хамруулан сургах боловсролын сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг багш сурган хүмүүжүүлэгчид ашиглах эсвэл өөрчлөн засварлахад хялбар байгаа эсэх тал дээр хянан шалгалт хийсэн үү?
- Багш сурган хүмүүжүүлэгч нар нь сургалтын ямар хэрэглэгдэхүүнийг, хэзээ ашиглах тал дээр өөрийн гэсэн бодол шийдвэрээ гаргах эрхтэй юу? Багш сурган хүмүүжүүлэгч нарын хэрэглэж буй сургалтын хэрэглэгдэхүүнд ямар нэгэн хязгаарлалыг тогтоосон уу?
- Багш боловсролын сургалтад ашиглагдаж буй сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, хэлбэрийг багш, сурган хүмүүжүүлэгчид өөрийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөх, ашиглах мэдлэг, дадлага туршлагыг эзэмшсэн үү?

## Зөвлөмжүүд

### Хэрэглэгдэхүүний зөвлөмж 6

*“Багш боловсролын сургалтад ашиглаж буй хэрэглэгдэхүүнийг багш сурган хүмүүжүүлэгч нар сонгон шалгаруулах, өөрчлөх болон ашиглах эрх чөлөөг эдлэх эрхтэй.”*

Тэгш хамруулан сургах боловсрол нь асуудал шийдвэрлэсэн, өөрчлөлт болон туршилтын нэгэн үйл явц болохыг зөвлөмж 1-д дурдсан билээ. Тэгвэл тэгш хамруулан сургах боловсролыг үр бүтээлтэй хөгжүүлэх чадвар бүхий багш, сурган хүмүүжүүлэгч нарыг бэлтгэхийн тулд сурах, сургах арга барилд уян хатан чиг хандлагыг бий болгож чадах тусгай хөтөлбөр шаардлагатай болно. Харин үүнийг хэрэгжүүлэхийн тулд тухайн орон нутгийн нөхцөл байдал болон оюутан-багш нарын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчилж болохуйц сургалтын хэрэглэгдэхүүнийг бий болгох хэрэгтэй.

Тэгш хамруулан сургах боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн бүр тэр бүр төгс байж чадахгүй. Үүнтэй адил аливаа улс орны засгийн газар, эсвэл багш боловсролын байгууллага бүрт өөрийн багш бэлтгэх явцад хэрэглэгдэж буй сургалтын хэрэглэгдэхүүнийг бүхэлд нь өргөн далайцтайгаар, түргэн шуурхай хянан шалгах эх үүсвэр, боломж байдаггүй. Иймээс багш, сурган хүмүүжүүлэгчид шинэ сургалтын хэрэглэгдэхүүнийг хайж олох, турших, тэдгээрийг өөрсдөө боловсруулах, эсвэл тухайн үед ашиглаж буй хэрэглэгдэхүүнийг өөрчлөн шинэчлэх тодорхой хэмжээний дадлага, туршлагатай, эрх чөлөөтэй байвал зохино. Түүнчлэн багш, сурган хүмүүжүүлэгч нарт багш боловсролын явцад ашиглаж буй хэрэглэгдэхүүнийг хайж олох, боловсруулах, өөрчлөн шинэчлэх дадлага, туршлагаа бие биетэйгээ хуваалцахад нь туслалцаа дэмжлэг үзүүлдэг

байх шаардлагатай. Энэ талаар зөвлөмж 5-д илүү дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Ихэнх улс оронд багш, сурган хүмүүжүүлэгч нарт иймэрхүү эрх чөлөө олгож, шаардлагатай дадлага, туршлагыг эзэмшүүлэх нь том хэмжээний бодлогын өөрчлөлтийг хийхэд хүргэнэ. Нэн ялангуяа төвлөрсөн шинжтэй, явцуу багш боловсролын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүнтэй улс оронд энэ нь бүр их чухал юм.

### **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 7**

*“Багш боловсролд ашиглагдаж буй хэрэглэгдэхүүн нь багш, сурган хүмүүжүүлэгч нарын тэгш хамруулан сургах боловсролд хийж буй үйл ажиллагаа, жишээг тусгасан байх шаардлагатай.”*

Багш боловсролд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Оюутан-багш болон багш, сурган хүмүүжүүлэгчдэд өөрийн гэсэн шүүмжлэлтэй хандах боломжийг олгосон байх.
- Багш, сурган хүмүүжүүлэгч нарт аливаа даалгавар эсвэл сэдвийг сонгох, өөрчлөн шинэчлэх эсвэл өөр сэдвээр солих зэрэг бололцоог олгосон байх.
- Багш, сурган хүмүүжүүлэгч нарт харилцан суралцах, бие даан суралцах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх гэх мэт төрөл бүрийн аргуудыг ашиглах боломж олгосон байх.
- Багш, сурган хүмүүжүүлэгч нарт сургалтын өөр өөр онцлог, шаардлагад нийцүүлэх зорилгоор шинэлэг чиг хандлагуудыг ашиглахад нь дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөсөн байх.

Дээрх шаардлагуудыг биелүүлэхийн тулд багш, сурган хүмүүжүүлэгч нарыг олон талын мэдлэг боловсролыг эзэмшүүлж, тэдгээрийн заах арга зүйн чиг хандлагыг дахин хянахад хүргэнэ. (Зөвлөмж 5-г үз)

### **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 8**

*“Багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг сурах идэвхитэй арга барилыг эзэмшсэн, аливаа хэрэглэгдэхүүнийг өөрчлөн шинэчлэх дадлага, туршлагатай хүмүүс төлөвлөж, бэлтгэж боловсруулсан байвал зохино.”*

Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулж, боловсруулж байгаа хүмүүс нь аливаа хэрэглэгдэхүүний агуулга болон чанарын сул ба давуу талыг мэдэхээс гадна идэвхтэй, суралцагч төвтэй, суралцагчдын үйл ажиллагааг хамруулсан заах, сурах арга барилуудын талаар сайтар ойлголттой байх шаардлагатай. Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж буй хүмүүс нь багш сурган хүмүүжүүлэгч нарт практик ач холбогдолтой зөвлөгөө, удирдамжийг өгөхийн тулд өөрсдөө хичээлийг уян хатан, үр дүнтэй заах дадлага, туршлагатай байх шаардлагатай.

## Монгол улс-Нөхцөл байдлын тодорхойлолт

*Монгол улсад “Тэгш хамруулан сургах багшийн боловсрол”-ын хэрэглэгдэхүүнийг боловсролын бодлогоор дэмжих, уян хатан олон хувилбартай байх талаар хийгдсэн ажил үндсэндээ байхгүй байна.*

Улс орны шалгалтын хатуу тогтсон тогтолцоо, агуулга стандарт, хувилбаргүй хөтөлбөр, үнэлгээний нэгдсэн журам нь багш сурган хүмүүжүүлэгч нарт хувилбартай хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжийг хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл сургалтын явцад ажиллуулах ялгаатай дасгал даалгавар, хүүхдийн хувийн онцлогт тохирсон шалгалтын ажлын хувилбарт даалгавар зэргийг боловсруулж хэрэгжүүлэх түүнийг үнэлж дүгнэх зохицуулалт байхгүй зэрэг нь сургалтын хэрэглэгдэхүүний уян хатан чанарт сөргөөр нөлөөлсөөр байна. Иймэрхүү уян хатан чанар байхгүй байгаа нь багш сурган хүмүүжүүлэгч нарт сургалтын хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр ашиглах, өөр бусад орны хэрэглэгдэхүүнийг өөрийн нөхцөл байдал болон оюутнуудын хэрэгцээ шаардлагад тохируулан өөрчлөн хэрэглэхэд бэрхшээлтэй болгодог ажээ.

Санал зөвлөмжүүд :

- Тэгш хамруулан сургах боловсролын сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг багш сурган хүмүүжүүлэгчид ашиглах эсвэл өөрчлөн засварлах түүний талаар тэмдэглэл хөтлөн баримтжуулах , өөрчлөлт сайжруулалтыг зохиогчийн багт илгээж хариу мэдээлэл солилцдог тогтолцоотой болох
- Багш сурган хүмүүжүүлэгч нар нь сургалтын хянагдсан зөвшөөрөгдсөн хэрэглэгдэхүүнийг, хэзээ ашиглах тал дээр хэрэглэгдэхүүнийг өөрийн гэсэн бодол шийдвэрээ гаргах эрхийг багш нарт өгөх
- Багш боловсролын сургалтад ашиглагдаж буй сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, хэлбэрийг багш, сурган хүмүүжүүлэгчид өөрийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөх, ашиглах мэдлэг, дадлага туршлага хуваалцах семинар уулзалт зөвлөгөө, цахим хэлэлцүүлгийг хийж хэвших, өөрчлөлт, тохируулгыг баримтжуулан үлдээх зэрэг болон сөрөг үр дагаврыг тэмдэглэхэд суралцаж тогтмолжсон үйл ажиллагаа болгон хэвших



# Бэрхшээл 4

## Явцуу хүрээг хамарсан сургалтын хэрэглэгдэхүүнээс зайлсхийх

### Улс орнуудын хувьд -Нөхцөл байдлын шинжилгээ

Багш боловсролын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүн нь багш боловсролын тогтолцоо, эсвэл багш нарын дунд ялгаварлан үзэх үзэл, хуурамч ташаа ойлголтуудыг тэр болгон үгүй болгож чаддаггүй болохыг зөвлөмж 3-аас бид харж болно. Багш боловсролд ашиглагдаж буй зарим хэрэглэгдэхүүн нь нийгэм дэх буруу ташаа ойлголт болон ялгаварлан үзэх үзлийг улам лавшруулж, улмаар агуулга, ашигласан хэл болон хэлбэрийнхээ шинж чанараас шалтгаалж тухайн оюутныг сурах үйл явцаас нь хөндийрүүлэхэд ч хүргэж болно.

*Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүнд өөр өөр хэлний онцлогийг харгалзан тусгаагүй байх.*

Зарим багш боловсролын хөтөлбөр болон хэрэглэгдэхүүнд олон хэлний боловсролын ач холбогдлын талаар тэр болгон гүйцэд тусгаагүй байдаг тул оюутан-багш нарт тухайн суралцагчдын эх хэлийг нь ашиглах арга барилыг зааж сургадаггүй байна. Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүнд хэл, соёлын талаар дорвитой авч үзсэн нь хомс хэвээр байна. Энэ нь оюутан-багшийг сургалтын явцад тухайн орон нутгийн хэл болон үндэсний хэл хоёрын хоёуланг нь ашиглах дадлага туршлагыг эзэмшихэд нь сөргөөр нөлөөлж байна.

*Монгол орны нөхцөлд казак хэл дээр гаргасан тэгш хамруулан сургах сургалтын чиглэлээр хэрэглэгдэхүүн бараг байхгүй байна.*

Олон улсын түвшинд ч хүн амын цөөнхийн хэл дээр бэлтгэсэн багш боловсролын талаар сургалтын хэрэглэгдэхүүн ховор байх нь цөөнгүй тохиолддог тухай энэхүү зөвлөмжинд тэмдэглэсэн байна. Жишээлбэл, ЮНЕСКО-гоос багш боловсролын тайланд зарим улс оронд цөөнхийн хэл дээр бичсэн ном, сурах бичиг огт байхгүй байхад өөр бусад орнуудад багш боловсролын байгууллагуудад үндсэн хэлнээс бусад хэл дээр бичсэн ном, сурах бичиг хязгаарлагдмал байна гэжээ.<sup>5</sup> Зарим газар цөөнхийн хэл дээр бичсэн хэрэглэгдэхүүн байгаа ч гэсэн тэр нь бусад хэлнээс шууд орчуулсан, тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохируулаагүй байдаг байна. Хүн амын цөөнхийн хэлээр ярьдаг оюутан-багш нарт өөрсдийнх нь хэл дээр бэлтгэсэн сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй, багш боловсролын хөтөлбөр хэрэглэгдэхүүнд хэл, соёлын ялгааг дутмаг харгалзан үзсэнээс үүдэн сурах үйл ажиллагаанаас тусгаарлагдсан мэт сэтгэгдэл төрж болох юм. Тухайлбал зарим багш боловсролын хэрэглэгдэхүүнд хүн амын цөөнхийн талаар хангалттай дурдаагүй эсвэл бүр буруу, ташаа ойлголт өгөхүйц мэдээллийг ч оруулсан байж

<sup>5</sup> Форгакс, 2012, 36 х

болно. Үүнтэй холбогдуулан зарим багш боловсролын хэрэглэгдэхүүнд хот, хөдөөгийн хүмүүсийн хоорондын ялгааг харгалзан үзээгүй байх тохиолдол ч байж болох юм.

*Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүн нь хэрэглэх боломжгүй эсвэл хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ташаа ойлголт өгсөн байж болно.*

Хэдийгээр багш боловсролын хөтөлбөрүүдэд тэгш хамруулан сургах боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролын талаар тусгай хичээл гаргасан эсвэл хөтөлбөрт тусгасан байсан ч гэсэн тухайн хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй оюутан-багш хөтөлбөрт хамрагдаж чадахгүй болно. Тухайлбал: Зарим Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудад Бройли үсгээр хэвлэгдсэн багш боловсролын талаарх хэрэглэгдэхүүн тун хомс байгааг ЮНЕСКО-гийн Бангкок дахь салбарын тайлангаас үзэж болно.<sup>6</sup> Энэ бол түгээмэл бэрхшээл бөгөөд Кэни улсын нэгэн оюутан-багш ийнхүү дурсаж байна.

“Би харааны бэрхшээлтэй бөгөөд багшийн ангийн оюутан. Бройлийн үсгийг хэрэглэдэг. Гэвч бидэнд Бройли бичгээр хэвлэгдсэн ном сурах бичиг маш цөөн байдгаас гадна үсгийн цаас нь ч олддоггүй. Түүнчлэн харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулсан тоо бодлогын хэрэгсэл, төхөөрөмж ховор тул энэ хичээлээр шалгалт өгөхөд хүндрэлтэй байдаг. Тусгай боловсролоор мэргэшсэн багш байдаггүй бөгөөд нэг л багш Бройлийн үсгийг уншдаг. Тиймээс бичиг үсгийг хөрвүүлэх болон үнэлгээн дээр хүндрэл бэрхшээлүүд их гардаг.”<sup>7</sup>

*Монгол улсын багш бэлтгэх сургуулийг төгссөн сонсголын бэрхшээлтэй багшийн яриа*

Надад суралцах явцад олон бэрхшээлүүд гардаг байсан. Багш нар хичээлээ ихэвчлэн лекцийн аргаар явуулдаг, зураг дүрс бүхий хэрэглэгдэхүүн бараг ашигладаггүй, дээр нь дохионы хэлний орчуулагч байхгүй тул би бүх хичээлийг оюутнуудаас хуулбарлан авч гэртээ харьсан хойноо гэрийнхнээрээ дохионы хэлний тусламжтайгаар тайлбарлуулахыг хичээдэг байв. Багш бэлтгэх сургуульд дохионы хэлний орчуулагч багш байсан бол би үүнээс илүү сурах байсан. Сонсголын бэрхшээлтэй хүмүүст өөрийн эх хэл дээр хичээлээ үзэж байгаа ч зарим үгийн утгыг ойлгохгүй толь бичгээс харах, бусдаар тайлбарлуулах зэрэг нэмэлт ажлууд үргэлж тулгардаг байлаа. Би уг нь дүрслэх урлагийн сургуульд суралцсан боловч тэнд миний онцлог хэрэгцээг харгалзах харилцааны болоод арга зүйн ямар ч дэмжлэг байгаагүйгээс би зөндөөн уйлж аргагүйн эрхэнд тэр сургуулийг орхисон ... тэгээд л багшийн сургуулийг сонгосон ...

<sup>6</sup> Форгакс, 2012, 37х

<sup>7</sup> П. Муаняло, И.Лүис. 2012. Заах аргыг сайжруулах нь. Муанялотой хийсэн ярилцлага. “Боловсролыг шинжихүй” сэтгүүл. 2012 оны 12-р сар. Дугаар 1

Түүнчлэн дээрх тайлангаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар багш боловсролын хэрэглэгдэхүүнд маш бага мэдээлэл тусгасан байгаа нь илэрсэн. Тухайлбал, нэгэн улсын сурах бичгүүдийг хянаж үзэхэд агуулгад гарч буй хүмүүсийн зөвхөн 0,35% нь л хөгжлийн бэрхшээлтэй байжээ. Үүнээс гадна тэдгээрт гарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сөрөг байдлаар оруулсан байжээ.<sup>8</sup> Багш боловсролын хэрэглэгдэхүүн дэх энэ хомсдол болон багш боловсролын хэрэглэгдэхүүн дэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар дурдсан сөрөг мэдээллүүд нь хүмүүсийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар буруу ойлголт төрүүлдэг бөгөөд тэдгээрийг багш болох ёсгүй гэсэн ташаа дүгнэлтэд хүргэдэг байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хамгийн сайн багш эдгээр бэрхшээлийг биеэр туулсан оюутан багш байж болох юм.

*Багш боловсролын хэрэглэгдэхүүнд хүйсийн ялгааны талаар буруу ойлголт өгөхүйц мэдээлэл орсон байх магадлалтай.*

Багш боловсролын зарим хөтөлбөрт хүйсээр ялгаварлан үзэх үзлийг агуулсан мэдээлэл байж болох талтайг зөвлөмж 3-аас бид харж болно. Хүйсийн асуудлын талаар зөв зохистой мэдээлэл агуулаагүй, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар буруу ташаа мэдээлэл агуулсан ийм жишээнүүдийг багш боловсролд ашиглаж байгаа бөгөөд агуулгын дийлэнх хэсгийг ихэвчлэн эрэгтэй хүн бэлтгэсэн байх тохиолдол ч байж болно.

Зарим улс орнуудын багш бэлтгэх сургуулийн хэрэглэгдэхүүнд хүйсийн тэгш эрхийн талаар маш бага дурдсан, зураг хүснэгтүүдэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох тэгш эрхийг алдагдуулсан мэдээ баримтууд цөөнгүй байгааг ЮНЕСКО-гийн Бангкок дахь салбарын тайлангаас харж болно.<sup>9</sup>

Багш боловсролын хэрэглэгдэхүүнд хүйсийн тэгш эрхийн талаар мэдээлэл хомс байгаа нь хожим оюутан-багш нарт хүйсийн тэгш эрхийг харгалзан үздэг болоход нь саад тотгор учруулахаас гадна зарим эмэгтэй оюутныг сургуулиа орхиход нь ч хүргэж болох юм.

**Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжилхэд дараах асуултууд тус болно:**

- Танай улсад багш боловсролын талаар цөөнхийн хэл дээр хичнээн, ямар ямар ном хэвлэл байдаг вэ? Тэдгээр нь оюутан-багш нарт хүртээмжтэй байдаг уу? Оюутан-багш нар өөрийн эх хэл дээр эсвэл үндэсний хэл дээр хичээлийг хэрхэн заах тал дээр суралцдаг уу? Хүн амын цөөнхийн бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хот хөдөөгийн ялгаа, ядуу өрх эсвэл нийгмийн гарал, үүсэл зэргийг тусгасан хичнээн ном, сурах бичиг байдаг вэ? Тэдгээр ном, сурах бичгүүдэд хүмүүсийг ижил тэгш харуулсан байдаг

<sup>8</sup> Форгакс, 2012, 37 х

<sup>9</sup> Форгакс, 2012, 35 х

уу?

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийг багш боловсролын хэрэглэгдэхүүнд ижил тэгш байдлаар үзүүлдэг үү? Аль нэгэнд нь илүү үүрэг хариуцлага ноогдуулсан байдаг уу?
- Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг хэн боловсруулдаг вэ? Материал боловсруулж буй хүмүүсийг нийгмийн янз бүрийн давхарга, гарал үүсэлтэй хүмүүсээс сонгон шалгаруулах журам байдаг уу?

Эдгээр асуудлын дагуу дүн шинжилгээ хийж хүйсийн тэгш эрхийг хангасан багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж боловсруулахад анхаарах шаардлагатай байна.

Энэ нь бэлтгэгдэн гарсан багш хүйсийн тэгш эрхийг ханган ажиллах дадлага туршлагатай болоход онцгой үүрэгтэй байх болно.

## Зөвлөмжүүд

### Хэрэглэгдэхүүний зөвлөмж 9

*“Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүн нь бүх оюутан-багш нарт ижил тэгш хүртээмжтэй байх ёстой.”*

Хэрвээ оюутан-багш нарын сурч байгаа сургууль нь тэгш хамруулан сургах боловсролыг дэмждэггүй бол үүний талаар яриад ч нэмэргүй. Иймээс багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүн өөрөө тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлалыг агуулсан байх ёстой. Багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг боловсруулж буй хүмүүс нь тухайн орон нутагт тохирсон агуулга бүхий мэдээллийг нутгийнх нь хэлээр боловсруулж, өөр хэлнээс орчуулсан хэрэглэгдэхүүнийг мөн л нөхцөл байдалд нь тохируулан шинэчлэн өөрчлөх шаардлагатай. Түүнчлэн багш боловсролд ашиглагдаж буй хэрэглэгдэхүүн нь өөр өөр хэлний төлөөлөгч (багш, оюутан багш, олон нийтийн төлөөлөгч гэх мэт) нараар хянуулсан байх шаардлагатай.

Багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй оюутан-багш нарт хүртээмжтэй болгох тал дээр нэлээд хүчин чармайлт гаргаж байна. Энэ нь нэгэн нийтлэг загварыг бий болгоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэг агуулгыг сонсох, томруулсан үсгээр, Бройли үсгээр гэх мэт хэд хэдэн хэлбэрээр хэвлэх шаардлагатай. Түүнчлэн сургалтын хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж дэлгэж байрлуулахад энгийн, хялбар болгох, дүрс бичлэгт хэрэглэгдэхүүнийг доороо бичигтэй гаргах, багш, сурган хүмүүжүүлэгч нарыг харааны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хэрэглэгдэхүүнийг хэрхэн боловсруулж бэлтгэх тал дээр зөвлөж байх шаардлагатай. Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан гаргах тал дээр төрийн бус байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашигийг

хамгаалсан байгууллагуудтай хэвлэлийн хэлбэр болон санхүүжилтын тал дээр зөвшилцөж байх нь чухал бөгөөд тэдний санал зөвлөгөөг тусган бэлтгэн гаргах нь хэрэглээ болоод санхүүгийн хувьд ач холбогдолтой болж таарна.

### **Хэрэглэгдэхүүний зөвлөмж 10**

*“Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүнд аливаа ташаа буруу ойлголт, ялгаварлан үзэх үзлийг агуулсан мэдээлэл байх ёсгүй бөгөөд бүх оюутан-багш нарт гарал үүслээс нь үл хамааран ижил тэгш хандаж байгаа гэдгийг харуулсан байвал зохино.”*

Багш боловсролд хувь нэмэр оруулж буй янз бүрийн гарал, үүсэлтэй хүмүүст багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулах тал дээр зөвлөгөө өгсөн байх шаардлагатай. Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах багийн бүрэлдэхүүнд тухайн орны нийгмийн янз бүрийн бүлэглэлүүдийг төлөөлсөн хүмүүс байх ёстой бөгөөд тэднийг ялгаварлан үзэх асуудлыг хэрхэн тодорхойлж шийдвэрлэх тал дээр тусгай сургалтад хамруулах шаардлагатай байдаг. Багш боловсролд хувь нэмэр оруулж байгаа хүмүүс болон сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж буй мэргэжилтнүүд ном хэвлэлээс илэрсэн аливаа ялгаварлан үзэх үзлийг харуулсан эсвэл буруу ташаа ойлголтыг төрүүлсэн мэдээллийн талаар нийтэд мэдээлэх шаардлагатай байдгаас гадна өөрсдийнх нь дуу хоолой, үзэл баримтлалыг нь хүндэтгэж байгаа гэдгийг тогтмол харуулж байх шаардлагатай.

Багш боловсролд ашиглаж буй бүх хэрэглэгдэхүүнийг тэгш хамруулан сургах боловсролын талаар бичсэн ч бай, үгүй ч бай дахин нягтлан шалгаж аливаа ялгаварлан үзэх үзэл, эсвэл буруу ташаа ойлголт өгч болох мэдээллийг агуулсан эсэхийг хянаж байх нь чухал. Тэдгээрээс ялгаварлан үзэх үзлийг бий болгох магадлалтай мэдээллүүдийг устгаж, өөр мэдээллээр сольж, орлуулах шаардлагатай.

Багш боловсролд ашиглаж буй бүхий л хэрэглэгдэхүүнийг ийнхүү өргөн хүрээтэй нягтлан хянах явдал нь их хэмжээний зардал, цаг зарцуулалтыг шаарддаг учраас удаан явагддаг. Нөгөө талаас багш, сурган хүмүүжүүлэгч нар өөрийн хэрэглэж буй хэрэглэгдэхүүнд байгаа ялгаварлан үзэх үзлийн талаар мэдээллийг илрүүлэх, түүнтэй хэрхэн тэмцэх талаар тусгай сургалтад хамрагдсан байдаг. Ингэснээр тэд сөрөг нөлөөтэй агуулгыг өөрт ашигтай сурах боломжоор өөрчилж оюутан-багш нараар хэлэлцүүлж болох сэдэвтэй болдог. Ийнхүү нягтлан хянах үйл явц нь сургалтын хэрэглэгдэхүүнд байгаа агуулгыг хожим нь оюутан-багшийн болон бусдын талаар үзэл баримтлалд сөргөөр нөлөөлөхгүй байхад чиглэсэн байвал зохино.

## Монгол улс-Нөхцөл байдлын тодорхойлолт

Монгол орны нөхцөлд казак хэл дээр гаргасан тэгш хамруулан сургах сургалтын чиглэлээрх хэрэглэгдэхүүн бараг байхгүй байна.Тэгш хамруулан сургах асуудлаарх ном гарын авлага нь гадаад хэлнээс орчуулагдсан байх нь элбэг бөгөөд манай орны нөхцөлд шууд буулган хэрэглэхэд бүрэн тохиромжтой биш байдаг. Багш бэлтгэх сургуулийн хэрэглэгдэхүүн ер нь сурах бичиг гарын авлагад хүйсийн тэгш эрхийн талаар маш бага дурдсан, зураг хүснэгтүүдэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох тэгш эрхийг алдагдуулсан мэдээ баримтууд цөөнгүй байдаг.Тухайлбал эрэгтэй хүүхдийн зургийг эвдэх сүйтгэх, амьтан зовоох зодолдох хэлбэрээр дүрсэлсэн харин охидын зургийг цэвэрлэх, асрах, арчлах үйлүүдтэй холбон зурсан байх элбэг бөгөөд зохиогчийн жендерийн тэнцвэрт анхаарах, хэрэглэгдэхүүнийг боловсруулагчид ихэвчлэн нийслэлийн багш нар байна. Энэ нь хот хөдөөгийн амьдрал ахуй, ажил хөдөлмөр болон бусад онцлогуудыг бүрэн тусгаж чадахгүй байна. Ихэвчлэн сургах бичиг гарын авлагад суурин амьдралын хэв маягийг харуулсан зураг дүрс голлож байна. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан багш хэрэглэхэд тохиромжтой хэрэглэгдэхүүн ховор тэдний багш мэргэжил эзэмших нөхцөл боломжийг хангаж чадахгүй байна.

## Санал зөвлөмжүүд

- Гадаад хэлнээс орчуулагдсан ном сурах бичгийг тодорхой шалгуураар хэрэглэх, өөрийн орны нөхцөл байдалд нутагшуулан хэрэглэх зөвлөгөө зааврыг тусгах, харьцуулсан жишээ баримтаар баяжуулах
- Дан нэг хүйсийн хүмүүс сурах бичгийн баг бүрдүүлэх нь бас л өрөөсгөл байна. Эрэгтэй эмэгтэй хүмүүс үндэсний цөөнх,нийгмийн өөр өөр бүлгийн хүмүүсийг сурах бичиг зохиох, хянах,болон зураач зөвлөхөөр ажиллахад тэнцвэртэй оролцуулах
- Сурах бичиг зохиогчдын багийг хот хөдөөнөөс болон бүс нутгаас тэнцвэртэй бүрдүүлэхэд анхаарах
- Сонсдог болон бройли хэлбэрээр сурах бичиг гарын авлагыг хувилбартай хэвлэхэд, мөн дохионы хэлний хэлмэрчгүйгээс сонсголын бэрхшээлтэй оюутнуудын сурах хэрэгцээ бүрэн хангагдахгүй байгааг анхаарах шаардлагатай.

## Зөвлөмжийн үр дүн хэрхэн илрэх вэ?

Зөвлөмж 1 буюу удирдамж бүлэгт зөвлөмжийн төлөвлөгөөг боловсруулах явцад ажлын үр нөлөө болон үйл явцыг хянах зорилгоор тодорхой заалтуудыг боловсруулах шаардлагатай болдог гэж өмнө нь дурдсан. Эдгээр заалт нь таны зөвлөмжийн зорилтуудаас шалтгаална. Төлөвлөгөө мэтийн заалтууд нь хэд хэдэн оролцогчдыг хамруулсан үйл явцын үр дүнд бий болдог. Байж болох заалтуудын жагсаалтыг доор харуулсан болно. Тэгш хамруулах сургалтад зориулж оюутан багшийг чанартай бэлтгэх зорилгоор багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг сайжруулах талаар гаргасан зөвлөмжүүдийг дараах шаардлагыг биелүүлсэн тохиолдолд үр дүнтэй хэмээн тооцож болно:

- Багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг төлөвлөх, санхүүжүүлэх үүрэг бүхий хүмүүс багш боловсролд ашиглах зорилгоор боловсруулсан тэгш хамруулан сургах боловсролын хэрэглэгдэхүүнүүдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн тохиолдолд
- Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулагчид материалын агуулгыг хянасны дараа тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал, агуулгын хэмжээ хангалттай бөгөөд явцуу хүрээнд хязгаарлагдаагүй тохиолдолд.
- Тухайн улс орон болон бүс нутагт тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой багш боловсролын хэрэглэгдэхүүнийг илүү ихээр боловсруулж, хэвлэсний үр дүнд багш, сурган хүмүүжүүлэгч болон оюутан-багш нарт агуулгын хувьд илүү тохиромжтой хэрэглэгдэхүүнийг хэрэглэх боломж нэмэгдсэн тохиолдолд
- Шаардлагатай бол боловсролын бодлогыг шинэчлэн боловсруулж багш, сурган хүмүүжүүлэгчдэд одоогийн байгаа хэрэглэгдэхүүнийг шинэчлэн өөрчлөх, сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрөө олж боловсруулах, дадлага, туршлагаа хөгжүүлэхэд нь туслалцаа дэмжлэг, эрх чөлөө олгосон тохиолдолд
- Боловсролын яам болон багш бэлтгэх сургуулиуд багш, сурган хүмүүжүүлэгчдэд практик үйл ажиллагааны удирдамжийг бэлтгэн гаргаад, гадаад, дотоодын хэрэглэгдэхүүнийг өөрийн нөхцөл байдалд тохируулан ашиглаж чаддаг болгосон тохиолдолд.
- Багш боловсролд ашиглаж буй хэрэглэгдэхүүнийг дахин хянаж, тэгш хамруулан сургах боловсролын талаар практик жишээ бүхий агуулгаар нэмэгдүүлсэн; тэгш хамруулан сургах боловсролын тухай онолын мэдээлэл нь бодит амьдрал дээр хэрхэн тусч байгаа талаар илүү дэлгэрэнгүй ойлголтыг оюутан-багш нарт өгсөн тохиолдолд
- Тухайн орон нутагтай холбоотой онцлог шинжийг агуулсан тэгш хамруулан сургах боловсролын талаар бодит жишээ, баримтуудыг хуримтлуулж, тэдгээрийг багш боловсролын хэрэглэгдэхүүний тусламжтайгаар бусадтай хуваалцсаны үр дүнд оюутан-багш нар тэгш хамруулан сургах талаар илүү сайн мэдлэг ойлголттой болсон тохиолдолд.

- Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулан сайжруулж, багш боловсролд ашиглах хэрэглэгдэхүүнийг боловсруулах үүрэг бүхий мэргэжилтнүүдийн дунд тэгш хамруулан сургах боловсролд ялгаварлан үзэх үзлийг үгүй болгох талаарх ойлголт, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлсэн тохиолдолд
- Багш боловсролын үйл явцад хувь нэмэр оруулж буй хүмүүс (дадлага туршлагатай багш нар, эцэг эх, оюутан, нийгмийн жижиг хязгаарлагдмал бүлгийн төлөөлөгчид) сургалтын хэрэглэгдэхүүнд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсны үр дүнд оюутан-багш нар өөрийн орон нутгийн онцлог шинж чанарыг тусгасан сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон тохиолдолд
- Сурах үйл ажиллагааны идэвхитэй арга, суралцагч-төвтэй сургалт, тэгш хамруулан сургах боловсролын талаар бодит амьдрал дээр тулгуурласан дадлага, туршлагыг эзэмшсэн хүмүүсийн боловсруулсан багш боловсролын хэрэглэгдэхүүний тоо, чанар нэмэгдсэн тохиолдолд
- Боловсролын яам болон багш боловсролын байгууллагуудад багш боловсролын хэрэглэгдэхүүнийг дахин хянаж шалган аливаа ялгаварлан гадуурхах үзлийг агуулсан мэдээллийг устгаж тэгш эрх, цөөнхийг хүндэтгэсэн үзлийг нэмэгдүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулсан тохиолдолд. Үүний үр дүнд багш боловсролын хэрэглэгдэхүүнийг хянах үйл явц нь тогтмолжиж тэгш хамруулан сургах хэрэглэгдэхүүний тоо, хэмжээ нэмэгдсэн тохиолдолд.
- Хүн амын цөөнхийн хэлээр боловсруулсан сургалтын хэрэглэгдэхүүний тоо хэмжээ нэмэгдсэн, хүн амын цөөнхийн бүлгийн төлөөлөгч болон хөгжлийн бэрхшээлтэй оюутан-багш нарт зориулсан хүн бүрт тэгш хүртээмжтэй, ашиглаж болох хэлбэрээр бий болгосон сургалтын хэрэглэгдэхүүний хэлбэр, төрөл, тоо хэмжээ нэмэгдэж оюутан-багш нар тэгш хамруулан сургах боловсролын талаар өөрийн биеэр бодит жишээн дээр ухамсарлан ойлгосон тохиолдолд.



# Хавсралт

Тус хүснэгтэнд бид дээр дурдсан дөрвөн бэрхшээлийн зөвлөмж тус бүрийг хэрэгжүүлэхэд туслалцаа дэмжлэг өгч чадах хүмүүсийн жагсаалтыг орууллаа. Түүнчлэн ямар аргыг, аль зөвлөмжинд тохиромжтой болох, мөн өөрийн улс орон, нөхцөл байдалд хэрхэн хэрэгжүүлэх талаар өөрийн бодол санаагаа тэмдэглэх зай үлдээсэн болно. Өөрийн санаа, үзэл бодлоо хэрэгжүүлэхдээ мэргэжил нэгт багш сурган хүмүүжүүлэгч болон бусад холбогдох хүмүүстэй зөвлөлдсөний үндсэн дээр гүйцэтгэх нь зохистой. Зөвлөгөө, арга, хэлбэрийн талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг Удирдамж 1-ээс авч болно.

Зөвлөмжүүд	Зөвлөмж хэнд зориулагдсан бэ?	Зөвлөмжийг өөрийн нөхцөл байдалд хэрхэн хэрэглэх вэ? *
<p><i>“Тэгш хамруулан сургах боловсролыг зөвхөн багш боловсролын онцгой, тусгай хэрэглэгдэхүүнээр хангах ёстой бөгөөд багш боловсролын хэрэглэгдэхүүний агуулгыг бүхэлд нь хамарсан байх ёстой”.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсрол болон багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнийг хариуцсан боловсролын яамны мэргэжилтэн</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг төсөвлөж, ханган нийлүүлэх үүрэг бүхий засгийн газрын холбогдох хэлтэс багш бэлтгэх сургуулийн удирдах зөвлөл, албан тушаалтан</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулах, ханган нийлүүлэх, захиалан бичүүлэх үүрэг бүхий боловсролын болон багш боловсролын байгууллагын мэргэжилтнүүд</li> <li>• Төрөл бүрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг үзэхийг хүссэн оюутан-багш нар</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг үндэсний, бус нутгийн хэмжээнд боловсруулах шаардлагатай бөгөөд агуулга сэдвийн хувьд тэгш хамруулан сургах боловсролын талаар тохирсон, сүүлийн үеийн мэдээлэл, жишээнүүдийг агуулсан байвал зохино. Гадаадад хэвлэгдсэн багш боловсролын хэрэглэгдэхүүнийг илүү бүтээлчээр, шүүмжлэлтэй хэрэглэх нь чухал.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны багш боловсролын хэрэглэгдэхүүнийг хариуцсан мэргэжилтэн</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүний төсөв, хангамжийг хариуцсан засгийн газрын хэлтсүүд</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулах, ханган нийлүүлэх, захиалах, боловсруулах үйл явцад оролцож буй боловсролын байгууллагын бие бүрэлдэхүүн</li> <li>• Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйчид</li> <li>• Орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн</li> <li>• Төрөл бүрийн нэмэлт хэрэглэгдэхүүнийг хэрэглэх хүсэлтэй байгаа оюутан-багш нар</li> </ul>	

<p><i>“Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулж, боловсруулж байгаа багшлах боловсон хүчин нь мэргэжлийнхээ дагуу сүүлийн үеийн мэдээ баримт, дэвшилтэт аргуудыг эзэмшсэн байхаас гадна дотоод, гадаадын дадлага, туршлагатай танил байх шаардлагатай. Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулж буй баг хамт олон нь улс орны олон онцлог шинжүүдийг сайтар мэддэг байх ёстой.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яам болон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах боловсон хүчнийг сонгон шалгаруулах, сургах, удирдах үүрэг бүхий багш боловсролын байгууллагын удирдах албан тушаалтан</li> <li>• Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг боловсруулагчид эсвэл сонгон шалгаруулагчид</li> <li>• Агуулга, сэдвийн хувьд өөрийн нөхцөл байдалд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг хүссэн оюутан-багш нар</li> <li>• Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг сонгон шалгаруулах, боловсруулах үйл явцад оролцох сонирхолтой ард иргэд</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын хэрэглэгдэхүүн нь тэгш хамруулан сургах боловсролын талаарх бодит амьдрал дээр тулгуурласан баримт жишээг боловсролын өөр өөр түвшинээр аль болох ихээр агуулсан байх шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг төлөвлөж, бичиж, боловсруулж, хянадаг боловсролын яамны болон багш боловсролын байгууллагын ажилтан</li> <li>• Тэгш хамруулан сургах төсөл, эсвэл сургуулиудыг дэмжин ажилладаг, энэ салбар дахь дадлага, туршлагыг тэмдэглэн баримтжуулж чадах төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд</li> <li>• Агуулга, сэдвийн хувьд өөрийн нөхцөл байдал, амьдралын туршлагад тулгуурласан сургалтын хэрэглэгдэхүүнийг хүссэн оюутан-багш нар</li> <li>• Багш боловсролыг хөгжүүлэх зорилгоор өөрийн дадлага, туршлагыг баримтжуулан үлдээхийг хүссэн багш, сурган хүмүүжүүлэгч болон хамтран оролцогчид</li> </ul>	

<p><i>“Оролцогч талууд тэгш хамруулан сургах боловсролын талаарх сургалтын материалыг хянахад илүү их үүрэг хүлээх шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг төлөвлөж, бичиж, боловсруулж, хянадаг боловсролын яамны болон багш боловсролын байгууллагын мэргэжилтэн тэгш хамруулан сургах талаарх мэдлэг туршлагатай мэргэжлийн зөвлөл</li> <li>• Тэгш хамруулан сургах төсөл, эсвэл сургуулиудыг дэмжин ажилладаг, багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах явцад оролцогч талуудыг хамруулж чадах эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд</li> <li>• Оролцогч талуудын тусламжтайгаар бий болсон сургалтын хэрэглэгдэхүүнтэй танилцахыг хүссэн оюутан суралцагчид</li> <li>• Тэгш хамруулан сургах боловсролын талаар тодорхой хэмжээний дадлага туршлагыг эзэмшсэн бөгөөд түүнийгээ бусадтай хуваалцахыг хүссэн оролцогч талууд</li> </ul>	
<p><i>“Багш, сурган хүмүүжүүлэгч нар багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгох, өөрчлөх, ашиглах эрх, үр чадварыг эзэмшсэн байвал зохино.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлогын талаарх шийдвэр гаргах эрх бүхий боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш боловсролын бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий багш боловсролын байгууллагын багш нар</li> <li>• Ашиглаж буй сургалтын хэрэглэгдэхүүн болон бодлогыг сонгох, өөрчлөхийг хүссэн багш сурган хүмүүжүүлэгч, оюутан-багш нар</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн нь багш, сурган хүмүүжүүлэгч нарын оюутан-багш нарт хэрэглэж буй тэгш хамруулан сургах үйл ажиллагааг тусгасан байх шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын хэрэглэгдэхүүнийг төлөвлөж, бичиж, боловсруулж, хянадаг боловсролын яамны болон багш боловсролын байгууллагын мэргэжилтнүүд зөвлөх баг</li> <li>• Багш сурган хүмүүжүүлэгч нарын мэргэжлийн үр чадварыг тогтмол дээшлүүлэх асуудлыг хариуцсан багш бэлтгэх боловсролын байгууллага болон боловсролын яамны удирдах албан тушаалтнууд</li> <li>• Тэгш хамруулан сургах үйл явцын талаар гүн мэдлэг, дадлага туршлагыг эзэмшихийг хүссэн оюутан-багш нар</li> </ul>	

<p><i>“Багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүнийг идэвхитэй сурах арга барил эзэмшсэн, сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрийн нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх чадвартай хүмүүс төлөвлөж, бичиж, боловсруулах шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулагчдыг бэлтгэх, сонгон шалгаруулах эрх бүхий боловсролын яам болон багш боловсролын байгууллагын мэргэжилтнүүд</li> <li>• Ашиглаж буй хэрэглэгдэхүүнийг дадал туршлагатай мэргэжилтнүүдээр илүү боловсронгуй, амьдралд нийцсэн болгохыг хүссэн багш сурган хүмүүжүүлэгч болон оюутан багш нар</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн нь бүх оюутан суралцагчдын хувьд тэгш, хүртээмжтэй байх шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулах эрх бүхий боловсролын яам болон багш боловсролын байгууллагын удирдлага сургалтын алба</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүний төсөв, ханган нийлүүлэлтийг хариуцсан засгийн газрын хэлтэсүүд</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг өөрийн төрөлх хэл дээр, зохих хэлбэрээр авахыг хүссэн оюутан-багш нар</li> <li>• Оюутан-багш нарын хүсэл сонирхолыг дэмжиж, техник, санхүү болон эрх зүйн туслалцаа дэмжлэг үзүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд болон бусад төрийн бус байгууллагууд</li> </ul>	
<p><i>“Багш боловсролын сургалтад ашиглаж буй хэрэглэгдэхүүн нь бусдыг ялгаварлан үзэхгүй, аливаа тогтсон ташаа ойлголтыг үгүйсгэн няцаасан, оюутан-багш нарыг гарал үүслээс нь үл хамааран ижил тэгш хамруулсан байх шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулах эрх бүхий боловсролын яам болон багш боловсролын байгууллагын эрх бүхий албан тушаалтан</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг дахин хянаж нягтлахыг хүссэн оюутан-багш нар</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнийг дахин хянаж нягтлахыг хүссэн хамтран оролцогчид</li> </ul>	



## Зөвлөмж 5-Арга зүй

5

АРГА ЗҮЙ

## Удиртгал

“Арга зүй” хэмээх энэхүү зөвлөмж нь “Тэгш хамруулан сургах багшийн боловсрол” сургалтад зориулан гаргасан цувралын тавдугаар нь юм. Энэхүү зөвлөмжийг дангаар нь болон цувралын бусад товхимолууд болох “Удирдамж”, “Бодлого”, “Хөтөлбөр”, “Хэрэглэгдэхүүн” зэрэгтэй хослуулан хэрэглэх боломжтой.

Энэхүү зөвлөмжид тэгш хамруулах сургалтад тулгарч буй бэрхшээлүүд болон сургалт явуулах арга зүйн талаар өгүүлэхийг зорилоо. Зөвлөмжид тусгасан сургалтын аргууд болон хэрэгжүүлэх стратегийг багш нар, багш бэлтгэдэг сургуулиуд, боловсролын холбогдох байгууллагын ажилтнууд өөрсдийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, өөрчлөх, боловсронгуй болгож хөгжүүлэхийг санал болгож байна.

### Тэгш хамруулан сургах сургалтын арга зүй

Зөвлөмжид санал болгож буй арга зүй нь багш бэлтгэх тогтолцоо, багш бэлтгэх сургуулиудад сурч буй оюутан-багш нарт зориулагдсан бөгөөд тэд сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр болон ирээдүйн багшлах үйл ажиллагаандаа энэхүү арга зүйг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага тулгарна. “Заах арга зүй” гэдэг нэр томъёо нь сургах, сурах үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх зэрэг ойлголтуудыг багтаах ба нөгөө талаас боловсролд тэгш хамруулах сургалт бодит амьдралд хэрхэн хэрэгжиж буйг илтгэнэ.

Тэгш хамруулан сургах сургалтын арга зүй нь сургалтын хөтөлбөртэйгээ нягт уялдаатай хэрэгжих ёстой. Өөрөөр хэлбэл тэгш хамруулах сургалтын хөтөлбөр нь тухайн сургалтынхаа арга зүйн тулгуур байна. (хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүйг “Зөвлөмж-3”– аас үзнэ үү) Хэдийгээр хөтөлбөрт тусгагдсан зүйлс агуулга, бүтцийн хувьд таны мөрдөж буй хөтөлбөртэй адил байсан ч хэрэгжилтийн тухайд, ялангуяа тэгш хамруулах сургалтыг бодит амьдралд, сургуулийн практикт хэрэгжүүлэх үйл явц нь зөрүүтэй байж болно.

Зөвлөмжид тэгш хамруулах сургалтын арга зүйтэй холбоотой дараах асуудлуудыг толилуульж байна.

- Заах арга ба ур чадвар эзэмшүүлэх:
- Сурах, сургах үйл нь уян хатан, суралцагч төвтэй, суралцагчдын бүхий л хэрэгцээг хангаж чадахуйц, сургалт явуулахад орон нутгийн болоод сургалт зохион байгуулагч байгууллага дотоод нөөц боломжоо ашиглан суралцагчдыг бүх талаар дэмжин туслахад чиглэгдвэл зохино. Үүний зэрэгцээ сургалтад явцын үнэлгээг чухалчилж үзнэ.
- Оюутан-багшийг дадлагажуулах, тэднийг бүтээлч эргэцүүлэлд сургах,

дэмжин туслах:

- Оюутан-багш нарыг сурган хүмүүжүүлэх дадлага хийх бололцоо, нөхцөлөөр хангах, дадлагын үеэр үйлийн судалгаа хийхэд нь дадлага удирдагч багш нарын зүгээс удирдлагаар хангах, түүнчлэн тэгш хамруулах сургалтын талаар олж авсан мэдлэг, чадвараа (тухайлбал, хүйсийн тэгш байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй болон олон хэлтэй суралцагсадтай ажиллах г.м) хэрэгжүүлэхэд нь бүхий л талаар дэмжин тусалвал зохино.

Монголд багшийн сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын ангид сургалтын арга зүйд дараах зарчмыг баримталж байна.

- Сургалт зохион байгуулахад үүсэх бэрхшээлийг тодорхойлох,
- Янз бүрийн хэрэгцээтэй суралцагчид зориулсан сургалтын олон талт үйл ажиллагааг зохион байгуулахад системтэй хандах
- Суралцагч төвтэй сургалтыг дэмжих
- Сургалтын идэвхитэй аргаас оновчтой хэлбэрийг сонгох
- Багшид хөтөлбөр, хэрэглэгдэхүүнээ сонгох, орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөх боломж олгох
- Оюутан- багшийн дадлагад анхаарах
- Бүтээлч эргэцүүллийг дэмжих

## Тэгш хамруулах сургалтын арга зүйн тулгамдсан асуудлууд

Тэгш хамруулах сургалт нь боловсролын болоод нийгмийн харилцаанд тулгуурласан хүний хүчин зүйлээс ихээхэн хамаардаг. Тэгш хамруулах сургалтын арга зүй нь нэг талаас тус сургалтын үндсэн бүрдэл болох багш бэлтгэдэг сургуулиуд болон дунд сургуулиудад ажиллаж байгаа хүний хүчин зүйлийн харилцаа, хамтын ажиллагааг хангадаг. Нөгөө талаас тухайн сургалтын концепци, онол, арга зүйг практикт хэрэгжүүлэх арга зам юм. Гэхдээ энэхүү арга зүйг хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл, бэрхшээл учирсаар байна. Ялангуяа тэгш хамруулах сургалтын талаарх ойлголт, суурь мэдлэг багатай болон огт байхгүй багш оюутнуудын тухайд илүү хүндрэлтэй байна. Иймд энэхүү сургалтыг ойлгон дэмжих, улмаар амжилттай хэрэгжүүлэхийн үндэс нь тус сургалтыг гардан зохион байгуулагч багш нар, мөн оюутан-багш нарыг дадлагажуулах, тэдний ажлыг дэмжих, арга зүйн зөвлөмжөөр хангах явдал мөн.

Тэгш хамруулах сургалт нь сургах, сурах үйлийн чанараас ихээхэн хамаардаг. Тус сургалтын арга зүй нь хэлбэр, үүргийн хувьд суралцагчдыг тэгш хамруулах зарчим дээр суурилах ба практик дээр тус сургалтын концепцийг хэрэгжүүлэх, цаашилбал хүсэн хүлээсэн үр дүнд хүргэх зорилготой. Жишээлбэл, хэрэв багш анги дотор янз бүрийн чадамж, хэрэгцээтэй суралцагчдыг баг бүлгээр амжилттай зохион байгуулж чадвал сурагчид чадвараасаа үл хамааран бие биеэ дэмжих,

сургалтад идэвхтэй оролцох болно. Энэхүү үйл ажиллагаанаас суралцагчдын потенциал, хамтран сурахуйн давуу талууд (эдгээр нь тэгш хамруулах сургалтын үндсэн зарчим билээ) тод харагдах болно.

Тэгш хамруулах сургалтын арга зүйг хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийн тулд сурах зорилтуудыг тодорхойлох шаардлагатай. Иймд сүүлийн үеийн судалгаан дээр тулгуурлан дараах зорилтуудыг авч үзэж байна.

- Тэгш хамруулах сургалтад тохиолдож буй бэрхшээлүүдийг тодорхойлох, янз бүрийн хэрэгцээтэй суралцагчдад зориулсан сургалтын олон талт үйл ажиллагаа зохион байгуулахад системтэй хандах
- Суралцагч төвтэй сургалтыг хөхүүлэн дэмжих
- Сургалтад идэвхтэй сургалтын аргууд ашиглах, суралцагчдад тохиромжгүй зарим нэг аргаас зайлсхийх
- Сургалтын хөтөлбөр болон хэрэглэгдэхүүнээ сонгох, орон нутгийн нөхцөл байдалдаа тохируулан өөрчлөн хэрэглэх боломжийг багш нарт олгох
- Сургалтад явцын болон бодит үнэлгээний хэлбэрүүдийг өргөн ашиглах<sup>1</sup>
- Суралцагч бүртэй тулж ажиллах ганцаарчилсан сургалтын хэлбэрийг хөгжүүлэх
- Оюутан- багш нарын дадлагын чанарт анхаарах, туслан дэмжих
- Сурган хүмүүжүүлэх дадлагыг өргөжүүлэх
- Тэгш хамруулах сургалтын бүрэлдхүүн хэсэг болох бүтээлч эрэгцүүллийг дэмжих

Энэхүү зөвлөмжөөс та бүхний урд ямар бэрхшээл хүндрэлүүд байгааг, тэдгээрийг хэрхэн даван туулах арга замын талаар олж мэдэхийг эрмэлзэх нь дамжиггүй. Харин бид энэхүү зөвлөмжид тэгш хамруулах сургалт явуулах арга зүйн асуудлыг хөндөх болно.

Монголд хэрэгжүүлж байгаа тусгай хэрэгцээт сургалтын ангид сургалт зохион байгуулахад дараах тулгамдсан асуудал байна.

- Хүний нөөц хомс, хамтын ажиллагаа сул
- Яам хоорондын хамтын ажиллагаа бодлого, журам заалтын боловсруулалт, хэрэгжилт сул
- Бүх шатны сургуулиуд, багш бэлтгэдэг Их дээд сургуулийн удирдлага, багш нарын нэгдсэн ойлголт, суурь мэдлэг хангалтгүй
- Оюутан багшийг дадлагажуулах ажил хомс
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгад тэр бүр тусгагдаагүй
- Тэгш хамруулах сургалтанд учирч буй бэрхшээлийг олж харах талаар

<sup>1</sup> Форгакс. Р. 2012. Багш боловсролыг 2015 он хүртэл сайжруулах нь. Оюутан-багш нарыг тэгш хамран сургах үзэл санаанд хэрхэн бэлтгэх вэ? Бангладеш, Камбож, Хятад, Лаос, Монгол, Непал, Тайланд, Вьетнам улсуудын багш боловсролын тогтолцоонд хийсэн анализын үр дүн (2008-2011), Бангкок, ЮНЕСКО



- оюутан багшаар эргэцүүлэмж хийлгэх
- Багш бэлтгэдэг сургууль шалгалтанд суурилсан боловсрол олгох, сургалт нь оюутнаар цээжлүүлэх хандлагатай явж ирсэн
- Суралцагч бүрийг татан оролцуулах арга зүй дутмаг
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутантай харилцах арга барил сул, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг хангалтгүй

# Бэрхшээл 1

## Харилцан адилгүй суралцагчидтай ажиллах нь

### Нөхцөл байдлын шинжилгээ

*Тэгш хамруулах сургалтад тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох, сургалтын олон талт үйл ажиллагаа зохион байгуулахад системтэй хандлага дутагдаж байна.*

Багш нарт боловсролын системд, тэр дундаа өөрийн сургууль, ангидаа тэгш хамруулах сургалтыг хэрэгжүүлэхэд тулгарах бэрхшээлийг илрүүлээд шийдвэрлэх арга замыг хайхад нь дэмжлэг тусалцаа зайлшгүй хэрэгтэй. Учир нь багш нар сургалтад тулгарч буй бэрхшээл гэж харахаасаа өмнө суралцагчдаа асуудал болгож харах нь олонтаа тохиолддог. Сургууль, анги дотор байгаа янз бүрийн хэрэгцээтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах сургалт явуулахад нь багшийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй бол энэ нь өөрөө хамгийн эхний бэрхшээл байх болно. Нөгөө талаас багш нар сургалтад тохиолдох хүндрэл бэрхшээлд хэт их анхаарал хандуулваас тус сургалтын үр дүн, багш нарын үндсэн үүрэг болох харилцан адилгүй суралцагчдыг таньж мэдэх, тэдэнтэй ажиллах, сургалтын орчин бүрдүүлэх зэрэгт сөргөөр нөлөөлнө. “Зөвлөмж 1” буюу Удирдамж хэсэгт дурдсанчлан тэгш хамруулах сургалтад тохиолдох хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлсноор боловсролыг бүх суралцагчдад хүртээмжтэй байлгах, харилцан адилгүй суралцагчдыг сургалтад жигд татан оролцуулах, суралцагчид академик болон нийгмийн түвшинд бүхий л чадвар боломжоо нээн харуулах зэргээр тус сургалтын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Тэгш хамруулах сургалтад учрах бэрхшээлүүд нь хүмүүсийн хандлага, амьдрал практик дээр тохиолддог асуудлууд, нөөц хэрэглэгдэхүүн, бодлого болон сурах орчинтой холбоотой байж болно. Эдгээр бэрхшээл нь янз бүрийн учир шалтгаантай, эсвэл өөр хоорондоо уялдаа холбоотой, эсвэл зарим тохиолдолд бүр давхацсан байж болдог. Жишээлбэл, эцэг эх, гэр бүл, нийгмийн зүгээс баримталдаг сөрөг үзэл дээр амьжиргааны ядуу зүдүү байдал нэрмээс болсноос орон нутаг болон алслагдсан хязгаарт сурагчид сургуулиа хаях шалтгаан болж байна. Түүнчлэн багш сурган хүмүүжүүлэгчид аутизм, Дауны синдром болон

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах талаар сөрөг хандлагатай байдаг бол ийм багш нар дээрх хүүхдүүдийг сургахад хүчин чармайлт гаргаж ажиллахгүй л болов уу. Тэр ч байтугай ийм хүүхдүүдийг хичээлдээ суулгахгүй байж мэдэх юм. Ийм бэрхшээл нь нийгмийн тэгш бус байдлаас эхтэй. Ядуу гэр бүл үр хүүхдэдээ боловсрол олгож чадахгүй байгаагаас тэдний ирээдүйд өсөн дэвжих, нийгэмд эзлэх байр сууриа алдахад хүргэж байна. Цаашилбал ийм гэр бүлүүдийн нийгмийн байр суурь алдагдаж, улмаар баян хоосны ялгаа, тэгш биш байдал гүнзгийрэх үр дагавартай.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжилэхэд дараах асуултууд тус болно**

- Боловсролын үндэсний бодлогод тэгш хамруулах сургалтын талаар хэр тусгасан байдаг вэ? Боловсролын бодлого нь тэгш хамруулах сургалтыг дэмждэг үү?
- Багш бэлтгэдэг сургуулиуд, тухайлбал танай сургууль тэгш хамруулах сургалтад учирч буй боловсролын тогтолцооны, сургууль, анги доторх бэрхшээлүүдийг оюутан-багш нар олж харах, тодорхойлоход нь дэмжлэг үзүүлдэг үү?
- Оюутан-багш нар бодит амьдрал дээр суралцагчид/анги хамт олон/ сургуулийнхаа давуу талыг олж харах, аливаа асуудлыг дотоод нөөц боломжийнхоо хүрээнд шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлдэг үү?

### **Монгол орны нөхцөл байдлын шинжилгээ**

- Хүүхэд биш, харин боловсролын тогтолцоо, сургуулийн үйл ажиллагаа бэрхшээл учруулж байна.
- Тогтолцоог өөрчлөхийн төлөө багш бүр тодорхой мэдлэгтэй байх
- Суралцагчдын харилцан адилгүй байдал, давуу тал харах
- Оюутан-багшийг суралцагч төвтэй, оролцоонд түшиглэсэн сургалтад хамруулах, дэмжих
- Суралцагчдын хэрэгцээ, шаардлага дээр үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хийж сургах
- Суралцагчдын хэрэгцээ, шаардлага дээр үндэслэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хийж сургах
- Үйлийн судалгаа хийж эргэцүүлэх чадварыг хөгжүүлэх

## Хэлэлцүүлгийн үеэр гарсан санал

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аав Б.

*Тэгш хамруулах сургахад багш ангидаа сэтгэл зүйн болон харилцааны таатай орчин бүрдүүлэх хэрэгтэй. Гэтэл өнөөдөр дунд сургуулийн багш нар харилцааны тал дээр хангалтгүй байна. Үүнд:*

*Багш нар хүүхэдтэй ажиллах итгэл муутай, хүүхдэд хандах эерэг хандлага хангалтгүй, сэтгэл хөндий, ялгаварлан гадуурхдаг, бусдын үгийг үл сонсогч, эерэг харилцаанд хүч өгч дэмждэггүй, адил тэгш бус, хүүхдийн нууцыг хадгалж чаддаггүй, хувиа хичээгч, ажилдаа эзэн болохгүй байна.*

*Үүнийг сайжруулах арга замын талаар ийм санал байна.*

*Лекц, ухуулга, дадлага ажил хийх, энэ эерэг харилцах ёс зүйг яагаад түлхүү үзээд байгааг ойлгуулах, оюутан багшид багшийн нэр хүндийг хайрлах, энэ нь таны ажил амьдрал гэдгийг ухааруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, өөртөө итгэх итгэлийг бий болгох, эцсийн эцэст хүүхэд бол таны ажил амьдрал, цалин гэдгийг л ойлгуулах нь чухал байна.*

## Зөвлөмжүүд

### Арга зүйн зөвлөмж 1

*“Тэгш хамруулах сургалтад тулгардаг бэрхшээл нь ихэвчлэн боловсролын тогтолцоо болон сургуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг. Суралцагчид хэзээ ч бэрхшээл үүсгэж байгаагүй.”*

*“Арга зүйн зөвлөмж -1” нь хоёр болон гуравдугаар зөвлөмжтэйгээ нягт холбоотой. Хэрэв та бүхэн тэгш хамруулах сургалтад тохиолдож буй бэрхшээлүүдийг боловсролын тогтолцоотой холбон авч үзэж байгаа бол, тус сургалтын үндсийг ойлгож нөхцөл байдлын шинжилгээг үнэн зөвөөр хийх боломжтой.<sup>2</sup>*

### Арга зүйн зөвлөмж 2

- 1) Тэгш хамруулах сургалтын бэрхшээлүүдийг илрүүлэх
- 2) Эдгээр бэрхшээлүүдийг даван туулах стратегийг боловсруулах
- 3) Тогтолцоог өөрчлөхийн төлөө ажиллах

<sup>2</sup> Бодит үнэлгээ ихэвчлэн суралцагчдыг үнэлгээний процесст татан оролцуулдаг.” Жнь: Хүүхэд өөрийгөө үнэлэх үйл ажиллагаанд татан оруулдаг. Бодит үнэлгээ нь суралцагчийг юуг хэрхэн хийж сурсныг нь бодитой, тохиромжтой хэлбэрээр үнэлдэг.”ЮНЕСКО. 2004. Суралцагчдад ээлтэй, тэгш хамруулах сургалтын орчин бүрдүүлэх нь, Товхимол- 5, Бангкок,ЮНЕСКО, 43 х.

Тэгш хамруулах сургалтад системтэй хандахад учрах бэрхшээлүүдийг илрүүлэх, тэдгээрийг даван туулах арга замыг тодорхойлох, энэ бүх үйл ажиллагаанд суралцагчдыг өөрсдийг нь татан оролцуулах хэрэгтэй. Энэ нь тэгш хамруулах сургалтын арга зүйн чухал хэсэг байх болно.

Тэгш хамруулах сургалтад учирч буй бэрхшээлүүдийг илрүүлэх нь боловсролын тогтолцоо, сургууль, багш нарын хандлага, сургалтын арга барилыг өөрчлөхөд зайлшгүй хийх ёстой эхний алхам мөн. Дараах хүснэгтэд боловсролын тогтолцоонд учирдаг түгээмэл бэрхшээл, тэдгээрийн ангилал, шийдвэрлэх арга замыг хэд хэдэн жишээн дээр авч үзсэн болно.

Танай нөхцөл байдалд аль бэрхшээл, шийдэл нь байгааг олж үзнэ үү.

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	Жишээ	Шийдэл
Хандлага	<ul style="list-style-type: none"> <li>• Сургууль, багш бэлтгэдэг сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, насанд хүрэгсэд, үндэстний цөөнх, нийгмийн ядуу бүлгийнхнийг ялгаварлан гадуурхах</li> <li>• Ойлгоц удаантай сурагчдыг сургах асуудлыг цагийн гарз гэж үзэх</li> <li>• Сургууль болон багш бэлтгэдэг сургуулиудад охид эмэгтэйчүүдийн талаарх сөрөг хандлага</li> <li>• Хүүхдүүд нийгэм, гэр бүлийнхээ төлөө хөдөлмөрлөх ёстой гэсэн үзэл</li> <li>• Хүүхэд бүр сурч чадахгүй гэсэн буруу ойлголт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчид өөрсдийн харилцан адилгүй байдлаа бэрхшээл гэж үл үзэх, харин боловсрол олж авах боломж гэж хардаг байх хандлагыг төлөвшүүлэх</li> <li>• Удаан ойлгодог сурагчидтай түргэн ойлгодог сурагчдын адил харьцаж дэмжин туслах</li> <li>• Охидыг сургуульд сурч боловсрох, эмэгтэйчүүдийг багш бэлтгэдэг сургуульд сурч боловсрохыг нь бүхий л аргаар дэмжих</li> <li>• Хүүхдээ боловсролтой болгохын үнэ цэнийг ухаарсан эцэг эх, гэр бүлүүдийг дэмжих</li> </ul>

<p><i>Практик дээр</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Цээжлүүлэх, цээжлэх сургалт</li> <li>• Шалгалтад суурилсан боловсрол</li> <li>• Мэдлэг дамжуулагч багш</li> <li>• Анги доторх сурагчийн ширээний байрлал</li> <li>• интерактив сургалт явуулахад тохиромжгүй</li> <li>• Суралцагч бүрийг татан оролцуулах сургалтын интерактив арга зүй дутмаг</li> <li>• Залхаан цээрлүүлэх шийтгэл</li> <li>• Ихэнх суралцагчдын ойлгохгүй хэлээр ярих</li> <li>• Сургалтын явцад санаатай болон санамсаргүй байдлаар хүйсээр ялгаварлан гадуурхах</li> <li>• Сургуулиуд болон багш бэлтгэдэг сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай харьцах сонирхолгүй, эсвэл харьцах чадваргүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтыг баг бүлэг болон сурагч бүрийн сонирхол, хэрэгцээнд нийцүүлэн хөгжилтэй, суралцагч төвтэй аргаар явуулах. Жишээлбэл, зураг зуруулах, жүжигчилсэн тоглолт хийлгэх г.м</li> <li>• Дэг журмыг зөв сахиулах</li> <li>• Сургалтыг олон хэл дээр явуулах</li> <li>• Сургууль дээр охид хөвгүүдтэй адил тэгш харьцах (Багш бэлтгэдэг сургуулиуд эрэгтэй болон эмэгтэй оюутнуудтай ижил тэгш харьцах)</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон иргэдийг боловсруулд тэгш хамруулах сургалтыг өөрсдөөсөө эхлэн хэрэгжүүлэх</li> </ul>
<p><i>Нөөц хэрэглэгдэхүүн</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурах бичиг, ширээ, сандлын хүрэлцээгүй байдал</li> <li>• Туслалцаа хэрэгтэй хүүхэд болон насанд хүрэгчдэд зориулсан тусгай хэрэглэл дутмаг</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх болон олон хэлтэй суралцагчдад зориулсан орон нутгийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамж муу</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тусгай хэрэгцээний ширээ сандал, сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авахад илүү мөнгө төсөвлөх</li> <li>• Орон нутгийн болон сургуулийн онцлогт тохирсон сургалтын нөөц хэрэглэгдэхүүнтэй болох</li> </ul>
<p><i>Бодлого</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүйсийн тэнцвэрт байдлыг бодлогоор дэмждэггүй</li> <li>• Сургалтыг зөвхөн олонхийн хэл дээр явуулах бодлого (сургалтыг суралцагчийн төрөлх хэл дээр явуулна гэсэн зарчимтай харшилдаж буй)</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, томчуудын сургалтыг бодлогоор дэмждэггүй</li> <li>• Сургалтад хүйсийн ялгаатай байдлыг ухаалгаар зохицуулах, сургалтыг тохиромжтой хэлээр явуулах, орон нутгийн онцлог, сургууль, ангийнхаа хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, материал боловсруулахад бодлогын зохицуулалтгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүйсийн тэгш байдлыг бодлогоор хангах</li> <li>• Сургалтыг төрөлх хэл болон олон хэл дээр явуулах бодлогын заалт оруулах</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дунд сургууль болон багш бэлтгэдэг сургуульд суралцахыг нь бодлогоор дэмжих</li> <li>• Багш нар сургууль, анги, суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагад тохируулан сургалтын хөтөлбөр, материалаа өөрчлөхийг дэмжих</li> </ul>

<p>Сургалтын орчин</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчдад тохиромжгүй анги танхимууд, тухайлбал олон давхар бүхий сургуулийн барилга, хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчид дээд давхарт гарахад хүндрэлтэй байх, налуу зам, тусгай хэрэгцээнд зориулсан ариун цэврийн өрөө байхгүй байх г.м</li> <li>• Цэвэр усны болон ариун цэврийн өрөөний хүрэлцээгүй байдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх сургуулийг цэвэр ус болон ариун цэврийн өрөөгөөр хангахын тулд нөөц бололцоогоо дайчлах (мөнгө, цаг зав, хүчин чармайлт г.м )</li> </ul>
------------------------	--	---

### Арга зүйн зөвлөмж 3

*“Суралцагчдын харилцан адилгүй байдлыг сул тал бус, харин давуу тал хэмээн үзвээс зохино”.*

Ангид байгаа харилцан адилгүй сурагчдын ялгаатай байдлаас айж эмээхийн оронд тэдгээрийн онцлог чанарыг сургалтын үнэ цэнэтэй зүйл болгон хувиргах нь чухал. Ингэснээр суралцагчдын нийгэмших чадвар болох бусадтай санаа бодлоо солилцох, хамтран ажиллах чадвар дээшилж бүх суралцагч сургуульдаа хувь нэмрээ оруулж чадна гэсэн итгэл үнэмшилтэй болно. Тэгш хамруулах сургалтын үнэ цэнэ нь суралцагчид өөрсдийн онцлог давуу талаа олж харан өөрийгөө нээх, хөгжүүлэх, ингэснээрээ нийгэмд шударга ёс тогтооход гар бие оролцож буй хэрэг юм. Жишээлбэл, янз бүрийн хэлтэй болон угсаатны төлөөлөл болсон суралцагчид түүх, үлгэр домог, дуу бүжгээрээ дамжуулан өөрсдийн соёл, уламжлал, зан заншлаа бусадтайгаа хуваалцах өргөн боломж нээгдэнэ.

## Бэрхшээл 2

### Заах арга ур чадвар

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Суралцагч төвтэй сургалт хэрэгжихгүй байна.*

Энэ асуудал нь хуучирсан арга зүйтэй холбоотой. Багш-төвтэй сургалт нь тэгш хамруулах сургалт явуулахад тохиромжгүй. Учир нь суралцагчдын янз бүрийн хэрэгцээг хангахын тулд суралцагч бүрийн авьяас чадвар, яс үндэс, өмнөх туршлага зэргийг харгалзсан уян хатан сургалт буюу суралцагч төвтэй арга зүй илүү тохирно. Багш-төвтэй арга зүй нь гүйцэтгэлийн шинжтэй, хэвшмэл сургалт байдаг бол суралцагч төвтэй арга зүй нь суралцагчдыг сургалтын үйл явцад идэвхтэй татан оролцуулдаг интерактив шинжтэй байдаг. Багш-төвтэй сургалт нь сурагчдыг зөвхөн мэдлэг хүлээн авагчид гэж үздэг бол суралцагч төвтэй сургалт нь сурагчдыг мэдлэг бүтээгч гэж ханддаг.<sup>4</sup>

<sup>4</sup> Фрэйр,П. 1996 Сурган хүмүүжүүлэх зүй ба дарангуйлал, Лондон, Пенгвин, 53 х

*Сургалтын интерактив арга зүй, олон талт үйл ажиллагаа хангалтгүй байна.*

Дээр дурдсанчлан одоогийн сургалт явуулж буй арга зүй нь нэлээд асуудалтай байгаа бөгөөд сургалт нь сонирхолгүй, зарим суралцагчдад хүртээмжгүй, бүх суралцагчдыг тэгш хамруулж чадахгүй байна. Багш нарын сургалт явуулж буй арга зүй нь хязгаарлагдмал, сурах үйл явц нь зөвхөн гүйцэтгэлийн шинжтэй, өөрөөр хэлбэл сургах, сурах үйл явц нь багшаас сурагчдадаа дамжуулж буй мэдлэг төдийгөөр хязгаарлагдаж байна. Суралцагчид багшийн лекцээр өгсөн зүйлийг буцаагаад өөрт нь давтаж хэлэх сургалт давамгайл явагдаж байна. Мөн сургалтын явцад хувь суралцагч болон баг бүлэг хоорондын харилцааны тэнцвэртэй байдлыг хангаж чадахгүй байна.

Энд сургалтын үйл явцад дан ганц багш суралцагчдыг татан оролцуулах асуудлыг яриад зогсохгүй хичээлийг хэрхэн зохион байгуулах асуудлыг ч авч хэлэлцэх болно. Хэрэв багш нар сургалт явуулахдаа ангийн ширээ сандлыг хөдөлгөх боломжгүй, уламжлалт байдлаар үлдээх аваас тэгш хамруулах сургалтын талаар яриад ч хэрэггүй. Энэ нь багш-төвтэй арга зүйд тохирсон байрлал бөгөөд орон нутагт ийм анги танхимыг олонтаа харж болно. Тэгэхээр тэгш хамруулах сургалт зохион байгуулах эхний алхам нь ширээ сандлын уламжлалт байрлалыг өөрчилж сурагчдад хичээлд оролцох, сургалтад тэгш хамрагдах боломж олгохоос эхэлбэл зохино.

Тэгш хамруулах сургалт явуулах энэхүү арга зүйг багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны аль алинд нь дэмжих шаардлагатай.

*Зөвхөн зарим суралцагчидтай холбоотой заах арга барилууд*

Зарим заах аргууд (жишээлбэл, багш-төвтэй, лекцэд-суурилсан арга зүй г.м) түргэн ойлгоцтой, хурдан ажиллах чадвартай суралцагчдад тустай ч ойлгоц удаан, эсвэл хэлний болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хувьд тохиромжгүй. Ялангуяа сонссон зүйлээ тогтоох чадвар тааруу суралцагчид нь багшийн лекцээс гадуур үлдэх магадлал өндөр байдаг. Гэхдээ хамгийн шилдэг заах арга гэж байдаггүй гэдгийг ямагт санах ёстой.

## Вьетнам улсын жишээ:

*“Шинэ сургууль” загвар<sup>5</sup>*

Боловсролд тэгш хамруулах бодлогыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд оюутан-багш нарыг “Шинэ сургууль” загварын дагуу бэлтгэж эхэлсэн. Энэхүү загвар нь анги дүүргэлт багатай анги болон жижиг баг бүлэгт сургалт явуулахад зориулагдсан. Энэхүү загвар нь дараах зүйлсийг хэрэгжүүлэхийг санал болгодог. Үүнд:

- Суралцагчдыг хэлэлцүүлэгт татан оролцуулах зорилгоор баг бүлгээр хуваах
- Суралцагчдыг өөрт тохиромжтой хурдаар сурах боломжоор хангадаг. Ангид сургалтын булан байгуулахыг дэмждэг (Төрөл бүрийн хичээлийн булан: математикийн булан г.м)
- Сургалтын талаар сурагчдаас санал хүсэлтийг нь сонсдог (Жишээ нь: сурагчдын дунд “шидэт хайрцаг” хайрцаг аялуулдаг.
- Сурагчид хичээлийн талаар болон багшийн талаарх санал сэтгэгдлээ бичиж хайрцагт хийх г.м. )
- Ойролцоо түвшний ангиудын хичээлийг хамтатган орох боломжийг эрэлхийлдэг (Жишээ нь: 2-3 –р ангийн хичээлийг хамтатган заах г.м)
- Эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан сургалтын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Сургалтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг багшийн ном, сурах бичиг, дасгалын ном зэргээр хангах

Бүх суралцагчдад янз бүрийн чадвар, хэрэгцээ байдаг тул тухайн нөхцөлд сонгосон арга зүй нь бусад арга зүйгээ үгүйсгэх тохиолдол гардаг. (Жишээ нь: Багш зөвхөн цээжлүүлсэн зүйлээ дуудаад асуудаг, эсвэл дандаа баг бүлгийн аргаар хичээл явуулаад байж таарахгүй). Энэ нь суралцагчдыг сургалтаас холдуулдаггүй юмаа гэхэд сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй.

*Сургалтын зарим нэг арга, хандлага нь сургалтын хөтөлбөр болон материалыг орон нутгийн нөхцөлд нийцүүлэн өөрчлөх боломж олгодоггүй.*

Тэгш хамруулах сургалтад түгээмэл тохиолддог бэрхшээлүүдийн нэг нь багш нар орон нутгийнхаа онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, сургалтын материалаа боловсруулах итгэл үнэмшил, чадвар хангалтгүй байгаа явдал юм. Ихэнх улсад сургуулийн хөтөлбөрийг төвлөрсөн зарчмаар боловсруулдаг. Багш нар дээрээс боловруулсан хөтөлбөрийг зөвхөн хэрэгжүүлэх үүргийг л хүлээдэг. Харин зарим оронд сургуулиуд нь хөтөлбөрийнхөө агуулгыг орон нутгийнхаа онцлог байдалд нийцүүлэн сонгохыг зөвшөөрдөг. Сургалтын хөтөлбөрийг төвлөрсөн/төвлөрсөн бус аль ч байдлаар хийснээс үл хамаарч суралцагчид, гэр бүл, нийгмийн

<sup>5</sup> ЮНЕСКО.2012. Бүсийн шинжээчдийн уулзалтын тайлан: Ази-Номхон далайн орнуудын багш боловсролын чанарыг сайжруулах замаар тэгш хамруулах сургалтыг хэрэгжүүлэх нь. Бангкок, ЮНЕСКО, 32-33 х



хэрэгцээтэй холбогдуулан хөтөлбөртөө зохих өөрчлөлт хийх үүргийг багш нар хүлээдэг. Хэдийгээр орон нутаг болон тухайн ангийн нөхцөл байдалд давхцал гарах ч энэ нь ихэвчлэн өөр өөр талбарт тохиолддог.

- Орон нутгийн иргэдэд зориулсан хөтөлбөр нь тухайн орон нутгийн соёл, нөхцөл байдлыг харгалзан хийгддэг (жишээлбэл, уугуул мэдлэг, нийгэм-эдийн засгийн нөхцөл, хот ба хөдөөгийн амьдрал г.м).
- Орон нутгийн сургууль, ангид зориулсан хөтөлбөр, сургалтын материал нь тухайн ангийн суралцагчдын тусгай хэрэгцээнд үндэслэнэ (жишээлбэл, хэлний болон суралцагчийн хэрэгцээ).

Багш бэлтгэдэг сургуулиуд суралцагчдынхаа бүтээлч байдал, сургалтын материалыг боловсруулах, сайжруулах чадварыг дээшлүүлэхгүй бол оюутнууд нь ажил дээр гараад сургалтынхаа материалыг нөхцөл байдалдаа тохируулан заах, өөрчлөх чадваргүй, үлбэгэр, бие даан ажиллах чадваргүй, мэргэжлийн итгэл үнэмшил муутай мэргэжилтэн болох аюултай. Иймэрхүү багш бүхий сургуулиудад тэгш хамруулах сургалт зохион байгуулахад хүндрэл бэрхшээл учрах нь ойлгомжтой. Маш сайн боловсруулсан хөтөлбөрийг ч гэсэн нөхцөл байдалтайгаа тохируулан өөрчлөх шаардлага заавал гардаг гэдгийг үргэлж санах хэрэгтэй.

*Явцын болон бодит үнэлгээ<sup>6</sup> хангалттай хэрэгжихгүй байна.*

Өнөөдөр нийт сургуулиудын тэн хагаст нь, зорилго, үүрэг хэлбэр нь тодорхойгүй, эсвэл сургалтын зорилтуудтай үл нийцсэн, уян хатан бус үнэлгээг хэрэглэж буйгаас сургалтын үйл явцын динамик чанар алдагдаж байна. Багш суралцагчид үнэлгээний хэлбэр, хэрэглээг ойлгохгүй бол түүнийг буруу хэрэгжүүлж улмаар сургалтын чанарт ахиц гарахгүй. Хэдийгээр сургалтад эцсийн үнэлгээ чухал боловч сургалтын процессыг үнэлэх явцын үнэлгээ нь тэгш хамруулах сургалтад хамгийн чухал нөлөөтэй билээ.

Хэрэв багш бэлтгэдэг сургуулиуд оюутнууддаа суралцах хугацаанд нь явцын үнэлгээний чухал болохыг ойлгуулж чадахгүй бол тэд төгсөж гарсныхаа дараа үнэлгээний энэхүү хэлбэрийг сургалтад амжилттай хэрэглэх, суралцагчдынхаа сурах үйлийг дэмжих зэрэг нь эргэлзээтэй болно. Ази, Номхон далайн орнуудад өндөр эрсдэл бүхий шалгалтын дүнд өндөр итгэл хүлээлгэдэг нь тэгш хамруулах сургалтын зарчимд үл тохирно.

Явцын ба эцсийн үнэлгээний (сургалтын үр дүнд чиглэгдсэн, оноо/тестийн хэлбэртэй бол) аль аль нь үнэлгээний хандлагыг таньж мэдэхэд чухал үүрэгтэй. Гэхдээ эдгээр үнэлгээ нь хязгаарлагдмал, суралцагчийн юу сурсныг үнэлэхэд чиглэгдсэн бол энэ нь зөвхөн тестэд сайн үр дүн үзүүлдэг суралцагчдад л

<sup>6</sup> ... Явцын үнэлгээ нь суралцагчдын юу сурсан бэ гэдгээс илүү хэрхэн сурсан бэ гэдгийг чухалчилж үздэг бөгөөд сургалтын чанарыг сайжруулж сургалтыг хурдасгагч хүчин зүйл болдог. (Садлер). 1998. Боловсрол дахь үнэлгээ. 5 (1) 77 х

ашигтай тусдаг. Түүнчлэн тодорхой тогтсон цаг хугацаанд хэрэгжүүлдэг эцсийн үнэлгээ нь явцын үнэлгээнээс ач холбогдлоор бага байдаг.

Үнэлгээ бодит биш, мөн суралцагчдыг үнэлгээнд татан оролцуулахгүй бол суралцагчдын сурах итгэлийг бий болгох, тэдний идэвхийг дээшлүүлж чадахгүй.

Багш бэлтгэдэг сургуулиуд оюутнуудаа зөвхөн явцын болон эцсийн үнэлгээний чиглэлээр бэлтгэдэг бол тэд төгссөнийхөө дараа суралцагчдынхаа янз бүрийн хэрэгцээг хангах, харилцан адилгүй суралцагчдыг үнэлж чадахгүйд хүрнэ.

Багш бэлтгэдэг сургуулиудын хувьд явцын, эцсийн болон бодит үнэлгээний хэрэгжилт нь үнэхээр асуудалтай байна.

*Ганцаарчилсан сургалт явуулах туршлага дутмаг байна.*

Дээрхээс үзвэл чанарын үнэлгээ нь багш нар сурагч бүрийнхээ онцлог байдал, чадвар, хэрэгцээ шаардлагыг ойлгож таньсан эсэхээс хамааралтай. Суралцагч бүртэй ганцаарчилж ажиллах төлөвлөгөө гаргахгүйгээр (гэр бүлийн боловсролын төлөвлөгөө, ганцаарчилсан боловсролын хөтөлбөр, ганцаарчилсан сургалтын шилжилтийн төлөвлөгөө г.м) ирээдүйн оюутан-багш нарт суралцагчдынхаа шаардлага хэрэгцээ, сурлагадаа гаргаж буй ахиц дэвшлийг үнэлэхэд нь хүндрэл, бэрхшээл учрах болно.

### **Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно:**

- Багш бэлтгэдэг сургуулийн оюутнуудад суралцагч төвтэй сургалт болон ганцаарчилсан сургалтын талаар ойлголт, мэдлэг эзэмшихэд нь тусалдаг уу?
- Явцын болон бодит үнэлгээг багш бэлтгэдэг сургуулиудад албан болон эцсийн үнэлгээтэй хослуулан хэрэглэдэг үү?
- Оюутан-багш нар суралцагчдын онцлог хэрэгцээнд тохирсон олон төрлийн аргуудыг (жишээлбэл, харааны, сонсголын, биеийн хөдөлгөөний чадамжтай сурагчидтай ажиллах, ой тогтоолтыг нь хөгжүүлэх, суралцагчийн анхаарлыг сайжруулах, баг бүлгийн ажлыг зохион байгуулах г.м) судалдаг уу? Дээрх аргуудыг суралцагчдын янз бүрийн хэрэгцээг хангахад хэрхэн ашиглах талаар заадаг уу?
- Багш бэлтгэдэг сургуульд суралцагч төвтэй сургалт хэрэгжиж чадаж байна уу?
- Багш, оюутан-багш нар сургалтын хөтөлбөр болон сургалтын материалыг орон нутгийн нөхцөл, сургууль, ангийнхаа хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх чадвартай юу?
- Багш бэлтгэдэг сургуулиудад суралцагч төвтэй арга зүй, явцын болон бодит үнэлгээ хэрэглэхийг боловсролын яамны зүгээс бодлогоор дэмждэг үү?

## Монгол орны нөхцөл байдал

- Ганцаарчилсан сургалт явуулах туршлага дутмаг
- ТХС-ын арга зүйг эзэмшихийн тулд заах арга зүйн тусгай сургалтанд хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах,
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын материалыг орон нутаг, сургуулийн онцлогт тохируулан өөрчлөхөд оюутан багшид туслалцаа үзүүлэх
- Оюутан багшийг ТХС-ын үнэлгээний янз бүрийн хэлбэр болох явцын, бодит, эцсийн үнэлгээ хийх сургалтанд хамруулж сургах
- Хамт олонтой ажиллах, заах арга барилдаа анхаарах
- Хамт олонтой ажиллах, заах арга барилдаа анхаарах

## Зөвлөмжүүд

### Арга зүйн зөвлөмж 4

*“Оюутан-багш нар тэгш хамруулах сургалтын гол арга зүй болох суралцагч төвтэй болон идэвхтэй оролцоонд түшиглэсэн аргуудын талаар мэдлэг туршлага багатай тул тэднийг заах арга зүйн сургалтад хамруулах шаардлагатай. Эдгээр аргыг эзэмшихэд тэдэнд идэвхтэй дэмжлэг туслалцаа хэрэгтэй.”*

Суралцагч төвтэй арга зүй нь багшид байх ёстой бусад чадваруудыг хөгжүүлэх (ажиглах, суралцагчийн итгэл үнэмшлийг бэхжүүлэх, зохион байгуулах г.м), багш суралцагчид ангид харилцан хариуцлага хүлээх зэрэг дээр тулгуурлан хэрэгждэг. Суралцагч төвтэй арга зүйг шууд л хэрэгжүүлж болмоор хялбар санагддаг. Гэвч уг арга зүйг ойлгож үр дүнтэй хэрэгжүүлэхэд оюутан-багш нарт сургууль, багш нарын зүгээс ихээхэн тусламж дэмжлэг хэрэгтэй. Ялангуяа сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр суралцагчдынхаа итгэлийг олж харилцаагаа бэхжүүлэхэд нь, суралцагчдаа таньж мэдэхэд нь оюутан-багш нарт дэмжлэг туслалцаа онцгой хэрэг болно. Оюутан-багш нар суралцах хугацаандаа суралцагч төвтэй арга зүйгээр хичээл заалгаагүй, энэ талаарх мэдлэг туршлагагүй бол амьдрал дээр гараад уг арга зүйг сургалтад хэрэгжүүлэхэд цаг хугацаа орох болно.

Суралцагч төвтэй арга зүйг хөгжүүлэе гэвэл багш бэлтгэдэг сургуулиуд өөрсдөө сургалтаа уг арга зүйгээр явуулах нь зүйтэй. Тэд өөрсдөө энэхүү арга зүйг хэрэгжүүлэх үлгэр жишээ буюу загвар нь болох ёстой.

Суралцагч төвтэй, тэгш хамруулах сургалтад доорхи зүйлс үнэхээр чухал үүрэгтэй. Үүнд:

- Багш нар мэдлэг дамжуулагч бус сургалтыг гардан зохион байгуулагч байх (жишээлбэл, баг бүлгийн ажлыг зохион байгуулахдаа суралцагчид харилцан бие биендээ туслах боломжийг бүрдүүлэх)
- Суралцагчдын янз бүрийн хэрэгцээ сонирхолд нийцсэн олон талт үйл ажиллагааг хангаж чадахуйц сургалтын аргуудыг хэрэглэх (суралцагчдын идэвхтэй оролцоог дэмжих), сургалт дахь ганцаарчилсан болон баг, бүлгийн ажлын зохистой харьцааг хангах
- Суралцагчдын онцлогт тохируулан дасгал даалгавар, үйл ажиллагааны зааварчлагыг ялгаатай байдлаар өгөх, хувь суралцагчийн чадвар, өөрийгөө удирдах, болон сурах итгэл, үнэмшлийг нь хөгжүүлэх

Суралцагч төвтэй сургалттай харьцуулахад багш-төвтэй сургалт нь багшаас өндөр ур чадвар, хичээлийн бэлтгэл, хичээл зохион байгуулах хүчин чармайлт зэргийг нэг их шаардаад байдаггүй. Багш төвтэй арга зүйд багшийн үүрэг давамгайлахын сацуу дидактик хандлага, сахилга батын шийтгэл, суралцагчдыг хичээлд татан оролцуулахдаа сүрдүүлгийг хэрэглэх нь түгээмэл байдаг. Харин суралцагч төвтэй арга зүйд багш суралцагчдыг сурах үйлд татан оролцуулснаар тэгш хамруулах сургалтын зарчим бүрэн хэрэгжих боломжтой юм. Ангид зөв сахилга батыг төлөвшүүлэх, анги удирдахтай холбоотой бусад аргыг ашиглах нь суралцагч төвтэй арга зүйг хэрэгжүүлэхэд тустай хэдий ч үүнийг богино хугацаанд хурдан хэрэгжүүлэхэд төвөгтэй. Ялангуяа суралцагч төвтэй арга зүйн талаарх суралцагчид, эцэг эх, тухайн сургуульд ажиллаж буй багш нарын ойлголт мэдлэг хангалтгүй бол энэхүү арга зүйг нутагшуулахад цаг хугацаа нэлээд шаардагдана.

### **Арга зүйн зөвлөмж 5**

*“Тэгш хамруулах сургалтын арга зүйг эзэмшихийн тулд заах арга зүйн тусгай сургалтад хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах, суралцагчдын хүйсийн эрх тэгш байдлыг хангах, сургалтыг янз бүрийн түвшинд, олон хэл дээр хэрхэн явуулах аргуудыг сурах шаардлагатай”.*

Тэгш хамруулах сургалтын арга зүй нь багш нараас суралцагчдаа сайн таньж мэдэхийг, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах, сургалт явуулах бүрэн итгэлтэй байхыг шаарддаг. Тухайлбал:

- Хүйсийн эрх тэгш байдлыг хангах: анги доторх хүйсийн ялгаатай байдалд мэдрэмжтэй хандаж түүнээс улбаалан гарч болох аливаа асуудлыг

зохицуулах чадвартай байх

- Хэлний бэрхшээлтэй байдал: үндэсний хэлээс өөр төрөлх хэлтэй сурагчдын хувьд сургалт явуулахдаа үндэсний хэлийг сургалт явуулах гүүр болгон ашиглахын зэрэгцээ сургалтыг сурагчдын төрөлх хэлтэй хослуулан явуулах чадвартай байх
- Янз бүрийн насны болон түвшин өөр суралцагчидтай ажиллах-шаардлагатай үед түвшин өөр янз бүрийн насны суралцагчдад сургалт явуулах чадвартай байх
- Хөгжлийн бэрхшээл: хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид нь багшаас онцгой анхаарал, тусламж, дэмжлэг шаарддаг тул олон төрлийн чадвартай байх

### **Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 186-р цэцэрлэгийн багш**

- Нэг үеэ бодвол багш нар тэгш хамруулан сургах үзэл санааны талаар ойлголт мэдээлэлтэй болсон. Гэхдээ арга зүйн талаас сурах зүйл их байна. Тэгш хамруулах сургалт явуулахад багшид арга зүйн талаархи дэмжлэгийг СӨБ-ын мэргэжилтэн, тусгай боловсролын мэргэжилтэн, тусгай сургуулийн багш нараас үзүүлэх хэрэгтэй. Хамгийн чухал нь сайн туршлага, үр дүнг судалж, түүнийг түгээн дэлгэрүүлж хэрэгжүүлэх нь чухал байна.

### **Арга зүйн зөвлөмж 6**

*“Сургалтын төлөвлөгөө, сургалтын материалыг орон нутаг, сургуулийнхаа онцлогт нийцүүлэн өөрчлөхөд нь оюутан-багш нарт дэмжлэг туслалцаа хэрэгтэй”.*

Багш бэлтгэдэг сургуулиуд тэгш хамруулах сургалтыг сургалтын хөтөлбөрийнхөө бүрэлдэхүүн хэсэг болгох ёстой. Түүнчлэн оюутан-багш нарт сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг орон нутаг, сургуулийнхаа онцлогт нийцүүлэн өөрчлөх чадвар эзэмшүүлэхийн тулд тэгш хамруулах сургалтын арга зүйд онцгой анхаарал хандуулбал зохино. Оюутан багш нар сурч байх хугацаандаа, мөн багшлах дадлагын явцад дээрх чадваруудыг эзэмшвэл ажлын байранд гараад тэгш хамруулах сургалт явуулах, суралцагчдыг үнэлэх үнэлгээний олон арга хэрэгслийг хэрэгжүүлж чадна.

Хэрэв багш нар энэ чиглэлийн сургалт явуулах чадвар, итгэлтэй бол тэд сургалтад мөрдөгдөж байгаа хөтөлбөр, сургалтын материалыг орон нутаг, сургууль болон суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж чадна. Энэ нь нэг талаас одоо багш мэргэжлээр сурч байгаа оюутан-багш нар дээрх чадваруудыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас оюутан суралцагчид төгссөнийхөө дараа эзэмшсэн чадвараа орон нутгийнхаа нөөц боломжид тулгуурлан сургалтад ашиглах чадвартай болгох (жишээлбэл, орон нутгийн уламжлал, зан заншил, баяр ёслолтой холбоотой) зорилготой юм.

Одоо ажиллаж байгаа багш нар төдийгүй багш мэргэжлээр сурч буй оюутнуудад дээрх чадваруудыг эзэмшүүлэхийн тулд сайтар дадлагажуулах хэрэгтэй. Үүний тулд багш нар санал бодол, ажлын туршлагаа харилцан солилцдог, тэдний хамтын ажиллагааг хангаж чадахуйц багш нарын нэгдсэн мэдээллийн сүлжээг нэн даруй бий болгож уг сүлжээнд багш нар, сургуулиуд, багш бэлтгэдэг сургуулиудыг нэгтгэх хэрэгтэй.

Багш нар сургалтын хөтөлбөр, материалаа орон нутаг, сургуулийнхаа нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх чадвартай болоход нь багш бэлтгэдэг их дээд сургуулиуд төдийгүй Боловсролын яамдаас сэтгэлзүйн болоод техникийн туслалцаа үзүүлэх шаардлагатай. Хэрэв багш нар сургалтын хөтөлбөр болон материалыг зөвхөн мөрдөх ёстой гэсэн үзэлтэй байвал тэдэнд өөрийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх хүсэл эрмэлзэл төрөхгүй нь мэдээж. Иймд тэдэнд сургалтын материал болоод хөтөлбөрийг өөрчлөн нийцүүлэх чадвар олгох нь багш бэлтгэх сургалт болоод багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын аль алинд нь чухал болно.

## Малайз улсын жишээ:

*Анги доторх сургалтын материал, нөөц хэрэглэгдэхүүнийг ашиглах чиглэлээр зохион байгуулдаг сургалтууд<sup>7</sup>*

Малайзийн зүүн бүс нутагт бага ангийн багш нарын дунд нэгэн төсөл хэрэгжүүлсэн байна. Уг төслийн хүрээнд багш нар сургалтын материал болон анги доторх нөөц хэрэглэгдэхүүнээ сургалтын хөтөлбөртэй нийцүүлэн хэрхэн ашиглаж буйд ажиглалт хийжээ.

Сургалтын материалыг хамтран боловсруулах багш нарын хамтын ажлыг дэмжихийн тулд тэдэнд зориулсан сургалт-семинарыг тогтмол зохион байгуулсан байна. Сургалт-семинарын хүрээнд багш нарт сурагчдад ээлтэй хичээлийн хэрэглэгдэхүүн хийх аргуудыг (хүүхэлдэй, сонирхолтой ном, баг, хувцас, хийх, хичээлд ашиглах дуу, шүлэг, тоглоом, хөгжим г.м) зааж сургахын сацуу, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээ хөтөлбөртөө нийцүүлэн боловсруулах, сайжруулах чадварыг сайжруулсан.

Энэ бүх үйл ажиллагаа нь орон нутгийн нөхцөлд тохирсон сургалт явуулах, сургалтын материал боловсруулахад багш нарын бүтээлч байдал, хамтын ажиллагааг дэмжих үр дүнтэй арга болж чаджээ. Хэдийгээр дээрх сургалтуудад ихэнхдээ бага ангийн багш нар хамрагдсан боловч сүүлийн үед сургуулийн удирдлагууд, орон нутгийн боловсролын байгууллагын мэргэжилтнүүд, эцэг эх ийм төрлийн сургалтад оролцох нь ихсэж байна. Цаашид ийм төрлийн сургалтад багш мэргэжлээр сурч байгаа оюутнуудыг татан оролцуулах өргөн боломж нээлттэй байна.

Дээрх сургалтуудын талаар Малайзийн нэгэн дүүргийн боловсролын мэргэжилтэн Саравак өөрийн санал бодлоо илэрхийлэхдээ:

*“Сургалт семинар маш үр дүнтэй боллоо. Багш нарын тухайд үнэхээр сайн байлаа. Манай дүүрэгт зохион байгуулагдсан сургалтад 15 сургуулийн багш хамрагдаж заах арга, сургалтын материал хэрхэн боловсруулах талаар шинэлэг зүйл ихийг сурлаа. Сурган хүмүүжүүлэх зүйн чиглэлээр зохиогддог бусад сургалтаар ихэвчлэн хичээлийн төлөвлөгөө хэрхэн боловсруулах тухай хөнддөг бол энэ удаагийн сургалтаар багш нар зөвхөн сонсож харах бус өөрсдөө хийж турших боломжтой байснаараа онцлог байлаа. Багш нарт сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож өөрсдийнхөө сургууль дээр хэн юу хийдэг талаар харилцан санал бодлоо солилцож бие биеэсээ суралцах боломж олгосон нь сургалтын давуу тал байлаа ” гэжээ.*

### Арга зүйн зөвлөмж 7

*“Оюутан-багш нарыг тэгш хамруулах сургалтын үнэлгээний янз бүрийн хэлбэрүүд болох явцын үнэлгээ, бодит үнэлгээ, эцсийн үнэлгээний чиглэлээр сургалтад хамруулж дадлагажуулах шаардлагатай байна. Багш бэлтгэдэг сургуулиуд өөрсдийн сургалтад үнэлгээний дээрх хэлбэрүүдийг хэрэгжүүлдэг байвал зохино”.*

<sup>7</sup> Каплан. И. 2012. Малайзийн Англи хэлний багшийн хөгжил төсөл: Төслийн дунд шатны тайлан. Куала Лумпур, Британий Зөвлөл, 29 х

Багш нарыг бэлтгэхдээ үнэлгээний бүхий л хэлбэрүүдийг (явцын, бодит болон эцсийн үнэлгээ) хэрэглэх чадвартай байхад анхаарах хэрэгтэй.

Явцын үнэлгээ нь тоон хэмжигдэхүүнээс гадна чанарын үзүүлэлтээр хэмжигддэг. Явцын үнэлгээ нь сурах үйлийн олон нотолгоон дээр тулгуурласан, багш суралцагчдын хувьд аль алианаас нь хариуцлагатай байхыг шаарддаг, сургалтыг суралцагчдын хэрэгцээн дээр тулгуурлан зохион байгуулахыг дэмждэг.<sup>8</sup> Тэгш хамруулах сургалтын үндсэн бүрдэл болох сургах үйл явцын үнэлгээ болон бодит үнэлгээ<sup>9</sup> явцын болон эцсийн үнэлгээтэй уялдуулан хэрэглэх нь зүйтэй. Дээрх үнэлгээнүүдийг хослуулан хэрэглэснийг тэгш хамруулах сургалтын үнэлгээ гэнэ.

Тэгш хамруулах сургалтын үнэлгээнд тоон үзүүлэлт дээр суурилсан тестээс гадна суралцагчдын сурах чадварыг хэмжиж илэрхийлэх бусад олон үзүүлэлтийг ашигладаг. Эдгээр үзүүлэлтэд: суралцагчид бие биетэйгээ хамтран ажиллаж буй байдал, суралцагчдын сэтгэл санааны байдал, суралцагчдын янз бүрийн хэрэгцээ (харааны, сонсголын, биеийн хөдөлгөөний чадамжтай г.м), суралцагчдын тогтоох чадвар, анхаарлаа төвлөрүүлэх, өөрийгөө хянах чадвар зэрэг олон хүчин зүйл багтана. Суралцагчдаа ингэж үнэлэхэд багш нараас тэднийг сайтар ажигладаг, бүтээлч эргэцүүлэл хийдэг байх зэрэг чадваруудыг шаардана. Ерөнхийдөө сургалтыг үнэлэхдээ суралцагчдын чадварыг бусадтай нь харьцуулах стандартыг баримталдаг. Харин тэгш хамруулах сургалтын үнэлгээнд суралцагч сургалтын явцад ямар амжилт гаргасныг үнэлэхийг чухалчилдаг. Тэгш хамруулах сургалтын үнэлгээнд дараах арга, хэлбэрийг хэрэглэдэг. Үүнд: багшийн ажиглалт, суралцагчийн бүтээлийн сан (зурсан, бичсэн, хийж бүтээсэн бусад зүйлс г.м), эзэмших ёстой мэдлэг чадварын жагсаалт, суралцагчдын тестийн дүн, өөрийн үнэлгээний хуудас, бүтээлч эргэцүүлэл г.м.<sup>10</sup> Тэгш хамруулах сургалтад үнэлгээний уян хатан байх зарчим чухал. <sup>11</sup> Учир нь үнэлгээний янз бүрийн хэрэгслийг ашиглан суралцагчдын цогц чадамжийг илрүүлж үнэлэх нь үнэлгээний гол зорилт юм.

<sup>8</sup> Виллям.Д.2006. Явцын үнэлгээ: Боловсролын үнэлгээ. Тэйлор ба Францис 11(3-4), 283-89 х

<sup>9</sup> Дарлин Харморд ба Шнайдер.Ж. 2000. Бодит үнэлгээг сургалтад ашиглах нь. Багш ба багш боловсрол.(16), 524 х

<sup>10</sup> Явцын үнэлгээний давуу талууд: ЮНЕСКО.2003. Тэгш хамруулах сургалтын материалууд. Менежерүүд болон удирдлагуудад зориулсан материалууд. Парис, ЮНЕСКО

<sup>11</sup> ЮНЕСКО.2004. Суралцагчдад ээлтэй, тэгш хамруулах сургалтын орчин бүрдүүлэх нь, Товхимол- 5, Бангкок,ЮНЕСКО, 41 х



## Багам улсын жишээ:

*Их дээд сургуульд суралцагчдын өөрийн үнэлгээ<sup>12</sup>*

Багамын их сургуулийн профессор суралцагчдын өөрийн үнэлгээ сургалтад ямар үнэ цэнэтэй болох тухай өөрийн байр сууриа ийнхүү илэрхийлжээ. “Суралцагчдаар өөрийн үнэлгээ хийлгэхээс өмнө тэднийг хос хосоор нь ажиллуулдаг. Хос болгонд өөрийн ажлыг үнэлэх стандарт/шалгуур бүхий хуудсыг өгдөг. Ийм үнэлгээг бүжгээс эхлээд математик зэрэг бүх хичээлд ашиглаж болно. Суралцагчдад үнэлгээг хэрхэн хийх удирдамжийг өгдөг бөгөөд түүнд юуг хийж болох, үл болохыг тодорхой зааварчилсан байдаг. Суралцагчид өөрсдийгөө үнэлэх явцад би шууд оролцож заавар өгдөггүй, харин тэдэнд зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлдэг.”

Суралцагчид үргэлж жуулчидтай харилцдаг тул өөрсдийн бодол санаагаа илэрхийлж гаргахад бэрхшээлтэй тулгардаггүй.

Тэд надаас асуулт асууж үнэлгээг хэрхэн хийх талаар санал зөвлөгөө авдаг. Заримдаа бид үнэлгээг хэрхэн хийх тал дээр хэлэлцүүлэг хүртэл зохион байгуулдаг. Ийм байдлаар тэгш хамруулах сургалтын үнэлгээнд ашиглаж болох нэмэлт мэдээлэл цуглуулж, харин суралцагчид маань үнэлгээндээ сэтгэл ханамжтай үлддэг байсан. Сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх тал дээр би санаачлагатай байж бусдад үлгэр дуурайл болохыг хичээдэг. Үүний үр дүнд суралцагчид маань туршлагаа хуваалцах, асуудал шийдвэрлэх зэрэг тэгш хамруулах сургалтын амин сүнс болсон сурах үйл ажиллагааны олон хэлбэрүүдийг дуртайяа хийж гүйцэтгэдэг болсон.

Суралцагчид үнэлгээний стандарт/шалгууруудын талаар хэлэлцэж дуусмагц бусадтайгаа ярилцаж санал үл нийлэх зүйл байгаа эсэх талаар ярилцдаг. Бүх суралцагчид саналаа нэгтгэж дуусмагц үнэлэх үйл ажиллагаа эхэлнэ. Үнэлгээ хийх явцад суралцагчид харилцан асуулт асуух, бие биеэ сонсох, шүүмжлэх, санаа оноогоо хэлэх зэргээр идэвхтэй оролцдог. Үнэлгээг ийм хэлбэрээр хийх үед багшийн зүгээс суралцагчдыг ажиглах нь ердийн үзэгдэл бөгөөд суралцагчийн өөрийн үнэлгээний хэлбэрийг анги танхимаас гадна тоглоомын талбай, лаборатори, олон нийтийн газарт ч хэрэглэж болно.

Даалгавар бүрийн дараа суралцагчид өөрсдийн алдаа оноогоо сайн дураараа хэлэлцэж ийм алдаануудыг цаашид дахин гаргахгүй байх арга замыг ярилцдаг ба энэ нь тэдний цаашдын сурлагын амжилтын үндэс болдог.

Хувь суралцагчид үнэлгээ хийх явцад идэвхтэй хамрагдсанаар шийдвэр гаргахад өөрийн оролцоог бий болгодог. Тэдний санаа оноо ямар чухал болохыг тэд өөрсдөө мэддэг.

<sup>12</sup> Мк. Доналд,Б. 2006. “Өөрийн үнэлгээ ба тэгш хамруулах сургалт, Багамд”. EENETсонин (10)

Хэлэлцүүлэгт оролцсоноор суралцагчдын хувийн хариуцлага сайжирдаг бөгөөд энэ нь тэгш хамруулах сургалтад чухал билээ. Харилцан адилгүй хүмүүстэй ажиллах нь Багамын хувьд аялал жуулчлалаас эхтэй.

Би өөрийн анги дотор байгаа харааны болон сонсголын бэрхшээлтэй суралцагчдыг сурах үйл ажиллагаанд татан оролцуулж бусад нь тэдгээрийг дэмждэг байх орчинг бүрдүүлж ажилладаг. Жишээлбэл, сонсголын бэрхшээлтэй суралцагчдыг бичлэг сонсох боломжоор хангадаг. Харин хурд удаан суралцагчдад бусдыгаа гүйцэх боломж олгодог. Анги танхимд бүх сурагчдад адилхан боломж олгохын тулд хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх нь чухал. Бидний харилцааны гол дүрэм бол их ярьдаг суралцагчид дуу муутай суралцагчдад ярих боломж олгодоггүй байдлыг таслан зогсоох явдал юм. Хэрэгцээ гарвал багшийн зүгээс би өөрөө оролцох шаардлага ч гардаг.

Нийгмийн эмзэг бүлгийн суралцагчдыг ч мөн адил ангид бусадтайгаа хамт эрх тэгш суралцах нөхцөлөөр хангах ёстой. Суралцагчдын ойр дотны хамтын ажиллагаа нь зан суртахууны доголдолтой суралцагчдыг найрсаг харилцаанд сургах ач холбогдолтой. Хамтран суралцахуйг ангидаа хэрэгжүүлснээр багшийн хувьд би суралцагчдынхаа харилцан адилгүй байдал, сэтгэл санааны стресс, түүнээс улбаалах үр дагаврыг урьдчилан харах боломжтой байдаг.

Өөрийн үнэлгээ нь суралцагчдын бүтээлч эргэцүүлэл, сурлагын ахиц, бүтээлч сэтгэлгээг дэмждэг. Суралцагчид маань хэн хэндээ ашигтай байхаар тохиролцож чаддаг байх ёстой. Энэ нь ердийн ангитай харьцуулахад чадвар тааруу суралцагчдад илүү боломж олгодгоороо давуу талтай. Түүнчлэн эрсдэлтэй-бүлэгтэй ажиллахдаа аливаа асуудлаас зайлсхийх хэрэгтэй болдог. Үүний тулд суралцагчдыг нийгмийн хэв шинжээр нь бүлэглэж ингэснээр хүн бүр тэгш хамруулах сургалтын үр ашгийг хүртэж чаддаг.

### **Арга зүйн зөвлөмж 8**

*“Суралцагчдынхаа хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хийх, тэгш хамруулах сургалтын бэрхшээлүүдийг даван туулахад нь оюутан-багш нарт дэмжлэг зайлшгүй хэрэгтэй.”*

Тэгш хамруулах сургалтын үнэлгээтэй холбогдуулан тэмдэглэхэд уг сургалтад суралцагч гэхээсээ илүүтэйгээр багш нарын хүлээх хариуцлага өндөр байна. Багш нар энэ хариуцлагаа хэрэгжүүлэхийн тулд тэгш хамруулах сургалтад тохиолдож буй саад бэрхшээлийг даван туулах, суралцагч бүртэй ажиллах ганцаарчилсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх нь чухал юм.

Гэхдээ ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ сургууль, ангийн сургалттай уялдуулах шаардлагатай. (жишээлбэл, суралцагчдын хамтын ажиллагаа, харилцааг хэрхэн хангах г.м) Түүнээс гадна тэгш хамруулах сургалтад тохиолдож буй бэрхшээлийг даван туулахдаа ганцаарчилсан сургалтын арга барилыг ухаалгаар хэрэгжүүлэх нь багш нарын хувьд маш чухал. Ганцаарчилсан

сургалтад хэт бага анхаарал хандуулах нь суралцагчдаа танихад саад тотгор болж улмаар тэгш хамруулах сургалтын тогтолцооны саад бэрхшээлийн нэг болдог. Ганцаарчилсан сургалтын арга нь суралцагчдыг тусгаарлахад бус, харин суралцагчдын суралцах арга барил, харилцан туршлага солилцох нөхцлийг олгох ганцаарчилсан болон баг бүлгийн ажлын тэнцвэрийг хангахад оршино.<sup>13</sup>

## Монгол улсын жишээ:

### *МУБИС-ийн сэтгэл судлал, тусгай боловсролын багш бэлтгэх ангийн оюутнууд*

“Тусгай сэтгэл судлал”, “Боловсролын үнэлгээ ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” хичээлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг судалж үнэлэх, үнэлгээнд тулгуурлан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах талаар онолын түвшинд нилээд дэлгэрэнгүй судалдаг. Гэхдээ энэхүү боловсруулсан ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөө практикт хэрэгжүүлэх боломж оюутан – багшид хангалтгүй байдаг. Энэ байдлыг арилгахын тулд тусгай сургууль, их сургуулийн багшийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутанд тусгай сургуульд ажиглалт, дадлага хийх боломжоор хангах талаар зохицуулалт хийж болох юм.

## Бэрхшээл 3

### Багшлах дадлага, эргэцүүлэл ба дэмжлэг

#### Нөхцөл байдлын шинжилгээ

*Тааруухан хяналт, муу дэмжлэг*

Хэрэв багш сурган хүмүүжүүлэгчид оюутан-багш нарт тэгш хамруулах сургалтын талаар зохих ёсны үнэлгээ, зөвлөмжийг байнга өгөхгүй бол тэдгээр нь төгсөж гараад багш болсон ч уг сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Энэ нь өмнө дурдсан тэгш хамруулах сургалтын үнэлгээтэй мөн холбоотой.

Хэрэв оюутан-багш нарт зөвхөн хангалтгүй, сөрөг үнэлгээ өгвөл тэд уг сургалтыг хэрэгжүүлэх сэдэл, урам зориг муутай байх болно гэдгийг санах хэрэгтэй. Нөгөө талаар суралцагчдад зохих ёсны урамшуулал, дэмжлэг өгөхгүй бол тэд чадварлаг бус, бүтээлч эргэцүүлэл, өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэлгүй багш нар болж хувирна.

Сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр тэгш хамруулах сургалтын талаар зохих ёсны удирдлага, дэмжлэг авч чадаагүй суралцагчдын хувьд амьдрал дээр

<sup>13</sup> Бланко,Р. 2009. Тэгш хамруулах сургалтын бүтэцчилсэн хүрээ. Аседо,С., Амадио,М. Опертти.Р Боловсролд тэгш хамруулах хөтөлбөр: Боловсролын олон улсын 48-р хуралдаанаас хийсэн эргэцүүлэл. Женев, ЮНЕСКО

гармагц тохиолдох хүндрэл бэрхшээлийг даван туулах итгэл, чадваргүй багш нар болох аюултай.

*Оюутан-багш нарын хувьд сурган хүмүүжүүлэх дадлага хийх боломж хомс байдаг.*

Оюутан суралцагчдад багш боловсролын онолыг түлхүү зааж практик дадлагын талыг нь орхигдуулснаас бодит амьдрал дээр бэрхшээлийг даван туулах чадваргүй багш сурган хүмүүжүүлэгчид төрж байна. Харамсалтай ч зарим нэг багш бэлтгэх хөтөлбөрүүд багшлах дадлагад хэт бага анхаарал хандуулж байгаа нь үнэн билээ. Оюутны багшлах дадлагад зохих анхаарал тавиагүйгээс оюутан-багш нар бодит амьдрал дээр гараад онол дадлагыг хослуулан хэрэглэж чадахгүй байна.

Түүнчлэн боловсролын удирдах ажилтнууд болон мэргэжилтнүүд өөрсдөө сургуулийн амьдралаас тасархай ажиллаж байгаа нь асуудал дагуулж байна. Боловсролын байгууллагад ажиллаж буй мэргэжилтнүүд сургууль, ангид болж буй үйл явцын талаар сүүлийн үеийн мэдээлэл байхгүй, багш, суралцагчидтай ажиллах туршлага байхгүйн улмаас тэдэнтэй хэрхэн ажиллах, ямар удирдлагаар хангаж ажиллахаа мэдэхгүйд хүрч байна. Мөн орчин үеийн сургалтын нөхцөл байдал, сургуулийн практикт тохиолдож буй бэрхшээл, зовлонг гадарлахгүй байна.

Зарим тохиолдолд боловсролын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд сургуульд ажиллаж байсан туршлагагүй, эсвэл өөрсдөө оюутан байхдаа л олж мэдсэн, олж авсан бага сага туршлагадаа дулдуйдан ажиллаж буй тохиолдол цөөнгүй байна. Хэрэв боловсролын мэргэжилтнүүд өөрсдөө энэ талын мэдлэг, туршлага муутай бол багш, суралцагчдад хэрхэн асуудал шийдвэрлэхэд нь тусалж чадах билээ. Түүнчлэн сургуулийн амьдралыг огт мэдэхгүй мэргэжилтэн онол дадлагыг хэрхэн хослуулах тал дээр багш суралцагчдад зөвлөж асуудлыг шийдвэрлэхэд нь арга зүйн тусламжаар хангахад бэрхшээл учирна.

*Бүтээлч эргэцүүллийн дадлага дутагдаж байна.*

Багш бэлтгэдэг сургуулиуд оюутнуудынхаа бүтээлч сэтгэлгээ, асуулт асуух чадвар, бүтээлч эргэцүүлэл хийх сэтгэлгээг нь хөгжүүлэхгүй бол бүтээлч, уян хатан, өөртөө итгэлтэй багш нарыг бэлтгэн гаргаж чадахгүй. Бүтээлч эргэцүүлэл хийхгүйгээр багш нар тэгш хамруулах сургалтын чухал бүрдэл болох сургалтын материалаа суралцагчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчлөх чадвар эзэмшихгүй.

## Өөрийн орны нөхцөл байдлыг задлан шинжлэхэд дараах асуултууд тус болно:

- Багш бэлтгэх хөтөлбөрт тусгасан оюутны сурган хүмүүжүүлэх дадлагын хугацаа (оюутнуудын хувьд) хангалттай юу?
- Танай сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчид сургууль багш нартай ажиллах талаар зохих мэдлэг, ажлын туршлагатай юу?
- Багшлах дадлагад гарсан оюутнуудад сургуулийн зүгээс арга зүйн тусламж үзүүлэх, дадлагатай холбоотой асуудлаар зөвлөгөө өгдөг үү? Үүнийг хэрхэн төлөвлөж санхүүжүүлдэг вэ?
- Оюутан-багш нарт энэхүү дэмжлэг туслалцааг хэрхэн ашиглахыг зааж сургадаг уу? (жишээлбэл, эцэг эх, бусад багш нар болон туслах ажилтнуудтай хэрхэн хамтарч ажиллах талаар)
- Сурган хүмүүжүүлэх дадлагаар оюутан-багш хангалттай туршлага хуримтлуулж чадах уу?
- Оюутан-багшаас бүтээлч эргэцүүлэл болон үйлийн судалгаа хийхийг шаарддаг уу?
- Багш бэлтгэдэг сургуулиуд болон дадлагын сургуулиуд хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайн уу? Энэ нь оюутан-багш нар тэгш хамруулах сургалтын талаар зохих туршлагатай болоход дэмжлэг болж чаддаг уу?

### Монгол орны нөхцөлд дараах байдал байна.

- ТХС үзэл санаа олж авах сурган хүмүүжүүлэх дадлагад гарах боломжоор хангах
- Сургалтын төлөвлөгөө, сургалтын материалыг орон нутаг, сургуулийн онцлогт тохируулан өөрчлөхөд оюутан багшид туслалцаа үзүүлэх
- Оюутан багшийг ТХС-ын үнэлгээний янз бүрийн хэлбэр болох явцын, бодит, эцсийн үнэлгээ хийх сургалтад хамруулж сургах

## Зөвлөмжүүд

### Арга зүйн зөвлөмж 9

*“Багш боловсролын хөтөлбөрийн хүрээнд оюутан-багш нарыг сурган хүмүүжүүлэх дадлагад гарах боломжоор хангах ёстой”.*

Багш бэлтгэх боловсролд зайлшгүй байх ёстой бүрэлдэхүүн хэсэг нь багшлах дадлага бөгөөд ирээдүйн багш нарыг бэлтгэж төлөвшүүлэхэд онцгой чухал үүрэгтэй. Тодорхой хугацаанд оюутнуудыг багшлах дадлага хийлгэснээр суралцагчид эзэмшсэн онолын мэдлэгээ дадлагатайгаа хослуулах, багшлах чадвараа хөгжүүлэх боломжийг олгоно. Багшлах дадлагаас суралцагчид

багшийн ажлын ихээхэн туршлагатай болно. Нөгөө талаас оюутны дадлагыг чанартай сайн удирдлагаар хангах нь тэгш хамруулах сургалт цаашид амжилттай хэрэгжихийн үндэс суурь болдог.

Багш боловсролын хөтөлбөрт оюутны сурган хүмүүжүүлэх дадлагад ноогдуулах хугацааг нарийн тусгах нь төвөгтэй байж болох юм. Гэхдээ оюутан -багш нар суралцах хугацаандаа жил бүр ийм дадлагад гарах боломжтой байвал чухал. Ийм боломжийг янз бүрийн арга замаар бүрдүүлж болох юм. Тухайлбал, сургууль, багш нарын ажилд сайн дураараа туслах, сургуулиудтай хамтран тусгай төсөл хэрэгжүүлэх, сургууль дээр хичээлийн ажиглалт хийх, багшлах дадлагыг тогтвортой хугацаанд гүйцэтгэх, эсвэл багшийн ажилд туслах г.м. Багш боловсролын хөтөлбөрт байгаа сурган хүмүүжүүлэх дадлагын хугацаа, давтамжийг нэмэгдүүлэх замаар оюутан-багш нарыг дадлагажуулж туршлагажуулах хэрэгцээ байна.

Дадлага удирдаж буй сургууль, багш нарын хувьд ч гэсэн ашигтай зүйл байна. Багш нар оюутан-багшийн дадлагыг удирдахын сацуу тэгш хамруулах сургалт явуулах чадвартай болоход нь ажиглах, хянан туслах үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ сургалт зохион байгуулах, анги удирдах, үнэлгээний талаар харилцан бие биеэсээ суралцах боломжтой. Оюутан багш нарт дадлага удирдагч багш нарын зөвлөгөө, санаа оноо маш чухал бөгөөд энэ тал дээр багш бэлтгэдэг сургуулиуд багш нарыг дэмжиж ажиллавал зохино.

Оюутан-багш нар тэгш хамруулах сургалтын бүхий л салбарт дадлагажиж туршлагатай болох нь чухал. Жишээлбэл: эмзэг бүлгийн, янз бүрийн яс үндэс бүхий, хөгжлийн бэрхшээлтэй, хотын болон орон нутгийн, авьяас билэгтэй зэрэг янз бүрийн суралцагчидтай ажилласнаар ийм туршлагыг олж авна.

Багш мэргэжлээр суралцагчдыг сурган хүмүүжүүлэх дадлагад хамруулах хөтөлбөр хэрэгжүүлснээр багш бэлтгэдэг сургуулиуд болон дунд сургууль хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх ач холбогдолтой бөгөөд ийм хамтын ажиллагаа нь харилцан ашигтай байх болно.

Сурган хүмүүжүүлэх дадлага хүлээн авч буй сургуулийн багш нарын хувьд мэргэжлээ дээшлүүлэх сайхан боломж нээгдэхийн сацуу өөрсдийн мэдлэг чадвар, туршлагаа бусадтай хуваалцсанаар багш боловсролд өөрсдийн хувь нэмрээ орууна. (Жишээлбэл, дадлагын үеэр оюутан-багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх, багш бэлтгэдэг сургуулиудаас зохион байгуулах сургалт семинарт оролцох боломжтой.)

## Мянмар улсын жишээ:

*Орон нутаг дахь дадлагын аялал*<sup>14</sup>

Мянмарын уугуул үндэстэн болох Каренчууд Тайланд, Карен мужийн хилийн завсар байрлах хоёр газарт багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Энэхүү хөтөлбөрт Карений хэл соёл, зан заншлыг өрнийн боловсролтой хослуулан заахыг тусгасан бөгөөд энэ нь багш мэргэжлээр сурч байгаа оюутнууд Мянмарын Карен нутгийн олон янзын суралцагчид бүхий сургуульд ажиллах, туршлагажих боломжийг бүрдүүлсэн байна.

Тус хөтөлбөрийн дагуу суралцагчид багш мэргэжлээр 2 жил суралцаад сүүлийн хоёр жилд нь Карен нутгийн сургуулиудад очиж багшлах дадлага хийдэг байна. Эхний хоёр жилд оюутнууд багш боловсролын хичээлүүдийг сургууль дээрээ үзэхийн зэрэгцээ жил бүр орон нутгийн сургуулиуд дээр дадлагад гарч зохих хэмжээний практик эзэмшдэг.

Ийм дадлагын нэг жишээ бол нэгдүгээр курсийн оюутнууд нэг сарын хугацаанд Карен нутгийн том жижиг мужуудаар аялж (ихэвчлэн явган аялал хийдэг) очсон нутгийнхаа сургуулийн багш, суралцагчид, эцэг эх, хүн ардтай уулздаг ажээ. Энэхүү аялал нь оюутан-багш нарт ирээдүйд очиж ажиллах Карен нутгийн сургуулийн багш суралцагчидтай уулзах, тэднээс ярилцлага авах, сургуулиудын талаар төсөөлөл, мэдлэгтэй болоход нь их тус нэмэр болдог. Аяллын үеэр оюутан-багш нар хүүхдүүд, эцэг эх мөн нутгийн ардын дунд төрөл бүрийн сонирхолтой арга хэмжээ зохиодог.

Энэ нь оюутан-багш нарын өөртөө итгэх итгэлийг бэхжүүлж туршлага хуримтлуулахад нь маш чухал дадлага болдог ажээ. Ийм аялалд оролцсон нэгдүгээр курсийн оюутнууд өөрсдийн сэтгэгдлээ ийнхүү илэрхийлсэн байна. “Миний хувьд хамгийн сонирхолтой агшин бол Карений багш сурагчидтай уулзсан явдал байлаа. Багш нар маш бага цалин авдаг ч гэлээ хойч үеэ сайн боловсролтой болгохын төлөө үнэхээр хүчин чармайлттай ажиллаж байлаа. Энэ нь багш болох надад маш их урам зориг өгсөн юм. Бас нэгэн эмэгтэй сурагч “тосгоноо орхиж явахгүйгээр өндөр боловсролтой болмоор байна” гэж ярьсан нь өндөр сэтгэгдэл төрүүлсэн юм. Тэндхийн багш сурагчид надад үнэхээр гүнзгий сэтгэгдэл үлдээж урам зоригийг маань бадраасан юм.”

<sup>14</sup> Каплан, Я. 2012. Карений багш боловсролын асуудалд. Докторын зэрэг горилсон диссертац. Карений ` багшийн коллеж. [www.ktwg-g.gov](http://www.ktwg-g.gov).

“Биднийг тосгонд ирэхэд тосгоны хүмүүс найрсаг дотноор угтсан нь их содон байлаа. Хүүхдүүд нь үнэхээр их зүйл сурахыг хүсч буй нь тэдний царайнаас харахад илт байв. Эцэг эх нь хүртэл бидний зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцож байлаа. Тэд хийж байсан ажлаа зогсоогоод бидэн дээр ирж бидний ажилд оролцож байсан нь үнэхээр сайхан санагдаж байв.”

“Бид нутгийн иргэдтэй хамт ажиллаж байхдаа бидэнд сурах мэдэх зүйл асар их байгааг мэдэрч байлаа. Тэгээд бид ямар нэг зүйл хийх бүртээ өөр хоорондоо харилцан зөвшилцдөг байв. Хүн бүр өөрдийн санаа оноогоо хэлж тэр дундаас хамгийн шилдгийг нь ярилцан байж сонгодог байлаа. Ирээдүйд боловсролын чанарыг сайжруулахын төлөө дүүрэг, хотын боловсролын байгууллагуудтай нягт холбоотой ажиллах хэрэгтэй.”

## Монгол улсын жишээ

*МУБИС-ийн сургалтын хөтөлбөрт сурган хүмүүжүүлэх багшлах дадлагыг 3-р курст 6-8 долоо хоног, мэргэших дадлагыг 4-р курст 4 долоо хоног тус тус тусгаж онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх, сургуулийн амьдрал, багшийн хөдөлмөртэй танилцах боломжийг оюутан багшид олгодог.*

Дадлагын хугацаа хангалттай боловч, оюутан багш дадлагын үеэр тэгш хамруулан сургах сургалтын үзэл санааг хэрэгжүүлэх арга зүйн чиглэлээр туршлага хуримтлуулж чаддаггүй тул, их дээд, дунд сургуулийн багш нар энэ тал дээр анхаарч үйл ажиллагааны төлөвлөлт хийх хэрэгтэй нь харагдаж байна.

### Арга зүйн зөвлөмж 10

*“Багш сурган хүмүүжүүлэгчид сургууль, сургуулийн хамт олонтой нягт холбоотой ажиллаж өөрийн багшлах арга барилдаа цаг ямагт анхаарвал зохино.”*

Сургууль багш нартай холбоотой байхын тулд боловсролын ажилтнууд сургуулиудтай хамтран ажиллах шаардлагатай. Хэрэв боловсролын ажилтнууд сургуулиудтай нягт хамтарч ажиллавал сургуулийн талаарх тэдний ойлголт өргөжин тэлэх болно. Ингэснээр багш сурган хүмүүжүүлэгчид оюутан-багш нарт үндэслэлтэй, ажил хэрэгч, шинэлэг, зохих хэмжээний дэмжлэг үзүүлж чадна.

Хэдийгээр үүнд багш нарын цагийн ачаалал ихсэх ч сургуулиуд уян хатан идэвхтэй ажиллаж чадвал багш нарт бэрхшээлийг даван туулах боломж байна. Эдгээр боломжуудаас дурдвал:



- Хамтарсан сургалт-семинар, бусад арга хэмжээг зохион байгуулах (жишээлбэл, тусгай чадвар болон цогц чадамжийг хөгжүүлэх, сургалтын материал боловсруулах г.м)
- Оюутнуудын сурган хүмүүжүүлэх дадлагын хугацаанд багш бэлтгэдэг сургуулиудын багш мэргэжилтнүүд дадлагын сургуулиуд дээр очиж сургуулийн багш, суралцагчидтай уулзах, оюутан-багш нарынхаа хичээлд сууж ажиглалт хийх
- Багш бэлтгэдэг сургуулийн дадлага удирдагч багш нар дунд сургуулиуд дээр богино хугацаанд зочин багшаар ажиллах

### **Арга зүйн зөвлөмж 11**

*“Сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр дадлага удирдагч багш нар оюутнуудыг байнгын, бүтээлч удирдамжаар хангах шаардлагатай.”*

Сурган хүмүүжүүлэх дадлагыг амжилттай удирдахын үндэс нь бэрхшээл тохиолдсон үед нь оюутан-багш нарт сэтгэл санааны болон арга зүйн (зөвлөх, урамшуулах, ёс зүйн) дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай. Багш бэлтгэдэг сургуулиуд оюутан-багш нарт туслах, дэмжлэг үзүүлэх ажлыг сайтар төлөвлөж хэрэгжүүлэх ёстой. Ийм дэмжлэг нь байнгын, тасралтгүй, багш, оюутнуудын харилцан итгэл дээр үндэслэвэл зохистой.

Түүнчлэн дадлага хүлээн авч буй сургуулийн багш нар оюутан-багшийн хичээлд сууж зохих зөвлөгөө, удирдлагаар хангах үүрэгтэй. Тэд оюутан-багш нарт хэрэгтэй үед (хүндхэн хичээлийн дараа) нь зохих дэмжлэг, зөвлөгөө өгдөг байвал сайн. Оюутан-багшийн дадлагыг удирдах багш нарт хэрхэн ажиллах удирдамжийг маш тодорхой болгож өгөх ёстой.

Багш бэлтгэдэг сургуулиуд дадлагын үеэр оюутан-багш болон сургууль хоорондын харилцааг хянах үүрэг хүлээнэ. Сурагчдын хэрэгцээ, шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх, сургалтын орчин нөхцөл нь хэр зохистой байгаа зэрэгт хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

### **Арга зүйн зөвлөмж 12**

*“Сургууль хоорондын нэгдсэн сүлжээг хэрхэн ашиглах, хөгжүүлэх талаар оюутан-багш нарт зааж сургах шаардлагатай.”*

Тэгш хамруулах сургалт явуулахад сургалтын таатай орчин бүрдүүлэх нь чухал. Оюутан-багш нарт сургуулийн дотор болон гадна орчинд хаана ч бай дэмжлэг үргэлж хэрэгтэй. Тухайлбал сургуулийн удирдах ажилтан, бусад багш нар, хичээлийн туслах ажилтан нартай хэрхэн үр дүнтэй хамтарч ажиллах, эцэг эхэд үр хүүхдийнхээ сургалтад хэрхэн туслах талаар нь зааж сургах хэрэгцээ байнга гардаг тул энэ бүхэнд суралцах шаардлага гарна.

Сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр оюутан-багш нарт эцэг эх, сургуулийн хамт олонтой ажиллах боломжийг олгох ёстой. Тэгш хамруулах сургалтыг амжилттай хэрэгжүүлэхийн эх үндэс болсон эцэг эх, сургуулийн хамт олонтой нягт хамтын ажиллагаа бий болгох, цаашид хөгжүүлэх асуудлыг багш мэргэжлээр сурч байх үеэс нь анхааран дэмжвэл зохино. Энэ нь оюутан-багш нар тэгш хамруулах сургалтад нийгмийн зүгээс учрах бэрхшээл, сургалтад учрах саад тотгорыг сурч байх үеэсээ эхлэн ойлгож ажиллахад нь тустай.

Багш нарын сүлжээнд нэгдсэнээр бусад багш нартай харилцаа тогтоож бие биеэ дэмжих, санаа оноогоо бүтээлчээр илэрхийлэхэд суралцах ба энэ нь багшийн бүтээлч эргэцүүлэл хийх чадварыг дээшлүүлнэ. Бүтээлч эргэцүүллийн асуудлыг дараах зөвлөмжид хөндөх болно.

### Арга зүйн зөвлөмж 13

*“Оюутан-багш нар үйлийн судалгаа хийснээр тэдний бүтээлчээр эргэцүүлэх чадвар дээшилнэ.”*

Үйлийн судалгаа нь оюутан-багшийн бүтээлчээр эргэцүүлэх чадварыг хөгжүүлээд зогсохгүй сурах, сургах үйлийг зохион байгуулахад өндөр ач холбогдолтой. Үйлийн судалгаа хийснээр суралцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг таньж мэдэх, түүн дээр үндэслэн сургалтын арга барилаа сайжруулах боломж гарна. Багш нар өөрсдийн практик үйл ажиллагааг ойлгох тусам, суралцагчдаа таньж мэдэхийн хирээр тэгш хамруулах сургалтад учрах бэрхшээлүүдийг гэтлэх боломжийг олж харна. Иймд оюутан-багш нарт сургалтын янз бүрийн арга барил эзэмшүүлж, өөрсдийн арга барилыг бүтээлчээр эргэцүүлэх, суралцагчид болон сургалтад тохиолдох бэрхшээлүүдийг илрүүлэх, түүнийг гэтлэн давах боломжийг олж харах, шийдлийг эрэлхийлэх бүтээлч сэтгэлгээнд сургах шаардлагатай.

Бүтээлч эргэцүүлэл нь сурах, сургах үйлийг хянах, үнэлэх арга хэрэгсэл болохын сацуу тэгш хамруулах сургалтын үнэлгээнд чухал байр суурь эзэлнэ.

Бүтээлч эргэцүүлэл нь үйлийн судалгааны салшгүй хэсэг бөгөөд тус судалгааг хийснээр тухайн сургуулийн тулгамдсан асуудал юу болохыг тодорхойлж улмаар тэдгээрийг шийдвэрлэх үйл ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, шаардлагатай бол дээрх үйл явцыг дахин давтан хийдэг.

Оюутан-багш нар төдийгүй дунд сургуулийн багш нарт үйлийн судалгааны талаарх мэдлэг, чадвар, дадал олгох хэрэгцээ шаардлага байна. Учир нь үйлийн судалгаа нь бүхэлдээ тэгш хамруулах сургалтын зорилгод нийцдэг. Жишээлбэл: ямар суралцагчид яагаад сургууль завсардсан, тэдгээр суралцагчдыг явал сургуульд нь эргүүлэн авчрах зэрэг асуудлыг судалж шийдлийг нь олохыг эрмэлздэг. Түүнчлэн үйлийн судалгаагаар тухайн сургуулийн сургалт нь сургалтын хөтөлбөртэйгээ хэр уялдаатай хэрэгжиж буйг илрүүлэн судалж болно. (жишээлбэл, математикийн хичээлээр суралцагчдаас асуулга авах г.м)

Үйлийн судалгаа, бүтээлч эргэцүүллийг дэмжих асуудал нь зөвхөн дадлагын сургуультай холбоотой төдийгүй багш бэлтгэдэг сургуулиудын хувьд ч анхаарууштай, сайтар хэрэгжүүлэх ёстой асуудлуудын нэг билээ. Нэг талаас оюутан-багш нар сурах үйлдээ эргэцүүлэл хийж, нөгөө талаас сургалт явуулагч багш нар сургалтдаа эргэцүүлэл хийнэ. Сургагч, суралцагч талуудын аль аль нь үйлийн судалгаа хийснээр багш бэлтгэдэг сургуулиудын сургалтад ахиц гарч ингэснээр тэгш хамруулах сургалт хэрэгжих суурь нөхцөл болно.

Бүтээлч эргэцүүлэл болон үйлийн судалгаа нь багш нарын мэргэжлийн хөгжлийн салшгүй хэсэг юм.

## Зөвлөмжийн эерэг үр дүн хэрхэн илрэх вэ?

Нэгдүгээр удирдамжид онцлон тэмдэглэсэнээр зөвлөмжийг төлөвлөх явцад өөрийн ажлаа хянах, үнэлэхэд туслах үзүүлэлтүүдийг боловсруулах ёстой. Боловсруулах үзүүлэлтүүд нь зөвлөмжийн зорилгоос хамаарна. Эдгээр үзүүлэлтийг боловсруулахдаа төлөвлөгөөний адил янз бүрийн саналуудыг тусгавал зүгээр.

Энэ хэсэгт бид зарим үзүүлэлтүүдийг санал болгож байна. Тэгш хамруулах сургалтын бодлоготой уялдуулан багш бэлтгэдэг сургуулиуд оюутнуудаа сайтар бэлтгэх, өөрсдийн заах арга зүйгээ сайжруулахын тулд дараах зүйлийг анхаарах шаардлагатай байна.

- Тэгш хамруулах сургалтад гардаг бэрхшээл хүндрэлүүд нь суралцагчдын талаас бус, тогтолцооны талаас учирдаг гэдгийг бүрэн ухамсарлах
- Тэгш хамруулах сургалтын процесст гардаг бэрхшээлүүдэд: бэрхшээлийг илрүүлэх, стратегийн шийдлийг олох, дээрх бэрхшээлүүдээс ангижрахын тулд тогтолцоог өөрчлөх зэрэг асуудал багтана.
- Суралцагчдын яс үндэс, хэлний, хүйсийн, хөгжлийн бэрхшээл, чадварын ялгаатай байдлыг тооцох, ялангуяа багш бэлтгэдэг сургуулиудад үүнийг давуу тал хэмээн үзэх
- Багш бэлтгэдэг сургуулиуд сургалтаа суралцагч төвтэй, суралцагчийн идэвхтэй оролцоонд түшиглэсэн арга зүйгээр явуулах

- Багш бэлтгэдэг сургуулиуд тэгш хамруулах сургалтын арга зүйгээр оюутан-багш нарт сургалт явуулах, тэдэнд байнгын тусламж дэмжлэг үзүүлэх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, хэлний бэрхшээлтэй, хүйсийн ялгаатай суралцагчдад сургалт явуулах арга зүйгээр хангаж ажиллавал зохино.
- Түүнчлэн багш бэлтгэдэг сургуулиуд сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг орон нутгийн нөхцөлд хэрхэн нийцүүлэн өөрчлөх чиглэлээр багш оюутнуудад сургалт явуулж удирдамжаар хангах
- Багш бэлтгэдэг сургуулиуд тэгш хамруулах сургалтын үнэлгээний чиглэлээр багш оюутнуудад зориулсан сургалт явуулах (явцын, бодит болон эцсийн үнэлгээ хэрхэн хийх талаар)
- Багш бэлтгэдэг сургуулиуд тэгш хамруулах сургалтын тогтолцооны бэрхшээлүүдийг даван туулахад анхаарч ажиллахын хамт суралцагчдын хувийн хэрэгцээ сонирхолд тулгуурласан ганцаарчилсан төлөвлөгөө хэрхэн боловсруулж хэрэгжүүлэх тал дээр оюутан-багш нарт тусалж дэмжих
- Багш мэргэжлээр сурч буй оюутнуудыг суралцах хугацаанд нь сурган хүмүүжүүлэх дадлага хийх бололцоогоор тогтмол хангах
- Багш бэлтгэдэг сургуулиуд дунд сургуулиудтай нягт холбоотой ажиллах
- Сурган хүмүүжүүлэх дадлагын үеэр оюутан-багш нарт туслах, байнгын, бүтээлч удирдлагаар хангах
- Сургуулийн болон багш нарын сүлжээнд хэрхэн нэгдэх, түүнийг ашиглах, боловсронгуй болгох чиглэлээр оюутан багш нарт удирдамж өгөх
- Багш бэлтгэдэг сургуулиуд багш оюутнуудад зориулж үйлийн судалгаа, бүтээлч эргэцүүллийн чиглэлээр сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх

# Хавсралт

Дараах хүснэгтэд тус зөвлөмжид дурдсан хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн давах зөвлөмжүүдийг санал болгон орууллаа. Түүнчлэн тус хүснэгтийн бөглөөгүй хэсэгт нь та бүхэн өөрсдийн нөхцөл байдалд тохирсон шийдэл, арга замын талаарх санаа оноогоо бичиж болно. Энэхүү зөвлөмжийг та бүхэн хамт олноороо хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах зорилт дэвшүүлээрэй. Тус удирдамжийг хэрхэн ашиглах талаар Удирдамж-1- ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Зөвлөмжүүд	Зөвлөмж хэнд зориулагдсан бэ?	Та үүнийг өөрийн нөхцөл байдалд хэрхэн хэрэглэх вэ?*
<i>“Тэгш хамруулах сургалтын бэрхшээлүүд нь ихэвчлэн тогтолцооноос улбаатай, хэзээ суралцагчидтай холбоотой гарч байсангүй.”</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын Яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалтын хөтөлбөр боловсруулдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Сургуулийн багш, олон нийт (эцэг эх)</li> </ul>	
<i>“Тэгш хамруулах сургалтын системтэй хандлагад дараах зүйлсийг багтааж ойлгоно. 1) тэгш хамруулах сургалт дахь бэрхшээлүүдийг илрүүлэх; 2) эдгээр бэрхшээлүүдийг гэтлэх шийдлийн стратегийг боловсруулах; 3) тогтолцоонд зохих өөрчлөлтүүд хийх.”</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын Яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалтын хөтөлбөр боловсруулдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Сургуулийн багш нар</li> </ul>	
<i>“Суралцагчдын харилцан адилгүй байдлыг давуу тал хэмээн үзэх”</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш боловсролын бодлого, хөтөлбөр, төсөв хариуцдаг Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Сургуулийн багш нар</li> </ul>	
<i>“Ихэнх оюутан-багш нар суралцагчийн хэрэгцээ шаардлагад тохирсон арга зүйгээр сургалт явуулах чадваргүй тул тэдэнд зориулж суралцагч төвтэй, идэвхтэй оролцоонд тулгуурласан сургалтын арга зүй чиглэлээр сургалт явуулах шаардлагатай.”</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Оюутны багшлах дадлагыг удирдагч дунд сургуулийн багш нар</li> </ul>	

Тэгш хамруулан сургах багшийн боловсрол: Зөвлөмж-5

<p><i>Тэгш хамруулах сургалтын арга зүй нь сургалтын тусгай аргууд болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, олон хэлтэн, янз бүрийн ангийн түвшний суралцагчидтай ажиллах арга барилыг эзэмшихийг шаардана.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> </ul>	
<p><i>“Оюутан багш нарыг сургалтын хөтөлбөр, материалаа тухайн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх, боловсруулах талаар тусгай сургалтад харуулах шаардлага байна.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> <li>• Сургуулийн багш нар</li> <li>• Сургуулийн ажилтнууд</li> </ul>	
<p><i>“Оюутан-багш нарыг үнэлгээний талаарх сургалтад хамруулж үнэлгээний олон хэлбэрүүд болох явцын, бодит болон эцсийн үнэлгээг хэрэглэх чадварт сургах шаардлагатай. Багш бэлтгэдэг сургуулиуд өөрсдөө үнэлгээний дээрх хэлбэрийг сургалтдаа ашигладаг байх хэрэгтэй.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээ, хяналтыг хэрэгжүүлэгч Боловсролын яамны мэргэжилтнүүд</li> <li>• Сургуулийн үнэлгээ, хяналт хариуцсан дүүрэг/хот/орон нутгийн боловсролын байгууллагын мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> </ul>	
<p><i>“Багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд оюутан багш нарт сурган хүмүүжүүлэх дадлагад тогтмол хамрагдах боломжоор хангах шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын дадлага хариуцдаг багш, ажилтнууд</li> <li>• Дунд сургуулийн дадлага хариуцагч багш нар</li> </ul>	
<p><i>“Багш сурган хүмүүжүүлэгчид дунд сургуулиудтай нягт хамтарч ажиллах, тэдэнтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж туршлага хуримтлуулах шаардлагатай.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлага</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын ажилтнууд</li> <li>• Дадлага хүлээн авч буй сургуулиудын багш ажилтнууд</li> </ul>	
<p><i>Тэгш хамруулах сургалтын арга зүй нь сургалтын тусгай аргууд болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, олон хэлтэн, янз бүрийн ангийн түвшний суралцагчидтай ажиллах арга барилыг эзэмшихийг шаардана.”</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын яамны зохих мэргэжилтнүүд</li> <li>• Багш бэлтгэдэг сургуулиудын удирдлагууд</li> <li>• Сургалт, сургалтын хөтөлбөр хариуцдаг багш бэлтгэдэг сургуулийн багш, ажилтнууд</li> </ul>	

ТАЛАРХАЛ

ЮНЕСКО-гоос энэхүү “Тэгш хамруулан сургах, багшийн боловсрол” хэмээх зөвлөмжийг өөрийн орны боловсролын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд үнэтэй санал өгч хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын багш ажилтан нарт төслийн баг хамт олны зүгээс талархал илэрхийлж байна.

Н.НАСАНБАЯР /БСШУЯ - Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга/  
Ө.ГАНБОЛД /БСШУЯ- Стратеги бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн/  
Р.ТУЯА Ph.D /БМДИ - Захиалгат сургалтын албаны дарга/  
Ч.ЖАРГАЛ /БМДИ - Захиалгат сургалтын албаны тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан арга зүйч/  
Д.ОДГЭРЭЛ Ph.D /МУБИС - Багшийн сургуулийн багш/  
Г.БАТЦЭНГЭЛ Ph.D /МУБИС -Боловсрол судлалын сургуулийн сэтгэл судлалын тэнхмийн багш/  
Д.ЦЭДЭВСҮРЭН Ph.D /МУБИС, МБУС-н Мэдээлэл зүйн тэнхимийн эрхлэгч /



## **Оюутан Л.Ариунцэцэг**

Би энгийн нэгэн биш байж болно  
Би тусгаарлагдсан нэгэн байж болно  
Бусдын бухимдлыг хүргэдэг байж болно  
Бусад хүмүүсээс хараат байж болно.

Хэрвээ надад туслах юм бол:

Энгийн нэгнээ эгэл хүн болгож  
Өөртөө адил нэгэн боломж нээж  
Өрөөсгөл ойлголттой хүмүүсийг  
Өөрийн гэсэн бодолтой болгож чадна.

Хэрвээ намайг дэмжихийн бол

Бусдын мэдэрдэг зүйлийг адилхан мэдэрч  
Хүртэхүй минь сайжирна.  
Мэдэхийг хүссэн зүйлээ адил мэдэж  
Мэдээлэл хүлээн авч чадна.  
Хийж бүтээхийг хүссэн зүйлээ хийж  
Олны хүртээл болгож чадна.

Гэвч миний хүссэн ирээдүй

Үлгэрийн орон зай

Дэмжлэг нийгэм

Энэ Монголд алга

Би дэмжээд байхад ахидаггүй нэгэн биш  
Би туслаад байхад ухаардаггүй нэгэн биш  
Би зөвлөөд байхад ухардаг нэгэн биш  
Би сургаж байхад ахиц гаргаж дэвшдэг нэгэн бодгаль хүн.

## **Оюутан Г. Уянга С. Мөнхцэцэг М. Сэрчмаа**

Бид адилхан л хүн

Тив дэлхийн хүмүүс та биднийг адилхан л гэх юм

Арьс өнгө зүс царай өөрч

Амьсгалах агаар амьдардаг дэлхий нэг л гэх юм

Дэлхийгээр дүүрэн бид тэгш эрхтэй л гэдэг ч

Тэр чин надад олдохгүй байна

Сонсох гэхээр аппарат алга

Сурах гэхээр орчин нь алга

Явах гэхээр автобус нь алга



Ядаж гарах гарц ч алга  
Би харж чадахгүй ч сонсож чадна  
Би сонсож чадахгүй ч харж чадна  
Би явж чадахгүй ч сэтгэж чадна  
Би хийж чадахгүй ч бодож чадна  
Энэ нийгмийн эмгэнэл гэвэл бид биш харин  
Биднийг ойлгох ухаангүй  
Бидэнд туслах сэтгэлгүй  
Бусдыг хүндлэх хүндлэлгүй  
Тэр хүмүүсийг хэлнэ

***Оюутан С. Буянхишиг Л. Ариунцэцэг Б. Гэрэлцэцэг А. Сэрчмаа М. Чагцал***

Хөл минь хөдлөхгүй энд байлаа ч  
Хүсэл мөрөөдөл минь алсын алсад бий  
Нүд минь харахгүй харанхуй байлаа ч  
Нарт ертөнцийг гийгүүлэх гэрэл гэгээ сэтгэлд минь бий  
Би энгийн нэгэн биш байж болно  
Би тусгаарлагдсан нэгэн байж болно  
Бусдын бухимдлыг хүргэдэг байж болно  
Бусад хүмүүсээс хараат байж болно  
Хэрвээ намайг дэмжих юм бол  
Энгийн нэгэн эгэл хүн болгож чадна  
Сонсохгүй ч мэдрэнэ Харахгүй ч сэтгэнэ  
Үзэх мэлмий минь байхгүй ч  
Үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй  
Харах мэлмий минь байхгүй ч гэлээ  
Хар барааныг даван туулдаг зоригтой хүн билээ

***Оюутан Энхчимэг, Отгонцэцэг, Бямбасүрэн, Золжаргал,  
Эрдэнэтунгалаг, Эрдэнэзул***

Тэнхээ заан ирээдүйд тэмүүлэгч  
Энгүй орчлонгийн бяцхан үрс бид  
Гэгээн бүхнийг өөртөө шингээн  
Шантрашгүй зоригоор ихийг бүтээнэ  
Хүсэл бүхнийг минь та дэмжээч  
Амьдралын ухаанд биднийг сургаач  
Мөрөөдөл хүслээрээ жигүүрлэн

Рашаан мэт амьдралыг тэтгэгч  
Ухаалаг нийгмийг та цогцлоогооч  
Уужуу сэтгэлээр биднийг дэмжээч  
Луу мэт хүчийг хайрлаач  
Амьдралын утга учрыг  
Хүн хүнээ хайрлахыг санаач

Төр нийгэм нь түшигтэй хандаж  
Эрх үүргээ биелүүлэхэд нь туслах  
Гэрэвшиж тээнэгэлзэхгүйгээр  
Шударга байж чадлаараа дэмжицгээе  
Хараа хяналт сул байгаа тэдэндээ  
Аюулгүй байдлыг нь хангаж  
Маргашгүйгээр тэдэндээ тусалцгаая  
Радио телевиз бусад сувгаар  
Урмын үгсийг хайрлаж  
Урагшаа хэмээн зүтгэж чадна гэсэн итгэлтэй болговол  
Лавтайяа тэд урамшина шүү  
Амжилт өөд тэмүүлэхэд нь  
Хайр халамжаа хайрлацгаая!

***Багш Хонгорзул, Бадамханд, Анхтуяа.  
Алтанцэцэг, Сувдаа, Саруул, Эрдэнэтуяа***

Таних танихгүй нь хамаагүй ээ  
Эх нар нэгтэй шүү бид  
Шат шатаар ч болов ахихыг хүснэ  
Хамтдаа сэтгэл зүйгээ өөрчилъе  
Адил тэгшээр мэдэрч ойлгооч  
Мэддэггүй болохоор бэрхшээл гэх юм  
Радио телевизээр төр засагт хүргээч  
Улс орон минь биднийгээ бүү гадуурхаач  
Ухаантай хүмүүс минь биднийг дэмжээч  
Лавтайяа бид хөгжих болно  
Асуудлаа бид давж чадна  
Хөгжилтэй Ирээдүй рүү хамтдаа алхая!

**Тусгай хэрэгцээт боловсролын багшийн нэг жилийн ангийн оюутнууд 63-р сургуулийн багш нар: Уранцэцэг, Ариунбаяр, Жанжинцэцэг, Жаргалсүх, Батхишиг, Загджае**

Хүүхэд инээдээр хөгжсөн гэрэлт өдрүүд  
Хүүхэд итгэлээр жигүүрлэсэн цагаахан шувууд  
Хүүхэд хайраар бойжих эмзэгхэн цэцэг  
Хүүхэд эрдмээр услуулсан танхилхан ертөнц  
Хүүхэд хяслаар биш хүслээр төрдөг амьд бие  
Хүүхэд бие эрхтэн, үзэл бодлоор... ялгаварлах эрхгүй  
Ховор эрдэнэ!

**Тусгай хэрэгцээт боловсролын багшийн нэг жилийн ангийн оюутнууд 55-р сургуулийн багш нар: Уранхүрэл, Ганзориг, Оюунжаргал, Туул**

Тусгай сургуулийн хүүхдүүдийн өмнөөс:

“Бид ер нь бурхнаас гуйж  
Бэрхшээлтэй болохыг хүсээгүй юм  
Харин бид чин бусад шиг  
Хайрын цэцэгнээс дэлбээлсэн юм”

**ЕБС-ийн хүүхдүүд:**

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэж  
Хөөж бид нар гадуурхаагүй  
Боломжийг тэдэнд олгож  
Тэдэнтэй хамт сургаач!  
Нараа тойрон хүүхдүүд бид  
Нэгэн сургуульд нэгдэх юмсан  
Харин тийм боломж нь  
Хатуу орчлонд байдаггүй юм уу?  
Тийм боломж нь олддог бол  
Тэгш эрхтэй суралцах юмсан  
Үеийн найзуудтайгаа нэгдэж  
Үерхэж нөхөрлөж дотносох юмсан!”